



Дэлхийн ӨВ залуу үеийнхний гарт



МЭДЭХ, СУДЛАХ, АЖИЛ ХЭРЭГ БОЛГОХ

Багш нарт зориулсан боловсролын
гарын авлага



Тусламжтайгаар:

Норвегийн Хөгжлийн Хамтын Ажиллагааны Агентлаг (NORAD) ын

“Дэлхийн Өв залуу үеийхний гарт” гэсэн энэхүү багш нарт зориулсан гарын авлагыг ЮНЕСКО-гийн тусламжтайгаар англи хэлнээс монгол хэл рүү хөрвүүлэн Гаргав.

Батламж

Энэ хэвлэлд хэрэглэж буй утга санаа, нэр томъёо болон танилцуулгууд нь аливаа улс орон, газар нутаг, хот суурин, тэдгээрийн удирдлага, эсвэл хил хязгаарын зааглалын талаарх хууль тогтоомжид хамааралтай асуудлаарх ЮНЕСКО-гийн аливаа үзэл бодлыг илэрхийлээгүй болно.

Энэхүү хэвлэлийн монгол орчуулгыг ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисс бүрэн хариуцах болно.

Тус номын анхны хэвлэл 1998 онд хэвлэгдэн гарсан.

UNESCO 2002

UNESCO 2004, for the Mongolian translation and adaptation

ISBN 92-3103843-5

ISBN 99929-10-02-X



“Өнгөт хэвлэл” ХК-д хэвлэв.

Өмнөх үг

ЮНЕСКО-ГИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Дэлхийн Өвийн боловсролын түүчээ болсон багш нарт үзүүлэх гүн хүндэтгэл

Упиран одсон зуун зууны турш бидний өв уламжлалын ихээхэн хэсэг нь эргэн нөхөгдөшгүйгээр устаж үгүй болжээ. Байгалийн гамшиг, дайн дажин, туйлын ядуурал, үйлдвэржилт болон хүрээлэн буй орчны бохирдолтын уршгаар энэхүү юугаар ч сольшгүй өв эрдэнэс эвдрэн сүйрч, доройтон муудсаар байгааг бид харсаар ирсэн билээ.

Өнө удаан үргэлжилж буй энэ эмгэнэлт байдал нь хүмүүс энэхүү өв сандаа хэнэггүй хайхрамжгүй хандаж, анхаарал хайр халамжаар дутаасантай бас холбоотой. Олон улсын хамтын нийгэмлэг бидний соёлын болон байгалийн дахин олдошгүй үнэт өвийг устаж үгүй болохоос урьдчилан сэргийлэхэд бэлэн байгаагаа 1972 онд Дэлхийн Өвийн Конвенц батлан гаргаснаар илтгэн харуулсан билээ. Тэр цагаас хойш дэлхийн 129 орны 754 гаруй дурсгалт газрыг Дэлхийн Өвийн жагсаалтанд бүртгэсэн бөгөөд энэ тоо жилээс жилд нэмэгдсээр байна. Дурсгалт газар бүр дэлхий дахины нийтлэг үнэт зүйл төдийгүй дэлхий дахины нийтлэг соёл иргэншлийг бүрдүүлэгч салшгүй хэсэг мөн. Устаж үгүй болохын аюулд учирсан болон эвдрэн сүйрч буй дурсгал бүр нь нийт хүн төрөлхтөнд учирч болох нөхөгдөшгүй гарз хохирол юм. Бидэнд үлдсэн өв ирээдүйд хэрхэх нь маргааш улс орны удирдагчид, шийдвэр гаргагчид болох өнөөдрийн залуу үеийнхний шийдэл, үйл ажиллагаанаас ихээхэн хамаарах болно. Ийм учраас "Конвенцид нэгдэн орсон улс орнууд хүн ардаа соёлын болон байгалийн өвийг хүндэтгэн хайрлах сэтгэлтэй болгох талаар бололцоот бүхий л арга хэрэгсэл, ялангуяа боловсрол, мэдээллийн хөтөлбөрүүдийг ашиглан хүчин чармайлт гаргах болно." гэж тунхагласан Дэлхийн Өвийн Конвенцийн 27-р зүйлийг хэрэгжүүлэх үүднээс ЮНЕСКО-гийн Дэлхийн Өвийн төвөөс 1994 онд "Дэлхийн Өв- залуу үеийнхний гарт" гэсэн ЮНЕСКО-гийн Дэлхийн Өвийн залуучуудын боловсролын төслийг ЮНЕСКО-гийн Холбоот Сургуулийн Төслийн Сүлжээгээр хэрэгжүүлж эхэлсэн юм.

Энэ төслийн нэг ололт амжилт бол багш нарт зориулсан "Дэлхийн Өв-залуучуудын гарт" гэсэн энэ гарын авлагыг бий болгож, шалгалт сорилтод оруулж, үнэлэлт дүгнэлт хийсэн явдал юм.

Энэхүү ном залуучуудад орон нутгийн, үндэсний болоод дэлхийн өвийг хамгаалахын чухлыг мэдрүүлэх, хамгаалж байх зайлшгүй чадварыг тэдэнд эзэмшүүлэх, энэ талаар амьдралынхаа туршид чармайж явах тэмүүлэл эрмэлзэлтэй болгоход багш нарт үнэтэй гарын авлага болсоор байна.

Дэлхийн Өвийн боловсролыг хөгжүүлэх сургалтын эх материалуудыг туршин хэрэглэхэд Холбоот Сургуулийн Төслийн Сүлжээний багш нар онцгой хариуцлагатай үүрэг гүйцэтгэж ирлээ.

Ийнхүү энэ их хэргийг эхлүүлсэн хувь нэмрийнх нь төлөө тэдэнд болон энэ дэлхийн бусад өв хамгаалагч мэргэжилтэн, багш нарт онцгой хүндэтгэл үзүүлж байна.

Энэ ном чанартай сайн болсон нь багш нарын маань онцгой хүчин чармайлтын үр дүн бөгөөд Дэлхийн Өвийг хамгаалах үйлсэд залуусын сонирхол оролцоог

болон сургууль, иргэдийн дунд суралцах явдлыг идэвхжүүлсэн бүтээлч, шинэлэг арга хандлагыг нь төлөө тэднийг би сайшааж магтмаар байна.

Боловсрол бол хувь хүний төлөвшил болон хөгжил дэвшил, тогтвортой байдал, энх тайван, сайн сайхан амьдралын түлхүүр мөн. Боловсролоор дамжуулан залуучууд соёлын болон байгалийн өв, биет ба биет бус өв, нутгийн болон дэлхийн өвийг хамгаалах үүрэг хариуцлага хүлээж, үйл ажиллагаагаа бэхжүүлэх шинэ шинэ арга замыг олох болно. Тэдний хүчин зүтгэл нь өнөө үеийнхэнд төдийгүй ирээдүй хойч үеийнхэндээ өгөөж буянаа хүртээх болно.

Дэлхийн өв гэсэн ойлголт хөдөлгөөнгүй зүйл бишээ. Жил бүр дэлхийн өвийн хороо түүхэн дурсгалт газруудыг Дэлхийн Өвийн Жагсаалтад бүртгэх асуудлаар хуралддаг. Дэлхийн өвийн боловсрол нь өөрөө динамик үйл явц юм. Мэдэхийн тулд суралцах, хийхийн тулд суралцах, оршин байхын тулд суралцах, хамтдаа амьдрахын тулд суралцах гэсэн 21-зуунд суралцах 4 үндсэн тулгуур асуудал түүгээр дамжин биелэлээ олж байна. 2000 оны 4-р сард Сенегалын Дакарт болсон Дэлхийн боловсролын чуулганаар сайшаан батлагдсан "Бүх нийтийн боловсрол"-ын хүрээнд тусгагдсан боловсролын чанарыг сайжруулах зорилттой дэлхийн өвийн боловсрол бас нягт холбоотой юм.

Дэлхийн өвийн боловсрол нь дэлхийн соёлуудын өвөрмөц онцлог шинжийг нь дахин илтгэн харуулах, тэдгээрийн дунд харилцан хүндэтгэл, яриа хэлэлцээ, олон төрөл байдлын нэгдэл, хоорондын нягтрал, нааштай харилцан үйлчлэл зэргийг бататгахын төлөө уриалан номлогч билээ. Энэ номыг түүх, газарзүй, дүрслэх урлаг, математик, хэл болон бусад мэргэжлийн багш нар сургалтын хөтөлбөр төлөвлөгөөндөө тусган, өргөн хэрэглээсэй гэж би хүсэж байна. Энэ номыг нэмэлт материалаар баяжуулж, ангийнхаа практик хичээлээр бататган хөгжүүлж ашигласнаар багш та нар даян дэлхийн хүмүүсийг итгэл найдвар, харилцан хүндлэл, эв нэгдэлтэй, ойр дотно хамтдаа аж төрдөг болгоход өнөөгийн залуусыг удирдан хөтлөхөд тус болно.

Өмнөх үг



ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссын Ерөнхий Нарийн Бичгийн Дарга Дэлхийн Өвийн Үндэсний

Хүн төрөлхтөн байгалийн үнэт өв болон бүтээн бий болгосон үнэт зүйлс, соёлын өвөө хадгалан хамгаалж хойч үедээ өвлүүлэн өгч байх нь хүн төрөлхтөн оршин тогтнох, хөгжин дэвших үндэс болдог байна.

Нэгэн үндэстний бүтээн бий болгосон буюу эзэмшиж байдаг байгалийн болон соёлын өв нь нийт хүн төрөлхтний хувьд түгээмэл үнэ цэнэ, ач холбогдолтой байх нь олонтаа. Иймээс ч түүнийг хадгалан хамгаалах явдал ганцхан тэр улс үндэстний хэрэг төдийгүй дэлхийн нийт улс орон, хүмүүст хамааралтай байдаг аж.

Тиймээс дэлхийн соёлын зүтгэлтэн буянт хүмүүсийн санаачлага болон ЮНЕСКО-гийн хүчин чармайлтын үрээр түүний гишүүн орнууд 1972 онд “Дэлхийн байгалийн болон соёлын өвийг хамгаалах тухай” Конвенцийг байгуулан хэрэгжүүлж эхэлсэн билээ. Өнөөдөр байгалийн болон соёлын өвийн Конвенцид 178 улс орон нэгдэн орсон бөгөөд 754 өв Дэлхийн өвийн жагсаалтад бүртгэгдсэн байна.

Монгол улс Дэлхийн өвийн Конвенцид 1990 онд нэгдэж орсон билээ. 1972 онд Конвенцийн 11-р зүйлийн 1-д заасны дагуу 1995-1996 онд Дэлхийн өвд бүртгүүлж болох Монголын байгалийн болон соёлын өвийн урьдчилсан жагсаалтыг боловсруулан Дэлхийн өвийн хороонд хүргүүлсэн нь анхны хамгийн амжилттай алхам болсон юм. “Увс нуурын ай сав” 2003 онд Дэлхийн байгалийн өвд, “Орхоны хөндийн соёлын дурсгалт газар” 2004 онд Дэлхийн соёлын өвд тус тус бүртгэгдсэн юм.

Дэлхийн өвийн Конвенц, түүний ач холбогдлыг олон нийтэд сурталчлан түгээх талаар их зүйл хийх хэрэгтэй байна. Үүний тулд дэлхийн өвийн тухай хичээлийг нийт сургуулиудын программд тусгах, “Дэлхийн өв залуу үеийнхний гарт” сэдэвт ЮНЕСКО-гийн хөтөлбөрийг Дэлхийн өвд орсон Увс нуур болон Орхоны хөндийн соёлын дурсгалт газар болон бусад дурсгалт газрын ойролцоох аймаг, сум болон сургуулиудад хэрэгжүүлэх, мэдээллийн хэрэгсэл, интернетийг ашиглан танин мэдэхүйн өргөн таниулга хийх нь чухал болж байна.

Энэ үүднээс ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссоос ЮНЕСКО болон Дэлхийн Өвийн Төв, Дэлхийн Өвийн Сангийн тусламжтайгаар ЮНЕСКО-гийн “Дэлхийн өв залуу үеийнхний гарт” сурах бичгийг орчуулан гаргаж, олон түмэн, залуучуудад толилуулж байна.

Сайн үйлс дэлгэрэх болтугай.

Док. Н. Уртнасан

БАГШ НАРТ ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

Агуулга	Хуудас
Оршил	7
Гарын авлагыг хэрхэн ашиглах тухай	11
Дэлхийн Өвд боловсролын үүднээс хандах нь	17
Дэлхийн Өвийн Конвенц	39
Дэлхийн Өв ба түүнийг таньж мэдэх	85
Дэлхийн Өв ба аялал жуулчлал	103
Дэлхийн Өв ба хүрээлэн буй орчин	125
Дэлхийн Өв ба энхийн соёл	147
Ашигласан материал	163

ОРШИЛ



Хуучин Хаван
ба түүний
цамхаг
Патримонин 2001

□ Дэлхийн Өвийн Жагсаалтад бүртгэгдсэн дэлхий дахины нийтлэг үнэ цэнэ бүхий соёлын болоод байгалийн гайхамшигт дурсгалт газруудын тухай илүү ихийг сурч мэдэх

□ ЮНЕСКО-гийн Дэлхийн Өвийн 1972 оны Конвенцоор хамгаалалтанд орсон дурсгалт газруудыг хамгаалахад шаардлагатай шинэ чадварыг эзэмших

□ Өнөө болон ирээдүй хойч үеийнхээ тусын тулд орон нутгийн болоод үндэсний, тэрчлэн дэлхийн өвийг хамгаалахын төлөө насан туршийн тууштай эрмэлзэл, шинэлэг арга хандлагатай болох

□ Олон улсын хамтын ажиллагаанд тулгуурлан дэлхий дээрх соёлын болон байгалийн асар олон төрөл зүйл бүхий үнэт өвийг хадгалж хамгаалахад цаашид идэвхтэй үүрэг гүйцэтгэх

Энэхүү төсөл нь олон төрлийн хичээлүүдээр дамжуулан музей, дурсгалт газрын менежер, орон нутгийн нийгэмлэгүүдтэй хамтран тухайн сургууль, нутгийн болон үндэсний дурсгалт газруудад өвийн боловсрол олгох, өв хамгаалах арга хэмжээнд оюутан сурагчдыг татан оруулах зорилготой.

Дэлхийн Өвийн боловсролын шинэ үзэл санааг ангид болон ангиас гадуур танилцуулахын тулд ЮНЕСКО “Багш нарт зориулсан боловсролын гарын авлага” номыг Францын Rhone- Poulenc сан болон хөгжлийн хамтын ажиллагааны Норвегийн агентлагийн /NORAD/ дэмжлэгтэйгээр 1999 онд бэлтгэсэн юм. Энэ гарын авлага нь залуучуудад зориулсан боловсролын шинэ үйл ажиллагааг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулсан ба Норвег /1995/, Хорвати /1996/, Зимбабве /1996/, Хятад /1997/, Япон /1998/, Сенегал /1999/, Марокко /1999/, Австрали /2000/, Перу /2001/, Швед /2001/-д ЮНЕСКО- гоос зохион байгуулж явуулсан олон улсын болон бүс нутгийн “Дэлхийн Өвийн залуучуудын чуулга уулзалтад” оролцсон 130 гаруй орны багш сурагчдын үйл ажиллагааны үр дүнд тулгуурласан юм.

Гарын авлагын анхны хэвлэл нь араб, хятад, англи, финн, франц, индонез, япон, лаос, орос, испани, узбек, вьетнам хэлээр хэвлэгдсэн бөгөөд 130 гаруй орон дахь ЮНЕСКО-гийн Холбоот Сургуулиудын төслийн сүлжээний багш сурагчид туршин хэрэглээд байгаа билээ. Гарын авлагын талаарх мэдээллийг ЮНЕСКО-гийн Дэлхийн Өвийн боловсролын www.unesco.org/whc/education веб сайтаас авч болно.

ЮНЕСКО-гийн залуучуудын Дэлхийн Өвийн боловсролын “Дэлхийн өв- залуу үеийнхний гарт” төслийн нэг хэсэг болох дэлхийн өвийн боловсролын багш нарын гарын авлагын 2-р хэвлэлтэй танилцъя.

Юнеско-гийн Дэлхийн Өвийн төв болон Холбоот Сургуулийн төслийн сүлжээгээр 1994 оноос хэрэгжүүлж эхэлсэн энэхүү төсөл нь сурагчдад доорхи мэдлэг, арга барилыг эзэмшүүлэх замаар Дэлхийн Өвийг хамгаалах явдлыг дэмжих боловсролын шинэ арга хандлагыг хөгжүүлэх зорилготой юм. Үүнд:

Дэлхийн ихэнх хэсэгт багш нарыг сургах дэд бүсийн сургалт зохион байгуулах замаар Дэлхийн Өвийн боловсрол, үйл ажиллагаанд залуучуудыг хамруулах, татан оруулах бүс нутгийн болон үндэсний стратегийг хөгжүүлж ирлээ. Энэ нь боловсролын шинэ үзэл хандлагыг албан ёсны сургалтын хөтөлбөртэй холбох зорилтыг шийдвэрлэхэд нь дэлхийн улс орнуудад тусалж дэмжих зорилготой.

Дэлхийн бүх өнцөг булан бүрт биш ч гэсэн зарим хэсэгт нь дунд сургуулийн янз янзын мэргэжлийн багш нар ашиглах гарын авлагатай болох явдал томоохон зорилт болж байна. Хэдийгээр энэ номыг олон орны багш нарын хөгжүүлж байгаа боловсролын бодит арга хандлага, үйл ажиллагаа, тэрчлэн дэлхийн олон орны багш, сурагчдын санал зөвлөмж, зааварчлагыг үндэслэн боловсруулсан хэдий ч энэхүү гарын авлагыг орон нутаг, үндэсний онцлогт нийцүүлэн хэрэглэх нь зүйтэй.


Гарын авлагын эхний хувилбарыг туршин хэрэгжүүлсэн олон олон багш, сурагчдаас ирсэн үнэтэй санаа оноо нь хоёрдахь хэвлэлийг сайжруулан гаргахад чухал болсон. Нөгөө талаас энэхүү номонд өгсөн үнэлгээний нэг гол дүгнэлт бол бүс нутаг болоод үндэсний хэмжээнд сургалт явуулахад баталгаатай "хэрэглүүр" болно гэж үзсэн явдал билээ. Дэлхийн хамтран ажилладаг түншүүдээс номын талаар ирүүлсэн олон хүсэлт, санаа оноонд нийцүүлэн ЮНЕСКО-гоос ялимгүй хянан засварласан номын эхийг 2-дахь хэвлэл болгон толилуулахаар шийдвэрлэсэн юм.

Боловсролын шинэ үзэл хандлагыг туршин хэрэгжүүлж байгаа багш нар, соёлын өвийн шинжээч судлаачид, сургалтын хөтөлбөрийг дэмжин хөгжүүлэгчдийн идэвхтэй оролцоо, хувь нэмэр нь бүсийн болон үндэсний гарын авлагыг бүтээн бий болгох замаар Дэлхийн Өвийн боловсролыг дэмжихэд түлхэц үзүүлсэн юм. Тухайлбал: Одоогоор ЮНЕСКО-гийн үндэсний комиссууд гарын авлагыг 15 орны хэл дээр хэвлүүлэхээр бэлтгэж байна. "Дэлхийн Өв- залуучуудын гарт- Номхон далайн хэтийн төлөв" гэсэн гарын авлагын бүсийн хувилбар 2004 онд хэвлэгдэнэ. Латин Америк дахь Дэлхийн Өвийн боловсролын үндэсний хороод нь бүс нутгийн болоод үндэсний төвшинд үйл ажиллагаагаа бэхжүүлэх арга замыг сүвэгчилж байна.

Сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэх явц нь судалгаа, сорилт шалгалт, үнэлгээ шаардсан хичээл оролдлогын үр дүн болно. Энэ бол цаг үргэлж явагдах үйл явц бөгөөд урт хугацааны зорилт. Одоо ба ирээдүйд эх дэлхийнхээ гайхамшигт өвийг хамгаалах үйлсэд бүх нийтээрээ хамтран тэмцэж, энх амгалан, эрүүл саруул дэлхий ертөнцийг бий болгохын төлөө шинэ итгэл найдвар, шинэ үзэл бодолтойгоор шинэ мянгандаа орсон шигээ боловсролын шинэ үзэл хандлагыг хэрэгжүүлж эхлэх тийм цаг үетэй тулгараад байна.

ЮНЕСКО-гоос хянан тохиолдуулсан:


Элизавет Каваджи



Бреда Павлик



Сара Тичен



Дэлхийн Өвийн эмблем болон Патримонито


Дэлхийн Өвийн эмблемд билэгдэн харуулсан шиг Дэлхийн Өвийн Конвенц нь соёлын боллоод байгалийн өвийг ямагт хамтад нь хамгаалах учиртай.



Эмблем нь голдоо хүний бүтээлийг бэлэгдсэн дөрвөлжин дүрс, байгалийг бэлэгдсэн тойрог хоёроос бүтсэн байх бөгөөд тэдгээр нь хоорондоо салшгүй холбогдсон ажээ. Тэр нь соёлын ба байгалийн дурсгалт газруудын харилцан шүтэлцээ хамаарлыг бэлэгдэж байна. Энэ эмблем нь дэлхий шиг дугуй хэлбэртэй байгаа нь байгаль дэлхийг, мөн түүний хамгааллыг давхар бэлэгдэж байгаа болно.



Патримонито гэсэн нэр нь 1995 онд Норвегийн Бергенд болсон Дэлхийн Өвийн залуучуудын анхдугаар чуулга уулзалтын үед анх төржээ. Өөрсдийгөө ямар нэг зүйлээр таниулж, төлөөлүүлэхийг хүссэн Испани хэлтэй сурагчид сэджээ. Патримонито гэдэг нь Испаниар “Бяцхан өв хамгаалагч” гэсэн утгатай бөгөөд энэ утгаараа өв хамгаалахад тусалдаг бяцхан иргэдийг ч хэлж болно.



Африкийн анхдугаар Дэлхийн Өвийн чуулга уулзалтаар хүүхдүүд Патримонитотой салах ёс гүйцэтгэж байгаа нь, Зимбабве
ЮНЕСКО



Гарын авлагыг хэрхэн ашиглах тухай

Энэ гарын авлагыг дунд сургуулийн багш нартаа зориулав:

□ Зарим газарт сургуулийн дэд бүтэц муу хөгжсөн, анги, сургуульд сургалтын материал хэрэгсэл хомсдолтой, нэг ангид хэтэрхий олон сурагчидтай, хичээлийн цаг нь хэтэрсэн байхад нөгөө газарт нь боловсролын сүүлийн үеийн технологиор тоноглогдсон /интернет, CD-ROM-д холбогдсон/ зэргээр дэлхийн өнцөг булан бүрт янз бүрийн нөхцөл байдалд та нар ажиллаж байгаа билээ.

□ Та бүхэн 12- 18 насны хүүхдүүдэд газарзүй, түүх, хэл, шинжлэх ухаан, математик, дүрслэх урлаг гэх мэт олон янзын хичээл заадаг билээ.

Энэхүү гарын авлагын зохиомж “багажны хайрцаг” ыг санагдуулна:

□ Энэ хайрцагнаас та өнөөдөр, маргааш, дараагийн долоо хоногт тэрч байтугай хэдэн сарын туршид ангидаа болон ангиас гадуур юу ашиглахыгаа сонгон авна.

□ Гарын авлагаа эхнээс нь эхлэн судалж, боловсролын арга хандлагын тухай юу гэж бичсэнийг уншиж болно.

□ Дэлхийн Өвийн Конвенц, Дэлхийн Өв түүнийг танин тодорхойлох нь, Дэлхийн Өв ба аялал жуулчлал, Дэлхийн Өв ба хүрээлэн буй орчин, Дэлхийн Өв ба энхийн соёл зэрэг сэдвүүдээс нэгийг нь шууд сонгон авч чадна.

□ Номонд орсон Дэлхийн Өвийн Конвенц, Дэлхийн Өвүүдийн байршлын газрын зураг болон гэрэл зураг зэрэг гарын авлагт орсон материалуудыг чөлөөтэй хэрэглэж болно.

□ Дэлхийн Өвийн дурсгалт газруудын тухай болон танай оронд буюу өөр хаа нэг газар Дэлхийн Өвийг хамгаалж байгаа талаар гарсан мэдээлэл, фото болон газрын зураг, та өөрөө болон сурагчдын чинь хийсэн материал гэх мэт өөрсдийн материалуудаар баяжуулж болно.

Гарын авлагыг хэрэглэхэд хялбар болгохын тулд дараах тэмдгүүдийг хэрэглэв:



Хуудасны /урд талын талбайд/ захын зайд гарын авлагын бусад бүлгүүдээс авсан ишлэлийг заана.

Тодруулсан үг өгүүлбэр нь гарын авлагын нэмэлт тайлбар толинд орсон байна.



Харилцах хаягууд

Харилцах хаяг- Дэлхийн Өвийн холбогдолтой мэдээлэл, баримт бичигтэй танилцахын тулд бусад байгууллагуудтай харилцах шаардлага гарвал харилцах хаягууд "Ашигласан материал"- д орсон байгааг заана.



Ашигласан материалын жагсаалт

Лавламж материалын жагсаалт- Дэлхийн Өвийн холбогдолтой бүх материалыг багтаах боломжгүй учраас үнэгүй захиалах ба худалдан авах боломжтой материалуудыг "Лавламж материалын жагсаалт"- д орсныг заана.



Сурагчийн гүйцэтгэх ажил- Гарын авлагат сурагчийн гүйцэтгэх 42 ажлыг хайрцаглан тэмдэглэсэн. Эдгээр ажлыг орон нутгийнхаа нөхцөл байдал, сурагчдын хэрэгцээ шаардлагатай уялдуулан хэрэглэж, шинэчлэн өөрчилж, цааш нь хөгжүүлж болно. Эдгээр ажлыг ашиглахад танд туслах зорилгоор дараах зурагт дөрвөлжин тэмдгүүдийг хэрэглэсэн болно.

Гүйцэтгэх ажлын хэлбэрүүд



Ярилцлага



Үзэж танилцах



Судалгаа



Дэлхийн Өвийн газруудаар аялах



Дасгал ажил



Дүрийн тоглолт

Гүйцэтгэх ажлын төрөл хэлбэрийн задаргаа



Ангийн ажил



Санал болгосон хичээл



Сургалтын хөтөлбөрөөс гадуурх ажил



Ашиглах гарын авлага материал



Төлөвлөсөн хугацаа



Бусад материал

Сурагчдад хичээл дээр шууд хувилан олшруулан ашиглах боломжтой “Сурагчдын дасгал ажлын хуудсууд”-ыг гарын авлагат оруулжээ.



Дэлхийн Өвийн
Конвенц

Дэлхийн Өвийн Конвенц- Гарын авлагын “Ашиглах материал”-д бүрэн эхээрээ орсон Дэлхийн Өвийн Конвенцийн тодорхой бүлгүүдийг заана.



Товч
тодорхойлол

Товч тодорхойлолт- 2004 оны 5-р сарын байдлаар Дэлхийн Өвийн дурсгалт газар нэг бүрийн тодорхойлолт, Дэлхийн Өвийн Жагсаалтад оруулахад хэрэглэгддэг шалгуурууд, Дэлхийн Өвийн Жагсаалтад бүртгэгдсэн он, сар, өдөр, зэргийг тусгасан ЮНЕСКО-гийн Дэлхийн Өвийн Төвийн баримт бичиг болох “Товч тодорхойлолт”-ыг ашиглахад хэрэглэгдэнэ.



Дэлхийн Өвийн
газрын зураг

Дэлхийн Өвийн газруудын байршлын газрын зураг- Оролцогч бүх улс орон Дэлхийн Өвийн Конвенцид нэгдэн орох гэрээ хэлцэлд гарын үсэг зурсан он, сар, өдөр, түүнчлэн бүсээр гаргасан Дэлхийн Өвийн дурсгалт газруудын нэрс бүхий Дэлхийн Өвийн дурсгалт газруудын байршлын газрын зургийг ашиглахад хэрэглэнэ.




Гэрэл зураг

Гэрэл зураг- Дэлхийн Өвийн байгалийн ба соёлын дурсгалт газруудын 26 гэрэл зургийг ашиглахад хэрэглэнэ. /Ар талд нь тухайн дурсгалт газрын нэр, товч тодорхойлолт, Дэлхийн Өвийн Жагсаалтад бүртгэгдсэн он, сар, өдөр, жагсаалтад орсон шалгуурууд зэргийг бичсэн/

Гарын авлагын талаар дэвшүүлсэн шинэ, уриалан дуудсан үйл хэргийг бүтээлчээр хэрэгжүүлэхэд тань танд их амжилт хүсье.
ЮНЕСКО цаашид ч мэдээ мэдээлэл түгээгч, таны дэмжин туслагч хэвээр байх болно.

Хятадын Бээжин хотод болсон Ази-Номхон далай орнуудын залуучуудын Дэлхийн Өвийн чүүлгэ уулзалтын үеэр Лууны сийлбэр үзэж байгаа нь. ЮНЕСКО



Дэлхийн Өвд боловсролын үүднээс хандах нь

**“Дэлхийн бүх шатны сургууль
болон сурагчдад Дэлхийн Өвийн
боловсролыг таниулж сургахад
багш нар бэлэн байна”**

**Зимбабве/ Замбиад болсон ДӨ-ийн
залуучуудын Африкийн анхдугаар
чуулга уулзалт**

Дэлхийн Өвд боловсролын үүднээс хандах нь

Дэлхийн Өвд боловсролын үүднээс хандах нь

Нэгдмэл сургалтын арга хандлага 18

Сурагчдын хийх ажил	18
Ярилцлага	19
Судалгаа	19
Дасгал ажлууд	19
Үзэж танилцах ажлууд /гэрэл зураг/	19
ДӨ-ийн дурсгалт газруудаар аялах	20
Сурагчийн гүйцэтгэх ажил 1: ДӨ-ийн дурсгалт газруудын тухай шалгалт авах	20

Түүхэн дурсгалт газрууд болон музей үзэх 21

Дурсгалт газруудаар аялах	21
Бэлтгэл ажил	21
Аяллын өмнөх үе	22
Аялж байх үе	22
Аяллын дараах үе	22
Сурагчийн дасгал ажлын хуудас: ДӨ-ийн газраар аялах	24
Музей үзэх	26
Музей үзэх явцад өрнөх тусгай ярилцлага	26
Музейн үзмэрүүдэд шинжилгээ судалгаа хийх	26
Сурагчийн дасгал ажлын хуудас: Музейн үзмэрүүдэд судалгаа шинжилгээ хийх	27
Гар урлалын газруудаар очих	28

Дүрийн тоглолт 28

Ангид дүрийн тоглолт хийх	28
ДӨ-ийн газруудад дүрийн тоглолт хийж, түүхийг дүрээр амьдруулах	29
Маргаантай асуудлыг эв зүйгээр шийдвэрлэхэд суралцах нь	30

Дэлхийн мэдээллийн сүлжээ ба интернет 31

Бүх нийтийн мэдээллийн сүлжээ	31
ДӨ-ийн боловсролыг дэмжих зорилгоор интернет ашиглах	32
Интернет	32
Цахилгаан и-мэйл	32
Дэлхий нийтийн вэб /www or the web/	32
Яагаад интернетийг ашигладаг вэ	33
Вэбдэх Дэлхийн Өв	34
Интернет дэх Холбоот сургуулиудын Төслийн Сүлжээ	36
Шаардлагатай интернет хаягууд	36



Нэгдмэл сургалтын арга хандлага

Ирээдүй хойч үеийнхээ тусын тулд ДӨ-ийг хадгалж хамгаалахын гайхалтай үнэ цэнэ, нийтлэг ач холбогдол, эх дэлхийгээ авран үлдээх тухай асуудал нь ер бусын сургах ба суралцах таатай боломжийг олон талаар бүрдүүлдэг. Олонх сургуулиудад сургалтын хөтөлбөр төлөвлөгөө нь хүнддэж, ДӨ-ийг хадгалж хамгаалахын чухлыг залуучуудад ойлгуулж, мэдрүүлэх, түүний төлөө зорьж яваа багш нарт тулгарч байгаа болон улам бүр өсөн нэмэгдэж буй хэрэгцээ шаардлага зэрэг нь нэгдмэл сургалтын хэлбэрийг сонгоход хүргэж байна.

Энэхүү нэгдмэл сургалтын хэлбэр нь түүх, газарзүй, шинжлэх ухаан, хэлний багш нарт ДӨ-ийн боловсролын элементүүдийг хичээлээрээ заах боломжийг өгч байгаа юм.

Гарын авлагын үндсэн бүлэг бүрийн төгсгөлд холимог хөтөлбөрийн арга хэлбэрийг санал болгосон. Бүх арга хандлага нь та болон таны сурагчдад тохиромжгүй байх аваас та сургалтынхаа хөтөлбөр, төлөвлөгөө, өөрсдийн нөхцөл байдалд тохируулан хэрэглэж болно.

ДӨ-ийн боловсрол нь ДӨ-ийг хадгалж хамгаалах үйлсэд хүчин зүтгэж, хайрлан хүндэтгэж, хамгаалах, энэ талаар илүү ихийг сурч мэдэх хүсэл эрмэлзлэлийг сурагчдад төлөвшүүлэх үйл хэрэгт хамтран ажиллахад нь янз бүрийн чиглэлийн багш нарыг дэмжиж тусалж байна.

▲ Сурагчийн гүйцэтгэх ажлууд

18

Энэхүү гарын авлагат өгөгдсөн сурагчдын гүйцэтгэх ажлууд нь нэгдмэл сургалтын хандлагыг хялбарчлах зорилготой. Эдгээр ажлуудыг ЮНЕСКО-гийн залуучуудын ДӨ-ийн боловсролын төсөл үүссэн цагаас эхлэн дэлхийн олон орноос сонгогдон ажиллаж байгаа багш нар судалж, сорилт туршилт хийж, зохих хэмжээнд үнэлэлт дүгнэлт өгсөн юм. Өгөгдсөн ажлууд нь орон нутгийн хэрэгцээ шаардлага, боловсролын янз бүрийн системийн нөхцөлд аль ч оронд хялбархан зохицон хэрэгжих үндэстэй. Гарын авлагад өгөгдсөн сургалтын арга барилын эцсийн зорилго нь өв уламжлалаа хадгалж хамгаалах гэсэн залуучуудын эрмэлзэл тэмүүллийг хөхүүлэн эрчимжүүлэх, цаашид орон нутгийн хөдөлгөөнд оролцох тэдний оролцоог нь дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг идэвхжүүлэх замаар сургууль болон нийгмийн хооронд үүссэн орон зайг ойлгуулахад туслах явдал юм.

Сурагчдын гүйцэтгэх ажлууд нь 6 үндсэн чиглэлд төвлөрч байна.

Ярилцлага
Судалгаа
Дасгал
Үзэж танилцах
ДӨ-ийн газруудаар аялах
Дүрийн тоглолт хийх

Ярилцлага

ДӨ-ийн боловсрол нь өвийн утга учир, үнэ цэнэ, ДӨ-ийг хадгалж, хамгаалах

арга барил, аялал жуулчлалын ДӨ-д нөлөөлөх давуу ба сул талууд зэрэг асуудлаар ярилцах боломж олгоно. ДӨ-ийн боловсрол нь мэдлэг болон ур чадвар эзэмших асуудлыг асуудлыг хоёуланг нь багтаадаг. Ярилцлага нь үүнд нэлээд тохирсон хэлбэр бөгөөд тухайлбал ДӨ-ийн хадгалалт хамгааллын талаар сурагчдад таниулж мэдүүлэх, тэднийг амьдралын турш өв хадгалж хамгаалах үйл хэрэгт идэвхтэй оролцдог болоход нь дэмжлэг үзүүлэхэд чухал



Словен сурагч өөрийн өв болох хийсэн чихрээ Дубровникт болсон залуучуудын чуулга уулзалтад оролцогчидтой хуваалцаж байна. ЮНЕСКО

Судалгаа

Шинжлэх ухаан, технологийн дэвшлийн ачаар зарим улс, нийгэмд мэдээллийн хувьсгал болж байна. Улам олон сургууль номын сан, интернэтээс мэдээлэл, баримт сэлт, судалгаа шинжилгээний материал, статистик дүгнэлтийн талаарх мэдээллийг авах болж, энэ нь цаашид улам өргөжих нь мэдээж. ДӨ-ийн боловсрол нь сурагчдыг ДӨ-ийн асуудлаар дүгнэлт гаргаж, авах арга хэмжээний талаар санал тавих, мэдээлэл хайн олж, дүн шинжилгээ хийх зэрэг судалгааны үндсэн аргуудтай танилцуулна.

19

Дасгал ажил

ДӨ-ийн боловсрол нь сурагчдыг практик үйл ажиллагаанд гар бие оролцуулж, ямар нэг зүйл бүтээх замаар сургах явдлыг чухалчлан үздэг. Энэ аргыг нь гол төлөв туршилтын сургалт гэдэг. Энэ сургалт нь сурагчдын бүтээн туурвих чадвар, уран сэтгэмж, асуудлыг шийдвэрлэх чадвар, уран сайхны болон гоо зүйн авъяас, тоглоом тоглох, дүр бүтээж жүжиглэх авъяас гэх мэтийг хөгжүүлэхэд их үүрэгтэй. Гарын авлагат байгаа зарим дасгалуудад сурагчид хялбархан ашиглан гүйцэтгэж болох дасгал ажлын хуудаснууд орсон байна.

Нүдээр үзэж таних

ДӨ-ийн боловсрол нь ДӨ-ийн жагсаалтад бүртгэгдсэн түүх соёлын дурсгалт газруудын /2004 оны 4-р сарын байдлаар 754 дурсгалт газар/ тухай сурч мэдэхэд нь сурагчдыг хөхүүлэн дэмжинэ. Гарын авлагат төрөл бүрийн гэрэл зургийг олноор оруулсан нь сурах үйл явцыг хөнгөвчилж байна. Олон залуус дурсгалт газруудыг анх эдгээр зурагнуудаас олж харах боловч магадгүй тэдгээрийг хэзээ ч мартахааргүй болж болох юм. CD-ROM, интернет зэрэг сургалтын шинэ технологи хэрэглэддэг газруудад ДӨ-ийн дурсгалт газруудын гайхамшгийг олж нээхэд эдгээр арга хэрэгслийг өргөн ашиглах нь ач холбогдолтой.

ДӨ-ийн дурсгалт газруудаар аялах нь



Унгарын сурагч
Унгар болон
Словакийн Аггтелек
Карст ба Словак
Карстын агуйг шууд
мэргэжилтнээс сурч
мэдэж авч байна.
ЮНЕСКО

ЮНЕСКО-гийн залуучуудын ДӨ-ийн боловсролын төсөл нь ДӨ-ийн тухай хэн илүү ихийг сурч мэдэж байна тэр улс орон, тивээсээ халин гарч илүү ихийг сурч мэдэх эрэл хайгуул хийж, судалгаа шинжилгээ явуулах илүү их хүсэл тэмүүлэл, зориг эрмэлзлэлтэй болдгийг харуулж байна. Гарын авлагат өгөгдсөн дасгал ажлууд нь дэлхийн янз бүрийн хэсэгт байгаа ДӨ-ийн соёлын болоод байгалийн зарим

дурсгалт газруудын шинж чанар, үнэ цэнэ, тэдгээрийн хамгаалалтын талаар илүү ихийг ойлгож мэдэх боломж олгож байна. Эдгээр мэдээлэл, гэрэл зургууд нь үзэж хараагүй алс газар аялаж, судалгаа хийх талаар төсөөлөлтэй болж, ингэснээрээ сурагчид тэдгээрийг сонирхож, халамж анхаарал тавихад нь дэм болно.

■ Сурагчийн гүйцэтгэх ажил 1



ДӨ-ийн газруудаар шалгалт авах

Зорилго: ДӨ-ийн дурсгалт газруудын тухай сурагчдын мэдлэгийг тодорхойлох ба ДӨ-ийг хадгалж хамгаалахад тэдний сонирхлыг хөгжүүлэх



Дасгал



Ангийн ажил



Нэг хичээлийн цаг



Газарзүй, нийгэм судлал



Гэрэл зураг, ДӨ-ийн жагсаалт, товч тодорхойлолт

□ Сурагчдад ДӨ-ийн дурсгалт газруудын талаар шалгалтын асуулт өгөх гэж байгаагаа тайлбарлан хэлж, тэдэнд үзүүлэх гэж байгаа дурсгалт газруудын гэрэл зургуудын нэрийг бичих 1-26 хүртэл дугаартай жагсаалт бичүүлэх. Хэрвээ бичсэн дурсгалт газрын нэрэнд эргэлзэж байвал тус дурсгалт газар байгаа улсынх нь нэрийг бичүүлж болно. Сурагчдад гарын авлагат байгаа 26 гэрэл зургийг /нэрийг нь гэрэл зургуудын ард нь бичсэн / нэг нэгээр нь үзүүлж, тэдгээр газруудын нэрийг бичих хугацаа өг.

□ Сурагчдад бүх зургийг үзүүлсний дараа хажуугийнхаа сурагчтай жагсаасан нэрсээ сопилцож, зөв хариулт тус бүрт 1 оноо, улсынх нь нэрийг зөв бичсэн бол хагас оноо /дурсгалт газрынх нь нэрийг бичилгүй/ өгч дүнг гаргана.

Дурсгалт газрууд болон музей үзэх

ДӨ-ийн боловсролын нэг чухал онцлог нь хүүхдүүдэд ангиас гадуур орон нутгийнхаа, улсынхаа, тэрч байтугай гадаад орнуудад түүх соёлын дурсгалт газраар аялах, музей үзэх зэрэг боломж олгодог явдал юм. Аялалыг үр дүнтэй болгохын тулд сайтар төлөвлөн, зохион байгуулж тодорхой арга хэмжээ авах шаардлагатай.

▲ Дурсгалт газраар хийх аялал

ДӨ-ийн боловсролын сэтгэл татам агшин бол ДӨ-ийн газруудаар аялах явдал гэдгийг туршилтаас харж болно. Дараах практик үйл ажиллагаанууд нь багш, сурагч аль алинд нь мартагдашгүй дурсамжийг үлдээх нь дамжиггүй.

Бэлтгэл ажил

Сайтар бодсон бэлтгэл ажил нь дурсгалт газарт амжилттай аялах гол нөхцөл болно. Үүнд:

- Дурсгалт газруудаар хийх багш нарын урьдчилан танилцах аялал
- Дурсгалт газар, түүнийг хадгалж хамгаалах талаар сурагчдын мэдлэг чадвар, үзэл хандлага, зан төлөвт аялалын өмнө ба дараа гарсан өөрчлөлтийг тодорхойлох асуултыг бэлтгэх
- Аялсан газрын тухай дурсамж домог ярих, зэргээс түүхийг дахин бүтээх, түүний зураг төслийг хийх зэрэг үйл ажиллагаанд сурагчдыг бэлтгэх
- Аялалын мөрөөр хийх ажлуудыг төлөвлөхийг санал болгох

21

Аяллын өмнөх үе

Аль болох янз бүрийн мэргэжлийн багш нарыг оролцуулахыг хичээ. Тэд танд сурагчдыг аялалд бэлтгэхэд туслах болно. Жишээ нь: Түүхийн багш дурсгалт газрын он цагийн талаар мэдээлэл өгнө, газарзүйн багш тухайн газрын байршил, газарзүйн онцлог шинжүүдийн талаар тусална, хэлний багш гэхэд уран зохиол, яруу найраг, жүжиг зэрэг онцгой чухал бичлэгүүдээр хангаж өгч чадна. Дүрслэх урлагийн багш дурсгалт газрын зургийг зурах, загварыг нь гаргах, математикийн багш нар соёлын дурсгалт газар хэрхэн баригдсан, байгалийн дурсгалт газар ойролцоогоор хэчнээн амьтан ургамлын төрлүүдтэй зэргийг тооцоолон гаргахад сурагчдад тусална. Байгалийн шинжлэх ухааны багш аялал жуулчлал, бохирдолт, хүмүүсийн сөрөг үйл ажиллагаа зэргээс дурсгалт газруудад учирч болох аюул хор хөнөөлийг таниулж чадна.



Холбоот
Сургуулиудын
Төслийн сурагчид
Египетийн
Сэггарад
Шаталсан
Хэлбэртэй
Пирамидад
зочилж байх үедээ
Египетийн эртний
толгойн алчуур
зүүсэн байдал.
ЮНЕСКО

Сурагчдад үндэсний хувцсыг нь өмсгөх, эртний болон уламжлалт дуу хөгжмийг хамтран дуулж, наргих хүндэт зочдыг урьж авчрах гэх мэтчилэн сурагчдын аяллыг сэтгэлд хоногшин үлдэхүйцээр явуулж болно. Аялал хийх газарт боловсролын мэргэжилтэнтэй бол аяллаа төлөвлөхөд түүний туслалцааг авч болно.

Тухайн дурсгалт газрын талаар зарим нэг боловсролын материал гарч байсан бол аяллынхаа өмнө сурагчдынхаа хамт түүнтэй танилц. Нийтийн үйлчилгээний үнэ тариф, ажиллах цагийн хуваарь, гэрэл зураг авах зөвшөөрөл, хоол хүнс, бэлэг дурсгалын зүйл худалдан авах бололцоо, амрах болон бие засах газар, анхны тусламж, мөн сурагчид нэгэн зэрэг байраар хангагдах боломжтой юу эсвэл бүлэг болон хуваагдах ёстой юу зэрэг хэрэгтэй бүх мэдээллийг цуглуул.

Дурсгалт газраар аялах явцад сурагчид бөглөх дасгал ажлын хуудаснууд, зургийн болон бичгийн цаас, гэрэл зургийн аппарат, үзэг харандаа зэрэг аялалд хэрэглэгдэх бүхий л материал хэрэгслийг бэлтгэж цуглуул. Хэрэв дүрс бичлэгийн камертай бол аялалын явцад бичлэг хийж, дараа нь сурагчид, эцэг эхцүүд бусад хүмүүст үзүүлж болно.




Сурагчийн
дасгал ажлын
хуудас

Дурсгалт газарт аялах

Дурсгалт газрын зургийг нь зурах, гэрэл зураг авах, тус газрын хөтөч тайлбарлагч, эсвэл өөрсдийнхөө дунд ярилцлага явуулах, хувийн журнал хөтлөх, бичлэг хийх, хөгжөөнт арга хэмжээ зохион явуулах гэх мэт аялалын явцад хийгдэж болох олон янзын үйл ажлыг урьдчилан төлөвлөхийг хичээ.

22

Сурагчид Бээжинд болсон ДӨ-ийн залуучуудын чуулга уулзалтын үеэр Тэнгэрийн сүмд зочилж, 25 метр урт цаасан дээр өөрсдийн орны өвийн газруудаа зурж байна. ЮНЕСКО




Замбиа ба Зимбабвейн Викторийн Хүрхрээд болсон дэлхийн өвийн залуучуудын чуулга уулзалтын үеэр сурагчид тус дурсгалт газрын тухай хэлэлцэж байна. ЮНЕСКО

Аялалын дараа хийх ажлууд

Сурагчид өөрсдийн үзсэн зүйлээ өөрийн болгох, түүнийгээ бусадтай хуваалцахад аялалын дараа хийх ажлууд нь бэлтгэл ажлын нэгэн адил чухал юм. Аялалын дараа хийх ажлыг дор дурдсан хэлбэрээр гаргана:

- Сурагчид юу үзэж харсан, юу олж мэдсэн, юу нь таалагдсан, таалагдаагүй талаар ярилцах

- Түүх соёлын дурсгалт газруудыг засч тохижуулах, хамгаалахын зэрэгцээ аялал жуулчлалыг сайжруулах, тус газар гарч болох хор хөнөөл, түүнийг шийдвэрлэх арга замыг тооцох, аялал жуулчлалын менежментийг хөгжүүлэхэд залуу хөтөч тайлбарлагчдыг сургах зэрэг судалгааны шинэ төслүүд хийхийг сурагчдад санал болгох
- Өөрсдийн хийсэн загвар, зураг дээр үндэслэн том хэмжээний зураг зурах, уран баримал барих, хийсэн бүтээлээрээ үзэсгэлэн гаргах зэрэг ажлыг сурагчдаар хийлгэх
- Аяллын явцад авсан гэрэл зургуудаа угаалгаж, өвийн холбогдолтой шилдэг гэрэл зургуудыг сурагчид болон эцэг эхчүүдээр сонгон шалгаруулж, шалгарсанд нь бяцхан урамшуулал олгох
- Сурагчдад хийсэн аялалынхаа тухай сургуулийн, орон нутгийн болон үндэсний сонин хэвлэлд өгүүлэл бичихийг санал болгох
- Өөр ямар дурсгалт газруудаар аялах хүсэлтэй байгаа талаар сурагчдаас санал авах



*Бээжинд болсон
ДӨ-ийн залуучуудын
чуулга уулзалт
ЮНЕСКО*

Сурагчийн дасгал ажлын хуудас

Дурсгалт газраар хийх аяллын өмнө, аялах явцад болон аяллын дараа сурагч нэг бүрээр бөглүүлнэ. /ялангуяа ДӨ-ийн дурсгалт газруудад/

Дурсгалт газрын нэр:

Сурагчийн нэр:

Аялал хийсэн сар, өдөр:

Аяллаас хүсэн хүлээж буй зүйлээ бич /ямар шинэ зүйлийг нээж, олж мэдэхийг хүсэж байсан/:

Аяллын явц

Танд онцгой сэтгэгдэл төрүүлсэн дурсгалт газрын хэсгээс эсвэл зарим онцлог шинж байдлын талаар зургийг нь зур. /өөр цаас ашиглан/

Тус газрын талаар мэдэж авсан зарим нэг баримт, тоон үзүүлэлтийг товчоолон бич.

Мэдэрсэн зүйлээ товчоол: Нүдээ аниад юу сонссон, юу үнэртсэн, өөрт чинь хамгийн их сэтгэгдэл төрүүлсэн зүйлийнхээ тухай санал бодлоо дүрсэл:

Дуу авиа:

Үнэр:

Үзсэн:

Аяллын дараа

Аяллаас хүсэн хүлээсэн зүйлүүд биелэгдсэн эсэх

Тийм


Үгүй

Тайлбар

Энэ дурсгалт газар яагаад чухал гэж та бодож байна вэ ?



Эцсийн дүгнэлт:




Гарын үсэг:

Он сар өдөр:

▲ Музей үзэх

Музей үзэх нь ДӨ-ийн боловсролын бас нэг чухал хэлбэр бөгөөд музейн ажилтнууд, олон улсын музейн зөвлөлийн гишүүд нь багш нарын дотны хамтран зүтгэгч нар болдог. Музей нь гол төлөв соёлын ба байгалийн өвөрмөц онцлог зүйлүүдийг үзэж судлах цорын ганц газар юм.

Музейгаас зайдуу орших сургуулиудын хувьд орон нутгийн өөр бусад байгууллага болон хүмүүс, эцэг эх, өвөө эмээ нь өнгөрснийг эргэн дурсах, өнөө үетэй холбож өгөхөд чухал үүрэг гүйцэтгэдэг.



Сенегалийн Горве арал дээр орших боолчуудын байр байсан түүхэн музейд сурагчид зочилж байна. ЮНЕСКО

26

Египетийн Александрагийн Роман музейд Холбоот Сургуулиудын Төслийн сурагчид тусгай лекц сонсож байна. ЮНЕСКО



Музей үзэх явцад хийх тусгай ярилцлага

Зарим музей нь маш баялаг үзмэртэй байдаг. Нэг удаагийн аялалаар бүгдийг нь нарийвчлан үзэж судлах боломжгүй мянга мянгаар тоологдох эд зүйлс, урлагийн бүтээлүүд тавигдсан байдаг. Тийм учраас зарим багш нар тусгай сэдэв, чиглэл гарган, түүнийхээ дагуу мэргэжлийн тайлбарлагч сонгон авч музейн аялалыг зохион байгуулдаг.

Музейн эд зүйлсийг нарийвчлан судлах нь

Музей үзэхийн өмнө сурагч бүрт нарийвчлан судлах, ажиглалт хийх тодорхой нэг зүйлийг тусгайлан зааж өгнө. Өгөгдсөн ажлаа хялбар гүйцэтгэх үүднээс сурагч бүрт "Музейн эд зүйлийг судлах нь" дасгал ажлын хуудас өгнө. Музей үзсэний дараа сурагчид үзэж мэдсэн зүйлээ ангидаа бусаддаа толилуулж болно.

Сурагчийн дасгал ажлын хуудас


Ажиглалт хийх чиглэл	Асуултууд	Ажиглалт	Цаашид хийх судалгаа
Физик шинж	<ul style="list-style-type: none"> ■ Ямар өнгөтэй вэ? ■ Юу үнэртэж байна вэ? ■ Юутай адипхан сонсогдож байна вэ? ■ Юугаар хийсэн юм бэ? ■ Байгалийн зүйл үү эсвэл үйлдвэрлэсэн юм уу? ■ Бүтнээрээ юм уу? ■ Өөрчилж, сэлбэн засаж байсан уу? ■ Элэгдэж муудсан уу? 		
Бүтэц	<ul style="list-style-type: none"> ■ Гараар уу эсвэл машинаар хийсэн үү? ■ Бүхэл цул зүйл цутгасан уу эсвэл жижиг хэсгүүдээс бүрдсэн үү? ■ Яаж хоорондоо бэхлэгдсэн бэ? 		
Зориулалт	<ul style="list-style-type: none"> ■ Яаж хэрэглэгдэж ирсэн бэ? ■ Зориулалт нь өөрчлөгдсөн үү? 		
Хийц загвар	<ul style="list-style-type: none"> ■ Санасан хэмжээнд хүртэл сайн хийгдсэн эсэх? ■ Янз бүрийн чимэглэл хийсэн байна уу? ■ Сайн материалаар хийсэн үү? ■ Харагдаж байгаа байдал нь танд таалагдаж байна уу? ■ Та яаж хийх байсан вэ? 		
Үнэ цэнэ	<ul style="list-style-type: none"> ■ Ямар үнэ цэнэтэй вэ? ■ Түүнийг бүтээсэн хүнд? ■ Түүнийг хэрэглэж байсан хүнд? ■ Түүнийг хадгалж байсан хүнд? ■ Танд? ■ Музейд? ■ Цуглуулагчид? 		

Гар урлалын газраар аялах нь



Ашигласан
материалын
жэгсвэлт

Музейд үзсэн зарим нэг гар урлал/ тухайлбал шаазан вааран эдлэл/ нь өнөөдрийг хүртэл хэдэн арав, заримдаа зуун жилээр нэгээс нөгөө үед уламжлагдан ирсэн гар урлал эрхэлж буй урчуудын бүтээн туурьвиж байгаа зүйл байдаг. Гар урлалын газарт аялал зохион байгуулснаар сурагчид музейд үзсэн уламжлалт гар урлалын бүтээлүүдийг өнөөдөр хэрхэн яаж хийж байгаатай биеэрээ танилцаж болно. Ингэснээр тэд өөрсдийн үндэсний онцлог, өв /ДӨ-ийг оруулаад/ уламжлал болон орон нутгийн гар урлалын хоорондын харилцаа холбоог гүнзгий ойлгох болно.



ЮНЕСКО-гийн урлаг болон гар урлалд сургах бүсийн төслийн хүрээнд Гватемалд сурагчид нэхэх, сүлжих урлагт суралцаж байна. ЮНЕСКО

Дүрийн тоглолт

ДӨ-ийг хадгалж хамгаалах үйлсэд оролцох сурагчдын хүсэл сонирхлыг татах талаар ямагт эрэлхийлж байдаг олон багш нар дүрийн тоглолт явуулах нь хамгийн үр дүнтэй хэлбэр гэдгийг тогтоожээ. Дүрийн тоглолтоор 5 үндсэн зорилтыг шийдвэрлэнэ:

- Ухамсарлан ойлгуулах
- Хүндэвтэр болон хийсвэр сэдвүүдийг ойлгоход хялбар дөхөм болгох
- Судалгааны шинэ чадвар эзэмшүүлэх
- Зохих арга барил, удаан хугацааны зорилго тэмүүлэлтэй болгох
- Сурагчдын бүтээлч чадавхийг хөгжүүлэх

▲ Ангид зохион байгуулах дүрийн тоглолт

ДӨ-ийн хадгалалт хамгаалал нь ДӨ-ийн жэгсвэлтанд шинэ газруудыг нэмж оруулах шийдвэр, хамгааллын холбогдолтой төрөл бүрийн материал арга барилын сонголт, хөгжил /хуучин барилгыг буулгах, аялал жуулчлалыг хөгжүүлэх/, хамгаалал болон удирдлагын төлөвлөлт, дурсгалт газарт тавих хяналт, дэмжлэг үзүүлэх аян зэрэг олныг хамарсан арга хэмжээ, зарим газарт санхүүжилт олгох газруудын тэргүүлэх чиглэлийг тогтоох зэрэг тулгамдсан цогц асуудлуудыг хамарна.

Дүрийн тоглолтоос сурагчид эдгээр асуудлуудыг илүү ойлгож, тэдгээрт тохирсон зөв шийдвэрийг хэрхэн гаргах талаар илүү их

сурах болно. Багш сурагчдыг жижиг бүлгүүдэд хувааж, бүлэг бүр нь өөрсдийнхөө байр суурь, тоглож байгаа дүрийнхээ талаар эрэгцүүлэн бодож судалгаа явуулна. Түүнчлэн шаардлагатай мэдээлэл, тоо баримтуудыг хаанаас олж болохыг зөвлөх маягаар багш тэдэнд туслана.

Мөн сонирхолтой хэсэг бүрийг дүрслэн бичсэн мэдээллийн картыг урьдчилан бэлтгэж бүлэг бүрт нэгийг өгнө. Бүлгүүд нь өөрсдийнхөө байр суурийг ярилцаад, өөрийн болон бүлгийнхээ байр суурийг хамгаалан дүрийн тоглолтонд оролцох нэг тоглогчийг сонгоно. Үлдсэн сурагчид тоглолтын талаар шийдвэр гаргахад санал өгөх шүүгчийн бүрэлдэхүүнд буюу хороонд ажиллана. Тоглолтын агуулга үзэл санааг бүрэн ойлгуулахын тулд дараах алхмуудыг хийсэн байх шаардлагатай.

- ДӨ-ийн газарт тулгарч буй хадгалалт хамгаалалтын асуудлууд, тэдгээрийн бодит байдлыг тодорхойлох
- Янз бүрийн сонирхолтой бүлгүүдийг төлөөлсөн сурагчид дээрх асуудлуудыг шийдвэрлэж болох арга замуудыг санал болгоно.
- Сурагчид санал болгосон шийдвэрүүдийг үнэлж дүгнэнэ.
- Сурагчид ил тод хэлэлцэх замаар хамгийн сайн шийдвэрийг сонгоно.
- Гарсан шийдвэрийг хэрхэн хэрэгжүүлэх талаар шийдвэр гаргана.
- Өөрсдийн сонголтын үр дагаварыг үнэлж дүгнэнэ.

▲ ДӨ-ийн дурсгалт газруудад жүжиг тоглож, түүхийг сэргээн бүтээх нь

ДӨ-ийн дурсгалт газруудад түүхэн холбогдолтой жүжиг тоглох нь залуучуудын оюун ухаанд гүн сэтгэгдэл үлдээж болно. Денмаркийн Кронборг сүмд тоглосон Шекспирийн Гамлет, Египедийн Люксорт тоглосон Вердийн Айда дуурь мэт хэд хэдэн алдарт тоглолтуудыг дэлхийн өвийн дурсгалт газруудад хийсэн байна. ЮНЕСКО-гийг Холбоот Сургуулиудын Төслийн Сүлжээний сурагчид ДӨ-ийн хот болох Харват Сплитэд Ромын эзэн хаан Диоклетэйны тухай тоглолтыг тэр эзэн хааны ордны туурь дээр хийсэн юм.



ДӨ-ийн хот болох Сплитээс ирсэн сурагчид дүрийн тоглолтоор түүхийг сэргээж байна. /Хорватын Диоклетейн ордны хамт Сплитийн түүхэн цогцолбор/ ЮНЕСКО

▲ Маргаантай асуудлыг эв зүйгээр шийдвэрлэх нь

Зарим тохиолдолд өмчийн үүдэлтэй маргаан, дайн дажин, барьж байгуулах төслүүдийн саналуудтай холбоотойгоор ДӨ-ийн хадгалалт хамгаалалтыг хөндсөн маргаан зөрчлүүд үүсдэг бөгөөд эдгээрийг эв зүйгээр хэлэлцэн, бүтээлч шудрага шийдвэрлэж байх хэрэгтэй. Дүрийн тоглолт нь залуучуудад аливаа маргаан зөрчлийг дарамт шахалт үзүүлэлгүй эв зүйгээр шийдэж байх чадварыг төлөвшүүлэх, маргаантай асуудлыг тал бүрээс нь авч үзэж, харилцан ойлголцон зохицон шийдвэрлэх аргыг хэрэглэх шаардлага болон түүний чухал болохыг ойлгоход туслах болно.

Бүтээн байгуулах хөгжлийн төлөвлөгөө нь ДӨ-ийн дурсгалт газрын хамгаалалд муугаар нөлөөлж байгаа тухай тоглолт бэлтгэж болно. Ангийг хэд хэдэн бүлэг болгон хувааж, бүлэг тус бүрийг хөгжлийн менежер, дурсгалт газрын хамгаалагч, өвийн мэргэжилтэн, орон нутгийн удирдлага, орон нутгийн барилгын ажилчин, жуулчин зэрэг өвөрмөц дүрүүдэд тоглуулж болно. Хүн бүрийн санаанд нийцсэн, дараа нь ямар нэг асуудал гарахааргүй тийм шийдвэр гаргахуйц яриа хэлцэлд бэлтгэхэд туслах үүднээс бүлэг бүрт дараах анхаарах зүйлийн жагсаалтыг өгнө.

Дүрийн тоглолтоор асуудлыг эв зүйгээр шийдвэрлэх замаар ДӨ-ийг хадгалж хамгаалахад анхаарах зүйлийн жагсаалт:

1. Маргаан хийж буй хүн дээр биш харин гол асуудалд анхаарлаа хандуул.
2. Өөрийгөө шүүмжилж буй хүний байр суурин дээр тавьж үзэхийг хичээ, нэг бүлэгт хэчнээн ч сонирхлын хүмүүс байж болно гэдгийг Мартаж болохгүй.
3. Таны шүүмжлэгч санал бодлоо чөлөөтэй хэлэх боломж олго. Анхааралтай сонс.
4. Шүүмжлэгчээ ойлгож, түүний гол үндэслэлийг ойлгохийг хичээ.
5. Учир зүггүй үгүйсгэн мэтгэлзэхийн оронд гол гол зүйлээр асуудлууд тавь.
6. Таны юу хэлэх гээд байгааг эсрэг тал чинь ойлгож байгаа эсэхийг асууж бататга.
7. Хэтэрхий нарийн ширийн зүйл битгий хөөцөлд.
8. Болж өгвөл бүх бүлгүүдийн хүсэл сонирхолд нийцсэн шийдвэр гарга. Зорилго бол хамгийн зохистой шийдвэр гаргах явдал юм.
9. Эсрэг талаа сүрдүүлж болохгүй.
10. Дарамт шахалт үзүүлж болохгүй.
11. Гайхлыг нь төрүүлэхүйц нааштай саналууд хэлэх нь чухал.
12. Хамгийн хүнд асуудлуудыг аажмаар нухацтай илэн далангүй ярилцан урагшилж, алхам алхмаар шийдвэрлэ.
13. Шинэ зөрчил үүсэхээс болгоомжлох талаар хамтарч ажилла.
14. Цаашид үүсч болох зөрчлийг шийдвэрлэх талаар саналаа нэгтгэ.

Багш нар ажиглагч болоод зогсохгүй тусалж дэмжихэд бэлэн байх нь зүйтэй.



Дэлхийн мэдээллийн сүлжээ ба интернет

Бид мэдээллийн дэлбэрэлтийн эрин зуунд амьдарч байна. Интернет ашигласнаар бид дэлхийн өнцөг булан бүрт байгаа номын сан, тоо баримтын сангууд, архив, цаг уурын болон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний мэдээлэл зэрэгт хоромхон зуур нэвтэрч чадна. Мэдээ мэдээлэл, баримт сэлт нь ДӨ-ийн боловсрол, судалгааны нэг чухал хэсэг болдог учраас шинэ технологи нь багш, сурагчдад ДӨ-ийн үнэт зүйлсийг олж нээх, тэдгээрийг хадгалж хамгаалах талаар илүү ихийг сурч мэдэх хүсэл тэмүүллийг нь оргилуулах шинэ зам нээж өгч байгаа юм.

Гэхдээ интернет хүн бүхэнд хүрч чадаагүй, дэлхийн бүх тив, бүс нутагт ихэнх хүмүүс ашиглах бололцоогүй байна. Хэдий тийм байлаа ч дэлхий даяар компьютерийн үнэ унаж, цахилгаан холбооны үйлчилгээний үнэ хямдарч байгаагаас интернет хэрэглэгчдийн тоо түргэн өсөх хандлагатай байгаа билээ.

▲ Дэлхийн мэдээллийн сүлжээ

ЮНЕСКО-гийн залуучуудын ДӨ-ийн боловсролын төсөл нь дэлхийн бүх хэсэгт байгаа бүх төрлийн дунд сургуулиудыг хамарсан дэлхийн мэдээллийн сүлжээний нэгэн хэсэг болох боломжийг сургуулиудад олгодог юм. Энэхүү төслийн чухал хэмжүүр нь ДӨ-ийг сургуулийн хөтөлбөрт оруулах талаар үр дүнтэй шинэлэг арга замыг нэвтрүүлэхэд хамтаараа суралцан харилцан туршлагаа хуваалцах явдал мөн.

Төсөлд хамрагдсан сургуулиудын олонх нь **ЮНЕСКО-гийн Холбоот Сургуулиудын Төслийн Сүлжээний гишүүн** байдаг. Энэхүү Сүлжээ нь ЮНЕСКО-гийн **ДӨ-ийн Төвтэй** хамтран тус Сүлжээгээр хэрэгжиж байгаа ЮНЕСКО-гийн залуучуудын ДӨ-ийн боловсролын төсөл зэрэг туршилтын төслийг хэрэгжүүлэх замаар **боловсролын, хүмүүнлэгийн, соёлын болон олон улсын үр нөлөөг хүчтэй болгоход чиглэгддэг билээ**. Холбоот Сургуулиудын Төслийн Сүлжээнд хамрагдсан сургуулиуд нь хоорондоо харилцаа холбоо тогтоож, зөвхөн туршлагаа төдийгүй зарим тохиолдолд нөөц боломжоо хүртэл харилцан солилцож байна.

Дэлхийн янз бүрийн хэсгийн багш, сурагчдыг цуглуулж хамтарсан арга хэмжээ зохион байгуулах явдал Сүлжээний нэг чухал зорилго бөгөөд түүнийг ЮНЕСКО-гоос **ДӨ-ийн Залуучуудын Чуулга Уулзалт**, багш нарын үндэсний болон бүсийн сургалт семинар зохион байгуулах хэлбэрээр хэрэгжүүлж байна. ЮНЕСКО-гийн гишүүн орнуудаас багш сурагчдад зориулсан тусгай сургалт зохион байгуулж явуулах санаачлагыг сайшаан дэмждэг.

Дэлхийн янз бүрийн орны багш сурагчдыг цуглуулж, хамтарсан үйл ажиллагаа явуулах нь санхүүгийн хувьд мэдээж хүндрэлтэй асуудал юм. Гэхдээ интернет зэрэг сүлжээний шинэ технологийг ашиглах нь хүмүүст бие биеэ таньж мэдэх, байнгын холбоотой байх, үзэл бодлоо хуваалцахад маш үр дүнтэй арга зам болох нь нотлогдсоор байна.

Үр ашигтай сүлжээ нь тасралтгүй мэдээлэл, найдвартай түншлэлийг шаардана. ЮНЕСКО-гоос залуучуудын ДӨ-ийн боловсролын төслийн талаарх мэдээллийг **интернет** болон янз бүрийн хэвлэлээр тогтмол цацаж байна.



Ашигласан
материалын
жагсаалт

▲ ДӨ-ийн боловсролд интернетийг ашиглах нь

Харилцаа холбооны шинэ технологи өргөн нэвтэрснээр мэдээлэл хүртэх арга хэрэгсэл урьд өмнө байгаагүйгээр өөрчлөгдөж, хөгжил цэцэглэлтийн шинэ шатанд гарлаа. Залуучуудын хувьд өнөөдрийн гол шаардлага нь тэд хүлээн авч болох мэдээ мэдээллийн тасралтгүй урсгалыг түргэн мэдэрч, түүнд сонголттой хандах аргыг эзэмших явдал юм. Нэмж хэлэхэд юуг, яаж, хаанаас хайх вэ гэдгийг мэдэх шаардлагатай.

Интернет

Интернет нь мэдээллийн түгээмэл дүрэм, стандартад тулгуурласан мэдээлэл солилцох бүх нийтийн сүлжээ юм. Интернет нь мэдээ мэдээллийн сан, цахилгаан сэтгүүл, ном зүйн каталог ба компьютерийн программуудыг агуулна. Тэрээр мэдээ мэдээлэл солилцох, түгээх шинэ боломжийг өгч байна.

Өнөөдөр интернет нь хэн ч төсөөлж байгаагүй тийм хурдацтай хөгжиж байна. Өдрөөс өдөрт шинэ вэб хуудсууд нэмэгдсээр байна. 1995 онд 56 сая интернет хэрэглэгч байсан бол 2001 онд энэ тоо 211 сая болж өслөө.

Цахилгаан шуудан /и-мэйл/

Цахилгаан шуудан нь компьютер ашиглан мэдээлэл, захиа солилцох арга юм. Захиаг бусад компьютертэй модем, телефон буюу цахилгаан шугамаар холбогдсон компьютер дээр бичиж байна.



Телефон шугамд холбогдсон янз бүрийн хурд, модем бүхий төрөл бүрийн компьютер ашигладаг аль ч сургууль и-мэйлээр харилцах боломжтой бөгөөд бүх нийтийн харилцааны шинэ сүлжээний нэг хэсэг нь болно.

Жишээ нь и-мэйлээр дамжуулан ЮНЕСКО-гийн ДӨ-ийн цахилгаан мэдээллийн үйлчилгээ /WHNEWS/ буюу ДӨ-ийн Мэдээллийн Сэтгүүлд холбогдоход хялбархан юм.

Түүнчлэн и-мэйлээр дамжин Дэлхий нийтийн Вэбээс мэдээлэл авах боломжтой.

Дэлхий нийтийн вэб /www /

Вэб нь дэлхий нийтийн бүх хэрэглэгчдэд интернетээр мэдээлэл хүргэх Нэг гол хэрэгсэл юм. Компьютер хэрэглэгч дэлгэцэнд бичиж мэдээллээ илгээнэ.

Сүлжээнд орсон бие даасан хуудсуудыг вэб хуудас гэх бөгөөд эдгээр вэб хуудсанд гол төлөв холбогдох бусад мэдээллийг авч болох вэб хуудас руу орох тайлбар үг, хэллэгүүд бичигдсэн байна. Зарим вэб хуудсанд мэдээллүүд нь текст хэлбэрээр орсон байхад зарим нь зураг, хөдөлгөөнт дүрс, дуу чимээ оруулсан байдаг.

Вэб сайт нь сургууль, байгууллага, хувь хүний тухай мэдээлэл өгч чадах хэд хэдэн вэб хуудаснаас бүрдэнэ.

Яагаад интернетийг ашигладаг вэ?

Интернет нь багш сурагчдад мэдээллийн олон шинэ эх үүсвэрийг толилуулахаас гадна дэлхийн бусад орны багш сурагчид, сургуулиудтай шууд холбоо тогтоох сайхан боломж олгоно. Энэ өргөн сүлжээнд орсон арвин нөөц мэдээллээс хэрэгтэй зүйлээ олж авахын тулд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдаж, ашиглах үр чадварыг эзэмжсэн байвал зохино.

Интернет ашигласнаар дараах ач холбогдолтой:

- Сурагчдад интернетийн үндсэн үүргүүдийг Танилцуулах
- ДӨ-ийн судалгаа явуулахад мэдээллийн технологийг ашиглах үр чадварыг хөгжүүлэх
- ДӨ-ийн тодорхой сэдвээр мэдээлэл, цахилгаан сэтгүүл, компьютерийн программ, мэдээлэл солилцооны санд орж мэдээлэл авах
- Дэлхийн бусад орны үе тэнгийхэнтэйгээ шууд харилцаа тогтоох замаар соёлоосоо харилцан суралцах боломж олох
- Онцгой нөхцөл байдалд асуудлыг шийдвэрлэхэд мэдээллийн шинэ технологи ашиглахыг дэмжих

Интернет ба и-мэйл ашигласнаар сурагчид алс холын үе тэнгийнхэндээ өөрийгөө болон соёл, зан заншил, үнэт зүйл, өв уламжлалаа танилцуулж болно. Ангиас гаралгүйгээр тэд бусад ард түмэн, тэдний соёл иргэншил, түүхэн дурсгалт өвийн газруудын тухай илүү ихийг олж мэдэхийн тулд өөрийн орны болон хилийн чанд дахь найз нөхөдтэйгээ шууд харилцах боломжтой. Дэлхийн янз бүрийн хэсэгт байгаа сургуулиуд, бидний өвийг бохирдолт, хотжилт, дайн дажин, хайхрамжгүй үйл ажиллагаанаас үүдэлтэй аюул сүйрлээс хамгаалах зорилго бүхий хамтарсан төсөл дээр ажиллаж болно.

Арга хэмжээ:

1. ДӨ-ийг хамгаалах талаар ЮНЕСКО хэрхэн ажиллаж байгаа талаар мэдэхийг хүсвэл түүний ДӨ-ийн вэб хуудсанд ороорой. /<http://www.unesco.org/whc/>
2. ДӨ-ийн боловсролд хамрагдсан сургуулиудын талаар мэдээлэл авахыг хүсвэл Холбоот Сургуулиудын Төслийн Сүлжээний вэб сайт-д ороорой. /<http://www.unesco.org/education/asp/>
3. Хоёр орны ДӨ-ийн дурсгалт газруудад хийх аялал жуулчлалын талаар тайлбар бичих, харьцуулах зэргээр ДӨ-ийн боловсролын төслийг боловсруулж гаргах
4. ДӨ-ийн жагсаалтад бүртгэгдэхээр нэр нь дэвшигдсэн түүхэн дурсгалт газруудын жагсаалт гаргаж, янз бүрийн орны сургуулиудын хооронд сопилцох
5. Орон нутгийн дурсгалт газраар Патримонтчуудын аялсан тухай хошин шог өгүүллэгүүд бичиж бусад сургуульд явуулах
6. ДӨ-ийн тодорхой нэг газрын тухай номын цэс гаргахын тулд бусад улсын их дээд сургуулиудын номын сангаас зөвлөгөө авах
7. Зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжийн хомсдолтой ДӨ-ийн боловсролын сургуулиудыг интернеттэй холбох, тоног төхөөрөмжөөр хангах, санхүүжилтийг нэмэгдүүлэх
8. ДӨ-ийн төслийн талаарх мэдээллийг агуулсан сургуулийнхаа өөрийн вэб хуудсыг нээх
9. Бусад орны үе тэнгийхэнтэйгээ ДӨ-ийн боловсролын талаарх мэдээллээр харилцахад сүлжээг ашиглах
10. Холбоот Сургуулиудын Төслийн Сүлжээг ашиглан ДӨ-ийн цахилгаан сэтгүүл захиалах ба ДӨ-ийн вэб сайтаас мэдээлэл авах

▲ Дэлхийн Өв вэб-д

Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалж хамгаалах тухай конвенцийн нарийн бичгийн дарга нарын газрын албан ёсны вэб сайт болох ДӨ-ийн вэб сайт нь ДӨ-ийн Жагсаалт, ДӨ-ийн Конвенц, түүний түншүүдын тухай хамгийн тодорхой мэдээллийн эх сурвалж болдог. Сүүлийн үеийн дэвшилтэд технологи бүхий вэб сайт нь түүхэн дурсгалт газруудын тухай мэдээ мэдээлэл, конвенц, үйл ажиллагаа, арга хэмжээ, хэвлэл нийтлэлүүд, бидний өвийг хамгаалахад оролцож байгаа олон байгууллагуудын дотроос хэнтэй харьцаж, хэрхэн тусалдаг тухай мэдээллийг багтаасан байна. ДӨ-ийн жагсаалтанд орсон 754 дурсгалт газар бүрийн тодорхойлолт болон бусад байгууллагуудтай харьцах хаягууд вэб хуудсанд бичигдсэн байна. Мөн конвенцид оролцогч 178 улсын ДӨ-ийг хамгаалах талаар явуулж буй үйл ажиллагаа болон холбогдох вэб хуудсанд орох хаяг, мэдээллийг вэб хуудсанд оруулжээ.

ДӨ-ийн вэб сайт нь 9 төрлийн мэдээллийг агуулна.

1. Конвенц
2. Дэлхийн Өвийн Жагсаалт
3. Хэн юу хийдэг
4. Бид хэрхэн ажилладаг
5. Үйл ажиллагаа
6. Бидний хамтрагчид
7. Мэдээ мэдээлэл, арга хэмжээ
8. Хэвлэл нийтлэл
9. Хэрэгсэл

“Конвенц” нь ДӨ-ийн конвенц хэрхэн ажиллаж байгаа тухай мэдээлэл өгнө.

34

“Дэлхийн Өвийн Жагсаалт” нь дурсгалт газруудын газарзүйн байршлын газрын зураг болон Дэлхийн Өвийн дурсгалт газруудыг бүсчилсэн буюу ангилсан жагсаалтыг багтаасан байдаг.

“Хэн юу хийдэг” буюу “Бид хэрхэн ажилладаг” нь конвенцийг гаргасан хүмүүсийн /Дурсгалт газрын нэрийг хэн дэвшүүлдэг, хэн сонгодог, хэн мэргэжлийн зөвлөгөө өгдөг буюу хөтөлбөрийг хэрхэн хэрэгжүүлдэг/ болон Дэлхийн Өвийн дурсгалт газруудын нэрийг дэвшүүлэх ба дэмжиж туслах үйл ажиллагааны талаарх мэдээллээр хангана.

“Үйл ажиллагаа” нь Дэлхийн Өвийн дурсгалт газруудын хадгалалт хамгаалалт болон боловсролын үйл ажиллагааны талаарх төслүүдийг танилцуулна.

“Бидний хамтрагчид” нь техникийн болон удирдлагын мэргэжлийн ур чадварыг бий болгож, дээшлүүлэхийн тулд нөөц хүчин чадлаа дайчлан тогтвортой хамтын ажиллагааг бүрдүүлэхийн зэрэгцээ Дэлхийн Өвийн удирдлагын санхүүгийн хувьд дэмжлэг үзүүлэх зорилготой юм.

“Мэдээ мэдээлэл ба арга хэмжээ” Дэлхийн Өвийн Төвийн хамгаалалтай холбоотой цаг хугацааны талаарх тоо баримт, мэдээ мэдээллээр хангана.

ДӨ-ийн вэб сайт- д орвоно: <http://whc.unesco.org/whc>

Шаардлагатай бусад хаягууд:

ДӨ-ийн жагсаалт:


whc.unesco.org/heritage.htm

Аюулд учирч буй ДӨ-ийн жагсаалт:

www.unesco.org/whc/danqlist.htm

Конвенцид оролцогч орнууд:

www.unesco.org/whc/wldrat.htm



ДӨ-ийн мэдээллийн сүлжээ /WHIN/

ДӨ-ийн мэдээллийн сүлжээ нь ДӨ-ийн төв ба ДӨ-ийн дурсгалт газруудыг хамгаалахад оролцдог бусад байгууллагуудын хоорондын түншлэл юм. Вэб хуудсанд бичигдсэн бол эдгээр байгууллагуудыг ДӨ-ийн мэдээллийн сүлжээнд оролцогч түншүүд гэж үзэх бөгөөд тэд вэбээр ДӨ-ийн дурсгалт газруудын талаарх шинэчлэн сайжруулсан мэдээ мэдээллийг дамжуулан хүргэхэд идэвхтэй оролцдог. ДӨ-ийн мэдээллийн сүлжээнд оролцогч улсуудтай холбоо тогтоох хаягууд нь вэб сайтын хуудсанд бичигдсэн байна. Илүү мэдээлэл авахыг хүсвэл ДӨ-ийн мэдээллийн сүлжээний өөрийн вэб хуудас <http://whc.unesco.org/whin/enindex.htm> -д орох буюу whinfo@unesco.org хаягаар захиа бичээрэй.

ДӨ-ийн Мэдээллийн Сэтгүүл


ДӨ-ийн мэдээллийн сэтгүүл нь 1992 оноос хэвлэгдэж эхэлсэн бөгөөд одоо сард 2 удаа 4 хуудастайгаар гарч захиалагчдад үнэгүй тараагддаг. Хэрвээ захиалахыг хүсвэл : wheditor@unesco.org и-мэйл явуулах буюу Newsletter, UNESCO, World Heritage Center, 7 place de Fontenoy, 75352 Paris 07 SP, FRANCE хаягаар захиа илгээж болно.

Уг сэтгүүлийн өнөөгийн болон урьд өмнөх дугаарууд хэрэгтэй болвол:

[Http://whc.unesco.org/newsletter](http://whc.unesco.org/newsletter)

▲ Холбоот Сургуулиудын Төслийн Сүлжээ Интернетэд /ASP net/

ЮНЕСКО-гийн Холбоот Сургуулиудын Төслийн Сүлжээний вэб сайт нь сүлжээний тухай ерөнхий мэдээлэл, түүний зорилго, оролцогч сургуулиуд болон орнуудын тоо, гол гол төслүүд, холбогдох бичиг баримт, ХСТС-ний үйл ажиллагааны гарын авлага, товхимолууд зэргийг багтаасан байна. Илүү мэдээлэл авахыг хүсвэл: aspnet@unesco.org хаягаар и-мэйл бичиж болно.



▲ Шаардлагатай интернет хаягууд

Холбоот Сургуулиудын Төслийн Сүлжээ /ХСТС/
<http://www.unesco.org/education/asp>

ЮНЕСКО-гийн Дэлхийн Өвийн Төв
<http://www.unesco.org/whc/>
и-мэйл: wh-info@unesco.org

Дэлхийн Өвийн Жагсаалт
<http://www.unesco.org/whc/nwhc/pages/sites/main.htm>

Дэлхийн Байгаль Хамгааллын Холбоо /IUCN/
<http://www.iucn.org>

Олон Улсын Музейн Зөвлөл /ICOM/
<http://www.icom.org>

Олон Улсын Хөшөө Дурсгал, Дурсгалт Газрын Зөвлөл /ICOMOS/
<http://www.icomos.org>


Соёлын үнэт зүйлийг хамгаалах, сэргээн засварлах судалгааны олон улсын төв /ICCROM/
<http://www.iccrom.org>

Дэлхийн Өв Хамгааллын Интернет Эх Сурвалж
<http://www.cr.nps.gov/ncpt/org>

Дэлхийн Өвийн Хотуудын Байгууллага /OWHC/
[Http://www.ovpm.org](http://www.ovpm.org)

Дэлхийн Өвийн Конвенц

Гяру улсын Мачу Пикчу түүхэн бурсгалт газар. ЮНЕСКО/ В. Моигои



...Соёлын болон байгалийн өвийн
сүйрэл мөхөл нь дэлхийн бүх
үндэстнүүдийн өвүүдэд хор хөнөөл
учруулна.

**Дэлхийн Өвийн конвенцийн
оршил**

Дэлхийн Өвийн Конвенц

Хуудас

Зорилго 39

Мэдлэг	39
Арга хандлага	39
Ур чадвар	39

Өвийн талаарх мэдлэг 40

Өв гэж юу вэ?	40
---------------	----

Сурагчийн гүйцэтгэх ажил 2: Өвийн утга учир Өвийг хадгалж хамгаалахад учрах ноцтой аюул занал	42
---	----

ДӨ-ийг хадгалж хамгаалах 43

Абу Симбелийг аврах ажил амжилттай болсон нь	44
--	----

Сурагчийн гүйцэтгэх ажил 3: Дэлхийн 7 гайхамшиг ДӨ-ийг хамгаалах конвенцийг гаргах	45 46
--	----------

Сурагчийн гүйцэтгэх ажил 4: Өв ба түүний хамгааллыг тодорхойлох	
---	--

ЮНЕСКО-гийн ДӨ-ийн конвенц 47

ДӨ-ийн конвенц	47
----------------	----

Сурагчийн гүйцэтгэх ажил 5: Өв хамгаалал-үндэсний хууль тогтоомж ба олон улсын конвенц Байгаль ба соёл салшгүй холбоотой Байгаль ба соёлын өв Соёлын дурсгалт газрууд	49 50 50 50
---	----------------------

ДӨ-ийг хамгаалах үйл явц 51

ДӨ-ийн жагсаалт- дэлхийн гайхамшигт үнэ цэнэт газрууд Төлөөллийн нийтийн бодлого ба тэнцвэржсэн ДӨ-ийн жагсаалт	53 53
---	----------

Сурагчийн гүйцэтгэх ажил 6: ДӨ-ийн газруудын загварыг гаргах	54
--	----

Сурагчийн гүйцэтгэх ажил 7: Орон нутгийнхаа ДӨ-ийн газруудыг таньж тогтоох	55
--	----

Сурагчийн дасгал ажлын хуудас: Орон нутгийнхаа ДӨ-ийн газруудыг таньж тогтоох	56
---	----

ДӨ-ийн газруудыг сонгох шалгуур 57

ДӨ-ийн соёлын дурсгалт газруудыг сонгох шалгуур	57
---	----

ДӨ-ийн байгалийн дурсгалт газруудыг сонгох шалгуур	58
--	----

ДӨ-ийн байгаль ба соёлын хосолмог дурсгалт газруудыг сонгох шалгуур	58
---	----

Хэрэглэгдэж буй шалгуур	59
-------------------------	----

Сурагчийн гүйцэтгэх ажил 8: ДӨ-ийн газруудын байршлыг тогтоох	60
---	----

Сурагчийн дасгал ажлын хуудас: ДӨ-ийн газруудын байршлыг тогтоох	61
--	----

Сурагчийн гүйцэтгэх ажил 9: ДӨ-ийн шалгууруудыг ойлгох	63
--	----

Сурагчийн дасгал ажлын хуудас: ДӨ-ийн шалгууруудыг ойлгох	64
---	----

Сурагчийн гүйцэтгэх ажил 10: Соёлын ба байгалийн дурсгалт газрын нэрийг дэвшүүлэх	66
---	----

Сурагчийн дасгал ажлын хуудас: Соёлын ба байгалийн дурсгалт газрын нэрийг дэвшүүлэх	67
---	----

Соёлын ба байгалийн дурсгалт газрын нэрийг дэвшүүлэх	67
--	----

ДӨ-ийн Хороо ба ЮНЕСКО-гийн ДӨ-ийн төв 69

Сурагчийн гүйцэтгэх ажил 11: Үндэсний Өвийн Хорооны хуралдаан	70
---	----

Сурагчийн гүйцэтгэх ажил 12: Колумбын Санта Круз де Момпоксын түүхэн төв	72
--	----


ДӨ-ийн газруудын хамгааллын байдалд хяналт тавих 74

ДӨ-ийн аюулд учраад байгаа газруудын жагсаалт	75
---	----

Сурагчийн гүйцэтгэх ажил 13: АНУ-ын Еллоустон	76
---	----

Сурагчийн гүйцэтгэх ажил 14: ДӨ-ийн талаар радиогийн нэвтрүүлэг	
---	--

Зорилго



Мэдлэг

- Өв ба ДӨ-ийн тухай ерөнхий ойлголт
- ДӨ-д учирч буй аюул занал, хор хөнөөл
- ДӨ-ийн конвенцийн ач холбогдол
- ДӨ-ийн жагсаалтанд бүртгэх үндэслэл, шалгуурууд
- ДӨ-ийг хадгалж хамгаалах гол үйл ажиллагаа зэрэг зүйлийн талаар ойлгож мэдэхэд сурагчдад туслана.

Арга хандлага

- Орон нутгийн өв хамгаалах үйлсэд оролцох
- Ө-ийн дурсгалт газруудыг үнэлж, хүндэтгэх
- Бусад соёлын талаар илүү мэдлэгтэй болох, сонирхох
- Соёлын болон байгалийн төрөл зүйлийг хүндэтгэн хайрлахад сурагчдыг дэмжих.

39

Ур чадвар

- Орон нутгийн болон ДӨ-ийг хамгаалах талаар хариуцлагатай шийдвэр гаргаж байх
- Өвийн холбогдолтой асуудлыг шийдвэрлэхэд санал бодлоо илэрхийлэх
- Өв хамгаалалд хувь нэмэр оруулах
- ДӨ-ийн тухай илүү ихийг мэдэхийн тулд судалгаа явуулах, аналитик шинжилгээний аргыг хэрэглэх зэргээр сурагчдад ур чадвараа хөгжүүлэхэд нь туслах

Бидний өвийн тухай ойлголт

▲ Өв гэж юу вэ?

Өнгөрсөн үеэс бидэнд өвлөгдөн үлдсэн, одоо бидэнд байгаа, ирээдүй хойч үе маань түүнээс суралцаж, түүнийг гайхан биширч, сэтгэлийн таашаал авч байх үүднээс тэдэнд уламжлан үлдээж байгаа аливаа зүйлийг өв гэж ерөнхийд нь тодорхойлдог.

Тайлбар: Толь бичигт "өв" гэдгийг өвлөгдөн үлдсэн ямар нэг зүйл гэж тодорхойлсон байдаг.

Өвийг:

1. Өвлөгдөж үлдсэн ба өвлөгдөж болох аливаа зүйл
2. Өвлөгдөж байгаа бодит явц, үе дамжсан залгамж холбоо
3. Өмчлүүлэх зорилгоор өгсөн буюу авсан аливаа зүйл
4. Өвлөгдсөн бүхэл буюу хэсэг зүйл...

гэж Оксфордын хураангуй толь бичигт тодорхойлжээ.


Хадгалж үлдэхийг хүссэн газар нутаг буюу эд зүйлийг өв гэж үзэж болно. Эдгээр нь өвөг дээдсээс бидэнд өвлөгдөн үлдсэн хосгүй нандин зүйл, шинжлэх ухааны чухал ач холбогдол бүхий юугаар ч орлуулшгүй, гайхамшигт жишээ төдийгүй бидний амьдрал, өөдрөг бадрангүй сэтгэлийн маань эх ундрага болохынх нь хувьд бидний үнэлж байдаг соёлын ба байгалийн дурсгалт газрууд, эд зүйлс юм. Үүгээр ч зогсохгүй тэрээр бидний хэн болохыг тодорхойлж байдаг нэг ёсны үндсэн таних тэмдэг юм. Энэхүү өв нь бидний өвөг дээсийн амьдрал, үйл хэргийг тусган харуулдаг бөгөөд тэдгээрийг хадгалж хамгаалах гэж онцгой хүчин чармайлт тавьж ирсний дүнд өнөөдрийг хүртэл хадгалагдсаар байдаг билээ.

Өөрийн амьдарч буй нутаг орноо ямар нэг өвгүйгээр төсөөлж чадах уу? Жишээ нь: Өөрөө болон сурагчдынхаа амьдарч буй газар нутгийг аваад үз л дээ. Өнгөрсөн, одоо, ирээдүйг юу төлөөлж байна вэ? Юуг нь бид хадгалж хамгаалах ёстой вэ, юуг нь нөхөн сэргээж болох вэ, юу нь нөхөн сэргээгдэшгүй вэ?

Дэлхий нь соёлын болон байгалийн гэсэн 2 төрлийн өвтэй. Өөрийн нутгийн археологийн болон хадны зураг урлал бүхий газар, сүм дугана, шашны болон тахилга бүхий ариун дагшин газрууд, түүхэн хот суурин, түүний балгас туурь зэргийг та мэдэж байгаа. Тэгвэл энэ бүхнийг соёлын өв гэнэ. Харин та ойн захад ч юм уу эсвэл үзэсгэлэнт сайхан эрэг орчим амьдардаг бол эдгээр чинь байгалийн өв юм. Ийм өвийг үл хөдлөх өв гэнэ. Учир нь тэднийг хөдөлгөн шилжүүлж болдоггүй. Мөнгө зоос, ургамлын төрөл, уран зураг, уран баримал, археологийн олдвор зэргийг нэг газраас нөгөөд шилжүүлж болдог учраас тэдгээрийг хөдөлгөөнт өв гэнэ.



Дэлхийн Өв ба
түүнийг таньж
тогтоох нь



■ Сурагчийн гүйцэтгэх ажил 2



ӨВИЙН УТГА УЧИР

Зорилго: Өвийн утга учир, үнэ цэнэ, хэлбэрүүдийн тухай ойлголттой болох



Ярилцлага



Ангийн ажил



Хичээлийн 2 цаг



Хэл, түүх, Нийгэм судлал



Гэрэл зураг



Ашиглах материал

Хөдөлгөөнт өв

□ Өвөг дээдсээс өвлөгдөн үлдсэн, таны үнэлж шүтэж явдаг /уран зураг, гоёл чимэглэлийн үнэт зүйл, хивс, шавар вааран сав гэх мэтийн / өөрийн эд зүйлээс сурагчдад үзүүл. Эдгээрийг хялбар хөдөлгөж, зөөж тээвэрлэж болдог учраас хөдөлгөөнт өвийн жишээ мөн болохыг тэдэнд тайлбарла. Уг зүйл соёлын өв үү, байгалийн өв үү?

□ Ярилцлага



Энэ чины юу юм вэ? Юугаараа танд үнэ цэнэтэй юм бэ, яагаад түүнийг хадгалж хамгаалах шаардлагатай юм бэ? Хэрэв та түүнийг хойч үедээ өвлүүлэн үлдээе гэвэл түүнийг хадгалж хамгаалахын тулд юу хийх вэ?



Дараагийн өдөр нь сурагчид өөрсдийн үнэ цэнэтэй эд зүйлээ авчирч, ангидаа тэр зүйлүүдээ дэлгэн үзүүлж, жижиг музей гаргана. Хойч үедээ үлдээхийг хүсэж буй эдгээр зүйлс нь юугаараа үнэ цэнэтэй болох талаар ярилц.

□ ЮНЕСКО нь хөдөлгөөнт соёлын өвийг хамгаалах талаар гарсан олон улсын Конвенцыг зохицуулж хэрэгжүүлдэг болохыг тайлбарла. / Соёлын эд зүйлийг хууль бусаар хилээр оруулах ба гаргах, түүнчлэн эзэмших эрхийг шилжүүлэхийг хориглох ба урьдчипан сэргийлэх тухай Конвенц, 1970 оны 11-р сарын 14 өдөр /

Үл хөдлөх өв

ЮНЕСКО-гийн ДӨ-ийн жагсаалтад орсон дурсгалт газрууд нь хялбар хөдөлгөх боломжгүй учраас үл хөдлөх өв болж байгааг тайлбарлаж, гэрэл зургуудаас жишээ ав.

□ Ярилцлага



Сурагчид урьд өмнө очиж байсан эсвэл судалж байсан /өөрийн орны буюу гадаадын/ газрын тухай бодож, тэдгээр нь биднийг хүртэл ямар мэдээлэл өгч, ямар утга агуулга дамжуулж ирснийг жагсааж бичих. /жишээ нь: гайхамшигт уран баримал, ховор ургамал амьтан /



Хойч үедээ унаган төрхөөр нь хадгалж үлдээх ёстой нутаг орныхоо байгалийн үзэсгэлэнт газруудын тухай, түүнчлэн тэдгээрийг хадгалж хамгаалах нь яагаад чухал болох талаар



Ашигласан материалын жагсаалт



Гэрэл зураг



Биет бус өв:
Бурундын бүжигчид
ЮНЕСКО

▲ Өвөө авран хамгаалахад учирч буй ноцтой аюул занал



Дэлхийн Өв ба түүнийг таньж тогтоох нь



Дэлхийн Өв ба аялал жуулчлал

42



Ашигласан материалын жагсаалт



Дэлхийн Өв ба хүрээлэн буй орчин

Бидний соёлын болон байгалийн өв нь маш эмзэг бөгөөд ялангуяа сүүлийн 100 жилд сөнөж мөхөхийн аюултай байнга тулгарч байна. Жишээ нь: Дэлхийн I, II дайны жилүүдэд эртний том, жижиг олон хот суурин устаж, чухал соёлын хөшөө дурсгалууд сүйрч үгүй болсон. Түүнчлэн бидний өв хотжилт, ядуурал, байгалийн гамшиг болон хүрээлэн буй орчны бохирдолт зэргээс шалтгаалан мөн л мөхлийн аюулд тулгараад байна. Мөн аялал жуулчлал хөгжсөн нь хөшөө дурсгал, байгалийн дурсгалт газрууд ихээр хэлмэгдэх нэг шалтгаан болж байна. Өвийг хадгалж үлдээхэд учрах нэг томоохон аюул бол хүмүүсийн байгаль дэлхийтэйгээ зүй бусаар хайхрамжгүй харьцаж буй явдал юм.

Эдгээр аюулаас сэргийлэх зорилгоор дэлхийн хоёр дайны хооронд НҮБ-ийн өмнөх байгууллага болох Үндэстүүдийн Холбоо, өвийг хамгаалах талаар үйл ажиллагаа явуулж эхэлсэн юм. Тус холбоо нь өвийг хамгаалах энэ үйлсэд хүчээ нэгтгэн хамтран ажиллахыг дэлхийн олон улс орнуудад уриалан дуудсан. Дэлхийн II дайны төгсгөлд буюу 1945 онд НҮБ-ийн Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Байгууллага /ЮНЕСКО/ байгуулагдсан нь онцгой ач холбогдолтой газруудыг авран хамгаалах компаниг ажлуудыг өрнүүлэх, хүн төрөлхтний өвийг хамгаалах тухай олон улсын шинэ конвенцууд, зөвлөмжүүдийн төслийг гаргах зэрэг үйлсэд чухал түлхэц болсон. Эдгээр Конвенцийн нэг нь дайны цагт соёлын өвийг хамгаалах тухайд жич зориулагдсан бөгөөд энэ нь "Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын өвийг хамгаалах тухай 1954 оны Гаагийн Конвенц юм.

Дэлхийн Өв

Дэлхий бол бидний өв
Миний ч өв, таны ч өв, бид бүгдийн өв
Маргаашийн үндэстнүүдийн тусын тулд түүнийг хамгаалах үйл хэргийг бидний гарт өгөөч.

Виктори нуурын дөлгөөн ус
Викторийн гайхамшигт хүрхрээ
Жигүүртэн шувуудын өлгий болсон Данубийн амгалан гол мөрөн
Мурилзан урсах Миссиссиппи ба Миссоури голууд

Зимбабийн үзэсгэлэнт сайхан байгаль, эртний хот балгас туурь

Фараонуудын эх орон дахь Египедийн ид шидийн пирамидууд
Иерусалемийн эртний хана, хятадын алдарт цагаан хэрэмийг би
харж байна.

Драконсбургийн сүрлэг уулс
Мучинга Эскапментийн өндөр өндөр уул толгод
Гималайн уулс болон Оросын Уралын дүнхэр нуруу
Канадын Рокийг тоолж, сэтгэл булаам Килиманжорог би харж
байна.

Чи, би, энэ дэлхийн бүх хүмүүс
Энэ л дэлхийнх учир
Дэлхий бол бидний өв
Түүнийг хамгаалах нь чиний ариун үүрэг
Бидний Дэлхийн Өвийг бүү сүйтгэ
Үзэсгэлэнт сайхан байгаль, өндөр сүрлэг уулсаа унаган хэвээр нь
байлгая
Цэцэрлэгт хүрээлэн тэдний амьд байгалийг бүү сүйтгэ
Конго болон Амазоны битүү ой, өтгөн ширэнгийг бүү сүйтгэ
Дэлхийн Өвөө ямагт хадгалж хамгаалж байцгаая.

ДӨ-ийн залуучуудын чуулга уулзалтанд оролцсон сурагч Маянеэй
Маребеса




Замбиа ба Зимбабвейн
Викторийн Хүрхрээ
ЮНЕСКО

Дэлхийн Өвийг хадгалж хамгаалах нь

1950-иад оны үед Египетэд Асваны Далан барих тухай шийдвэр гаргасан нь ЮНЕСКО-гоос дэлхийн онц чухал өвийг авран хамгаалах үйлсэд олон улсыг уриалан дуудсан анхны алхам хийхэд хүргэсэн билээ. Абу Симбелийн сүм эртний Грекийн соёл иргэншлийн гайхамшигт үнэт эрдэнэсийг агуулсан Нил мөрний ай сав газар усанд автатгасан нь олон улсын сэтгэлийг зовоож, түүнийг нэн даруй авран хамгаалах талаар шуурхай зохицуулагдсан үйл ажиллагаа явуулах шаардлагатай болсон байгааг дэлхий дахинд түгшүүрийн дохиог дэлдсэн. Египед, Суданы засгийн газрын мэдэгдлийн дараа Абу Симбелийг аврах олон улсын компанит ажлыг ЮНЕСКО 1959 онд эхэлсэн. Энэхүү өвийг авран хамгаалах 18 жилийн аяны хугацаанд ЮНЕСКО-гийн санаачлага, хүчин чармайлтыг дэлхийн 50 орчим орон дэмжиж, нийт 80 сая долларын хандив оруулжээ.

Орчин үеийн инженерийн шинжлэх ухааны ололтын ачаар Филае арал дээрх сүмүүдийг чулуу нэг бүрээр нь хуулан буулгаж, Нил голын уснаас зайдуу орших Агилкаи арал дээр дахин босгожээ. Энэ арал дээр уг объектыг босгохын тулд арлын хад чулууг тэсэлгээ хийж бутлан оронд нь буулгасан сүмийн хүнд хүнд бүтцүүд хадан хананд шигтгэн суулгах замаар эх байдлаар нь бүтээн босгожээ. Чулуун бүтэц нэг бүр нь хагас тонноос 12 тонн жинтэй бөгөөд 40000 орчим тийм бүтцийг шилжүүлэн байрлуулах шаардлагатай байв. Шинэ сүм барихад орох бүтцүүдийг хуучин байрлал, дарааллыг нь алдагдуулахгүйн тулд дугаарласан байлаа.

Энэхүү Абу Симбелийн сүм нь Асваны Далангийн хамтаар Нил мөрний усанд бүхэлдээ живж болзошгүй байсан учраас соёлын үл хөдлөх өв болох эдгээр сүм дуганыг нүүлгэн шилжүүлсэн нь тэднийг аврах цорын ганц зам байсан юм. Гэхдээ дэлхийн нийтийн өв хамгаалагчид соёлын дурсгалт өвийг шилжүүлэн байрлуулах нь Абу Симбелийг эс тооцвол тийм ч хүсүүштэй зүйл биш хэмээн үздэг байна.



Египетийн Абу Симбелээс Филайд нүүлгэн шилжүүлсэн хөшөө дурсгал ЮНЕСКО/НЕНАДОВИК

▲ Абу Симбелийг амжилттай авран хамгаалсан нь

Абу Симбелийн сүмийг аврах ажил нь хүмүүст дурсгалт газраас элс хол байдаг ч гэсэн тэдэнд бас хамааралтай дэлхий дахинд нийтлэг гайхамшигтай үнэт зүйлүүд дэлхий дээр байдаг юм байна гэдгийг ойлгуулсан. Түүнчлэн түүхийн өвийг хамгаалахад олон үндэстнүүд нэгдмэл нэгэн хариуцлага хүлээж, эв нэгдэлтэй байх нь чухал болохыг харуулсан. Энэ компани ажил амжилттай болсон нь дурсгалт газрыг авран хамгаалах олон улсын бусад компани ажлуудын эхлэл болсон юм: Үүнд: Италийн Венец, Пакистаны Моенжодаро, Индонезийн Боробудур зэргийг оруулж болно. Нэрлэхэд хэдий цөөн ч одоо зарим нь амжилттай хэрэгжиж байна. Тухайлбал: Камбож улсын Анкорийн дурсгалт газрыг хамгаалах олон улсын хөтөлбөрийг энд дурдаж болно.

■ Сурагчийн гүйцэтгэх ажил 3

ДЭЛХИЙН 7 ГАЙХАМШИГ

Зорилго: Эрт дээр үеэс өнөөг хүртэл хадгалагдаж ирсэн гайхамшигт газруудын тухай ойлгох мэдэх



Ярилцлага



Ангийн ажил



Хичээлийн 1 цаг



Түүх, Газар зүй, Нийгэм судлал



ДӨ-ийн байршлын газрын зураг, товч тодорхойлолт

Чухал дурсгалт газруудын жагсаалт гаргах санаа нь маш эртнээс үүсэлтэй бөгөөд Эртний Грекчүүд дараах газруудыг дэлхийн 7 гайхамшигт тооцож байв.

- Египетийн Пирамид
- Вавилоны Дүүжин цэцэрлэг
- Ифисусийн Артемис сүм
- Олимпийн Зэвсийн хөшөө
- Халикарнассусын Бунхан
- Родесын Колосус
- Александрын гэрэлт цамхаг



Египетийн Жизагаас Дахшур хүртэлх Пирамидийн талбай-Мемфис ба түүний оршуулгын газар ЮНЕСКО

Эртний дэлхийн энэ 7 гайхамшигаас Египетийн пирамид л одоог хүртэл хэвээр хадгалагдаж, бусад 6 нь бараг устаж үгүй болж, археологийн бүртгэлд ул мөр төдий үлджээ.

Эртний Грекчүүдийн энэхүү 7 гайхамшигийг газар дундын тэнгис орчмын соёлын хөшөө дурсгалуудын сонгодог жишээ хэмээн үздэг байв. ДӨ-ийн жагсаалт нь дэлхий нийтийн хэмжээний соёлын болоод байгалийн өвийн дурсгалт газруудыг багтаасан байдаг бөгөөд ДӨ-ийн конвенц нь тэдгээрийг хамгаалах эрх зүйн гол баримт бичиг болж өгдөг. Дээрх дэлхийн 7 гайхамшигтай тохиолдсон эмгэнэлт явдлыг давталгүйгээр ирэх зуу зуун жилийн туршид дэлхийн бүхий л өвийг авран хамгаалж чадахыг бид хүсэж байна.

□ Сурагчид өөрсдийнх нь бодлоор ертөнцийн 7 гайхамшиг гэж үзэж байгаа 7 чухал газрын жагсаалт гаргаж, тэдгээр газруудыг Дэлхийн Өвийн жагсаалтад бүртгэгдсэн дурсгалт газруудтай харьцуулан, үр дүнг нь ярилцана.



Дэлхийн Өвийн газрын зураг



Товч тодорхойлолт

▲ Дэлхийн Өвийг хамгаалах тухай конвенцийн төсөл бичих нь



Харилцах хаягууд



Дэлхийн Өв ба хүрээлэн буй орчин

Абу Симбелийг авран хамгаалах ажлын шууд үр дүн нь болсон соёлын өвийг хамгаалах тухай конвенц гаргах бэлтгэл ажлыг ЮНЕСКО засгийн газрын бус байгууллага- Хөшөө дурсгал, түүх соёлын дурсгалт газрын олон улсын зөвлөл /ICOMOS/-ийн тусламжтайгаар эхэлсэн. АНУ болон байгаль хамгаалах олон улсын холбоо /IUCN/ буюу одоогийн Дэлхийн байгаль хамгааллын холбооноос байгалийн болон соёлын өвийг хоёуланг нь хамгаалах асуудлыг эрхзүйн нэг баримт бичигт нэгтгэх санал гаргасан бөгөөд уг саналыг 1972 оны 9-р сард Шведийн Стокгольмд болсон “Хүн төрөлхтний хүрээлэн буй орчин” сэдэвт НҮБ-ийн бага хуралд танилцуулсан. /20 жилийн дараа 1992 онд Риогийн Дээд хэмжээний чуулга уулзалтаар түүнийг үргэлжлүүлсэн. Гол үндэслэл нь дэлхий дахины нийтлэг гайхамшигт үнэт зүйл болох соёлын болоод байгалийн өвийг хоёуланг нь хамгаалах талаар олон улсын баримт бичиг гаргах явдал байсан юм. НҮБ-ийн боловсрол, шинжлэх ухаан, соёлын өргөн асуудлыг хамарсан төрөлжсөн агентлаг болохын хувьд ЮНЕСКО-д Стокгольмын бага хурлаас соёлын ба байгалийн өвийг хоёуланг нь хамгаалах тухай Конвенц боловсруулах асуудлыг итгэн хариуцуулсан.

Хүрээлэн буй орчны асуудлаарх Стокгольмын бага хурлаас хойш хэдхэн сарын дараа 1972 оны 11-р сарын 16-нд дэлхийн соёлын ба байгалийн өвийг хамгаалах тухай конвенцийг Францын Парис хотноо ЮНЕСКО-ийн төв байранд хуралдсан ЮНЕСКО-гийн ерөнхий бага хурлын 17-р чуулганаар баталжээ.

■ Сурагчийн гүйцэтгэх ажил 4

ӨВ БА ТҮҮНИЙ ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТЫГ ТОДОРХОЙЛОХ

Зорилго: Өв ба түүнийг хамгаалах үзэл хандлагыг илүү ойлгож мэдэж



Ярилцлага



Ангийн ажил



Хичээлийн 2 цаг



Хэл



Нэмэлт тайлбар



Толь бичиг

□ Сурагчид өв болон түүний хамгааллын тухай цөөн үгээр Богино өгүүллэг бичнэ. Орон нутагт өв хамгаалах талаар хэрэгжиж буй төслүүдийг хэр мэдэж байгаа эсэхийг сурагчдаас асууж, бусдад нь санал болго.

ЮНЕСКО-гийн ДЭЛХИЙН ӨВИЙН КОНВЕНЦ

▲ Дэлхийн өвийн Конвенц

**НҮБ-ийн Боловсрол Шинжлэх Ухаан, Соёлын
байгууллага**
**United Nations Educational, Scientific and Cultural
Organization**
**Organizacion de las Naciones Unidas para la Education, la
Ciencia y la Cultura**
**Organisation des Nations Unies pour l'education, la
science et la culture**

**Организация объединенных наций по вопросам
образования, науки и культуры**

**Дэлхийн соёлын ба байгалийн өвийг хамгаалах тухай
конвенц**
**Парист 1972 оны 11-р сарын 16-нд Ерөнхий бага хурлын
17-р чуулганаар батлагдав.**



**Convention concerning the protection of the world cultural
and natural heritage**

Дэлхийн Өвийн
Конвенц

47

**Convencion sobre la proteccion del patrimonio mundial,
cultural y natural**

**Convention concernant la protection du patrimoine
mondial, culturel et naturel**

Конвенция об охране всемирного культурного и



Францын Парис хотод байрладаг ЮНЕСКО-гийн Төв байр ЮНЕСКО

Энэхүү конвенц нь дэлхий дахины нийтлэг гайхамшигт үнэт зүйл болох юугаар ч орлуулж болшгүй соёлын болон байгалийн өвийг тодорхойлох, хадгалж хамгаалах зайлшгүй шаардлагаас урган гарсан олон улсын анхны албан ёсны баримт бичиг юм.

Конвенц нь олон улсын хамтын ажиллагаа явуулж, бидний соёлын болон байгалийн нийтлэг өвд хамааралтай бүхнийг хамгаалах ёс суртахууны болон санхүүгийн хариуцлагыг бид бүгдээрээ хүлээх ёстой гэдгийг баттайгаар нотолж байгаа билээ.

Дэлхийн Өвийн тухай үзэл хандлага

- Дэлхий дахины нийтлэг гайхамшигт үнэт зүйл болох өвийн хадгалалт хамгаалалт
- Соёлын ба байгалийн өв
- Үл хөдлөх өв
- Дахин нөхөгдөшгүй өвийн хадгалалт хамгаалалт
- Дэлхийн өвийн хадгалалт хамгаалалт нь олон улсын нэгдмэл үйл ажиллагаанаас хамаарах нь

■ Сурагчийн гүйцэтгэх ажил 5



ӨВИЙН ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ-ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖУУД БА ОЛОН УЛСЫН КОНВЕНЦУУД

Зорилго: Үндэсний болон олон улсын өвийг хоёуланг нь хадгалж хамгаалах ажлыг хэрэгжүүлэх тухай ойлголт ухамсарыг нь дээшлүүлэх:



Ярилцлага



Ангийн
ажил



1 цагийн
хичээл



Хэл, түүх,
Нийгэм судлал



ДӨ-ийн байршлын
газрын зураг,
ДӨ-ийн Конвенц



Ашиглах
материалын
жагсаалт

□ Сурагчдыг 2 бүлэгт хувааж, дараах судалгааны ажил ба асуултуудыг тарааж өг:

А. Танай улс хэдийд Конвенцид нэгдэн орсон улс болсон бэ? /дэлхийн өвийн газрын зураг дээр ямар ямар улс орон хэзээ Конвенцид нэгдэн орсон улс болсныг хар/ Конвенцид нэгдэн орсны гол утга учир давуу тал юунд байгааг нэгдүгээр бүлгийн сурагчдаас асуу.

Б. Олон улсын хамтын нийгэмлэгээс /ЮНЕСКО/ ДӨ-ийн Конвенцийг гаргах болсон шалтгааны жагсаалтыг хоёрдугаар бүлгийн сурагчдаар гаргуул.

В. Сурагчид ДӨ-ийн Конвенцийг уншаад, дүгнэлт гарган ярилц.

49

Дэлхийн нийтийн боловсролын хөтөлбөрт ДӨ-ийг оруулсны ач холбогдлыг Конвенцийн 6-р бүлгийн 27-р зүйлд онцлон тэмдэглэсэн байдаг бөгөөд энэхүү Конвенц нь соёлын болон байгалийн өвийг хүмүүс илүү ихээр биширч хүндэлдэг болгоход бүхий л боломжит хэлбэрээр, ялангуяа боловсрол мэдээллийн хөтөлбөрүүдээр хүчин чармайлт гарган оролцохыг Конвенцид нэгдэн орсон бүх улс оронд уриалсан юм.



Дэлхийн Өв

Бидний тангараг. . . Боловсрол соёлын болон байгалийн өвийн төлөө байгаа учир Үндэсний Сургалтын Хөтөлбөрт байраа олох болсон ДӨ-ийн Конвенцийг бид судалж ойлгох болно. Боловсролын энэ хэлбэр нь мэдлэгийг хичээлээр олгохын зэрэгцээ дурсгалт газруудаар аялах боломж бидэнд олгодог юм.

Норвегийн Бергенд болсон ДӨ-ийн залуучуудын анхдугаар чуулга уулзалтанд оролцсон сурагчид

Өвийг хадгалж хамгаалах учир шалтгааныг залуучуудын ой ухаанд ортол ухааруулж ойлгуулахгүй юм бол мэргэжлийн энэ олон байгууллага ажиллуулж, үндэсний хууль тогтоомжууд гаргаж байж өвийг хадгалж хамгаалсны утга учир алга болно шүү дээ. Дубровникт болсон ДӨ-ийн Европын бүсийн залуучуудын анхдугаар чуулга уулзалтын нээлт дээр Хорватын соёлын сайд ноён Бозо Бискупикийн хэлсэн үгээс.



Норвегд болсон Бергений ДӨ-ийн Чуулга Уулзалтад оролцсон хүүхдүүд ЮНЕСКО

▲ Байгаль ба соёлын салшгүй холбоо



Дэлхийн Өв ба түүнийг таньж тогтоох нь



Дэлхийн Өвийн Конвенц

Байгаль ба соёлын хадгалалт хамгаалалтыг холбож өгдөг учраас энэ Конвенц нь үнэхээр онцгой юм. Байгаль болон соёлын хадгалалт хамгаалалтын асуудлыг бүх талаар нь холбож өгдөг тийм хууль үндэсний хэмжээнд цөөн тоотой байх бөгөөд харин олон улсын хэмжээнд уг конвенцоос өөр конвенц байхгүй юм. Мэдээж байгаль соёл 2 бол хос зүйл юм: янз бүрийн ард түмний соёлын онцлог нь тэдний амьдарч буй хүрээлэн буй орчинтой салшгүй уялдаатай бөгөөд иймээс ч үзэсгэлэнт сайхан хөшөө дурсгал, байшин барилга, дурсгалт газрууд нь ойр орчмын байгалийн гоо үзэсгэлэнд түшиглэсэн байдаг юм. Түүнчлэн зарим нэг бахдам сайхан байгалийн газрууд нь хэдэн зуун жилийн хүний үйл ажиллагааны ул мөрийг тээж байхын хамт оюуны болоод соёл, урлагийн асар их үнэ цэнэтэй. ДӨ-ийн бэлэг тэмдэг нь соёлын ба байгалийн дурсгалт газруудын, мөн соёл ба байгалийн өөр хоорондын уламжлалт шүтэлцээг бэлэгддэг юм.

▲ Соёлын болон байгалийн өв

Конвенцийн нэгдүгээр бүлэгт соёлын өв, хоёрдугаар бүлэгт байгалийн өвийг тодорхойлсон байдаг.



Дэлхийн Өвийн Конвенц

50



Холбоот Сургуулиудын Төсөлд хамрагдах Непалийн сурагчид Бажраяогини сүмийн шатыг цэвэрлэж байна. ЮНЕСКО

Хотуудын соёлын өвийн жинхэнэ хамгаалагч, асран тэтгэгч нь тухайн хотын иргэд юм. Тэднийг хаанаас олж болох вэ? Хаанаас ч олж болно. Гэхдээ Сургуульд сурч байх үеэс нь эхлэх нь илүү үр дүнтэй. ЮНЕСКО-гийн сүлжээг ч бас үүнд чиглүүлэх хэрэгтэй: ЮНЕСКО-гийн Холбоот Сургуулиудын Төслийн Сүлжээнд олон улсын хамтын ажиллагаанд оролцдог олон мянган сургууль орсон байна.

Норвегийн Соёлын сайд Хатагтай Ас Клевленд (1995)




Харилцах хаягууд

▲ Соёлын дурсгалт газрууд

1992 оноос эхлэн ДӨ-ийн Хороо нь байгаль болон соёлын гайхамшигт харилцан холбоог уялдаанд нь авч үзэн соёлын дурсгалт газрыг хүлээн зөвшөөрсөн юм.

Шинэ Зеландын Тонгарирогийн Үндэсний парк, Австралын Улуруката Тжутагийн Үндэсний парк, Филиппины Филиппин Кордилерасын цагаан будааны дэнж, Португалийн Синтрагийн Соёлын дурсгалт газар, Чехийн Леднайс- Волтис, Австрийн Холстет- Дачейн/ Салзкамергут Соёлын дурсгалт газар, Испани/ Францийн Пиренес-Монт Перду, Италийн Костериа Амалфитано, Портовенер, Синкью Терр, /Палмариа, Тино, Тинетто/ арлууд, Шведийн Өмнөд Оландийн Хөдөө Аж Ахуйн соёлын дурсгалт газар зэрэг нь ДӨ-ийн жагсаалтанд бүртгэгдсэн. ДӨ-ийн соёлын дурсгалт газруудын талаар илүү мэдээлэл авахыг хүсвэл ЮНЕСКО-ийн ДӨ-ийн Төв буюу интернет дэх вэб сайтаас авч болно.





Португалийн Синтра хотын соёлын дурсгалт газар ЮНЕСКО

ДӨ-ийг хамгаалах үйл явц


ДӨ-ийг хадгалж хамгаалах асуудал бол бүхий л амьдралын туршид үргэлжлэх үйл явц бөгөөд энэ хугацаанд хэд хэдэн чухал алхам хийх хэрэгтэй. Эхлээд улс орнууд нь Конвенцийн гишүүн улс болж, түүх соёлын дурсгалт газруудаа ДӨ-ийн жагсаалтанд оруулахаар нэрийг нь дэвшүүлснээр ДӨ-ийг хамгаалах үүрэг хүлээнэ.

Доорх зургууд нь нэр дэвшүүлэх үйл явцыг харуулж байна.



1 Аливаа улс ДӨ-ийн Конвенцид гарын үсэг зурснаар түүний гишүүн орон болж, соёлын болон байгалийнхаа өвийг хамгаалах үүргийг хүлээнэ.

2 Конвенцийн гишүүн улс нь өөрийн нутаг дэвсгэрт байгаа дэлхий дахины нийтлэг үнэ цэнэ бүхий гэж үзэж болох гайхамшигт соёлын ба байгалийн өвийн газруудынхаа урьдчилсан жагсаалтыг бэлтгэнэ.



3 Гишүүн улс нь өөрийн гаргасан урьдчилсан жагсаалтнаас ДӨ-ийн Жагсаалтанд нэрийг нь дэвшүүлэх газраа сонгоно.



4 Нэр дэвшүүлэх тусгай маягтыг бөглөөд ЮНЕСКО-гийн ДӨ-ийн Төвд хүргүүлнэ.

5 ЮНЕСКО-гийн ДӨ-ийн Төв нь нэр дэвшүүлсэн материал бүрдсэн эсэхийг хянаад Олон Улсын Музейн Зөвлөл /ICOMOS / буюу Олон Улсын хөшөө дурсгал, түүх соёлын дурсгалт газрын зөвлөл /IUCN/-д



6 Шинжээчид газар дээр нь ирж, эдгээр дурсгалт газруудын хамгаалалт ба менежментэд үнэлгээ өгнө.

7

Олон Улсын Музейн Зөвлөл /ICOMOS / буюу Олон Улсын хөшөө дурсгал, түүх соёлын дурсгалт газрын зөвлөл /IUCN/ нь соёлын ба байгалийн өвийн шалгууруудыг хэрэглэн нэрийг нь дэвшүүлсэн газруудад үнэлгээ өгнө.



52



8 Олон Улсын Музейн Зөвлөл /ICOMOS / буюу Олон Улсын хөшөө дурсгал, түүх соёлын дурсгалт газрын зөвлөл /IUCN/ дүгнэлт гаргасан тайлангаа бичнэ.

9 ДӨ-ийн товчооны 7 гишүүн нэр дэвшүүлсэн ба дүгнэсэн байдлыг дахин хянаж үзээд ДӨ-ийн Хороонд зөвлөмж өгнө.



10 ДӨ-ийн Хорооны 21 гишүүн хуралдаж уг газрыг Дэлхийн Өвийн Жагсаалтад бүртгэх, хойшлуулах, татгалзах гэсэн ангиллаар эцсийн шийдвэр гаргана.

▲ Дэлхий дахины үнэ цэнэтэй гайхамшигт дурсгалт газруудын ДӨ-ийн жагсаалт

ДӨ-ийн Конвенцид орсноор тухайн улс Конвенцид оролцогч улс болж, өөрийн улсын нутаг дэвсгэрт байгаа соёлын болон байгалийн өвийг одоо болон ирээдүй хойч үедээ хадгалан үлдээх үүрэг хүлээнэ.

Конвенцид нэгдэн ормогцоо тухайн улс ДӨ-ийн жагсаалтанд оруулахаар өөрийн орны дурсгалт газруудынхаа нэрийг дэвшүүлэх үйл ажиллагааг явуулж эхлэнэ. Нэрийг нь дэвшүүлэх дурсгалт газрын талаарх анхан шатны саналыг нутгийн ард иргэдээс авч, засгийн газрын албан ёсны байгууллагаар уламжлан ЮНЕСКО-д явуулна. Эхлээд Конвенцид оролцогч улс нь тухайн дурсгалт газрын нэрийг нь дэвшүүлэх эсэх шийдвэрийг гаргах ёстой. Сонгон шалгаруулалтын энэ үйл явцыг таньж тогтоох үе гэнэ. Конвенц нь оролцогч орнуудаас өөрийн орны нутаг дэвсгэр дээрх дэлхийн гайхамшигт үнэт зүйл хэмээн тодорхойлж болох соёлын болон байгалийн дурсгалт газруудынхаа тодорхойлолтыг гаргасан байхыг шаарддаг. Оролцогч орнууд дэлхийн өвд бүртгүүлэхээр сонгож авсан газраа ЮНЕСКО-гийн ДӨ-ийн Төвд Урьдчилсан Жагсаалт болгон хүргүүлнэ.



Сурагчийн дасгал ажлын хуудас

Оролцогч орон нь дурсгалт газрынхаа нэрийг дэвшүүлэхдээ тусгай маягтийг бөглөж материал бүрдүүлнэ. Ялангуяа оролцогч орон нь ДӨ-ийн Хорооны баталсан сонгон шалгаруулах шалгууруудаар уг дурсгалт газар нь ДӨ-ийн жагсаалтад орох бүрэн үндэслэлтэй болохыг тодорхойлж, түүнчлэн энэхүү дурсгалт газар нь зүй ёсоор хамгаалагдаж үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгааг харуулах ёстой. Нэрийг нь дэвшүүлсэн газраа ийм хэв маягийн бусад газруудтай харьцуулсан судалгаа, дүгнэлтийг гаргаж явуулах нь бас чухал юм. Хөшөө дурсгал, түүх соёлын дурсгалт газрын олон улсын зөвлөл /ICOMOS/ ба олон улсын музейн зөвлөл /IUCN/ нь нэр дэвшүүлсэн газарт үнэлгээ гаргаж, ДӨ-ийн Хороонд саналаа явуулах ба ДӨ-ийн Хороо нь уг газрыг ДӨ-ийн жагсаалтанд бүртгэх тухай эцсийн шийдвэрийг гаргана.

2004 оны 5-р сарын байдлаар ДӨ-ийн жагсаалтанд 129 орны 754 газар бүртгэгдсэнээс 582 нь соёлын, 149 нь байгалийн, 23 нь байгаль соёлын хосолмол газрууд байна.



Товч тодорхойлол

▲ ДӨ-ийн жагсаалтыг жигд төлөөлөлтэй, тэнцүүхэн болгох дэлхий дахины стратеги

ДӨ-ийн хороо нь Африк, Арабын нэгдсэн Улс, Ази- Номхон Далай, Европ, Хойд ба Латин Америк, Карибын Тэнгисийн орнууд дахь ДӨ-ийн дурсгалт газруудыг бүс бүсийг төлөөлүүлэн ДӨ-ийн жагсаалтанд жигд оруулах талаар шургуу ажиллаж байна. 1994 онд ДӨ-ийн Хороо нь ДӨ-ийн жагсаалтын соёлын ба байгалийн олон янз байдлыг хангахад онцгойлон анхаарах нь зүйтэй гэж үзэж "Түүх соёлын дурсгалт газрын ДӨ-ийн жагсаалтыг жигд төлөөлөлтэй, тэнцвэртэй болгох дэлхий дахины стратег"-ийг баталжээ.



Дэлхийн Өвийн газрын зураг

Би одоо юу бодож байгаагаа хэлье. Африкийн өвийн талаар хангалттай мэдээлэл байхгүй юм шиг надад санагддаг.

Замбиа ба Зимбабве, Викториа хүрхрээ, ДӨ-ийн залуучуудын чуулга уулзалт дээр Мозамбекийн сурагчийн хэлсэн үг.

■ Сурагчийн гүйцэтгэх ажил 6



ДӨ-ИЙН ГАЗРУУДЫН ОРОН ЗАЙН ЗАГВАРЫГ БҮТЭЭХ

Зорилго: ДӨ-ийн дурсгалт газруудын талаар нарийвчлан мэдэх ба бүтээлч чадварыг хөгжүүлэх



Дасгал



Ангид хийх
буюу хөтөлбөр-
өөс гадуурх
ажил



Хичээлийн
хэд хэдэн
цаг



Математик,
урлаг,
түүх, Газар зүй



Гэрэл
зураг



Картон
цаас, цавуу,
баримал

□ Сурагчдад фото зургууд үзүүлж, тэд эдгээрээс нэг буюу хэд хэдэн ДӨ-ийн газруудыг сонгон авч орон зайн загварыг нь хийнэ. Математикийн багш загварыг ямар хэмжээгээр буулгах тооцоог гаргах, дүрслэх урлагийн багш, орон нутгийн зураач, уран барималч загварыг яаж хийх, түүхийн багш түүхэн үнэний талаар зөвлөгөө өгч чадна. Хийсэн загваруудаараа үзэсгэлэн гаргаж, эцэг эх бусад хүмүүсийг урьж үзүүлж болно.





■ Сурагчийн гүйцэтгэх ажил 7

БҮС НУТАГТАА БАЙГАА ДӨ-ИЙН ГАЗРУУДЫГ ТАНЬЖ МЭДЭХ

Зорилго: Бүс нутагтаа байгаа ДӨ-ийн дурсгалт газруудыг талаар мэдээлэлтэй болох



Судалгаа



Ангийн ажил



1-2 цагийн хичээл



Газар зүй, Түүх



“Бүс нутагтаа байгаа ДӨ-ийн газруудыг таньж мэдэх” сурагчийн дасгал ажлын хуудас, ДӨ-ийн байршлын газрын зураг, товч тодорхойлолт

□ Боломжтой бол сурагч бүрт фото зургийг хувипан өгч, Сурагчийн дасгал ажлын хуудсан дээр ажиллуулна.

Өөрийн болон хөрш зэргэлдээ улсад байдаг ДӨ-ийн 10 түүх соёлын дурсгалт газрын жагсаалтыг сурагчдаар гаргуул.

Танай орон ДӨ-ийн Конвенцид элсэн орсон уу?

Танай оронд ДӨ-ийг Конвенцийг хэрэгжүүлэх асуудлыг ямар байгууллага хүмүүс хариуцдаг вэ? /соёлын болон байгалийн өвийг хамгаалах/

Танай орон ЮНЕСКО 2-ын хооронд ямар холбоо харилцаа байдаг вэ? Танай улсад ЮНЕСКО-гийн Үндэсний Комисс байдаг уу? гэх мэт асуултыг сурагчдад тавина.

Сурагчийн дасгал ажлын хуудас

ДӨ-ийн байршлын газрын зургаас ДӨ-ийн Конвенцид оролцогч улсуудын жагсаалт, ДӨ-ийн жагсаалтад орсон 754 түүх соёлын дурсгалт газрын байршил зэргийг харж болно.



Дэлхийн Өвийн газрын зураг

Танай улсад болон хөрш орнуудад чинь байдаг ДӨ-ийн 10 дурсгалт газруудыг олж, дараах хүснэгтэд тэдгээрийн нэр, газарзүйн байршлыг бичих ба эдгээр нь соёлын, байгалийн эсвэл соёл байгалийн хосолмол газруудын аль нь болохыг тодорхойл.

Хариултуудыг хамтдаа ярилцах:



Дэлхийн Өвийн Конвенц

№	ДӨ-ийн газруудын нэрс	ДӨ-ийн жагсаалтад бүртгэгдсэн он	Оролцогч орон	Газрын хэлбэр /соёлын, байгалийн, соёлын ба байгалийн хосолмол/
1				
2				
3				
4				
5				
6				
7				
8				
9				
10				

Нутагтаа байгаа ДӨ-ийн газруудыг таньж мэдэх

ДӨ-ийн дурсгалт газруудыг сонгон шалгаруулах шалгуур

ДӨ-ийн шалгуурын тухай багш нарт зориулсан тусгай тайлбар

Шалгуур нь ДӨ-ийн хадгалалт хамгаалалтын чухал хэсэг бөгөөд ДӨ-ийн боловсрол олгох таны үйл ажиллагааны алхам бүрт хэрэг болно гэдгийг санаж яваарай.

ДӨ-ийн Жагсаалтыг гаргах нь олон улсын нийгэмлэгийн чухал уриалга болдог: ДӨ-д ороход дурсгалт газар, хөшөө дурсгал, цогцолбор газрыг хэрхэн шалгаруулдаг вэ? Өөрөөр хэлбэл, байгалийн гайхамшигт үнэт зүйл эсвэл ДӨ-ийн соёлын ба байгалийн үнэ цэнэ бүхий газруудыг бүрдүүлдэг зүйлс нь юу вэ?

ДӨ-ийн Конвенцийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны Удирдамжийг ДӨ-ийн хорооноос жилээс жилд улам боловсронгуй болгож ирсэн. Энэхүү Удирдамжид ДӨ-ийн жагсаалтад дурсгалт газруудыг хэрхэн нэрийг нь дэвшүүлэх, ямар шалгууруудаар дэвшүүлэх талаар тодорхой тайлбарласан байдаг.



Ашигласан материалын жагсаалт

▲ ДӨ-ийн соёлын дурсгалт газруудыг сонгон шалгаруулах шалгуур

Одоо мөрдөгдөж буй энэхүү Удирдамжинд ДӨ гэж үзэж болох хөшөө дурсгал, уран барилгын цогцолбор, дурсгалт газар гэх мэт соёлын өвийг сонгон шалгаруулахад хэрэглэх 6 шалгуурыг оруулжээ.

Соёлын дурсгалт газрын хувьд:



- (i) Хүний гоц авьяас суу билгээр бүтээгдсэн уран бүтээлийн дээжис байх

Алжирин Тэссили н Ажжер
UWIG/OPNT

- (ii) Дэлхийн ямар нэг соёлын хүрээнд болон тодорхой цаг хугацааны туршид уран барилга, технологи, сүрлэг баримал, хот төлөвлөлт, байгалийн дурсгалт газрын хөгжил дөх хүн төрөлхтний үнэт зүйлийн онцгой чухал харилцан нөлөөллийг илтгэн харуулсан байх



Гэрэл зураг



- (iii) Одоо байгаа болон үгүй болж байгаа соёлын уламжлал соёл иргэншлийн хосгүй гэрч юмуу наад зах нь онцгой чухал жишээ байх

Дөнмаркийн Желлин Моундс
эртний хадны бичээс ба сүм
ЮНЕСКО

- (iv) Хүн төрөлхтний түүхийн чухал үеийг илтгэн харуулсан барилга, уран барилга, технологийн цогцолбор үзэсгэлэнт байгалийн хосгүй жишээ болох



Гэрэл зураг



Гэрэл зураг

(v) Тодорхой соёлыг, ялангуяа анхныхаа байдалд хэзээ ч орохооргүйгээр өөрчлөгдөн маш эмзэг болсон соёлыг төлөөлсөн хүний уламжлалт амьдрал, ахуй, газар ашиглалтын хосгүй үлгэр жишээ болох



Гэрэл зураг

(vi) Дэлхий дахины нийтлэг бөгөөд хосгүй ач холбогдол бүхий үйл явдал юмуу амьд уламжлал, үзэл санаа, сүсэг бишрэл, урлагийн болон уран зохиолын бүтээлүүдтэй шууд юмуу илт байдлаар холбогдсон байх /ДӨ-ийн Хороо нь ДӨ-ийн жагсаалтад зөвхөн онцгой тохиолдолд соёлын ба байгалийн бусад шалгууруудтай холбоотой байх үед энэ шалгуураар сонгон шалгаруулна гэж үздэг./

Соёлын өвийн эх төрх байдлаа хадгалсан байдал, түүний хадгалалт хамгаалал болон менежмент нь нэгэн адил ач холбогдолтой.

▲ ДӨ-ийн байгалийн дурсгалт газруудыг сонгон шалгаруулах шалгуурууд

Удирдамжид ДӨ-ийн байгалийн дурсгалт газруудыг сонгон шалгаруулах 4 шалгуурыг оруулсан байна.



(i) Амьд байгалийн он цагийн түүх, газар дэлхий хэлбэржин хөгжих болон ач холбогдол бүхий геоморфик буюу физиографикийн шинжүүдийн геологийн чухал үйл явцууд зэрэг манай газар дэлхийн түүхэн дэх гол гол үеүүдийг төлөөлөн харуулсан хосгүй гайхамшигт үлгэр жишээ болохуйц

Германы Месселийн амьтдын чулуужсан орд газар ЮНЕСКО

Велизийн усан доорх хадан хана ЮНЕСКО

(ii) Хуурай газар, цэвэр ус, эрэг орчмын ба далай тэнгисийн экосистем болон амьтан, ургамлын аймгийн хөгжин хувьсах байгалийн ба биологийн онцгой чухал үйл явцыг төлөөлөн харуулсан хосгүй гайхамшигт жишээ болохуйц



(iii) Байгалийн онцгой үзэсгэлэнт байдал болон гоо сайхны ач холбогдол бүхий газар нутаг ба байгалийн гоц үзэгдлийг агуулсан байх

(iv) Биологийн төрөл зүйлийн өлгий нь болохын хувьд тэдгээрийг хадгалж хамгаалахад чухал ач холбогдолтой байгалийн газар нутгийг хамруулна. Үүнд шинжлэх ухаан болон хадгалж хамгаалах үүднээс аюулд учраад байгаа дэлхийн хосгүй гайхамшигт үнэт зүйл болсон төрөл зүйлүүдийг мөн оруулна. орно.

Байгалийн өвийн бүрэн бүтэн байдлыг хадгалах болон түүний хадгалалт хамгаалалт, менежмент нь нэгэн адил ач холбогдолтой.

▲ Соёлын ба байгалийн хосолмол ДӨ-ийн дурсгалт газруудыг сонгон шалгаруулах шалгуурууд

Соёлын болон байгалийн хосолмол ДӨ-ийн дурсгалт газрууд нь байгалийн ба соёлын хосгүй гайхамшигт үнэ цэнийг хоёуланг нь багтаасан байдаг. Тиймээс соёлын ба байгалийн өвийн шалгууруудыг



Гэрэл зураг



Гэрэл зураг

аль алиныг нь харгалзан Дө-ийн жагсаалтад оруулна. Одоогийн байдлаар ДӨ-ийн жагсаалтад орсон 23 байгаль ба соёлын хосолмог дурсгалт газрууд байна. (Жишээ нь, Шведийн Лапонианы газар нутаг, Перу улсын Мачу Пикчугийн Түүхэн Дархан цаазат газар байна.)



Товч
тодорхойлол

▲ Шалгууруудыг хэрэглэх нь

ДӨ-ийн жагсаалтанд хэтэрхий олон газар бүртгэх буюу улс орны бүртгүүлэхийг хүсэж буй бүх газруудыг оруулсан энгийн нэг жагсаалт болгохгүйн үүднээс шалгуурыг хатуу чанд баримталдаг.

Бүх улс орон өөрийн үндэсний бахархал болсон орон нутгийн болон үндэсний түүх соёлын дурсгалт газруудтай байдаг. Конвенц нь тэдгээр улс орнуудад өөрсдийнхөө өвийг олж тогтоох ба ДӨ-ийн жагсаалтад орсон ч ороогүй ч тэднийг хадгалж хамгаалахад нь тусалдаг.



Дэлхийн Өе ба
түүнийг таньж
тогтоох нь

■ Сурагчийн гүйцэтгэх ажил 8



ДӨ-ИЙН ДУРСГАЛТ ГАЗРУУДЫН ГАЗАРЗҮЙН БАЙРШЛЫГ ТОГТООХ

Зорилго: ДӨ-ийн дурсгалт газруудын газар зүйн байршил, төрөл ангийг нь сурч мэдэх



Судалгаа



Ангийн ажил



Хичээлийн хэд хэдэн цаг



Газар зүй, Нийгэм судлал



"ДӨ-ийн дурсгалт газруудын газарзүйн Байршлыг тогтоох" сурагчийн гүйцэтгэх Ажил товч тодорхойлолт, ДӨ-ийн байршлийн газрын зураг, фото зураг

□ Боломжтой бол сурагч бүрт сурагчийн дасгал ажлын хуудсыг хувиалан өгч, ажиллуул.


□ Сурагчид 1-10 хүртэл доор жагсаасан ДӨ-ийн дурсгалт газруудыг газрын зураг дээр олж тэмдэглэн, соёлын, байгалийн, эсвэл байгаль соёлын хосолмол дурсгалт газрын аль нь болохыг тодорхойл.

□ Даалгавараа хэр зэрэг хийснийг шалгахын тулд сурагчид харилцан солилцож болно. Ангиараа даалгаврыг хэр сайн гүйцэтгэсэн бэ? Даалгаварыг сайн гүйцэтгэсэн сурагчдыг Патримонитогийн зураг зэрэг зүйлээр урамшуул.

2-3 долоо хоногийн дараа газрын зураг дээр 10 дурсгалт газрыг нэмэгдүүлэх замаар уг дасгалыг давтан хий. Энэ дасгалыг хэд хэдэн удаа давтан хийлгэж болно.

Хариулт

- | | |
|------------------|--|
| 1. Чили | Рапа Нуйн Үндэсний парк /Зүүн арал/ |
| 2. Куба | Хуучин Гавана ба түүний бэхлэлтийн хана |
| 3. Мексик | Ел Визкайногийн халимын дархан цаазат газар |
| 4. Гана | Хэрэм цайз, Волта Агуу Асра, Төв ба баруун бүс |
| 5. Япон | Эртний Киото хотын түүхэн Хөшөө дурсгал /Киото, Ужи, ба Отсу хотууд/ |
| 6. Иордан | Петра |
| 7. Франц | Монт-Сэйнт-Мичел ба түүний Бэй |
| 8. Хятад | Тайшан уул |
| 9. Танзанийн улс | Бүгд Найрамдах Серенгетийн Үндэсний парк |
| 10. Нигер | Айр ба Тенерийн Үндэсний тусгай хамгаалалттай газар |



Нигерийн эгээр мандлын байгалийн тусгай хамгаалалттай газар IUCN

Сурагчийн дасгал ажлын хуудас


Дэлхийн газрын зураг дээр ДӨ-ийн жагсаалтад орсон 10 дурсгалт газрыг тэмдэглэсэн.

Сурагчид хавсрагасан газрын зураг дээр өгөгдсөн ДӨ-ийн дурсгалт газруудын жагсаалтыг /1-10/ тохируулах ба тэдний нэр, газарзүйн байршил болон соёлын, байгалийн эсвэл байгаль соёлын хосолмол дурсгалт газрын аль нь болохыг тодорхойл.

Үсэг	Тохирох тоон дугаар /1-10/	ДӨ-ийн дурсгалт газрын нэр	Оролцогч орон	Дурсгалт газрын төрөл / соёлын, байгалийн, байгаль соёлын хосолмол
А				
Б				
В				
Г				
Д				
Е				
Ё				
Ж				
З				
И				

Сурагчийн дасгал ажлын хуудас

62



ДӨ-ийн газруудын газарзүйн байршлыг тогтоох

■ Сурагчийн гүйцэтгэх ажил 9

ДӨ-ИЙН ШАЛГУУРЫН ТАЛААР ОЙЛГОЛТ АВАХ НЬ

Зорилго: ДӨ-ийн жагсаалтад дурсгалт газрыг бүртгэх тухай шийдвэр гаргахад хэрэглэдэг шалгууруудыг илүү сайн ойлгох



Дасгал




Ангийн ажил



Хичээлийн ба хэд хэдэн цаг



Газар зүй



“ДӨ-ийн байршлийн газрын зураг, товч тодорхойлолт”

Дурсгалт газруудыг ДӨ-ийн жагсаалтад бүртгүүлэхэд ДӨ-ийн Хорооны баталсан шалгууруудад тэнцсэн байх шаардлагатай.

□ Ангийг жижиг бүлгүүд болгон хувааж, бүлэг бүр нь ДӨ-ийн газрын байршлийн зураг, товч тодорхойлолттой танилцаж, дасгал ажлын хуудасны сул зайд бүс бүсээс нэг газрыг шалгуур нэг бүрээр тодорхойлон бичнэ. /ДӨ-ийн жагсаалтад орсон газруудын ихэнх нь нэгээс дээш шалгууруудаар бүртгэгдсэн Байдаг/

□ Хосолмол газруудын хувьд бүс бүрээс 1-2 газрыг сонгон, газар тус бүрийн нэр, шалгуурыг бичнэ.

□ Гаргасан шийдвэрийнхээ талаар ярилцна.



Товч тодорхойлолт

Сурагчийн дасгал ажлын хуудас


Соёлын дурсгалт газар	Хүний гоц авьяас суу билгээр бүтээгдсэн урлагын гайхамшигт бүтээлийн дээжис байх	Хүн төрөлхтний үнэт зүйлийг харилцан солилцсон үлгэр жишээ байх	Одоо байгаа болон устаж алга болж байгаа соёлын уламжлал, соёл иргэншлийн хосгүй гайхамшигт гэрч нотолгоо болох	Барилга, уран барилга, технологийн цогцолбор, дурсгалт газрын хосгүй гайхамшигт жишээ болох	Уламжлалт амьдрал ахуй, газар ашиглалтын хосгүй гайхамшигт жишээ болох	Уламжлал, үзэл санаа, сүсэг бишрэл, урлагийн болон уран зохиолын хосгүй ач холбогдолтой байх
Африк						
Латин Америк, Карибын тэнгис						
Арабын улс орнууд					Гадамесийн хуучин хот	
Ази, Номхон Дапай						
Европ, Хойд Америк						

64

Байгалийн дурсгалт газар	Дэлхийн түүхэн дэх үндсэн үеүдийг харуулсан байх	Экологийн ба биологийн онцгой чухал үйл явцыг харуулсан байх	Байгалийн хосгүй гайхамшигт гоо үзэсгэлэнг харуулсан байх	Биологийн төрөл зүйлийг хадгалж хамгаалж байдаг чухал, ач холбогдолтой орчин
Африк		Маново-Гоунда Флорис Үндэсний парк / Төв Африкийн БНУ/		
Латин Америк, Карибын тэнгис				
Арабын улс орнууд				
Ази, Номхон Дапай				
Европ, Хойд Америк				

ДӨ-ийн шалгуурыг ойлгож мэдэх нь

Бүс нутаг	Хосолмол газрын нэр	Байгалийн өвийн шалгуурууд /1,2,3,4/	Соёлын өвийн шалгуурууд /1,2,3,4,5,6/
Африк			
Латин Америк, Карибын тэнгис			
Арабын улс орнууд			
Ази, Номхон Далай			
Европ, Хойд Америк	Туркийн Горемын Ундэсний парк болон Харрадосиагийн Рок сайтсийн нутаг	3	1,3,5



Туркийн Горем байгалийн цогцолбор газар ба Каппадосиагийн хад чулуу ЮНЕСКО



■ Сурагчийн гүйцэтгэх ажил 10

СОЁЛЫН БА БАЙГАЛИЙН ДУРСГАЛТ ГАЗРУУДЫН НЭРИЙГ ДЭВШҮҮЛЭХ НЬ

Зорилго: ДӨ-ийн жагсаалтад дурсгалт газрыг бүртгүүлэхээр нэр дэвшүүлэх үйл явцыг сурч ойлгох



Дасгал



Ангийн ажил



1 ба хэд хэдэн хичээлийн цаг



Хэл, урлаг



“Соёлын ба байгалийн дурсгалт газруудын нэрийг дэвшүүлэх нь” сурагчийн дасгал ажлын хуудас, сурагчдад зориулсан зөвлөмж

□ Үндэсний өвийн жагсаалт букуу бүртгэлд орон нутгийн, бүсийн өвийг нэр дэвшүүлэх ажилд бэлтгэхэд анги хамт олныг оролцуулах зорилгоор сурагчийн дасгал ажлын хуудас болон зөвлөмжийг ашигла.

□ Сурагчдийг бүлгүүд болгон хувааж, бүлэг бүр орон нутгийн нэг газрын нэрийг дэвшүүлнэ.

□ Нэр дэвшигдсэн газруудын танилцуулгыг ханын зурагт хуудас, эмхэтгэсэн товхимол хэлбэрээр гаргаж болно. Товхимолын хуулбарыг сурагчдын мэндчилгээний хамтаар орон нутгийн болон бүсийн удирдлагуудад хүргүүлнэ. Мөн Үндэсний Өвийн Хороонд хандаж гарсан саналыг хамтад нь явуулна.



Сурагчийн
гүйцэтгэх
ажил 11

Сурагчдад зориулсан заавар

Үндэсний Өвийн жагсаалт буюу бүртгэл дансанд оруулахаар өөрийн орон дахь дурсгалт газрын нэрийг дэвшүүлэх

Танай улс үндэсний соёлын болон байгалийн дурсгалт газруудынхаа жагсаалтыг гаргахаар шийдвэрлэжээ гэж бодье. Танай ангийнхан энэ жагсаалтад орон нутгийнхаа нэг буюу хэд хэдэн соёлын болон байгалийн дурсгалт газрын нэрийг дэвшүүлэх ёстой. Энэ ажил нь хичээлээр буюу хөтөлбөрөөс гадуурх нэмэлт ажлын хэлбэрээр явагдана. /дурсгалт газруудаар аялах/

Нэр дэвшүүлэхэд бэлтгэх заавар

Нэр дэвшүүлэх ажилд бэлтгэхэд дор дурьдсан зүйлийг авч үзэн хавсралтад байгаа маягтийг ашиглах:

Тодорхойлолт гэсэн нүдэнд:

- дурсгалт газрын тодорхойлолт ба түүний гол шинж чанаруудын жагсаалт /байгалийн үзэсгэлэнт газрын хувьд шувуу, мод, ургамал амьтны төрөл зүйл, соёлын дурсгалт газрын хувьд барилга, археологийн төрөл зүйлүүд/
- дурсгалт газрын түүх
- байршлын газрын зураг
- фото материалууд /хавсаргана/
- тухайн газрын холбогдолтой мэдээ мэдээллийн гол эх материалыг жагсаасан товч тайлбарын жагсаалт зэргийг бичнэ.

Дурсгалт газрыг үндэсний соёлын болон байгалийн өвийн жагсаалтад оруулах гол үндэслэл гэсэн нүдэнд:

- энэ газрыг үндэсний чухал ач холбогдолтой гэж үзсэн шалтгаан. Хэрэв танай улс үндэсний ач холбогдолтой гэж үзсэн газруудаа шалгаруулах шалгууртай бол түүнийгээ Ашигла.

Дурсгалт газрын хадгалалт хамгаалалт гэсэн нүдэнд:

- газрыг хэн харж хамгаалах үүрэгтэй вэ? Орон нутгийн ард иргэд өөрсдөө хамгаалдаг уу, орон нутгийн, бүсийн, үндэсний байгууллагууд оролцдог уу? Газрыг харж хамгаалж байгаа хүмүүс хэр зэрэг чадварлаг вэ? Тэдэнд хангалттай мөнгө санхүү, арга туршлага байна уу? Энэ газрыг хамгаалах хууль тогтоомж байна уу? зэргийг бичнэ.

Ижил төстэй бусад газруудтай харьцуулах гэсэн нүдэнд:

- танай улс болон бүс нутагт байгаа адил төстэй бусад газруудын талаар тодорхой бичнэ.
- Уг газрын хамгааллын өнөөгийн байдлыг үндэсний бусад ижил төстэй газруудтай харьцуулан тодорхойлно.

Энэ дурсгалт газар нь аврагдаж сэргээгдэшгүйгээр муудаж доройтсон уу? Жишээ нь байгалийн дурсгалт газрын хувьд зарим ургамал амьтны төрөл зүйл нь сөнөж мөхөхийн аюулд хүрсэн үү?

Сурагчийн дасгал ажлын хуудас

Дурсгалт газрын оршдог улсын нэр:.....

Номинацийг бэлтгэсэн хүний нэр:.....

Он сар

өдөр:.....

Дурсгалт газрын нэр:

Дурсгалт газрын газарзүйн байршил:

Дурсгалт газрын тодорхойлолт:

Үндэсний соёлын болон байгалийн өвийн жагсаалтад тус газрыг оруулах үндэслэл:

Ямар шалгууруудаар тэнцсэн:

Дурсгалт газрын хадгалалт хамгаалалт:

Ижил төстэй бусад газруудтай харьцуулах нь:

ДӨ-ийн Хороо ба ЮНЕСКО-гийн ДӨ-ийн Төв



Дэлхийн Өвийн Хороо хуралдаж байгаа нь. R. Milne

Түүх соёлын дурсгалт газруудыг Дэлхийн Өвийн Жагсаалтад оруулан бүртгэх тухай шийдвэрийг Дэлхийн Өвийн Хороо гаргана.

Жилд нэг удаа хуралддаг ДӨ-ийн Хороо нь 4 үндсэн үүргийг гүйцэтгэнэ:

- ДӨ-ийн жагсаалтад бүртгэхийн тулд соёлын ба байгалийн дурсгалт газрыг сонгон шалгаруулах замаар ДӨ-ийг тодорхойлно. Энэ үүргийг гүйцэтгэхэд нь ДӨ-ийн Хороонд **ICOMOS** ба **IUCN** оролцогч орнуудаас ирсэн номинацийг нарийвчлан судлан үзэж, номинац тус бүрд нь үнэлгээний тайланг гаргах замаар туслалцаа үзүүлнэ. **Соёлын өмчийг хамгаалах, сэргээн засварлах судалгааны олон улсын төв /ICCROM/** нь түүнчлэн ДӨ-ийн Хороонд зөвлөгөө өгнө. /жишээ нь, соёлын өвийн сургалт, хамгаалах арга техникийн асуудлаар/
- ДӨ-ийн дурсгалт газруудын хамгааллын үнэлгээний тайланг хянаж үзэх ба оролцогч орнуудад зүй ёсоор хамгаалагдаагүй газруудыг онцгой анхааралдаа авах шаардлагыг тавьдаг.
- Аюулд учраад байгаа ДӨ-ийн газруудын жагсаалтад аюул нүүрлээд Байгаа газруудыг оруулах уу үгүй юу гэдгийг холбогдох оролцогч оронтой зөвлөлдсөний үндсэн дээр шийдвэрлэнэ.
- Дэлхийн Өвийн санг удирдан явуулж, өвөө хамгаалуулахаар хүсэлт гаргасан орнуудад техникийн болон санхүүгийн туслалцаа үзүүлэх, хуваарилах үүрэгтэй.

Конвенцийг хэрэгжүүлэгч нарийн бичгийн дарга нарын газар нь ЮНЕСКО-гоос дэмжлэг авдаг. Үүнийг ЮНЕСКО-гийн Дэлхийн Өвийн Төв гэж нэрлэдэг. Төв нь оролцогч орнуудад Конвенцийн өдөр тутмын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэхээс гадна ДӨ-ийн Хорооны шийдвэрийг хэрэгжүүлж, саналаа гаргадаг.



Харилцах хаягууд



Харилцах хаягууд



■ Сурагчийн гүйцэтгэх ажил 11

ҮНДЭСНИЙ ӨВИЙН ХОРООНЫ ХУРАЛДААН

Зорилго: Өвийн дурсгалт газруудын нэрийг дэвшүүлэх Шийдвэр гаргах үйл явцыг ойлгож мэдэх



Дүрийн тоглолт



Ангийн ажил



Хөтөлбөрөөс гадуурх ажил



Хичээлийн хэд хэдэн цаг



Хэл, газар зүй, Нийгэм судлал

Сурагчийн гүйцэтгэх энэ ажилд сурагчид үндэсний өвийн хорооны гишүүдийн үүргийг гүйцэтгэнэ. Хороо нь сурагчдын санал болгосон орон нутгийн болон бүс нутгийн дурсгалт газруудыг судалж, тэднийг хамгаалах шаардлагатай юу гэдгийг тодорхойлно.

□ Нэг удирдагч, 2 туслах, 1 илтгэгчийг сонгоно. Охид хөвгүүдийн тооны харьцааг тэнцвэржүүлэх хэрэгтэй. Эдгээр 3 сурагч нь ярилцлага бэлтгэх ба хэлэлцүүлгийг удирдаж хөтөлнө.

□ Үлдсэн сурагчдыг бүлгүүдэд хувааж, бүлэг бүр нэг газрыг судалж, хороонд саналаа өгнө. /энэ газрыг хамгаалах буюу үндэсний өвийн жагсаалтад оруулах шаардлагатай юу үгүй юу?/

□ Нэр дэвшүүлсэн маягыг судалж, дараах зүйлүүдийг Тогтооно:

- i. Энэ газар орон нутгийн, бүс нутгийн, үндэсний эсвэл дэлхийн үнэт зүйлийн аль нь болох
- ii. Энэ газар нь хангалттай сайн хамгаалагдаж байгаа эсэх
- iii. Уг газрын талаар хамгаалалтын хуулийн орчин ямар байдаг
- iv. Уг газрыг хамгаалах, удирдах хангалттай төлөвлөгөө байгаа эсэх
- v. Орон нутгийн хүмүүс уг газрын нэрийг дэвшүүлэхэд санал нэгтэй байгаа эсэх

□ Бүлгүүдийн үнэлгээг нээлттэй хэлэлц. Дурсгалт газруудын аль нь үндэсний үнэт зүйл болохыг хэлэлцэнэ. Үндэсний өвийн жагсаалтад ямар газруудыг нэмж оруулах ёстойг шийдвэрлэхийн тулд санал хурааж болно. Дараа нь ДӨ-ийн жагсаалтад эдгээр газруудаас 1-2-ыг оруулах ёстой юу үгүй юу гэдгийг сурагчдаас асуу.



Сурагчийн гүйцэтгэх ажил 10

■ Сурагчийн гүйцэтгэх ажил 12



КОЛУМБЫН МОМПОКС ХОТЫН САНТА КРУЗЫН ТҮҮХЭН ТӨВ

Зорилго: Дурсгалт газрыг ДӨ-ийн жагсаалтанд нэр дэвшүүлэх үйл явцын шат алхмуудын талаар илүү ойлголт авах



Аялал



Ангийн ажил



Хичээлийн хэд хэдэн цаг



Түүх, Газар зүй



Гэрэл зураг, товч тодорхойлолт, ДӨ-ийн байршлын газрын зураг

Дурсгалт газрын нэрийг дэвшүүлэх буюу ДӨ-ийн жагсаалтад бүртгэх үйл явцад хийгдэх алхмуудын талаар сурагчдад илүү ойлголт өгөх үүднээс Колумбиас 1994 онд нэр нь дэвшигдэж, 1995 онд жагсаалтад бүртгэгдсэн дурсгалт газрын тухай авч үзлээ.

□ Дараах мэдээллийг сурагчдад танилцуулна.

ДӨ-ийн жагсаалтад уг газрыг оруулах болсон үндэслэл

Латин Америкд Испаны колончлолын үеэр урлагийн хэд хэдэн хосгүй ололтууд гарсан. Момпокс нь энэ нутагт өөр хаана ч байхгүй өвөрмөц дүр төрхийг илтгэсэн ер бусын гайхамшигт хотын жишээ юм.

Соёлын өвийн зэрэглэл /Конвенцийн 1-р бүлэг/: барилгын цогцолбор

Түүх

Момпоксийг 1540 онд Картаген хотын амбан захирагч Жуан де Санта Круз үүсгэн байгуулж, өөрийнхөө нэрээр нэрлэжээ. Хот нь Магдалено голын эрэг дагуу өргөжин тэлж, худалдаа арилжаа болон материал хангамжийн чухал ач холбогдолтой газар байсан: Картагены боомт ба дотоодын усан замын аялал, түүнчлэн хуурай замын гол чиглэлүүдийн уулзвар болсон юм. Момпокс өргөжин тэлсэн нь колончлогчдын нийгмийн удирдах анги гарч ирсэнтэй холбоотой бөгөөд тэд Индианчуудыг колони дэглэмээр ажиллуулж эзэмшсэн газар нутаг дээрээ өөрсдийн эрх ямбыг тогтоон, Индианчууд өөрийн нутагтаа хөлсний ажилчин мэт ажиллаж байлаа. Ийнхүү Индианчууд өөрийн эзэмшлийн газар нутаггүй болж, хязгаарлагдмал өчүүхэн газарт амьдарч байлаа. Индианчуудын энэхүү хүнд байдал, байгаль цаг уурын хатуу ширүүн, таагүй нөхцөл зэргээс үүдэн тэдний эрхэлж байсан газар тариалангийн аж ахуй нь улам бүр доройтон, эцэст нь алгуур хөгжиж байсан хотын хувьд нийгэм эдийн засгийн бат бэх үндэс суурь нь ганхаж, оршин тогтнох ямар ч баталгаагүй болжээ. Ийм байдал нь түүнчлэн хүн амын доторх үл бүтэх этгээдүүдэд аятай нөхцлийг бүрдүүлж, тэдний амьдралын гол арга зам нь хил давуулан хулгайн наймаа хийж ашиг хонжоо олох явдал болов. Колончлолын үе дэх энэхүү өсөлт нь газар тариалангийн аж ахуй, худалдаа наймаанаас ашиг олж байсан цөөн тооны илүү чинээлэг оршин суугчидтай холбоотой. Картагенаас Момпокст урчууд ирж, хээнцэр орчин, тансаг эдлэлийн хэрэгцээг нь хангадаг байв. Лам хуврагууд болон шашны төлөөлөгчид нь удирдах өөр нэг бүлэг элементийг бий болгожээ.

Удирдлагын менежмент ба хамгаалал

Хуулийн статус: Момпокс нь хувь хүч, байгууллага, Ромын католик сүм болон нутгийн орон нутгийн удирдлагуудын дундын эзэмшлийнх юм. Энэ түүхэн төвийг Үндэсний хөшөө дурсгалын цогцолбор гэж тунхагласан бөгөөд хот нь 1970 оноос хотын захиргааны барилгын журмаар зохицуулагдаж байна.

Удирдлагын менежмент: Түүхэн төвийг удирдах менежментийн төлөвлөгөө байхгүй. Гэхдээ тус нутгийн барилгын тусгай журам болон хотын зохицуулалтын дүрэм журмаар үр ашигтай зохицуулагдаж байдаг.

Хадгалалт хамгаалалт ба эх төрхөөрөө байгаа байдал

Хадгалалт хамгаалалт: Түүхэн төвийг сэргээн засварлах, хамгаалах талаар сүүлийн 10 жилд нэлээд хөрөнгө мөнгөний ажил хийгдсэн бөгөөд бүхэлд нь найдвартай хамгаалалтанд авчээ. Түүнийг эзэмшигчид нь засгийн газрын оролцоогүйгээр найдвартай нөхцөл байдалд хадгалж байгаа өөрсдийн өв хөрөнгөөр ихэд бахархдаг.

Эх төрхөөрөө байгаа байдал: Момпокс нь 19-р зуунд эдийн засгийн чухал ач холбогдлоо алдсан нь Латин Америк дахь энэ маягийн бусад хотуудад нөлөөлсөн энэхүү түүхэн төвийг сэргээн хөгжүүлэх боломжгүй гэсэн үг биш юм. Гудамжны дүр төрх, барилгын материал зэрэг нь хэвээр хадгалагдсаар байна. Түүхэн төв нь хэлбэр, материалын хувьд анхны эх шинж чанараа хамгийн сайн хадгалж чаджээ.

ICOMOS -ын үнэлгээ

ICOMOS 1995 онд Момпокст зочилж, түүнийг соёлын өвийн /4,5/ шалгуурыг үндэслэн ДӨ-ийн бүртгэлд оруулах талаар ДӨ-ийн хороонд зөвлөмж өгсөн.



Колумбын Санта Крузын Момпокс түүхэн төв Н. van Hooff

Түүнчлэн ICOMOS нь Колумбын удирдлагуудад Момпоксыг хамгаалах цаашдын үйл ажиллагааны талаар хэд хэдэн зөвлөмж гаргаж өгсөн. Эдгээр санал зөвлөмжийг ДӨ-ийн хороонд өргөн барьсан бөгөөд барилгын гаднах өнгө үзэмжийг сэргээн засах, сүүлийн үед барьсан зах зээл, худалдаа наймааны газрыг нүүлгэн шилжүүлэх, түүний барилгуудыг буулгах, усан онгоцны буудал, аялал жуулчлалын мэдээллийн төв болгон ашиглах зорилгоор захын барилгыг хадгалж хамгаалах, голын сав газрын усны цэвэр байдлыг баталгаажуулах ажлыг үргэлжлүүлэх, түүхэн төв болоход гудамж, явган замуудыг нэгэн жигдийн

болгох, аялал жуулчлалын нарийвчилсан төлөвлөгөөг гаргах, санал болгосон ДӨ-ийн дурсгалт газрын хойд хил заагийг дахин тогтоох зэрэг асуудлыг хамарсан. ICOMOS нь 1995 оны 7-р сард хуралдсан ДӨ-ийн хорооны товчооны хуралдааны өмнө Колумбын удирдлагаас "Момпоксийг хадгалж хамгаалахад энэ бүх шаадлагыг анхааралдаа авсан" гэсэн

ДӨ-ийн Хорооны товчооны хуралдаан, 1995 оны 7-р сар

Нэр нь дэвшигдсэн тус газар нутгийн хил хязгаарыг шинэчлэн тогтоох ICOMOS-ийн зөвлөмжийн дагуу шинэ төлөвлөгөөг Колумбын удирдлагаас хүлээн авсан тухайгаа ICOMOS Товчоонд мэдэгджээ. Товчоо нь Хороондоо соёлын өвийн шалгууруудыг үндэслэн Санта Крузын Момпоксийн түүхэн хотыг ДӨ-ийн жагсаалтад бүртгэх тухай санал тавихаар шийдвэрлэсэн байна.

ДӨ-ийн Хорооны хуралдаан, 1995 оны 12-р сар

Хороо нь Санта Крузын Момпоксийн түүхэн төв нь голын эрэг дээр баригдсан, стратегийн болон худалдаа наймааны чухал ач холбогдолтой, өнөөг хүртэл унаган төрхөө хадгалж үлдсэн Испаний колончлолын үеийн хот суурингийн гайхамшигт жишээ мөн гэж үнэлээд соёлын өвийн 4, 5-р шалгууруудыг үндэслэн Санта Круз Момпоксийг ДӨ-ийн жагсаалтад оруулахаар шийдвэрлэжээ.

Колумбын удирдлагууд уг газарт аялал жуулчлалын нөлөөг судлах зорилгоор ДӨ-ийн сангаас 30000 ам доллар хүссэн ба ДӨ-ийн хороо уг

Он дарааллын хураангуй

1994	Колумб улс ЮНЕСКО-гийн ДӨ-ийн төвд Момпоксийн нэрийг дэвшүүлсэн
1995 оны 2-р сар	ICOMOS үнэлгээ өгсөн
1995 оны 7-р сар	ДӨ-ийн Товчоо шалгаж үзсэн
1995 оны 12-р сар	ДӨ-ийн Хороо соёлын өвийн 4, 5-р шалгууруудыг үндэслэн Момпоксийг ДӨ-ийн жагсаалтад бүртгэсэн. Хорооноос уг газарт аялал жуулчлалын нөлөөг судлахад зориулж 30000 ам доллар олгов.

Түүхэн дурсгалт газрыг ДӨ-ийн жагсаалтад нэрийг нь дэвшүүлэх, бүртгэх алхмуудын талаар сурагчидтай ярилц. Сурагчидтайгаа хамтран дэлхийн гайхамшигт үнэт зүйл болж чадахуйц орон нутгийн болон үндэсний дурсгалт газруудыг сонгож, сурагчдаар сонгож авсан газраа ДӨ-ийн жагсаалтад бүртгүүлэхэд хийгдэх үйл ажиллагааны төлөвлөгөө гаргуул.

Дүгнэлт

Оролцогч орнууд нь ДӨ-ийн жагсаалтад оруулах газруудын нэрийг дэвшүүлэхдээ урьдчилсан жагсаалт гаргаж, нэр дэвшүүлэх маягт материалыг бүрдүүлж, ЮНЕСКО-гийн ДӨ-ийн төвд явуулна. ICOMOS болон IUCN номинацид үнэлгээ дүгнэлт өгч, зөвлөмж гаргана. ДӨ-ийн Хороо дурсгалт газрыг жагсаалтад бүртгэх тухай эцсийн шийдвэрийг гаргана. Дурсгалт газрыг ДӨ-ийн жагсаалтад бүртгэх шийдвэр гаргахад сонгон шалгаруулалтын хатуу шалгууруудыг ашиглана. Нэмж хэлэхэд, дурсгалт газар нь сайтар хамгаалагдсан байх ёстой бөгөөд соёлын дурсгалт газрууд нь жинхэнэ эх төрх байдлаа, байгалийн дурсгалт газрууд нь унаган төрх, бүрэн бүтэн байдлаа хадгалж үлдсэнээрээ сорил шалгуурт тэнцэх ёстой.

ДӨ-ийн газруудын хамгааллын байдалд хяналт шалгалт явуулах

ДӨ-ийн хадгалалт хамгаалалт нь байнгын үргэлжлэх үйл явц юм. Конвенцид оролцогч улсууд, IUCN, ICOMOS зэрэг нь ДӨ-ийн газруудыг хамгаалж байгаа байдал, тэдгээрийг хамгаалах талаар авч байгаа арга хэмжээ, соёлын ба байгалийн өвийн үнэт зүйл, тэдгээрийг хамгаалахад олон нийтийн ухамсрыг дээшлүүлэхэд тавьж буй хүчин чармайлт зэргийн талаар ДӨ-ийн хороонд тогтмол мэдээлж байдаг.

Оролцогч орнууд өөрийн хүлээсэн үүрэг хариуцлагаа сайн ухамсарлаж байгаа нь практик үйл ажиллагаанаас харагдаж байна. Хэрэв оролцогч аливаа улс нь Конвенцид заасан үүргээ биелүүлээгүй буюу ДӨ-ийн жагсаалтад орсон газарт ноцтой аюул учирсан тохиолдолд тэр газрыг жагсаалтаас хасах шаардлагатай болдог. Ийм маягаар Конвенц нь тодорхой шийтгэлийг хүлээлгэнэ. Одоогоор жагсаалтаас хасагдаж байсан газар гараагүй.

ЮНЕСКО нь ДӨ-ийн дурсгалт газарт аюул учирч болохыг сэрэмжлүүлэн тогтоож, энэ сэрэмжлүүлэг нь үндэслэл сайтай бөгөөд учирч буй аюул нь ихээхэн ноцтой тохиолдолд Аюулд ороод байгаа ДӨ-ийн дурсгалт газрын жагсаалтад оруулдаг. Энэ жагсаалт нь дурсгалт газрыг жагсаалтад оруулахад гол үндэслэл нь болж байсан шинжүүдэд нь аюул учруулж байгаа байгалийн буюу хүний үйл ажиллагаанд дэлхий нийтийн анхаарлыг хандуулахад чиглэгддэг юм. Энэ жагсаалтад орсон аюулд ороод байгаа дурсгалт газруудыг хамгаалахад онцгой хүчин чармайлт гаргах шаардлагатай байдаг.

Зөвхөн дайн самуун дэгдэх зэрэг онцгой бөгөөд зайлшгүй тохиолдолд /жишээ нь: Дубровник 1991/ ДӨ-ийн хороо Конвенцид оролцогч улсаас албан ёсны хүсэлт шаардлагыг хүлээн авалгүйгээр аюулд өртөж болох газруудын жагсаалтыг гаргана.

▲ Аюулд ороод байгаа ДӨ-ийн дурсгалт газруудын жагсаалт

Дурсгалт газрыг аюулд ороод байгаа ДӨ-ийн дурсгалт газруудын жагсаалтад оруулах явдал нь ДӨ-ийн жагсаалтад оруулахад чухал үндэслэл нь болж байсан үнэ цэнэд нь аюул тулгараад байгаа газруудад дэлхий нийтийн анхаарлыг хандуулах буюу түүнийг хамгаалах зайлшгүй шаардлагатай үйл ажиллагаа явуулахад чиглэгдсэн юм.

Аюулд ороод байгаа ДӨ-ийн дурсгалт газруудын жагсаалт

Конвенцийн 11-р бүлэгт /4/ заасны дагуу ДӨ-ийн хорооноос 35 газрыг ДӨ-ийн аюулд ороод байгаа дурсгалт газруудын жагсаалтад оруулахаар шийдвэрлэжээ. Энэ жагсаалт 2003 оны 8-р сар хүртэл хүчинтэй байна.

Афганистан	Бамиан хөндийн соёлын дурсгалт газар ба архиологийн үлдэц Минарет ба Жамын археологийн үлдэц
Албани	Бутринти
Алжир	Тираса
Азербайжан	Баку ханат хот, Ширваншахын ордон, Майдэн цамхагийн хамт
Бенин	Абомэйн Хааны Ордон
Африкийн БНУ	Маново-Гоунда Сейнт гудамж Фпорисын Үндэсний парк
Гован	Дархан цаазат Нимба уул Комое Үндэсний парк
Конгийн Ардчилсан улс	Вирунгийн Үндэсний парк Гарамбын Үндэсний парк Кахузи- Биегийн Үндэсний парк Окапи байгалийн дархан цаазат газар Салонгийн Үндэсний парк
Эквадор	Сангэйн Үндэсний парк
Египт	Абу Мена
Етиоп	Симений Үндэсний парк
Герман	Кологн Кафедрал
Гвени	Байгалийн Дархан Цаазат Нимба уул
Гондурас	Рио Платаны шим мандлын дархан цаазат газар
Энэтхэг	Манас байгалийн дархан цаазат газар Хампийн цогцолбор хөшөө дурсгал
Ирак	Ашур
Иерусалем	Иерусалемийн эртний хот ба түүний хана
Мали	Тимбукти
Непал	Катманду Хөндий
Нигер	Агаар ба тенерийн байгалийн дархан цаазат газар
Пакистан	Лахорын цайз ба Шаламарын цэцэрлэг
Перу	Чан Чаны археологийн бүс
Филиппин	Филиппинны Кордилерасын цагаан будааны дэнж
Сенегаль	Джоуж Үндэсний шувууны дархан цаазат газар
Тунис	Ичкейлийн Үндэсний парк
Танзаны БНУ	Килва Кисиваний ба Сонго Мнарагийн үлдэц туурь
АНУ	Евергладесийн Үндэсний парк
Иемен	Забидын түүхэн хот

75



Ардчилсан Бүгд Найрамдах Конго Улсын Вирунгагийн Үндэсний парк ЮНЕСКО/ INCAFO/ G. Grande



Сурэгчийн гүйцэтгэх ажил 13

АНУ-д байдаг Елоустон нь ДӨ-ийн аюулд учирч буй дурсгалт газруудын жагсаалтад орсноор түүнд учирч буй аюул улам бүр ноцтой болж байгаа үед паркийг зайлшгүй хагаалахад үндэсний болон олон улсын анхаарлыг чиглүүлж чадсан тод жишээ юм.



■ Сурагчийн гүйцэтгэх ажил 13

АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН ЕЛОУСТОН

Зорилго: Дурсгалт газрыг ДӨ-ийн жагсаалтанд нэр дэвшүүлэх үйл явцын шат алхмуудын талаар илүү ойлголт авах



Аялал



Ангийн ажил



Хичээлийн хэд хэдэн цаг



Хэл, газарзүй Шинжлэх ухаан



Гэрэл зураг, товч тодорхойлолт, ДӨ-ийн байршлын зураг

Сурагчдад дараах мэдээллийг танилцуул.

Он дарааллын түүх

- 1973 АНУ ДӨ-ийн конвенцид нэгдэн орсон анхны улс болсон.
- 1978 Елоустон- дэлхийн анхны үндэсний парк- ДӨ-ийн жагсаалтад орсон эхний 12 дурсгалт газрын нэг болсон.
- 1978 Елоустон- дэлхийн анхны үндэсний парк- ДӨ-ийн Жагсаалтад анх бүртгэгдэж байсан 12 газрын нэг болсон.
- 1995 ДӨ-ийн Хороо тус газрыг ДӨ-ийн аюулд учраад буй дурсгалт газруудын жагсаалтад оруулах шийдвэр гаргасан.

Елоустон ДӨ-ийн үнэт зүйл болох нь

Елоустон Виомины баруун хойд хэсэгт өргөн уудам газар нутгийг эзлэн Монтана Идахо мужуудтай хил зааглан оршино. Парк үндсэндээ шатаж тундас болсон хад чулуу бүхий жижиг хэмжээний галт уулын тавцан юм. Энэ нь хэд хэдэн сонирхол татсан гүнзгий ангалууд болон хүрхрээтэй. Удаан хугацаагаар үргэлжилсэн галт уулын идэвхжилтийн улмаас тэнд 10000 халуун рашаан, халуун булаг шанд үүсч, арвин баян ус унднаас ундаалсан амьтан ургамлын баялаг ертөнц бий. Паркийн төв хэсэгт дэлхий дээр хамгийн том Индонезийн Кракатад байдгаас 10 дахин том галт уулын тогоо байдаг. Бүр хуучны цохио нь 2.7 тэр бум жилийн өмнөх үеийнх бөгөөд хамгийн залуу нь өнөөдөр ч хэлбэр дүрсээ олсоор байна. Тогоон дотор 27 хэсэг газар чулуужсан ой байдаг.

Сөнөж мөхөхийн аюулд тулгараад байгаа ховор амьтад

Парк нь хүрэн баавгай, уулын арслан, халзан бүргэд, ганцхан үлдсэн чонын сүрэг зэрэг аюулд тулгараад байгаа амьтны төрөл зүйлийг авран хамгаалах аюулгүй орчныг бүрдүүлсэн төгс төгөлдөр байгалийн цогц газар нутаг болж байдаг юм.



Америкийн
Нэгдсэн
Улс, Елоустон
/Шар чулуут/
ЮНЕСКО

Елоустонд тулгарч буй аюул

1995 оны 2-р сард ЮНЕСКО-гийн ДӨ-ийн төвд паркт учирч байгаа олон янзын аюулын талаар, ялангуяа уул уурхайн ажил явуулах санал, түүнээс гадна ой мод ихээр сүйтсэн, аялал жуулчлалын нөлөө, зэрлэг амьтдыг хамгаалах бодлого зэргээс үүдэлтэй аюулын талаар мэдээлсэн байна.

1995 оны 7-р сарын ДӨ-ийн Товчооны 19- р чуулган

1995 оны 7-р сард ЮНЕСКО-ийн төв байранд болсон ДӨ-ийн товчооны хуралдаан дээр АНУ албан захидал танилцуулжээ. Энэхүү

захидалдаа Елоустонд учирч болзошгүй аюулуудын талаар дурьдаад, ДӨ-ийн хороо болон IUCN н төлөөлөгчдийг паркийн нөхцөл байдалд хяналт шалгалт хийлгэх зорилгоор урьж, мөн тус газрыг ДӨ-ийн аюулд учирч буй дурсгалт газруудын жагсаалтад оруулах тухай авч хэлэлцэхийг ДӨ-ийн Хороонд санал болгожээ.

Елоустоны ойролцоо уул уурхайн ажил явуулах саналын эсрэг дуу хоолой

Уул уурхайн ажил явуулах гээд байгаа нь Америкийн паркийн системийн сор болсон үнэт зүйлд учрах ноцтой аюул юм. "Нью-Йорк Таймс" Энэхүү үйл ажиллагааг явуулах нь Елоустон д учраад байгаа аюулыг өчүүхэн төдий ч нимгэлэхгүй.

Билл Клинтон, АНУ-ын ерөнхийлөгч

Энэ онцгой газрын эзний хувьд америкчууд нь зөвхөн өөрийн иргэдийн төлөө бус, дэлхий нийтийн зон олны төлөө, зөвхөн өнөө үеийнхний төлөө бус, дараа дараачийн үеийнхний төлөө түүнийг хамгаалах үүрэг хариуцлагыг хүлээх ёстой.

Лүндэсний Парк ба Хамгааллын холбоо, 1995 оны 9-р сар/

Хяналт шалгалтын хамтарсан арга хэмжээ , 1995 оны 9-р сар

Тус газар 1995 оны 9-р сард хамтарсан хяналт шалгалтын арга хэмжээ явагдав. Арга хэмжээний үеэр олон нийтийн хэлэлцүүлгүүд зохиогдож, аж үйлдвэрийн, засгийн газрын болон хүрээлэн буй орчныг хамгаалах байгууллагын хүмүүс илтгэл тавьсан.

ДӨ-ийн Хорооны 19-р чуулган, 1995 оны 12-р сар

Оролцогч орон болох АНУ ба IUCN 1995 оны 12-р сард болсон ДӨ-ийн Хорооны хуралдаандээр шалгалтын дүнг илтгэжээ. Уул уурхайн том хэмжээний төсөл хэрэгжүүлэх, дамжуулах хоолой цоорсноос ус бохирдсон, эмх замбараагүй овоолсон хог хаягдал, зам барих, аялал жуулчлалын ачаалалд дарагдах, хулд загас зэрэг ховор амьтдын тоо цөөрөх, одос үхрийн бруселлоиозын халдвар өсөх зэргээс уг газарт учирч байгаа аюул улам бүр ноцтой болж байгаа нь харагдаж байлаа.

Удаан хугацаагаар хэлэлцсэний дараа одоогийн нөхцөл байдлыг болзошгүй эрсдлийн хамт харгалзан үзэж ДӨ-ийн хорооноос Елоустоны паркийг ДӨ-ийн аюулд учирч буй дурсгалт газруудын жагсаалтад оруулахаар шийдвэрлэсэн байна.

АНУ-ын ерөнхийлөгчийн мэдэгдэл 1996 оны 9-р сар

Ерөнхийлөгч уул уурхайн ажлын талаар нааштай шийдвэрт хүрэхийн төлөө хүчин чармайлт гаргахаа олон нийтэд мэдэгдлээ.

ДӨ-ийн Хорооны 20-р чуулган, 1996 оны 12-р сар

АНУ ын төлөөлөгч Елоустоны паркийг хамгаалах талаар маш чухал ахиц дэвшил гарч байна хэмээн мэдэгдлээ.

Цаашид хэрхэх вэ?

Энэхүү ДӨ-ийн дурсгалт газрын хамгааллыг баталгаажуулах үүднээс Хороо байгаль орчны нөлөөллийг судлах болон хамгаалах ажлын үр дүнгийн талаар тогтмол илтгэж байхыг хүссэн. Ийм байдлаар тус газрын хамгаалал, нөхцөл байдал ДӨ-ийн Хорооны байнгын анхааралд байх юм. Цаашид



Аюулд учраад буй Елоустон: Америкийн Нэгдсэн Улс, Елоустон ЮНЕСКО/ M. Spier- Donati

хэрэв Елоустоны паркийг хамгаалах ажлын үр дүнд ДӨ-ийн Хороо сэтгэл ханамжтай байсан тохиолдолд түүнийг аюулд учирсан ДӨ-ийн газрын жагсаалтаас гаргах асуудлыг шийдвэрлэж болох юм. Аюулд учирч байгаа ДӨ-ийн жагсаалтад орсон үндэсний гайхамшигт парк Елоустоныг хамгаалах үйлсэд Америкийн ард түмэн, ерөнхийлөгч болон

■ Сурагчийн гүйцэтгэх ажил 14

ДӨ-ИЙН ТУХАЙ РАДИОГИЙН НЭВТРҮҮЛЭГ ХИЙХ

Зорилго: ДӨ-ийг хадгалж хамгаалахын төлөө холбоо харилцаа байгуулах чадварыг сайжруулах



Дасгал



Ангийн ажил ба хөтөлбөрөөс гадуурх ажил



Хичээлийн хэд хэдэн цаг



Хэл, хөгжим



Товч тодорхойлолт, ДӨ-ийн байршлын газрын зураг



Номдүрс бичлэгийн хуурцаг гэх мэт

□ Сурагчдыг бүлгүүдэд хувааж, ДӨ-ийн сэдвээр хийх радиогийн нэвтрүүлэгийн хөтөлбөрийг төлөвлө. Хөтөлбөрт:

ДӨ-ийн жагсаалтад орсон газруудыг дэмжсэн буюу үгүйсгэсэн сурагчид хоорондоо ярилцах
ДӨ-ийн жагсаалтад орсон газрын чухал ач холбогдол, байршил болон үзэсгэлэнт байдлыг нь тодорхойлох
Шүлэг, яруу найргаас ДӨ-ийн газруудын талаар ишлэл татах
ДӨ-ийн газрыг магтан дуулсан дуу хөгжим /байгаль, ан амьтан, ерөөл, магтаал, / зэргийг оруулна.



□ Анги хамт олны тоглолтоос авч болох шинэ сайхан санааг сайшаан дэмжиж, улам боловсронгуй болгон хөгжүүл. Бүлгүүдэд даалгавар хуваарилан өгч, хөтөлбөрөө хальсанд бичиж, бичлэгийг орон нутаг, бүс болон үндэсний радиод явуул.

▲ Дэлхийн Өвийн Сан

Конвенцийн нэг томоохон ололт бол ДӨ-ийг хамгаалах талаар хэрэгжүүлэх төслийг санхүүжүүлэхэд ДӨ-ийн сангаас олон улсын дэмжлэг туслалцаа үзүүлдэг явдал юм.

ДӨ-ийн сан нь ДӨ-ийн дурсгалт газрын муудан доройтох шалтгааныг тогтоох, улмаар арилгах талаар туршилтын судалгаа явуулах, хамгаалах ажлыг төлөвлөх, байгалийн үзэсгэлэнт газрыг хамгаалах, хөшөө дурсгалыг сэргээхэд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх, техникийн шинэчлэл хийх буюу өв хамгаалах чиглэлээр орон нутгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулах гэх мэт техникийн хамтын ажиллагаа, төрөл бүрийн дэмжлэг туслалцаа үзүүлэхэд зориулагдана.



Дэлхийн Өвийн
Конвенц

Түүнчлэн энэхүү сангаас соёлын болон байгалийн өвийн урьдчилсан санал гаргах, ДӨ-ийн жагсаалтад нэрийг нь дэвшүүлэх зэрэг үндэсний үйл ажиллагаанд тусламж үзүүлнэ. Хороо буюу ерөнхий захирал нь хүссэн дэмжлэг туслалцааны төрөл болон хэмжээнээс шалтгаалж, оролцогч аль ч улсад дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

Нэн тэргүүнд онцгой хамгаалалт хийх шаардлагатай болон аюулд учирсан ДӨ-ийн жагсаалтад орсон газруудыг хамгаалахад санхүүжилт хийнэ.

ДӨ-ийн Конвенциор 1972 онд байгуулагдсан ДӨ-ийн санг өөрийн орлогын дийлэнх хувийг гишүүн орнуудаас ЮНЕСКО-д төлдөг хандивын нэг хувь, түүнчлэн сайн дурын хандиваас бүрдүүлдэг. Орлогын бусад эх үүсвэр гэвэл улс орнуудын тусгай зориулалтын хандив, ДӨ-ийн хэвлэл нийтлэлээс олох ашиг зэрэг болно.

Жилд орж ирэх мөнгөний нийт дүн нь дөнгөж 3.5 сая хүрэхгүй шахам ам доллар бөгөөд энэ нь зорилтынхоо гол хэсгийг хэрэгжүүлэхэд л хүрэлцэхүйц юм.

ДӨ-ийн сангийн нөөц нь ДӨ-ийн хорооны хүлээн авсан бүх санал хүсэлтийг санхүүжүүлнэ гэвэл хаана нь ч хүрэхгүй. Гэхдээ сан нь Африк, Ази номхон далайн бүс нутаг, Арабын улс орнууд, Латин Америк, Карибын тэнгис, Европ дахь соёлын болон байгалийн дурсгалт газруудыг хамгаалах хэд хэдэн сая долларын өртөг бүхий чухал төслүүдийг санхүүжүүлсэн юм.

Хэрэв та болон танай сурагчид ДӨ-ийн санд хандив өргөж ДӨ-ийн хамгаалалд оролцохыг хүсвэл дараах банкуудад олон улсын мөнгө тушаах буюу банкны гуйвуулга хийж болно.

80

Хэрэв гуйвуулга Америк доллараар хийгдвэл:



Сурагчийн
гүйцэтгэх
ажил 15

UNESCO Account N 949-1-191558
CHASE JP MORGAN BANK
International Money Transfer Division
4 Metrotech Center, Brooklyn
NEW YORK
NY 11245, United States of America
SWIFT Code: CHASUS 33-ABA N 0210-0002-1

Еврогоор гуйвуулга хийвэл дараах ЮНЕСКО-гийн банкд шилжүүлнэ:

UNESCO A/C No. 30003-03301-00037291909-97
SOCIETE GENERALE
Paris Seine Amont
10 rue Thenard
75005 PARIS, France
SWIFT code: SOGEFRPPAFS

Өөрийн сургуулийн нэр хаяг болон ДӨ-ийн санд хандив илгээж байгаа тухайгаа бичээрэй.

■ Сурагчийн гүйцэтгэх ажил 15



УХАМСАР ОЙЛГОЛТЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ

Зорилго: ДӨ-ийн хадгалалт хамгаалалтад сурагчдын идэвхтэй оролцоог хангаж эв нэгдлийг дэмжих



Ярилцлага



Ангийн болон
хөтөлбөрөөс
гадуурх
арга хэмжээ



Хичээлийн
хэд хэдэн
цаг



Хэл




ДӨ-ийн байршлын
газрын зураг,
товч тодорхойлолт

□ Орон нутгийн, үндэсний болон ДӨ-ийн талаар нутгийн ард иргэдэд илүү их ухамсарлуулан ойлгуулахад сурагчид хэрхэн хувь нэмрээ оруулж болох талаар ярилц. Тэдний саналыг жагсааж бич. Эдгээрээс 1 буюу түүнээс илүү санал хэрэгжих боломжтой юу?

□ ДӨ-ийн сангийн зорилгын талаар ярилц.

□ Орон нутгийн болон ДӨ-ийг хамгаалахад туслах зорилгоор санг арвижуулах үйл ажиллагааг зохион байгуулах боломжийн талаар ярилц.





Сэдвийн дүгнэлт: Дэлхийн Өвийн Конвенц

Урлаг

Урлагийн түүхийг заахын тулд ДӨ-ийн гэрэл зураг, мэдээ мэдээллийг ашиглах
ДӨ-ийн газруудын загвар бүтээх
ДӨ-ийн газрууд, тэдгээрийг хамгаалахад олон нийтийн ухамсрыг дээшлүүлэх
зорилгоор сурталчилгааны ажил бэлтгэх
ДӨ-ийн газруудаар аялж, тэдгээрийг зурах, гэрэл зургийг нь авах
Уран барилгын хэв маягийг заахад ДӨ-ийн газруудыг ашиглах

Гадаад хэл

Бусад орны байгалийн ба соёлын өвийн талаарх мэдээллийн ухуулах хуудсыг
унших Бусад орны талаар болон тэдний одоо ба өнгөрсөн үеийн тухай мэдэх
зорилгоор ДӨ-ийн газруудыг судлах
ДӨ-ийн газруудыг хамгаалах зайлшгүй хэрэгцээ шаардлагын талаар өгүүллэг
бичих

Түүх

Түүхэн цаг үеүүдийг илэрхийлж чадах ДӨ-ийн дурсгалт газрууд болон ойр
зэргэлдээх өвийн газруудад зочлох
Тодорхой цаг үеийг судлахдаа тэр цаг үетэй хамааралтай ДӨ-ийн газруудын
талаар мэдэж авах

Хэл/ уран зохиол

Конвенцийн талаар, эсвэл тодорхой нэг ДӨ-ийн газрын талаар ангидаа буюу
сонин хэвлэлд нийтлэл, өгүүллэг бичих
ДӨ-ийн газрын ойролцоох оршин суугчдаас сурвалжлага авч, тус дурсгалт
газрын талаар юу бодож буйг мэдэх
Дурсгалт газрын тухай мэдээллийн ухуулах хуудас бичих
Түүхэн тоглолт хийх
Дурсгалт газрын тухай тууж, богино өгүүллэг бичи

Математик

ДӨ-ийн газрын физик шинж чанарыг /амьтны төрөл зүйлийн тоо, барилгын
хэмжээ/ судлах ба график, бүдүүвч зураг, статистик тоо баримтыг ашиглан үр
дүнг нь графикийн аргаар дүрслэх
Хөшөө дурсгал, барилгын хэмжээ талбайг судалж, загвар гаргах

Шашны сургалт


Янз бүрийн шашин, сүсэг бишрэлтэй холбоотой ДӨ-ийн газруудын зургийг
үзүүлэх

Интернет

ЮНЕСКО-гийн ДӨ-ийн төвийн вэб сайт: <http://www.unesco.org/whc/>
Холбоот сургуулиудын төслийн вэб сайт:
<http://www.unesco.org/education/asp>

ДӨ ба түүнийг танин мэдэж тогтоох нь

Хягагчдын албарт хэрэм. ЮНЕСКО



ДӨ ба түүнийг танин мэдэж болох нь

**"Байшингаа эргэн тойрон ханаар
хүрээлж, бүх цонхоо түгжээд суухыг би
хүсэхгүй. Бүх дэлхийн соёлын салхиар
манай гэр орон аль болох уужим
чөлөөтэй амьсгалж байгаасай гэж би
хүсэж байна. Гэхдээ аль нэг соёл нь
намайг үндэсний хөрснөөс минь
ховхлон хийсгэхийг зөвшөөрөхгүй."**

ДӨ ба түүнийг танин МЭДЭЖ ТОГТООХ НЬ

	Хуудас
Зорилго	85
Мэдлэг	85
Арга хандлага	85
Чадвар	85
ДӨ: танин мэдэ ж тогтоох нь	86
Би хэн, бид хэн гэдгээ танин мэдэх нь	86
Сурагчийн гүйцэтгэх ажил 16: Нэрнээс нь таньж тогтоох нь	87
Эрчимтэй өөрчлөгдөж буй дэлхий ертөнцөд ДӨ-ийг таньж тогтоох нь	87
ДӨ-ийн газрууд ба тэдгээрийг таньж тогтоох нь	88
Сурагчийн гүйцэтгэх ажил 17: ДӨ-ийн газрууд ба тэдгээрийг таньж тогтоох нь	89
Барилгын өвөрмөц хэлбэр маягууд нь ДӨ-ийг таньж тогтоох тэмдэг болох нь	90
Сурагчийн гүйцэтгэх ажил 18: Барилгын өвөрмөц хэлбэр маяг нь ДӨ-ийг таньж тогтоох тэмдэг болох нь	91
Сурагчийн гүйцэтгэх ажил 19: Хотын түүхэн хэсгийн ирээдүйн талаар Хотын Зөвлөлөөс шийдвэр гаргасан нь	92
Сурагчийн гүйцэтгэх ажил 20: Соёлоо харилцан сурч мэдэх нь	93
ДӨ-ийг таньж тогтоох ба нутгийн уугуул иргэд	
Сурагчийн гүйцэтгэх ажил 21: Зимбабын Аугаа их Зимбабын Үндэсний хөшөө дурсгал	94
Сурагчийн гүйцэтгэх ажил 22: АвстралийнУлуру-ката Тжута Үндэсний парк Монголын ОХСДГ ба Увс нуурын Ай сав	96 99
Сэдвийн дүгнэлт: “ДӨ ба түүнийг таньж тогтоох нь”	100

Зорилго



Мэдлэг

- Эрчимтэй өөрчлөгдөн хөгжиж буй дэлхий ертөнцөд тогтвортой хөгжлийг бататган хадгалж байгаа бөгөөд олон төрлийн соёлын илэрхийлэл болсон ДӨ-ийн соёлын болон байгалийн түүхэн дурсгалт газрууд
- Соёл тус бүрийг тодорхойлох онцлог ба соёл бүр нь нийт хүн төрөлхтний соёл иргэншлийн нэг бүрэлдүүн хэсэг болох тухай
- Байгаль болон соёл хоорондын, түүнчлэн соёлууд хоорондын харилцан үйлчлэл, харилцан хамаарал зэргийн талаар мэдлэгээ баяжуулах, ойлголт авахад туслана.

Арга хандлага

- Өөрийн орны соёл, түүх, хүрээлэн буй байгаль дэлхийгээ ойлгож хүндэтгэх
- Өөрсдийн нийгмийн нийтлэг үнэт зүйл болон эдгээр үнэт зүйлсийн үндэс язгуурыг таньж тогтоох
- Бүх ард түмэн, тэдгээрийн соёлыг хүндэтгэх үзлийг түгээж, олон улсын харилцан ойлголцол, хүндэтгэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах үүрэг хариуцлагаа ухамсарлан ойлгоход сурагчдад дэмжлэг үзүүлнэ.

Ур чадвар

- Удам угсаа, гарал үүслээ цаашид судлах /гэр бүлийн, өөрийн орны/
- Асуудлыг ил тод, ардчилсан маягаар хэлэлцэх
- ДӨ-ийн хадгалалт хамгаалалтыг дэмжихэд хүмүүсийг араасаа дагуулах зэрэг чадварыг сурагчдад хөгжүүлэхэд туслана.

Дэлхийн Өв ба түүнийг таньж тогтоох үндсүүд

ДӨ-ийн тухай ойлголт нь бидэнд өөрийн удам угсаа, гарал үүсэл, соёл болон нийгмийнхээ өвөрмөц онцлогыг илүү их танин мэдэж ойлгоход туслах болно. ДӨ-ийн жагсаалтад бүртгэгдсэн ямар нэг газрыг гүнзгий таньж мэдэх нь ард түмнүүдийн шашин шүтлэг, үнэт зүйл, мэдлэгийн өвөөс болон тэрхүү соёлыг өвийг бүтээн бий болгосон юмуу тэрхүү байгалийн, холимог, соёлын дурсгалт өвтэй нягт холбоо бүхий соёл иргэншлийг судалж ойлгоход тустай. Түүнчлэн энэ нь биет болоод биет бус өвийн тухай сурч мэдэх асуудлыг ч хамаарна.

Соёлын болоод байгалийн дурсгалт газрууд нь хүмүүс сэтгэл зүй, шашин шүтлэг, боловсрол, эдийн засгийнхаа хувьд хамаарч байдаг тэрхүү хүрээлэн буй орчинг нь бүрдүүлж байдаг юм. Энэ хүрээлэн буй орчин эвдрэн сүйрч, алсаараа доройтон муудаж байгаа нь бидний өвөрмөц онцлог байдал, улс үндэстнүүд, манай гариг дэлхийг авран хамгаалж, тэсэн гарах үйлсэд хор хөнөөл учруулж болох юм. Бид ирээдүй хойч үеийнхэндээ эдгээр дурсгалт газруудыг хамгаалан үлдээх эрхэм нандин үүрэгтэй.

Норвегийн Бергенхотноо болсон ДӨ-ийн залуучуудын чуулга уулзалтын ДӨ-ийн тангараг

▲ Би хэн, бид хэн бэ гэдгээ таньж тогтоох нь

1. Адил төстэй байхын онцлог чанар, нөхцлүүд; бүх талаар адилхан байх, гол шинжүүдээр адил байх; бусадтай адил биш байх
2. Бодгаль болон бие хүн хувь хүний оршихуй
3. Сэтгэл мэдрэмж, сонирхол болон бусад зүйлээр хэн бэ гэдэг нь таньж тогтоогдсон байх нөхцлүүд

Оксфордын хураангуй товч толь бичиг

Бидний хэн нь ч эхээс мэндэлсэн цагаас эхлэн өөрийн хувь хүний шинж байдлаараа, тухайлбал: бидний эцэг эх, өвөг дээдсээс өвлөгдөж ирсэн генийн болоод бие бялдрын шинжүүдээрээ бусдаас ялгардаг. Жишээ нь: бидний хурууны хээ хувь хүний хээээ ч арилшгүй бусдаас ялгарах өвөрмөц онцлогийг илэрхийлж байдаг. Бидэнд уламжлагдан ирсэн бидний овгийн нэр ба бидний өөрсдийн нэр бол амьдралын явцад өөрчлөгдөж болох боловч биднийг хувь хүний хувьд бусдаас ялгах өвөрмөц онцлогийн салшгүй нэг хэсэг болж байдаг юм.

Бергинд болсон Дэлхийн Өвийн залуучуудын чуулга уулзалтанд оролцогчид үндэсний хувцастайгаа байгаа нь. Норвег, ЮНЕСКО

Гэхдээ өвөрмөц онцлогтой байх нь зөвхөн хувь хүн гэсэн үг биш юм. "Би хэн бэ?"- гэх нь "Бид хэн бэ?" гэдэгтэй гүнзгий холбоотой. "Бид" гэдэг нь жишээ нь нэг угсааны аймаг юмуу үндэстэн эсвэл бидний шүтэж гишүүн нь болж байдаг шүтлэг орно. Нэг бүлгийн гишүүний хувьд бид байгаагийн хувьд бид тус бүлгийн бусад гишүүдтэй хэл, шашин шүтлэг, зан үйл, ёс зүйн хэм хэмжээ, зан заншил, хоол хүнс, хувцас хунар зэргээр хүйн холбоотой. Үндэстний өвөрмөц онцлог нь гол төлөв хэл, үндэсний хувцас, туг дэлбаа, сүлд дуу зэрэг бэлэг тэмдгүүдээр илэрхийлэгдэж байдаг.



■ Сурагчийн гүйцэтгэх ажил 16



ОВОГ НЭР НЬ ХҮНИЙ ӨВӨРМӨЦ ОНЦЛОГИЙГ ХАРУУЛАХ НЬ

Зорилго: Бидний хувийн болон гэр бүлийн өвөрмөц онцлогийг танин илэрхийлэх нь



Судалгаа



Ангийн ажил



Хөтөлбөрөөс гадуурх ажил



Хичээлийн 2 цаг ба сургуулиас гадуурх ажлын цаг



Хэл

□ Эцэг эх, хамаатан садныхаа тусламжтайгаар овог ургийнхаа нэрийн утга учрыг судалж олж мэдэхийг сурагчдаас хүсэх. Мөн өөрсдийнх нь нэрийг хэрхэн өгсөнбуюу /анхны, хоёрдогч/ нэрийнхээ талаар юу бодож явдгаа дараах асуултад хариулж, тайлбарла. Энэ нэр бүс нутагтаа олонтой тохиолддог уу? Энэ нэр бүс нутгийн соёлын болоод байгалийн чухал ач холбогдолтой түүхэн дурсгалт газруудтай ямар нэгэн замаар холбоотой юу? Ер бусын ховор нэр үү? Тодорхой хувь хүн тухайлбал өвөг эцэг, бусад төрөл төрөгсдөөс эсхүл түүхэн хувь хүн, киноны баатрууд зэрэг тодорхой хувь хүнийг бэлэгдэж өгсөн нэр үү? Энэ нэр нь тухайн хувь хүнийг телеелөн илэрхийлж чадах уу? Хэрэв тийм бол хэрхэн илэрхийлж байна вэ?

87

▲ Эрчимтэй өөрчлөгдөн хөгжиж буй дэлхий ертөнцөд өвөрмөц онцлогийг таньж тогтоох нь

Дэлхий ертөнц эрчимтэй өөрчлөгдөн хөгжиж дийлэнх хүмүүс өөрийнхөө удам угсаа гарал үүслээ умартан гээж 21-р зуунд хошууран орж байна. Энд өөр зам байх л учиртай. Гарал үүсэл, удам угсаа, соёлоо бид оршин тогтнохын үндэс суурь хэмээн хүндлэн дээдэлж хүлээн зөвшөөрөх ёстой. Бид ирээдүйгээ цогцлон байгуулах болно.

Хятадын Бээжин хотод болсон ДӨ-ийн залуучуудын чуулга уулзалтанд сурагчдын зөвлөмжөөс

Хувь хүний адил гишүүд нь бид болж байдаг угсаатны бүлэг, үндэстнүүд нь цаг хугацааны эрхээр, хүрээлэн буй байгаль орчин болон хүмүүсийн бусад нийтлэгүүд болон бусад соёлтой харилцан үйлчлэлцсэний үр нөлөөгөөр өөрчлөгдөж байдаг. Энэ их өөрчлөлтийн айзам хэмнэл, эрч хүч нь шинжлэх ухаан, технологийн хувьсгал, ялангуяа орчин үеийн тээвэр, холбоо болон мэдээлэл зүй, телефон, телефакс, телевиз, интернет, хиймэл дагуулын холбоо зэрэг нийтийн харилцаа холбоо хөгжсөнөөр болон "Даяарчлал" гэж хэлэгдэж байгаа үйл явцын нөлөөгөөр 20-р зуунд улам бүр хүчээ авсаар байна.

Даяарчлал нь давын өмнө эдийн засгийн онцгой үзэгдэл гэж үзэж болох боловч цаанаа нийгэм соёлын маш чухал учир холбогдолтой юм. Үүний нэг жишээ бол дэлхийн бараг бүх хэсэгт хүмүүсийн, ялангуяа залуучуудын хувьд нийтлэг тархсан алдартай хөгжим, кино телевизийн нэвтрүүлэг, хувцас хунар, түргэн хоол гэх мэтийн дэлхий нийтэд сурталчлагдсан өргөн хэрэглээний тодорхой бүтээгдэхүүнийг илүүд үзэх, шүтэх хандлага газар авч буй явдал юм.

ЮНЕСКО-гийн 2 үндсэн баримт бичигт соёлын даяарчлалын талаар дурьдсан байдаг.

... Соёл нь аажмаар даяарчлагдаж байгаа хэдий ч одоохондоо бүхэлдээ хамрагдаагүй байна. Бид даяарчлалын сайн сайхныг ч мөн түүнтэй холбогдон гарч болох эрсдлүүдийг ч анзаарахгүй байж болохгүй, хамгийн наад зах нь хүний гайхамшигт язгуур шинж чанаруудыг мартан гээж болох эрсдлийг хайхрахгүй байж болохгүй. Энэ нь баялаг уламжлал соёлоороо дамжуулан өөрсдийн ирээдүйгээ сонгох, нөөц чадамжаа бүрэн дайчлан сурч хөдөлмөрлөхөд тэдэнд өөрсдөд нь хэрэгтэй юм. Бид одооноос анхааралтай хандахгүй бол өнөөгийн өөрчлөлт хөгжлийн явцад тэрхүү үнэт соёл уламжлал нь сөнөж мөхөх аюулд учирч болно.

Сургалт: 21-р зууны боловсролын тухай олон улсын комиссын илтгэл, р. 17. Парис, ЮНЕСКО-гийн хэвлэл, 1996

Энэ нь өнөөдрийн эрчимтэй өөрчлөгдөж хөгжиж буй дэлхий ертөнцөд амьдарч байгаа хувь хүмүүс, нийгэмлэгүүдэд өөрсдийн түүх уламжлалын үнэт зүйлсээ гээхгүйгээр дэлхий нийтээрээ даяарчлагдаж байгаа соёлд дасан зохицоход ач холбогдолтой юм.

Африкийн үндэсний оюуны үнэт зүйл, тухайлбал, уламжлалт шашин нь хүн ба байгаль, материаллаг ба материаллаг бус, оюун ухааны ба зөн совингын, өнгөрсөн ба одоо үеийнхний хоорондын амин чухал шүтэлцээ хамаарлын ач холбогдлыг гүнээ хүндэтгэсэн байдгийг тодорхой харж болно. Энэхүү мэдлэг болон үнэт зүйлсийн их сан нь хүрээлэн буй орчноо авран хамгаалах эсвэл ялгаатай талууд ба зөрчилтэй байдлыг зрхицуулах зэрэг өнөөгийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой.

Бидний бүтээл туурвилын олон төрөл байдал. Соёл болон хөгжлийн Дэлхийн Комиссын илтгэл, р. 166. Парис, ЮНЕСКО-гийн хэвлэл, 1996

ДӨ-ийн газрууд ба тэдгээрийг таньж тогтоох нь

Олон олон улс үндэстэнг ДӨ-ийн жагсаалтад орсон дурсгалт газруудтай нь адилтган тогтоодог ёс бий. Цөөн боловч хэдэн жишээ хэлэхэд: Аугаа их Зимбабвейн балгас туурь бидэнд Зимбабвейн колони өмнөх Африк үндэстнийг санагдуулна. Оросын Холбооны улсыг Москва Кремль, Улаан талбайгаар нь, Италийг Венис ба түүний Лагуун бас Писаг цамхагаар, мөн Флоренс хотоор нь, Ливаныг Баалбек ба Библ, Энэтхэгийг Аграгийн Таж Махал, Гватемалаг Антигва, Узбекистаныг Бухаарын түүхэн төвтэй адилтган нэрлэдэг жишээг дурьдаж болно.

Тодорхой нэг байгалийн дурсгалт газар, тухайлбал АНУ-ын Евергладесийн үндэсний парк ба Гранд Канионы үндэсний парк, Танзаны БНУ-ын



Серентегийн үндэсний парк, Непал дах Сагарматын үндэсний парк, Аргентины лое-Гласиар зэрэг нь бүлгийн буюу үндэсний өвөрмөц онцлог байдлыг илтгэн харуулж байдаг.

Италийн И Сасси ди Матера ЮНЕСКО/М. Молдавану

■ Сурагчийн гүйцэтгэх ажил 17



ДӨ-ИЙН ГАЗРУУД БА ТЭДГЭЭРИЙН ӨВӨРМӨЦ ОНЦЛОГ

Зорилго: ДӨ-ийн газруудын үнэ цэнийг ойлгох



Ярилцлага




Ангийн ажил



Хичээлийн нэг цаг, хөтөлбөрөөс гадуурх ажил



Түүх, Нийгэм судлал



ДӨ-ийн байршлын газрын зураг, товч тайлбар

□ Хүн төрөлхтний болон байгаль хамгааллын түүхэнд чухал үүрэг гүйцэтгэсэн, ДӨ-ийн жагсаалтад орсон зарим нэг дурсгалт газруудыг сурагчдад танилцуулах зорилгоор гарын авлагат өгөгдсөн гэрэл зургууд болон бусад холбогдох материалыг ашигла.

Тухайлбал:

- Ард түмнүүдийг адилтган тодорхойлдог соёлын болон байгалийн дурсгалт газрууд
- Дэлхийн улс төрийн түүхэнд ул мөрөө үлдээсэн Газрууд
- Дэлхийн шашинболон сүсэг бишрэлтэй холбоотой газрууд
- Аж төрөх ёсны янз бүрийн хэв маягийн жишээ болсон газрууд

Ярилцлагад ашиглаж болох загварыг доор өгөв.

	Хүний гарал үүсэл	Ан агнуур болон жимс ургамлаар амьдардаг хүний нийгэм	Хүмүүсийн уламжлалт нийгэм	Газар тариалан эрхлэдэг хүмүүсийн нийгэм	Худалдаа наймаа эрхлэгчдийн нийгэм	Аж үйлдвэрийн ажилчдын нийгэм	Орчин цагийн нийгэм
Ази, Номхон далай	Бээжингийн эртний хүний нутаг			Кордиллерасын Цагаан Будааны дэнж /Филиппин/			
Арабын улс орнууд		Тадрарт Ахакусын Хадны зургийн дурсгалт газар /Ливийн Араб Жамахириа/					
Африк					Мозамбек-ийн арал /Мозамбек/		
Европ, Хойд Америк			Л Сасси ди Матера /Итали/		Любекийн хансийтик хот /Герман/	Жоржийн төмөр гүүр Жорж /Англи/	Баухауз ба түүний Газар /Герман/
Латин Америк ба Карибын тэнгис						Оуро Претогийн түүхэн хот /Бразил/	Бразилиа /Бразил/

Барилгын өвөрмөц хэлбэр маяг нь ДӨ-ийн өвөрмөц онцлогийг танин тодорхойлох илэрхийлэл болох нь

Зарим ДӨ-ийн газруудад байдаг барилгын өвөрмөц сонин хэлбэр маягаас хүн, хүрээлэн буй байгаль хоёрын хоорондын харилцан үйлчлэлийг тод харуулсан онцгой дүр зураг харагдана. Тийм нэг жишээ бол ДӨ-ийн газар болох Норвегийн Бергений Бригген дүүрэг бөгөөд энэ нь Норвегийн модон урлал

Норвегийн соёлын өвөрмөц онцлогийг тодорхойлогч хүчин зүйл хэрхэн болсныг илтгэн харуулдаг юм.



Норвегийн мод Норвегийн соёлд хэрхэн нөлөөлсөн тухай

Норвегийн барилгын материал Норвегийн соёл хоёр хоорондоо ямар нэг харилцан хамааралтай юу?

Норвегийн соёлын өвийн газрын ерөнхий захирал Стефан Тшуди-

90

Норвег.
Соёлын өв.
Хөшөө
дурсгалууд
ба дурсгалт
газрууд.

Мэдсон бичихдээ:

*Эхлээд модоо аваад үзье л дээ. Хамгийн гол шинж нь түүний өндөр юм. Өргөн навчит энэ модны аль нь ч өндөр гоолиг, эгц шулуун ургадаг учраас нэгэн хэв маягийн бат бөх дүнзэн байшин барихад тохиромжтой бат бөх гуалинг түүнээс гарган авч болдог бөгөөд гуалингуудыг хөндлөнгөөр нь хооронд углуурагдаж хийнэ. . . .
Барилгын материал болон хэрэглэгддэг энэхүү өндөр, гоолиг, алдартай модны хэмжээсүүдийн талаар зарим нэг зүйлийг дурдъя.*

/Нарс мод Норвегид хамгийн өргөн хэрэглэгддэг барилгын материал юм./ Энэ нь 1861 онд Хоф сүмийг буулгахад анх олдсон бөгөөд нийт урт нь 15 м гэж тогтоогджээ. Энэ бол хамгийн урт нь юм. Үүнийг голоор нь хувааж нэгэн загварын ердийн байшин барихад илүү тохиромжтой. Хаад ноёд, тайж язгууртан хэн нь ч энэхүү модны өөрийнх нь тогтсон хатуу хэмжээ харьцааг зөрчих эрх байхгүй. Байшингууд нь хэнд ч ялгаагүй нэгэн адил хуулиар баригдах боловч дүнзний зузаан, хээ угалз, засал чимэглэлээрээ ялгагдана. Хэн нэгнээс ийм ёс нь нийгэмд ардчилагч нөлөө үзүүлсэн үү гэсэн асуулт гарч ирж болох юм. Хүн ба нийгэм хоёрын зохицолдоонд нийцсэн нэгэн ижил хэмжээний энэ өрөөнүүдийн шинж чанар нь яагаад ч гэсэн үнэхээр нийтлэг бөгөөд хүнлэг ажгуу. Дүнзэн хананы хэвтээ байрлал нь амрах, тайвшруулах нөлөө үзүүлэхийн зэрэгцээ газарт ойрхон суулгагдсан нь сэтгэлд хичнээн өег тав тухтай гээч. Түүгээр ч зогсохгүй модон эдлэл нь тусгай чухал үүрэгтэй. Тэр нь онцгой сайн тусгаарлагч болдог төдийгүй, гар хүрэхэд ч тааламжтай байдаг юм.

Модоор барилга барьдаг энэ уламжлалт зан заншил одоо ч хадгалагдсаар байгаа ба өнөөдөр бүх шинэ барилгуудын 80 орчим хувь нь модоор баригдсан байна. Норвегийн соёлын өв чухам юугаараа онцлог юм бэ гэж ярихад хүрвэл бид нар маш бат бөх үндэс суурьтай гэж хэлж болно. Энэ бол манай мод юм. Манай мод өөрийн нөхцөл байдал болон чанараараа манай хөгжилд нөлөөлж чадсан билээ.



■ Сурагчийн гүйцэтгэх ажил 18

БАРИЛГЫН ӨВӨРМӨЦ ХЭЛБЭР МАЯГ НЬ ДӨ-ИЙН ӨВӨРМӨЦ ОНЦЛОГИЙГ ТАНЬЖ ТОГТООХ ИЛЭРХИЙЛЭЛ БОЛОХ НЬ

Зорилго: Ойр орчны барилга, хөшөө дурсгал, үндэсний парк гэх мэт бодит өвүүдийг судалснаар түүнийг таньж тогтоох, өвөрмөц онцлог шинжийг нь илүү таньж ойлгох



Судалгаа



Ангийн
ажил




Хичээлийн
2 цаг



Хэл,
газар зүй



Гэрэл
зураг



- Сурагчдаар өөрийн улсын, бүс нутгийн барилга байгууламж, хөшөө дурсгалын өв, үндэсний парк зэргийн онцлог шинж чанарыг дүрсэлсэн нийтлэл бичүүлэх; Эдгээр нь ДӨ-ийн газрууд мөн үү? Энд бидний соёл болоод барилгын материал, барилгын хэв загвар /хот, тосгондоо уг барилга ямар байдалтай баригдсан / байгалийн нөөц /орон нутгийн хайрга, чулуу гэх мэт/ бодит байгаль /нуурыг тойруулан хот байгуулах/ зэрэг хоорондоо уялдаа холбоотой байна уу? Танай соёлын өвөрмөц онцлог шинжийг танай байшин барилга, хэрхэн баригдсан арга болон орсон материал зэргээр нь тодорхойлж болох уу? зэрэг асуултуудыг тавина.

■ Сурагчийн гүйцэтгэх ажил 19

ХОТЫН ТҮҮХЭН ХЭСГИЙН ИРЭЭДҮЙН ТАЛААР ЗӨВЛӨЛӨӨС ШИЙДВЭР ГАРГАСАН НЬ

Зорилго: Өв хамгаалах үйл ажиллагааны нарийн учрыг илүү сайн ойлгох



Дүрийн
Тоглолт



Ангийн
ажил



Хөтөлбөрөөс
гадуурх ажил



Хичээлийн
хэд хэдэн
цаг



Нийгэм
судлал,
математик



Гэрэл
зураг



Дэлхийн Өвд
болговсролын
үүднээс
Хандах нь

□ Ангидаа дараах зохиомжилсон нөхцөл байдалд дүрийн тоглолт зохион байгуул.

Орон нутгийн эрх бүхий байгууллага танай хотын төвийн хөгжлийн хэтийн төлөвлөгөөг тоймлон гаргажээ. Хотын төв нь маш эртний бөгөөд бүс нутгийн уламжлалт хэдхэн байшинг багтаажээ. Ийм ч учраас байшин барилгууд нь танай орон нутгийн өвөрмөц онцлогийг илэрхийлэх чухал толь юм.

Хотын энэ онцлог хэсгийн байшин барилгын стандарт нь барилгын шинэчлэлийн үйл явцаас хол хоцрогдож байгаа юм. Ус дамжуулах хоолой, амралтын өрөөний тоноглол зэргийг тавьж, суурьлуулах боломж байхгүй. Хэрэв хөгжлийн төлөвлөгөө хэрэгжвэл хотын бүүр хуучны хэсгийг үгүй болгож, орчин үеийн сууцны барилгууд баригдах юм. Орон нутгийн зарим удирдлагууд хөгжлийн төлөвлөгөөг дэмжиж байхад орон нутгийн зарим улс төрчид үүний эсрэг байдаг. Өнөөдөр оролцогч талууд энэ талаар ярилцаж, төлөвлөгөөг хэрэгжүүлэх эсэх шийдвэр гаргаж байна.

□ Сурагчдыг доорх бүлгүүдэд Хуваа:

1. төлөвлөгөөг дэмжиж буй орон нутгийн удирдлагууд
2. төлөвлөгөөг эсэргүүцэж буй орон нутгийн удирдлагууд
3. Хуучин хотын оршин суугч, иргэд
4. Шинжээч/уран барилгач, хотын төлөвлөгч
5. Хэвлэл мэдээллийн төлөөлөгчид

□ Ярилцлагыг удирдах нэг ахлагч, 2 орлогч, хэлэлцүүлэх илтгэл тавих 2 илтгэгчийг сонгоно.

□ ДӨ-ийн болон аюулд учирч буй ДӨ-ийн жагсаалтад орсон газруудад нүүрлэж байгаа ижил төстэй аюул хөнөөлийг хэлэлцэж, дүгнэлт хийнэ.

■ Сурагчийн гүйцэтгэх ажил 20

СОЁЛ ХООРОНДЫН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ МЭДЛЭГ ОЛОХ

Зорилго: ДӨ-ийн газрууд ба өвөрмөц онцлогийг танин тодорхойлохын хоорондын харилцан уялдааг илүү сайн ойлгож мэдэх



Судалгаа



Ангийн ажил



Хичээлийн хэд хэдэн цаг



Хэл, нийгэм судлал



ДӨ-ийн байршлын газрын зураг, товч тодорхойлолт



Интернет

□ Сурагчдыг хэд хэдэн бүлэг болгон хувааж, бүлэг бүр дараах сэдвүүдийн аль нэгээр нь товч танилцуулга бичнэ.

- Манай сургууль
- Манай анги
- Манай орны ДӨ-ийн газрууд

□ Танилцуулгаа гадаадын нэг букуу түүнээс дээш сургуультай, и-мэйл, факс, интернетээр солилцох. Та хариуд нь юу олж мэдэж болох вэ, энэ нь аль хир удаан хугацаанд хийгдэх вэ, тэднийг яаж харьцуулж болох вэ


□ Эцэг эх чинь залуу зандан байх үед байгаагүй өнөөгийн харилцаа холбооны шинэ хэрэгслүүд, дэлхийн өнцөг булан бүрийн хүн ардыг хэрхэн холбож өгч байгаа талаар ярилц.

93

Өвөрмөц онцлог байдал ба нутгийн уугуул иргэд

Тухайн ард түмэн байгалийн ба соёлын өвтэйгээ хэрхэн холбоотой байдаг тухайсурч мэдэх нь хувь хүн, бүлэг, үндэстнийг тодорхойлох өвөрмөц онцлог байхын ач холбогдол болон Дэлхийн Өвөөр уламжлан энэхүү өвөрмөц онцлогийг хэрхэн хүлээн зөвшөөрч, хадгалж хамгаалах вэ гэдгийг ойлгоход чухал. "Сурагчийн гүйцэтгэх ажилд" өгөгдсөн жишээнүүд нь өөрийгөө ямар нэг тайлбаргүйгээр шууд таниулан ойлгуулах тийм жишээнүүд юм. Эдгээр нь өөрийн орон нутгийн болон өөр хаа нэг газрын бусад жишээг судлах, улмаар ийм маягийн үйл ажиллагааг хөгжүүлэх хүсэл тэмүүлэлтэй болгоно.

Викториа Фоллст болсон ЮНЕСКО-гийн ДӨ-ийн залуучуудын чуулга уулзалтын үеэр харилцан соёлоо солилцож байгаа нь ЮНЕСКО



■ Сурагчийн гүйцэтгэх ажил 21

ЗИМБАБВЕЙН “АУГАА ЗИМБАБВЕЙН ҮНДЭСНИЙ ХӨШӨӨ ДУРСГАЛ

Зорилго: Дурсгалт газрын түүхэн гарал үүслийг сайн ойлгох



ДӨ-ийн
газраар
аялах



Ангийн
ажил



Хичээлийн
хэд хэдэн
цаг



Түүх,
Газар зүй,
Нийгэм судлал,
иргэний
боловсрол



ДӨ-ийн
байршлын
газрын
зураг, товч
тодорхойлолт



Интернет

□ Сэтгэл булаам, чухал дурсгалт газрын түүхэн гарал үүслийн талаар хэлэлцэхэд жишээ болгон Аугаа Зимбабвейн тухай домог өгүүллэг ярих. Аугаа Зимбабвейн археологийн судалгаанаас энэхүү дурсгалт газар нь Африкийн унаган соёл гэдгийг тогтоожээ.

Аугаа Зимбабвейн өвөрмөц онцлог гэвэл тэрээр Үндэсний бэлэгдэл болж, өргөн тархсан явдал юм. Энэ улсын жинхэнэ өөрийнх нь нэр нь энэ алдартай сэтгэл булаам чулуун балгаснаас гаралтай. Зимбабвей гэдэг нь чулуун байшингууд гэсэн утгатай.

Аугаа Зимбабвей нь цэлгэр уудам тал газар орших ба Сахарын Африк дахь хамгийн том эртний байгууламж юм. Энд 2 хэсэг байх бөгөөд нурсан туурийн овоо толгод болон акрополис, барьцалдуулж тогтоосон хана, том том боржин бул чулуунаас бүтсэн жинхэнэ цайз хэрэмээс бүрдэнэ. Дараа дараагийн эзэмшигчид чулуун хана, том бул чулуунуудыг жижиг хашпагууд, нарийн хонгил гарган хооронд нь холбосон бөгөөд Хөндий дэх туурь болон аугаа том хашлага нийлээд сэтгэл татам хөшөө дурсгалыг бүрдүүлжээ. Аугаа том хашлагыг тойрсон хана нь 250 гаруй м урт, нямбайлан тэгшилж зассан чулууны жин нь 15 мянган тонн бөгөөд энэ нь эртний хамгийн том цорын ганц байгууламж болно.

Эртний туурь болон тэр үеийн цэцэглэн хөгжиж байсан соёлыг Африкийн унаган соёл болохыг тогтоох гэсэн эрэл хайгуул нь тухайн үедээ Родес гэж нэрлэгдэж байсан цагаан арьстан шилжин сууршигчдын эсрэг болж байв. Түүхээ дахин бүтээх зорилгоор улс төрчид, суртал нэвтрүүлэгчид Поенисиан, Араб, Энэтхэг, Еврей соёлын нөлөө байгааг нотлохыг оролдсон. Парламентийн халуун хэлэлцүүлгийн эцэст Аугаа Зимбабвей нь Африкийн соёлоос үүсэлтэй биш гэж үзсэн байна.

Гэвч Рандалл Маклвер, Гертруд Катон-Цомтсон нарын археологчид Аугаа Зимбабвейд малтлага хийж, энэхүү балгас нь жинхэнэ Африк үндэстнийх мөн” гэж тогтоожээ. Урлагийн бараг бүх олдворууд нь Шона нутгийн гаралтай байгаа бөгөөд бүхий л төвшинд хийгдсэн малталтууд нь Африк үндэсний амьдралын хэв заншлын үндэгдлийг харуулж байна.

Энэ ажил болон бусад археологчид, хэл шинжээчид, хүн судлаачдын уйгагүй судалгааны дүнд Аугаа Зимбабвейн түүхийг хамгийн наад зах нь 3 үе шат болгон хувааж үзэх нь зүйтэй гэсэн байр суурийг дэмжсэн байна.


Гүвээ толгод дээр шургааг, шавраар урц барин амьдарч байсан 11-р зууны үеэс хамгийн эрчимтэй суурьшлын үе эхэлсэн. Хожим нь 2 зууны дараа эдгээр урцууд нь илүү бөх бат шавар байшингуудаар солигдож, анхны чулуун хана баригджээ. Дараагийн зуунд энэ бүлэг хүмүүс Африк тивийн зүүн эрэг дагуух хүн ардтай, ялангуяа муслимын худалдаачидтай наймаа арилжаа хийж, хөгжиж дэвжсээр байв. Гэвч 15-р зуунд Аугаа Зимбабвей удаан оршин тогтнож чадсанг үй, алгуур мөхөж эхэлсэн.

Өргөн хүрээтэй байсан наймаа арилжааны тэмдэг Аугаа Зимбабвейн барилгын хийц загвар болон чулуун бүтцүүдийн хамт Эртний туурь нь Африк гаралтай гэдэг үндэслэлийг үгүйсгэж, дахин дахин маргаанд хүргэж байв.

Эртний Зимбабвейн үнэн бодит түүхийг болон өвөрмөц онцлогийг нь дахин бичих он жилүүд дууссан билээ. Аугаа Зимбабвейн туурь нь өнөөдөр үндэсний сэтгэл зүрх, Африкийн өвийн үнэт эрдэнэ болон гэрэлтэж байна.

□ Сурагчид энэхүү нөхцөл байдлыг хэрхэн үзэж байгаа талаар богино эссээ бичиж, харьцуулан ярилцана.

*Зимбабвейн Аугаа
Зимбабвейн хөшөө
дурсгал*



■ Сурагчийн гүйцэтгэх ажил 22

АВСТРИЙН УЛУРУ ТЖУТИЙН ҮНДЭСНИЙ ПАРК



Зорилго: Соёлын дурсгалт газрын тухай төсөөлөл, ба ДӨ-ийг

хамгаалахад нутгийн хүмүүсийн үүрэг хариуцлагын талаар илүү сайн ойлголт авах



ДӨ-ийн
газраар
аялах



Ангийн
ажил



Хичээлийн
2 цаг



Газар зүй,
Түүх, Нийгэм
судлал,



Товч тайлбар,
ДӨ-ийн байршлын
газрын зураг

Энд хоёрдох жишээ болгон толилуулж байгаа Австралийн Улуру- Ката Тжутийн үндэсний парк нь аливаа дурсгалт газрыг ДӨ-ийн жагсаалтад бүртгэх нь нутгийн уугуул ард түмний өвөрмөц онцлог болон амьдралын хэв ёсыг хүлээн зөвшөөрч, хадгалж хамгаалахад ямар ач холбогдолтой байдгийг харуулж байна.

Нөгөө талаар парк нь нутгийн уугуул иргэд ба засгийн газрын хадгалалт хамгаалалт хариуцсан агентлагын хоорондын түншлэлийг дэмжсэнээр дурсгалт газарт менежментийн бодлого, үйл ажиллагааг амжилттай явуулахын жишээ юм.

Энэ газар нь 1987 онд байгалийн дурсгалт газар хэмээн тогтоогдсон. 1994 онд түүнийг хүн болоод байгаль хоёрын хамтын бүтээл, хүн ба түүний хүрээлэн буй байгаль орчны харилцан үйлчлэл, нөлөөллийг илтгэсэн соёлын дурсгалт газар гэсэн ангилалаар ДӨ-д дахин нэрийг нь дэвшүүлсэн байна. Ийнхүү Улуру- Ката Тжутийн үндэсний парк нь ДӨ-ийн жагсаалтад бүртгэгдсэн анхны соёлын дурсгалт газар болжээ.

Улуру- Ката Тжутийн үндэсний парк нь уугуул иргэд өнөөг хүртэл амьдарч байгаа, үндсэн хэл болсон унаган хэлээрээ ярьдаг тийм уламжлалт уугуул иргэдийн нутагт байдаг ажээ. 1985 онд Австралийн засгийн газар уг газрыг Австралийн баруун говийн нутгийн уугуул иргэд Анангуд эргүүлэн өгжээ. Эргүүлж авсныхаа дараа Анангу үндэснийхээ паркийг Австралийн байгаль хамгааллын агентлагт түрээсээр эзэмшүүлсэн байна. Анангу болон Австралийн байгаль хамгааллын агентлаг одоо үндэснийхээ паркийг хамтдаа хамгаалж авч явдаг. Паркийг эргүүлэн өгсөн явдал болон хамтарсан менежмент нь уугуул нутгийн газрын эрхийн төлөө хөдөлгөөний түүх болоод мөн Австралийн өвийн хамгаалалтын түүхийн чигийг заагч луужин боллоо гэж үзэж болно.

Анангугын мэдлэгийн өв, амьдрал, өвөрмөц онцлог, нийгмийн бүтэц, ёс зүй, шашин шүтлэгийн тогтолцоо болон тэдний амьдарч буй дурсгалт газар нутгийн байдал энэ бүгдийг Тжукурпа зохицуулж, зааварчилж байдаг. Зарим үед "Мөрөөдлийн цаг" гэж оновчгүй орчуулагддаг Тжукурпа нь Анангу нийгмээ бүрдүүлэн байгуулах, бие биесээ, газар нутгаа харж хамгаалах, ер нь бүхий л үйл ажиллагааг нь зохицуулж байх арга замыг зааж байдаг. Улуру ба Ката Тжута байдаг тэр газар нутгаар Анангучууд хэрэн аялж явахдаа манай гариг хэлбэржин төлөвшөөгүй байх үед ч өвөг дээдсүүд нь тэр газруудаар хийж байсан аялал, үйл ажиллагааных нь талаар улам бүр илүү ойлголт мэдлэгийг олж авч байдаг билээ.

Өнөөдөр, өнгөрсөн үеийн адил, энэ мэдлэгийг ёслол, дуу хөгжим, бүжиг урлаг ба гар урлал зэрэгт дурсан өгүүлсэн байдаг. Тиймээс Анангу хүмүүсийн амьдарч байсан энэ газар нь соёлын гайхамшигт үнэт зүйл болж чаддаг.

ДӨ-ийн сонин, № 10, 1996-3-р сар

Австралийн
Улуру- Ката
Тжутагийн
Үндэсний парк
С. Титчөн



Тжукурлагийн хувьд энэ газар нь бидэнд чухал болохыг бид үргэлж ойлгож байдаг, өнөөдөр гадаадаас ирсэн болон орон нутгийн бус хүмүүс энэ газрыг соёлын чухал ач холбогдолтой хэмээн үздэг нь бидэнд таатайсэтгэгдэл төрүүлдэг. Урьд нь зарим хүмүүс түүнийг үл тоон, зүүд мөрөөдөл төдий үздэг байсан хэдий ч Тжукурпа бол одоо бодитой оршин байж, бидний хууль бидний хэл, бидний газар нутаг, гэр орон минь болсоор байна.

Улуру- Ката Тжутагийн удирдлагын хэлтсийн дарга Яами Лестер

Конвенцэд батлагдсан тэр даруйд бидний өвөрмөц онцлог, соёлын үндэс суурь нь дэлхийн бусад соёл, өвөрмөц онцлогуудтай хэрхэн холбогдолтой болохыг ойлгох боломжгүй. Бидний үндэсний болон угсаатны өвийг хамгаалах нь яагаад чухал болохыг бид ойлгож болох боловч бусад соёлын өвтэй хэрхэн холбогдож байдгийг олж харахад хэцүү байж болох юм. Энэ харилцаа холбоог олж харах нэг арга зам бол дэлхийг соёлын арал мэтээр тухайлбал шүрэн уул бүхий далай тэнгистэй зүйрлүүлэн үзэх явдал юм.

Филиппины
Туббатаха
далайн уул
IUCN Ж.
Торсгал



Шүрэн уул нь шүрэн амьтдын олон үе давхаргаас бүтэх бөгөөд хамгийн дээд давхарга нь амьд оршин байдаг. Хэдэн жилийн дараа тэдгээр амьтад үхэж мөхдөг бөгөөд үүний оронд амьд амьтдын шинэ давхарга үүсч бий болдог. Амьтдын шинэ давхарга үүсч бий болсноор шүрэн уул нь өндөр болон талбайн хувьд бага багаар өсч байдаг. Амьтан бүр нь чөлөөтэй хөдөлж байгаа мэт санагдавч үнэндээ анхны хэлбэрээрээ хөдөлгөөнгүй тогтдог. Шүрэн амьд амьтан бүр нь бусад амьд амьтадтай холбоогүй мэт санагдах боловч далай доторх зарим нэг амьтдын үе давхарга нь нэгэн ижил уулын нэг хэсэг болж байдгийг та харах болно. Үүссэн давхаргууд нь хөндлөнгийн ямар нэг аюул, бохирдлоос үүдэн устаж үгүй болсноор тухайн ууланд хэрхэн муугаар нөлөөлснийгмөн та ойлгож болно. Манай гариг дэлхий энэ шүрэн аралтай яг адилхан. Дэлхий ертөнц бидний өмнөх мянга мянган үе удам, тэдгээрийн үзэл бодол, үхэл, мөхөл, үүсэл гаралын хамт үүсч бүрэлдэж ирсэн. Энэ нь бидний нэг хэсэг, бид оршин байгаагийн нэг хэсэг юм. Энэ бол бидний өвөрмөц онцлог, энэ бол бидний өв юм.

Норвегийн Осло их сургуулийн Хүн Судлалын профессор Томас Хиллард Ериксон.

Дэлхийн Өв- Орхоны хөндийн соёлын дурсгалт газар (ОХСДГ)

Орхоны хөндийн соёлын дурсгалт газар нь Өвөрхангай аймгийн Хархорин, Хужирт, Бат-Өлзий, Архангай аймгийн Хотонт, Хашаат сумын нутгийн зарим хэсгийг хамардаг юм. ОХСДГ нь Төв Азийн нүүдэлчид, түүний дотор Монгол үндэстний бий болгосон нүүдлийн соёл иргэншил, түүнийг хөгжүүлж ирсэн төвүүд болон улс гүрнүүдийн үүсэл, хөгжлийг нотлон харуулж байгаа археологи, түүх-соёлын дурсгалаар асар баян нутаг билээ.

Орхоны хөндийд хуучин чулуу, хүрэл, төмрийн үеийн Мойлтын амын бууц, Орхон-7 зэрэг эртний хүмүүсийн оромж, суурин, дархны газрын ул мөр элбэг бий. Энэ дурсгалт газар нь Түрэгийн үеийн хаадын тахил шүтээний алдарт бунхант дурсгал, бичигт хөшөөнүүд, Уйгарын эзэнт гүрний нийслэл Хар



Орхоны хөндийн соёлын дурсгалт газар. Монгол

30-нд) Орхоны хөндийн соёлын дурсгалт газрыг Дэлхийн өвд бүртгэн авсан билээ. Ийнхүү Орхоны хөндийн соёлын дурсгалт газар нь хүн төрөлхтний нийтлэг үнэ цэнэ бүхий соёлын гайхамшигтай дурсгал мөн гэдгийг Дэлхий дахинд зарлан тунхагласан болно.

Балгас хотын туурь, Чингис хааны үндэслэсэн Монголын эзэнт гүрний нийслэл түүхт Хархорум хот, Монгол дахь бурханы шашны бэлэг тэмдэг болсон Эрдэнэзуу болон Төвхөн хийд, бусад олон зуун дурсгалтай бөгөөд түүгээрээ ч Төв Ази, улмаар хүн төрөлхтний түүхийн тодорхой хэсгийн давтагдашгүй бодит гэрч болж байдаг юм.

Дэлхийн Өвийн Хороо БНХАУ-ын Сүжоу хотноо болсон 28 дугаар хурлаараа (2004 оны 7 дугаар сарын

Дэлхийн Өв- Увс нуурын ай сав

Увс нуур нь Монгол улсын баруун хязгаарт Монгол, ОХУ-ын хил дамжин Азийн эртний их нуурын хотгорт оршино. Увс нуурын ай савд чийглэг хөрст ой хээр, ой тайга, давсархаг намаг, цөлөрхөг хээр, элсэн зурвасууд, мөнх цаст уул нуруу зэрэг газар нутгууд зэрэгцэн оршдог онцлогтой.

Ийнхүү Увс нуур нь хээр тал нутагт байдаг томоохон давстай нуур бөгөөд түүний ай сав нь Евро Азийн нэлээд хэдэн экосистемүүдийн цогцолбор нутаг болдог аж. Энэ дурсгалт нутаг бол олон төрлийн ховор болон ховордсон ургамлыг хадгалагч, олон төрлийн нүүдлийн шувууд болон ховор зэрлэг амьтад амьдарч идээшин дассан өлгий билээ.




Увс нуурын Ай сав газар. Монгол

Энэхүү ай савын нутаг дэвсгэрт 2 мянга гаруй эртний Скифийн соёл, Хүннү, Түрэг ба Монголчуудтай холбоотой эртний булш манхнууд байдаг. Эдгээр булш манхнууд өнөөг хүртэл хөндөгдөөгүй хадгалагдаж ирсэн бөгөөд энэ нь нутгийн ард иргэдийн тахилга шүтлэгтэй холбоотой ба мөрдөж буй уламжлалт ахуй амьдралынх нь гэрч болж өгч байна.

Дэлхийн Өвийн Хороо нь 2003 онд өөрийн ээлжит 27-р хурлаараа Монгол улс болон Оросын Холбооны Улсаас хамтран нэр дэвшүүлсэн Увс нуурын ай савыг Дэлхийн байгалийн өвийн II, IV шалгуурыг хангасан гэж үзэж Дэлхийн байгалийн өвд бүртгэсэн болно.

Увс нуурын ай савыг ийнхүү Дэлхийн нийтийн нийтлэг үнэ цэнэ бүхий байгалийн гайхамшигт өв мөн болохыг Дэлхийд зарлан өргөмжилсөн билээ.

“Дэлхийн Өв залуу үеийхний гарт” гэсэн энэхүү багш нарт зориулсан гарын авлагыг ЮНЕСКО-гийн тусламжаар англи хэлнээс хөрвүүлэн гаргав.



Сэдвийн дүгнэлт: ДӨ ба өвөрмөц онцлогууд

Дүрслэх урлаг

Хүний бүтээн туурьвих агуу их суу билгийн хосгүй гайхамшигт жишээ болсон ДӨ-ийн дурсгалт газруудыг зурж үзүүлэх, тэдгээрийн бүтээгчид, хэрэв тэр нь соёлын дурсгалт газар бол хамгаалагчдынх нь янз бүрийн өвөрмөц онцлогийн нь талаар дүрслэн бодох

Гадаад хэл

Өөр хэл дээр текстүүд уншиж байхдаа төрөлх хэлэнд чинь бас байгаа тийм ижил үгнүүдийг түүж авах ба тэгээд эдгээр үгүүд нь яагаад адилханбайгаа юм бэ, тэдгээр нь улс орнуудынхоорондын соёлын харилцааны тухай юу хэлж чадах талаар хэлэлцэх

Өөрийн улсын ДӨ-ийн газруудын тухай мэдээллийн зурагт хуудсыг өөр хэл рүү хөрвүүлэх

Эх текстэнд эргэлзээнгүйгээр орсон бөгөөд тайлбарлах шаардлагатай утга санаа буюу үгүүдийг олж бичих ба тэдгээр нь тухайн ард түмнүүдийн өвөрмөц онцлогийг яаж илэрхийлж буй талаар ярилцах

Газарзүй/ Шинжлэх ухаан

100

ДӨ-ийн жагсаалтыг судалж үзэх, оршин суугчид болон газарзүйн байршлын хоорондын уялдаа холбоог дүрслэн үзүүлэх

Норвегийн модны үүрэг гэх мэтээр энгийн жишээн дээр ард түмнүүдийн өвөрмөц онцлог байдал бүрэлдэн төлөвших үйл явцад байгалийн гүйцэтгэх үүрэг ямар байдаг талаар ярилцах

Түүх

ДӨ-ийн дурсгалт газар, боломжгүй бол өөр соёлын болон байгалийн дурсгалт газрууд дээр дүрийн тоглолт хийх ба уг дурсгалт газрыг бүтээсэн буюу одоо энд амьдарч буй ард түмэнтэй санал бодлоо хуваалцахад нь сурагчдад дэмжлэг үзүүлэх

Хэл/ утга зохиол

Ямар нэг соёлын дурсгалыг тодорхойлох өвөрмөц онцлогийг хадгалж хамгаалах нь чухал болох тухай эссээ бичих, зарим гол санааг нь жүжиг тоглоход оруулах, тусгай нэг байгалийн юмуу соёлын дурсгалт газрыг хадгалж хамгаалах талаар 5 минутын илтгэл тавих тэмцээнд оролцох

ДӨ-ийн газартай холбоотой буюу эсвэл тэднийг тодорхойлох өвөрмөц онцлог зүйлийн тухай тууж, богино өгүүллэгүүдийг уншиж ярилцах, дараа нь сурагчдаар өөрийнх нь дурсгалтэй холбоотой жижиг өгүүлэл бичүүлэх

Танай бүс нутагт байгаа байгалийн ба соёлын дурсгалт газруудыг тодорхойлох өвөрмөц онцлог зүйлүүдийн талаархи үзэл бодлыг тусгасан тийм жүжгийн тоглолтуудыг олох

Гүн ухаан/ шашны судалгаа

Сүсэг бишрэлийн тогтолцоог дүрслэн үзүүлэх зорилгоор нэмэлт материал болгон шашны дурсгалт газрууд, барилгуудын гэрэл зураг, зургийг ашиглах Сүм дуган, хийд гэх мэт шашны газраар очихдоо бэлэгдлийн чанартай зүйлийг ажиглах ба мэдэж ойлгох

Дэлхийн Өв ба аялал жуулчлал



Италийн Пиза, Пизаза дөл. Дуомо. J. A. Taylor.

Дэлхийн Өв ба аялал жуулчлал

1998 онд 552 Дэлхийн Өвийн дурсгалт газарт 500.000.000 жуулчид зорчив.

ДӨ ба аялал жуулчлал

Зорилго	103
Мэдлэг	103
Арга хандлага	103
Ур чадвар	103
Аялал жуулчлал дэлхий нийтийн үзэгдэл бөгөөд өргөн бизнес болох нь	104
Сурагийн гүйцэтгэх ажил 23: Аялал жуулчлалын чиг хандлагыг тодорхойлох нь	105
Сурагчийн дасгал ажлын хуудас: Дэлхийн аялал жуулчлалын статистик мэдээ Хүснэгт 1	106
Сурагчийн дасгал ажлын хуудас: Дэлхийн аялал жуулчлалын статистик мэдээ Хүснэгт 2	107
Сурагчийн дасгал ажлын хуудас: Дэлхийн аялал жуулчлалын статистик мэдээ Хүснэгт 3	108
ДӨ-ийн хамгаалалд нөлөөлөх аялал жуулчлалын давуу талууд ба учруулах аюул	109
Сурагчийн гүйцэтгэх ажил 24: ДӨ-ийн хамгаалалд нөлөөлөх аялал жуулчлалын давуу талууд ба учруулах аюул	110
Аялал жуулчлалын шинэ хэлбэр маягийг нэвтрүүлэх хэрэгцээ ДӨ, аялал жуулчлал ба экологийн хувьд тогтвортой хөгжил	111
Сурагчийн гүйцэтгэх ажил 25: ДӨ ба аялал жуулчлал тоглоом	112
Сурагчийн дасгал ажлын хуудас: ДӨ ба аялал жуулчлал тоглоом	113
Сурагчийн гүйцэтгэх ажил 26: Бүдүүлэг, замбараагүй жуулчинг эрхэм хүндтэй жуулчин болгоё	114
Жуулчдын мөрдвөл зохих ерөнхий заавар	114
Үзэж аялах ДӨ-ийн газруудыг нэмэгдүүлэх нь	115
Сурагчийн гүйцэтгэх ажил 27: ДӨ-ийн газрууд дахь жуулчдад үйлчлэх хангамж нөхцөлд үнэлгээ хийх	116
Сурагчийн дасгал ажлын хуудас: ДӨ-ийн газруудад дахь жуулчдад үйлчлэх хангамж нөхцөлд үнэлгээ хийх	117
Ур ашигтай аялал жуулчлал ба ДӨ	118
ДӨ-ийн газруудын аялал жуулчлалын менежмент	119
Сурагчийн гүйцэтгэх ажил 28: ДӨ-ийн байгалийн дурсгалт газруудад зам тавих асуудал	120
Сурагчийн дасгал ажлын хуудас: ДӨ-ийн байгалийн дурсгалт газруудад зам тавих асуудал	121
Сэдвийн дүгнэлт: ДӨ ба аялал жуулчлал	122

Зорилго



Мэдлэг

- Дэлхийн аялал жуулчлалын чиг хандлага болон түүний ДӨ-ийн газруудад үзүүлж болох нөлөөлөл
- Аялал жуулчлал нь ДӨ болон бусад соёл, үнэт зүйлс, уламжлалын талаар илүү ихийг сурч мэдэхэд бидэнд хэрхэн туслаж чадах вэ
- Дурсгалт газрын менежментэд жуулчин хүлээн авах менежментийг оруулж өгөх хэрэгцээ шаардлага гэх зэрэг асуудлын талаар мэдлэг ойлголтыг нь хөгжүүлэхэд сурагчдад туслах

Арга хандлага

- Өвийг үнэлэн үздэг, түүний хамгаалалтад ээлтэй тийм аялал жуулчлалын шинэ хэлбэрүүдийг нэвтрүүлэх хэрэгцээ шаардлагыг ойлгуулах
- Нийтийн аялал жуулчлалаас ДӨ-ийн газрыг хамгаалах талаар авсан арга хэмжээг ойлгож, түүнд оролцоход нь сурагчдад дэмжлэг үзүүлэх

103

Ур чадвар

- Дараах чадварыг хөгжүүлэхэд сурагчдад туслана.
- Аялал жуулчлалын чиг хандлага, ДӨ-ийн хамгаалал хоёрын хоорондын харилцан хамаарлыг илүү сайн ойлгох үүднээс статистик тоо баримтад хэрхэн дүн шинжилгээ хийх, тайлбар өгөх талаар мэдлэг олох
- ДӨ-ийн газруудын хөтөч байх үндсэн чадварыг эзэмших
- Хүндэтгэл, хариуцлагатайгаар соёлын ба байгалийн дурсгалт газраар аялах
- Жуулчдын тусын тулд ДӨ-ийн дурсгалт газруудыг үзүүлж харуулах талаар бүтээлч санааг хөгжүүлэхийн хамт тэдгээрийн хадгалалт хамгаалалтыг хангах

Аялал жуулчлал бол дэлхий нийтийн үзэгдэл бөгөөд өргөн бизнес болох нь

Бусад ард түмэн, бусад соёлтой харьцахгүйгээр нэг ч хүн, нэг ч соёл хөгжих боломжгүй. Соёл бүхэн бусад бүх соёлоос хамааралтай байдгийг бид мартаж ёсгүй. Соёлын дурсгалт газруудаар хийх аялал жуулчлал нь соёл болон соёл иргэншлийн хоорондын харилцан ойлголцол, яриа хэлэлцээг илэрхийлж чадах тийм илүү үр өгөөжтэй бөгөөд цаг үеэ олсон жуулчлалын хэлбэр болж чадна гэдгийг бид ойлгох ёстой. Бие биедээ зочилж, жуучилж очих нь өөрсдийн соёл, өвөө үнэлэн хүндэтгэх, хүрээлэн буй байгаль орчноо илүү ойлгож мэдэхэд ач холбогдолтой.

ЮНЕСКО-гийн ерөнхий захирал Коичиро Мацура НҮБ-ын Боловсролын хөтөлбөрийн сайд нарын хэмжээнд болсон хүрээлэн буй орчны чуулга уулзалт дээр хэлсэн үгнээс Найрови, 2001, 2,8

Өнгөрсөн 40 жилийн дэлхий нийтийн томоохон үйл явцын нэг бол нийтийн аялал жуулчлал хөгжсөн явдал юм. Энэ нь ДӨ-ийн газруудаар аялагчдын тооны өсөлтөд нэлээд нааштай нөлөөлсөн.

Тээврийн технологийн хөгжил хурдасч хүмүүсийн амьдралын төвшин дээшилж, чөлөө цаг, амралтаа өнгөрүүлэх зардал мөнгө нэмэгдсэний ачаар хүмүүс урьд өмнө байгаагүйгээр олноороо мөн аль болох хол газар аялаж жуулчлах болжээ. Жишээ нь: Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас гаргасан тооцоогоор 1950 онд жуулчдын тоо 25 сая байсан бол 1999 онд 664 саяд хүрч, сүүлийн таван жилийн жуулчдын тоо даруй 25%-иас илүү өссөн байна. Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын урьдчилсан мэдээгээр жуулчдын тоо 2010 онд 1 тэрбумд хүрэх хандлагатай байна.

Олон хүн сонирхсон шинэ газар нутгийг очиж үзэхийг хүсдэг бөгөөд ялангуяа дэлхийн хосгүй гайхамшигт үнэт зүйл гэж ДӨ-ийн жагсаалтад бүртгэгдсэн тохиолдолд хүмүүс тийм газрыг сонгон аялал хийдэг болжээ. Томоохон хотуудын оршин суугчдын тоо өсөн тэлж байгаа нь тэр хүмүүсийг байгалийн гоо үзэсгэлэнгээрээ алдартай газар нутаг болон ДӨ-ийн дурсгалт газруудаар аялах хүсэл сонирхолтой болгож байна. Тийм аялалыг заримдаа эко туризм буюу байгалийн аялал гэж үздэг байхад соёлын дурсгалт газраар хийх аялалыг соёлын аялал гэж үзэж байна.

Жуулчин- нэг буюу хэд хэдэн газар аялан очиж үзэж байгаа хүн/тойрон аялал хийж байгаа хүн/; ялангуяа түүнийг амрах, биеэ сувилах зорилгоор хийж байгаа хүн; өөрийн хүсэл сонирхлын дагуу дурсгалт газруудаар аялах, соёлыг бишрэн, сэтгэлийн таашаал авах зорилгоор аялаж байгаа хүн
Оксфордын хураангуй толь

Аялал жуулчлал аялж, жуулчлах талаарх онол, дадлага; таашаал авах зорилгоор аялах
Оксфордын хураангуй товч толь



Харилцах хаягууд



Францын Монт-Сен-Мичел ба түүний Вейд аялаж буй жуулчид
Patrimoine 2001/
D. Chenot

Аялал жуулчлал нь ажлын орон тоо гаргаж, ихээхэн хэрэгцээтэй байдаг гадаадын валют оруулдгаараа улс орны хөгжилд ихээхэн ач холбогдолтой. Жишээ нь: 1950 оны байдлаар жуулчид 2.1 сая Америк доллар оруулж байсан бол 2000 онд 486 тэр бум долларт хүрсэн байна.

Та аялал жуулчлалын чиглэлээр илүү их мэдээлэл авахыг хүсвэл ДАЖБ-ын вэб сайтад хандаарай: /<http://www.world-tourism.org/>

Соёл гэдэг нь хүмүүсийг хөдөлгөөнд оруулж байдаг зарчмын нэг хөдөлгөгч хүч болж байдаг учраас аялал жуулчлалыг соёлгүйгээр төсөөлөхийн аргагүй. "Соёл, аялал жуулчлал, ба хөгжил" сэдэвт дугуй ширээний ярилцлага: 21-р зуунд шийдвэрлэх асуудал, р. 7 Парис, ЮНЕСКО, 1996 оны 6-р сар 26-27



■ Сурагчийн гүйцэтгэх ажил 23

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН АРГА ХАНДЛАГЫГ ТООЦООЛОХ НЬ

Зорилго: Дэлхийн арга жуулчлалын чиг хандлага болон ДӨ-ийн хамгаалалд жуулчид аль хэр оролцож байгаа судалж тооцоолох нь



Судалгаа



Ангийн ажил



Хичээлийн нэг буюу хэд хэдэн цаг



Математик, нийгэм судлал



Сурагчийн дасгал ажлын хуудас, дэлхийн аялал жуулчлалын талаарх тоо баримтууд, тооны машин, ДӨ-ийн газрын зураг, гэрэл зураг

□ Сурагчдад сурагчийн дасгал ажлын хуудсын 1-р хүснэгтийг үзүүл. /Боломжтой бол бүх сурагчдад хувилж тараа./ Тэдэнд мэдээ баримтуудыг тайлбарлаж, статистик тоо баримтуудыг цуглуулах, боловсруулж тайлбарлах, хэрэглэх талаар зарим мэдээллийг өг. Хамгийн олон жуулчид зорчдог 15 орныг сонгон авч, орон тус бүрт хэчнээн ДӨ-ийн дурсгалт газрууд байгааг ДӨ-ийн газрын зураг дээр олуулах. Мөн орон тус бүр дэхь дурсгалт газрууд, тэнд ирэх жуулчдын тооны харьцааг бодож гаргуулах, мөн Африк, Америк ба Карибын тэнгис, Ази номхон далай, Арабын улсууд, Европ дахь хамгийн олон жуулчид зорчдог 10 орны газарзүйн байршлыг газрын зураг дээр тэмдэглүүлэх

□ Сурагчдад 2-р хүснэгтийг танилцуулж 15 орныг үйлдвэржсэн, буурай үйлдвэржсэн гэсэн 2 ангиллаар нэг нэг хуудсанд жагсаан бичүүлэх: Үйлдвэржсэн орон болон ДӨ-ийн дурсгалт газруудаараа аялуулж хамгийн их орлого олдог орон хоёрын хооронд хамаарал байгаа эсэхийг бодож гаргуулах. Олж мэдсэн зүйлийнхээ тухай ярилц: аялал жуулчлалаас хамгийн их орлого олдог нь хэдэн орон ДӨ-ийн дурсгалт газруудтай байна вэ?

□ Сурагчдад 3-р хүснэгтийг үзүүлж, өсөлтийн хэмжээ гэж юу болох тухай болон яагаад өсөлтийн хэмжээ нь арав арван жилээр өөр өөр байгаа талаар ярилцах

□ Өөрийн орон дахь ДӨ-ийн түүх соёлын дурсгалт газруудад ирсэн жуулчдын тоо, аялал жуулчлалын талаарх статистик тоо баримтыг олж мэдэх, түүнийгээ танилцуулах

Хүснэгт 1

Дэлхийн аялал жуулчлалын оргил 15 улс

Олон улсын жуулчид

Дугаар	Улс	Олон улсын жуулчид / Сая /		Өөрчлөлтийн хувь 2000/1999	Зах зээлийн ноогдол 2000
		1999	2000		
1.	Франц	73.0	75.5	3.4	10.8
2.	АНУ	48.5	50.9	4.9	7.3
3.	Испани	46.8	48.2	3.0	6.9
4.	Итали	36.5	41.2	12.8	5.9
5.	Хятад	27.0	31.2	15.5	4.5
6.	Англи	25.4	25.2	-0.8	3.6
7.	Орос	18.5	21.2	14.5	3.0
8.	Мексик	19.0	20.6	8.4	3.0
9.	Канад	19.5	20.4	4.9	2.9
10.	Герман	17.1	19.0	10.9	2.7
11.	Австр	17.5	18.0	2.9	2.6
12.	Польш	18.0	17.4	-3.1	2.5
13.	Унгар	14.4	15.6	8.1	2.2
14.	Гон Конг	1.3	13.1	15.3	1.9
15.	Грек	12.2	12.5	2.8	1.8

Эх сурвалж: Дэлхийн аялал жуулчлалын байгууллага, 2001 оны 8-р сарын байдлаар

Хүснэгт 2

Дэлхийн аялал жуулчлалын оргил 15 улс

Аялал жуулчлалаас хамгийн их орлого олдог орнууд

Дугаар	Улс	Аялал жуулчлалын мөнгөн орлого / \$ тэр бум/		Өөрчлөлтийн хувь 2000/1999	Зах зээлийн ноогдол 2000
		1999	2000		
1.	АНУ	74.9	85.2	13.7	17.9
2.	Испани	32.4	31.0	-4.3	6.5
3.	Франц	31.5	29.9	-5.1	6.3
4.	Итали	28.4	27.4	-3.2	5.8
5.	Англи	20.2	19.5	-3.4	4.1
6.	Герман	16.7	17.8	6.5	3.7
7.	Хятад	14.1	16.2	15.1	3.4
8.	Австр	12.5	11.4	-8.7	2.4
9.	Канад	10.2	10.8	5.9	2.3
10.	Грек	8.8	9.2	5.0	1.9
11.	Австрал	8.0	8.4	5.3	1.8
12.	Мексик	7.2	8.3	14.8	1.7
13.	Гон Конг	7.2	7.9	9.4	1.7
14.	Турк	5.2	7.6	46.8	1.6
15.	Орос	7.5	.		

Эх сурвалж: Дэлхийн аялал жуулчлалын байгууллага, 2001 оны 8-р сарын байдлаар

ДАЖБ-ын гаргасан аялал жуулчлалын 2020 хүртэлх урт хугацааны урьдчилсан тооцоо

Хүснэгт 3

Бүсчилэн гаргасан урьдчилсан тооцоо
Жуулчдын тоог бүсээр харуулсан нь /сая

Бүс	Анхны жил		Урьдчилсан тооцоо		Жилийн дундаж өсөлтийн хэмжээ %		Зах зээлийн ноогдол %	
	1995	2010	2020	1995-2020	1995	2020		
Африк	20.2	47.0	77.3	5.5	3.6	5.0		
Америк	108.9	190.4	282.3	3.9	19.3	18.1		
Зүүн Ази- Номхон Далай	81.4	195.2	397.2	6.5	14.4	25.4		
Европ	338.4	527.3	717.0	3.0	59.8	45.9		
Ойрх Дорнод	12.4	35.9	68.5	7.1	2.2	4.4		
Өмнөд Ази	4.2	10.6	18.8	6.2	0.7	1.2		
Бүс хооронд	464.1	790.9	1,183.3	3.8	82.1	75.8		
Холын аялал	101.3	215.5	377.9	5.4	17.9	24.2		

Эх сурвалж: Дэлхийн аялал жуулчлалын байгууллага, 2000 оны 7-р сарын байдлаар

1. Бүс хоорондын тоонд уг гарал нь тогтоогдоогүй байгаа улс орон орно.
Холын аялалд бүс хоорондын аялалаас бусад аялал орно.

▲ ДӨ-ийн хамгаалалд аялал жуулчлалын давуу талууд ба учруулж болох аюул

Аялал жуулчлал нь олон сайхан илт давуу талтай. Жуулчдыг хүлээн авах улс орон, хотууд, өвийн газруудын хувьд аялал жуулчлал нь ажлын орон тоо нэмэгдүүлж, гадаад валют өөртөө оруулж, зам харилцаа холбооны тоног төхөөрөмж, эмнэлэгийн асрамж гэх мэт дэд бүтцийг сайжруулдаг. Жуулчид дэлхийн гайхамшгуудыг шүтэн биширч, бусад орон, түүний байгаль орчин, соёл, үнэт зүйлс, амьдралын хэв маягийг нь илүү сайн мэдэж, ингэснээрээ улс хоорондын харилцан ойлголцол эв нэгдлийг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулж байдаг юм. Бусдаас суралцсанаар бид өөрсдийн талаар илүү ихийг мэдэж авдаг билээ.



Дэлхийн Өв ба түүнийг таньж тогтоох нь

Аялал жуулчлал нь ийнхүү олон давуу талтай ч бас сөрөг үр дагавартай. Жишээ нь: Индонезийн маш халуун чийглэг бүсэд оршдог ДӨ-ийн түүхэн дурсгалт газар болох Боробудурын сүм хийдийн цогцолборын дурсгалыг үзэхээр сая сая жуулчид ирдэг. Жуулчны баазын жолооч нар зарим үед жуулчид аяллаас буцан ирэхийг хүлээж байхдаа жуулчдын тав тухтай, амар амгалан байдлыг хангах гэж мотороо унтраахгүйгээр хөргөх төхөөрөмжөө ажиллуулж машинаа сэрүүцүүлж байдаг юм. Эндээс ялгарсан нүүрстөрөгчөөс гарах утаа нь чулуун сүмд хөө тортог суулган муутгах нь мэдээж хэрэг.




Индонезийн Боробудур сүм хийдийн цогцолбор ЮНЕСКО/ A. Voronzoff

Автомашин хөдөлгөөн нь ДӨ-ийн газруудад гол аюул заналыг учруулж байна. Их Британы алдарт чулуун хөшөөний цогцолборын ойролцоох зам нь уг дурсгалт газрын бүрэн бүтэн байдалд аюул учруулах болсон юм. Египедэд Гиза-гаас Дашур хүртэлх Пирамид байгаа газрын дэргэдүүр хурдны төв зам тавих саналыг Египедийн удирдлагууд ЮНЕСКО-гийн хүсэлтийн дагуу зогсоосон байна. ДӨ-ийн Конвенц нь ДӨ-ийн аюулд учраад байгаа газруудын жагсаалтыг авч үзээд эрс хурдасч буй хотжилт, аялал жуулчлалыг хөгжүүлэх томоохон төслүүд нь ноцтой аюул занал учруулж болохыг сануулж байгаа билээ.

Нэгдсэн Хаант Улсын Авебури хад чулуу ЮНЕСКО/ G. Lacoudre

Аялал жуулчлал нь өвийн дурсгалт газруудад эерэг ба сөрөг нөлөө үзүүлж байна. Эерэг нөлөөллийг нь улам бататгаж, сөрөг нөлөөллийг нь арилган зайлуулах хэрэгтэй байна.

Исурагчийн тангараг, ДӨ-ийн залуучуудын чуулга, Берген, Норвег/



■ Сурагчийн гүйцэтгэх ажил 24

ДӨ-ИЙН ДУРСГАЛТ ГАЗРУУДАД НӨЛӨӨЛӨХ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ДАГУУ ТАЛУУД БА УЧРУУЛЖ БОЛОХ АЮУЛУУД

Зорилго: ДӨ-ийн дурсгалт газруудад нөлөөлөх аялал жуулчлалын давуу талууд ба учруулж болох аюулуудын талаар илүү сайн ойлголт авах



Ярилцлага



Ангийн ажил



Хичээлийн нэг цаг



Хэл, нийгэм судлал



2 том хуудас цаас

□ Сурагчдыг 2 бүлэг болгон хувааж, 1-р бүлэгт орон нутгийн болон ДӨ-ийн газруудад аялал жуулчлалын давуу талуудыг жагсаан бичих, 2-р бүлэгт ДӨ-ийн газруудад аялал жуулчлалын учруулж болох аюулуудыг жагсаан бичих санал тавь. Бүлэг бүрээс нэг сурагчийг гарган өөрсдийн бичсэн жагсаалтыг нь уншиж танилцуулж, аялал жуулчлалаас учирч болох аюул заналыг хэрхэн багасгаж болох талаар ярилц.

▲ Аялал жуулчлалын шинэ хэлбэрийг хөгжүүлэх хэрэгцээ шаардлага

Аялал жуулчлал нь хүмүүст соёлын олон төрөл зүйл, амьдралын хэв маяг, хүрээлэн буй байгаль орчин зэргийг шууд ойлгож мэдрэх боломж олгож, залуучуудын хувьд олон улсын соёлын ашигтай харилцан солилцоог хөгжүүлэхэд тус болно.

Аялал жуулчлал бол цор ганцхан атлаа хязгааргүй олон янз байдлыг хослуулсан энэ дэлхийтэй учран золгуулж байдаг хүлцэл тэвчээрийн их сургууль байж болох билээ” хэмээн “21-р зуунд шийдвэрлэх гол асуудлууд” сэдэвт Соёл, аялал жуулчлал, хөгжлийн тухай дугуй ширээний ярилцлагын баримт бичигт дурьджээ.

Парис, ЮНЕСКО, 1996 оны 7-р сарын 26-27

Хэдий тийм ч гэсэн нутгийн хүн амын хэрэгцээнд зориулсан сургууль, зочид буудал барьж байгуулахын оронд жуулчдад зориулсан зочид будал, усанд орох газар, ресторан барих зэргээр аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэхийг нэн тэргүүнд тавиваас аялал жуулчлал нь эдийн засаг нийгмийн тэнцвэртэй байдлыг алдагдуулахад хүргэж болох юм.

Экологийн хувьд тогтвортой хөгжихөд ач тустай, жуулчин авч буй орны соёлын өвөрмөц онцлогийг тодотгож, соёл болоод байгаль дэлхийг нь жуулчид хайрлаж хамгаалсан, түүнийг улам түгээн алдаршуулсан тийм аялал жуулчлалын шинэ хэлбэрийг хөгжүүлэх шаардлага тулгарч байна. Олон төрлийн соёлын бодитой яриа хэлэлцээр, хүмүүсийн харилцан хүндэтгэл, эв нэгдлийг төлөвшүүлэн тогтоох хэрэгцээ ч бас байна. Усны хомсдолтой орнуудад очсон жуулчид гар нүүрний алчуур, орны даавуугаа өдөр бүр солиулах гэхгүйгээр ус хэмнэх талаар өөрсдийн эв нэгдлээ илэрхийлж болох жишээтэй.

Дэлхийн Өв ба аялал жуулчлал, экологийн хувьд тогтвортой хөгжил



Дэлхийн Өв ба хүрээлэн буй орчин

Хэрэв нутгийн хүн амыг аялал жуулчлал хөгжүүлэх бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд өргөнөөр оролцуулж, тэдний эрмэлзэл, үүрэг оролцоонд түшиглэхийн хамт тухайн аялал жуулчлал явуулж буй байгаль болон соёлын дурсгалт газар нь хадгалалт хамгаалалтын удаан хугацааны төлөвлөгөөнд үндэслэсэн байвал аялал жуулчлал нь чанартай тогтвортой хөгжихөд хувь нэмрээ оруулж чадна.

Соёл, аялал жуулчлал, хөгжлийн тухай дугуй ширэний ярилцлага: 21-р зуунд тулгарах асуудлууд п.7Парис, ЮНЕСКО-гийн хэвлэлийн газар, 1996-6-26-27

Нийтийн аялал жуулчлал нь соёлын болоод байгалийн дурсгалт газруудыг хадгалж хамгаалахад ноцтой нөлөөлдөг. Жуулчид олноор ирснээр соёлын үнэт зүйлс эвдэрч муудах ч юм уу, жуулчдын хаясан хог хаягдлаас бохирдох, жуулчид гадны ургамал амьтан авчрах, эмзэг газруудад жуулчны бааз, амралтын газрууд байгуулах зэргээр байгалийн дурсгалт газрыг доройтуулж болно. Дурсгалт газар, ялангуяа ДӨ-ийн дурсгалт газруудыг хадгалж хамгаалах үйл ажиллагаа зүй ёсоор зохион байгуулагдсан байх учиртай. Энэ нь ирээдүйн шийдвэр гаргагч болохын хувьд залуучуудад дурсгалт газрын менежментэд хувь нэмрээ оруулах боломж өгч байгаа учир их чухал юм.

“Бидний өвөг дээдэс энэхүү дурсгалт газруудыг бидэнд өвлөн үлдээсэн учраас л бид тэдгээрийг үзэн баясаж, ойлгон бахархаж байгаа билээ. Үүний нэгэн адил үр хүүхдэдээ тэдгээрийг өвлөн үлдээх нь бидний эрхэм үүрэг. Бидний үр хүүхэд ч гэсэн тэдгээрийг харан баясаж, бахархаж урам зориг, онгод хиймороо хөглөж байх учиртай.”

Бээжинд болсон БНХАУ-ын ДӨ-ийн залуучуудын чуулга уулзалтаас гаргасан сурагчдын зөвлөмжөөс

ДӨ-ийн дурсгалт газрууд нь үр дүнтэй менежмент, хадгалалт хамгаалалтын үлгэр дууриал болох ёстой. Эдгээр хосгүй үнэт зүйлсийн хадгалалт хамгаалалтын өнөөгийн байдал нь тэр болгон бидний хүсэн хүлээсэн түвшинд хүрэхгүй байгаа нь харамсалтай. Гэхдээ хатуу хараа хяналтан дор хүрээлэн буй орчныг хамгаалах талаар хариуцлагатай тийм аялал жуулчлал нь /дурсгалт газрын/ тэдгээрийн олонхийг санхүүжүүлэхэд болон урт хугацааны туршид хадгалж хамгаалахад дорвитой хувь нэмрийг оруулж чадах билээ. ”

Аялал жуулчлал, экологийн ба тусгай хамгаалалттай газар нутаг, Х, Сибалос-Ласкурайр, IUCN, 1996

■ Сурагчийн гүйцэтгэх ажил 25

ДӨ БА АЯЛАН, ЖУУЛЧИЛЖ ТОГЛОХ НЬ

Зорилго: Дурсгалт газрын менежмент ба аялал жуулчлалыг холбогдолтой чухал асуудлыг хөгжилтэй тоглоомын хэлбэрээр ойлгож мэдэх



Дасгал ажил




Ангийн ажил



Хичээлийн 3 цаг



Нийгэм судлал, газар зүй



ДӨ-ийн байршлын газрын зураг, товч тодорхойлолт



Шоо ба зооснууд

Дүрэм:


□ Сурагчдыг 2-4 гишүүнтэй багуудад хуваа.

□ Эхний хичээл дээр баг бүрт мэдээ баримт, гэрэл зураг, байршил, гол шинжүүд гэх мэт ДӨ-ийн газрын тухай мэдээллийг өгнө. Баг тус бүр нь тоглоомын бүхий л явцад сонгосон түүх соёлын дурсгалт газрынхаа танилцуулгыг хийнэ. Багшийн дэмжлэгтэйгээр баг тус бүр өгөгдсөн дурсгалт газрынхаа аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөөг боловсруулна.

□ 2-р хичээл дээр сурагчид тоглоомоо эхэлж болно. Багууд шоо хаяж, тусгай заалт бүхий газруудыг дамжин нүүн уралдан тоглоно. Уралдаж эхлээд тусгай заалт бүхий нүдэн дээр очсон баг бүр заасан даалгаврыг гүйцэтгэнэ. /10-30 мин/ Хэрэв даалгавраа амжилтгүй гүйцэтгэвэл урагшилж чадахгүй болно.

□ “Зурагт хуудас” гэсэн нүдэн дээр буувал баг өгөгдсөн хугацаанд дурсгалт газрын тухай зурагт хуудас бэлтгэнэ. Даалгавруудыг бүрэн биелүүлж, зурагт хуудсаа дуусгаад “бариад” түрүүлж хүрсэн баг нь ялагч болно.

3-р хичээл дээр сурагчид үр дүнгээ ярилцаж, хийсэн зурагт хуудсаа танилцуулна.



Викторийн хүрхрэний Варден паркийн захиргаа Замби болон Зимбабве-д болсон Африкийн бүсийн Дэлхийн өвийн залуучуудын өнхдугаар чуулга уулзалтанд оролцогч сурагчид болон жуулчдад үзүүлэх сургалт хийж байгаань



<p>Гараа</p> <p>Таны сонгосон газар Дө-ийн жагсаалтад бүртгэгдсэн байна. Аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөөг бусад багуудад үзүүлэх</p> <p>1</p>	<p>ЗУРАГТ ХУУДАС</p> <p>2</p>	<p>ЗУРАГТ ХУУДАС</p> <p>3</p>	<p>Дурсгалт газар байгалийн гамшигт нэрвэгджээ. Юу болсныг тайлбарла. /Дурсгалт газрынхаа гол шинж байдлыг, учирсан хохирлыг авч үз./</p> <p>Гараа руу ухрах</p> <p>4</p>	<p>ЗУРАГТ ХУУДАС</p> <p>5</p>	<p>Энэ дурсгалт газарт их хэмжээний хог хаяжээ. Энэ асуудлыг шийдвэрлэх 5 арга замыг бич.</p> <p>6</p>
<p>ЗУРАГТ ХУУДАС</p> <p>7</p>	<p>ЗУРАГТ ХУУДАС</p> <p>8</p>	<p>ЗУРАГТ ХУУДАС</p> <p>9</p>	<p>Дурсгалт газар дээрх мэдээллийн төв тоног төхөөрөмж дутагдалтай байна гэж шүүмжилсэн. Төвийг шинэчлэн тоноглоход хандив оруулгахыг жуулчдаас хүсэн захидал бич.</p> <p>5 нүд ухрах</p> <p>10</p>	<p>ЗУРАГТ ХУУДАС</p> <p>11</p>	<p>Танай дурсгалт газар хамгийн олон жуулчид ирвэ. Сэргэн засварлах үндсэн төлөвлөгөөг эхлэхэд мөнөний боломжтой болов. Та юу эхлээд чухалчлах вэ? Яагаад? Үг хэлэхгүйгээр, зургаар үүнийг тайлбарла. Урагшва 5 нүд ахих.</p> <p>12</p>
<p>Дурсгалт газрын нэг хэсэг нь хамгаалалт муугаас муудан доройтжээ. Шийдвэрлэвэл зохих асуудлуудын жагсаалтыг гаргаж, арга хэмжээнүүдийн нээгдэх нь 5 асуудал бич.</p> <p>Гарааруу бүд</p> <p>13</p>	<p>Хадгалалт хамгаалалтын талаар бичсэн хүсэлт, өргөдөл нээлтэй шийдэгдэж болох юм. Яагаад мөнө хэрэгтэй болсон? Шалтгааныг оруулсан хүсэлтээ бич.</p> <p>5 нүд ахих</p> <p>14</p>	<p>Жуулчдад зориулсан шинэ буудал баригджээ. Менежер Дө-ийг хамгаалахын чухлыг сайн ойлгож байна. Буудлынхаа талаар сэтгүүлд гаргах зарлал бичих</p> <p>4-р нүдэн дээр оч</p> <p>15</p>	<p>ICOMOS-ын 5 жилийн тайлан үнэлгээ танай хамгаалалтын тайланг шүүмжилжээ.</p> <p>9 нүд ухрах</p> <p>16</p>	<p>ЗУРАГТ ХУУДАС</p> <p>17</p>	<p>Танай түүх соёлын дурсгалт газрын тухай үндэсний төлөвлөлтөөр нэвтрүүлжээ.</p> <p>3 нүд Урагшлах</p> <p>18</p>
<p>ЗУРАГТ ХУУДАС</p> <p>19</p>	<p>Танай дурсгалт газраар хэт олон жуулчид ирж, элэгдэл гэмтэлт учруулжээ. Танай дурсгалт газар дахь аялал жуулчлалын 5 давуу тал, 5 сул талыг бич.</p> <p>11 нүд Ухрах</p> <p>20</p>	<p>ЗУРАГТ ХУУДАС</p> <p>21</p>	<p>Дээвэрээс дуссаал дуссан учир хаагдажээ.</p> <p>5 нүд Ухрах</p> <p>22</p>	<p>ЗУРАГТ ХУУДАС</p> <p>23</p>	<p>Бариа</p> <p>Менежментийн сайн төлөвлөлтөөр танай дурсгалт газар сайн хамгаалагдажээ. Өөрийн менежментийн төлөвлөлт, тулгарч буй асуудлууд, түүнийг хэрхэн шийдвэрлэх тухай илтгэл</p> <p>24</p>



■ Сурагчийн гүйцэтгэх ажил 26

БҮДҮҮЛЭГ ЗАМБАРААГҮЙ ЖУУЛЧНЫГ ЭРХЭМ ХҮНДЭТ СОЁЛЧ ЖУУЛЧИН БОЛГОЁ

Зорилго: Хүнтэй жуулчин болох



Дурийн
Тоглолт




Ангийн
ажил



Хичээлийн
хэд хэдэн
цаг



Хэл, нийгэм
судлал



ДӨ-ийн газрын
зураг,
Тодорхойлолт,
гэрэл зураг



Тоглолтын
хэрэглэгдэх-
үүнүүд

□ Түүх соёлын дурсгалт газрыг үл хүндэтгэсэн, хог тарьдаг, ханан дээр эрээчих буюу өөр хэлбэрээр гэмтээн муутгадаг, нутгийн уламжлал, зан заншлаар доог тохуу хийж шоолдог, зөвхөн хувийн тав тухийг л боддог гэх мэт хүмүүжлийн буруу зуршил араншинтай жуулчдын талаар бичих буюу тоглолт хийхийг сурагчдад санал болго. Харин тодорхой зорилго чиглэлтэй, хүмүүжилтэй жуулчид нь дурсгалт газрын түүх, нутгийн гар урлал, урлагийн бүтээлүүд, дуу хөгжим, хоол хүнс, хувцас гэх мэт нутгийн уламжлал, зан заншил соёлын талаар илүү ихийг сурч мэдэх эрмэлзлэлтэй байдаг. Ийнхүү дүрийн тоглолтыг бичиж тоглох. Харин одоо доорхи бичигдсэн жуулчин хүний баримтлах үндсэн удирдамжийг үндэслэн орон нутгийн болон ДӨ-ийн газруудад очих сонирхолтой, тэдгээрт хүндэтгэл үзүүлдэг эрхэм жуулчдын тухай дүрийн тоглолт хийх талаар ярилц.

□ Орон нутгийн, үндэсний болон ДӨ-ийн газрыг сонгон авч уг газарт зорчих шинэ маягийн жуулчны төлөвшүүлэх нийтийг хамарсан арга хэмжээнүүдийн саналын жагсаалт гаргахыг санал болго. Гарсан саналуудаа хэлэлцэн, орон нутгийн жуулчны байгууллага буюу өв хамгаалдаг олон нийтийн байгууллагуудтай санал бодлоо хуваалцах

Жуулчдын мөрдвөл зохих ерөнхий заавар

Аяллаа төлөвлөхдөө жуулчид дараах зүйлийг Анхаарах:

1. Очих газрынхаа тухай боломжийн хирээр аль болох ихийг мэдэх
2. Хүрээлэн буй орчныг хамгаалах эрмэлзлэлээ харуулж буй нисэх онгоц, жуулчны операторууд, жуулчны газрууд, зочид буудал гэх мэт үйлчилгээний газруудыг дэмжиж тэднээр үйлчлүүлэх
3. Аль болохоор жуулчдын ид ачааллын бус үеэр амралт, аялал зугаалгаа төлөвлөх
4. Нэг их нэрд гараагүй газарт очиж дэмжихийг хичээх

Жуулчлах газартаа ирээд жуулчид дараах зүйлийг анхаарвал зохилтой:

1. Тухайн нутгийн соёл, уламжлалыг хүндэтгэх
2. Аялж буй газар орныхоо хүмүүсийн амьдрал, соёл, зан заншил, уламжлал зэргийг хүндэтгэн харгалзан үзэж байх
3. Тэндхийн уламжлалт бараа бүтээгдэхүүнээс нь худалдан авах, үйлчлүүлэх зэргээр орон нутгийн эдийн засагт тус дэм үзүүлэх
4. Дурсгалт газрыг орон нутгаас хадгалж хамгаалж буй үйл Ажиллагаанд хувь нэмэр оруулах
5. Байгаль орчин, түүний экосистем болон амьд байгалийг хадгалж хамгаалах
6. Соёлын үнэт дурсгалт газар болон хөшөө дурсгалыг гэмтээн сүйтгэхгүй байх
7. Эрчим хүч, усыг үр ашигтай арви гамтай хэрэглэх, хог хаягдлаа цэвэрлэх
8. Гал түймэр гаргахаас болгоомжилж сэргийлэх
9. Онцгой шаардлагагүйгээр чимээ шуугиан гаргахгүй байх
10. Зөвхөн зориулалтын зам зөргөөр явах

Жуулчдын дагаж мөрдвөл зохих ерөнхий заавар, Аялал жуулчлал зохион байгуулахад харгалзах хүрээлэн буй орчны ёс зүйн дүрэм, НҮБ-ын Хүрээлэн буй орчны тухай хөтөлбөр

Аялж очиж үзэх ДӨ-ийн газруудыг олшруулах

ДӨ-ийн жагсаалтад анх 1987 онд 12 дурсгалт газар бүртгэгдсэн билээ. 1978 он гэхэд хэдийн 289 газар жагсаалтад бүртгэгдэж, түүнээс 15 жилийн хойно буюу 2004 онд 754 болсон байв. Жил бүр ДӨ-ийн хороо жагсаалтандаа олон газар шинээр бүртгэж байдаг юм. ЮНЕСКО-гийн **ДӨ-ийн Залуучуудын Чуулга Уулзалтад** оролцсон залуучууд аль болох олон Дө-ийн газруудаар аялахыг маш их сонирхож байгаагаа илэрхийлжээ. Гэтэл олонхи сургууль ДӨ-ийн газруудаас алс хол байдаг бөгөөд тэдгээр дурсгалт газрыг үзэхэд маш их зардал шаардана. Ийм учраас сурагчид, сургууль хамт олноороо үзэхэд дурсгалт газрын төлбөрийг хөнгөлөх, бүр чөлөөлөх, түүнчлэн ДӨ-ийн газруудыг сургууль хамт олноороо үзэхэд нь бизнесийн байгууллагууд тээвэр, унааны зардлыг санхүүжүүлэх, ивээн тэтгэх зэргээр туслалцаа үзүүлж байх тухай саналуудыг гаргажээ. Зарим тохиолдолд сургууль хамт олон нь ДӨ-ийн газруудыг үзүүлэх мөнгө олох зорилгоор талх нарийн боов, чихэр жимсний худалдаа гаргах, машин угаах, урлагийн төлбөртэй тоглолт зохион байгуулах гэх мэтээр санхүүгийн хүчин чадлаа нэмэгдүүлэх өргөн хүрээтэй ажлыг хийдэг юм.



Соёлын болон байгалийн дурсгалт газрыг сурагчдад улам үзүүштэй, сонирхолтой болгоход бэлтгэхдээ нэлээд анхаарал бодлоготой хандах хэрэгтэй. Аялал жуулчлал нь хэдийгээр түүх соёлын дурсгалт газрыг устаж үгүй болоход нөлөөлдөг ч, зүй ёсоор сайн зохион байгуулж чадах юм бол тэдгээрийг цаашид удаан хугацаанд хадгалж хамгаалах юмсан гэсэн сурагчдын хүсэл тэмүүллийг хөгжөөж чадна.

Түүхэн хот Суходай ба
түүний орчмын түүхэн хотууд,
Тайланд улс
Patrimoine 2001/ P. Aventurier



■ Сурагчийн гүйцэтгэх ажил 27

ӨВИЙН ГАЗАР ДЭЭРХ ЖУУЛЧДЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ- ИЙН ХАНГАМЖИЙН БАЙДАЛ



Зорилго: Өвийн газар дээр жуулчдад үйлчлэх боломж хангамжийн талаар ажиглах, судлах арга барил эзэмших



Судалгааны ажил



Ангийн ажил



Хөтөлбөрөөс гадуурх ажил



Хичээлийн 2 цаг, сургуулиас гадуурх ажил



Хэл газарзүй Нийгэм судлал



Сурагийн дасгал ажлын хуудас “Өвийн газар дээрх жуулчдын үйлчилгээний Тоног төхөөрөмжийн хангамжийн байдал

- Жуулчид их ирдэг ойролцоох өвийн газрыг үзэх аяллын төлөвлөгөө гаргах
- Сурагчийн дасгал ажлын хуудсыг хувилж, сурагч бүрт өгөх
- Сурагчдыг очих гэж байгаа дурсгалт газрынх нь тухай мэдээллээр хангах хүснэгт бөглөх, тайлан бичихийн ач холбогдлыг ойлгуулах
- Сурагчид өөрсдийн тайлан /илтгэлийг/ хийсэн дүгнэлтийн хамт багшдаа өгч тоног төхөөрөмжийн хангамжийг хэрхэн сайжруулах талаар ярилцах

ДӨ-ийн дурсгалт газруудад:

- Эмзэг, эрхэм нандин газарт учирч болох аюулаас урьдчилан сэргийлэхийн тулд дурсгалт газар ирж буй жуулчдын тоонд хяналт тавих
- Өндөр настан, хүүхэд, тахир дутуу иргэдэд зориулсан тусгай замтай байх
- Гол гол дурсгалт газрын орчимд худалдаа наймааны ш газруудыг байлгахгүй байх

БНХАУ-ын Бээжин хотод болсон ДӨ-ийн залуучуудын чуулга уулзалтаас гаргасан сурагчдын зөвлөмжөөс

■ Сурагчид тоног төхөөрөмжийн боломж хангамжийн байдалд үнэлгээ өгөх, ингэхдээ тохирсон хүснэгтийн нүдэнд тэмдэг зураас тавина.

Үйлчилгээ хангамж	Хангалтгүй	Хангалттай	Сайн	Маш сайн
Тэмдэг дохио				
Машины зогсоол				
Угаалгын газар				
Мэдээлэл				
Үзэсгэлэн				
Бэлэг дурсгал				
Хогийн сав				
Цэвэрч байдал				
Тайлбарлах, сурталчлах байдал				
Зуушны газар				
Бусад				

ДӨ-ийн дурсгалт газрын менежерт мэдээлэх нь

Хүндэт Ноён/ Хадагтай

Би саяхан танай дурсгалт газар зочилж ийм дүгнэлтэд хүрлээ. . . .

- Дурсгалт газрын үйлчилгээ, тоног төхөөрөмжийн хангамж хангалттай
- Дурсгалт газрын үйлчилгээ, тоног төхөөрөмжийн хангамж хангалтгүй ба цаашид доорхи зүйлсийг хийж сайжруулах хэрэгтэй байна. Үүнд:

.....

Миний энэхүү тайлан нь танай дурсгалт газрын цаашдын хөгжилд тус дэм болно гэдэгт би найдаж байна.

Нэр:

Гарынүсэг:

он, сар, өдөр

Сурагчид энэ хүснэгтийг бөглөөд багшдаа өгнө.

Үр ашигтай аялал жуулчлал ба Дэлхийн Өв

Шинэ технологи хөгжсөнөөр ДӨ-ийн болон бусад дурсгалт газруудад яг тэнд нь очихгүйгээр аялах боломжтой болж байна.

Жишээ нь: зарим орнуудад цэнгэлдэх хүрээлэн, музейнүүд, бүхэл бүтэн тосгон эсхүл хотын хэсгийг зохиомлоор харуулсан асар том амралтын газруудтай болж байна. Английн Иоркод жуулчид газар доогуур дахин шинээр бүтээн барьсан Жорвикийн Викинг тосгонд очиж жижиг автомат галт тэргээр аялж болох юм. Амралт зугаалгын паркуудад 3 хэмжээст дэлгэц болон тусгай гэрлийн нөлөөг ашиглан хийсэн маш их сонирхоп татсан нэг зүйл бол өнөөдөр хүмүүсийг сансар огторгуйд ч оруулж чадах янз бүрийн газарт аялуулж болох дуриамал тээврийн хэрэгслүүд бүтээсэн явдал юм. Ингэхдээ хүмүүсийг хөдөлж явдаг тусгай сандлуудад суулгаж бэхэлдэг юм. Энэ бол аялал жуулчлалын нэг шинэ хэлбэр юм. Багш сурагчид хамтран аялал жуулчлалын энэхүү шинэ хэлбэрийн давуутай болон дутагдалтай талуудын талаар болон ялангуяа ирээдүйд хэрхэн хөгжих тухайд шүүн ярилцаж болох юм.




Ашигласан материалын жагсаалт

Би аялагч, та зочлогч, тэд нар болохоор жуулчид. Эндээс л өөр хоорондоо зөрчилдсөн зүйлүүд гарч ирж байгаа юм. Бид үзэсгэлэнт сайхан онгон зэлүүд газруудаар аялах дуртай. Гэтэл нөгөө талаас тэгээж буй хүмүүсийн үйл ажиллагаа биднийг айлган цочирдуулж байна. Хүн болгон л өөрийн чөлөөт цагаа аятайхан өнгөрүүлэх сонирхолтой. Ийнхүү бид хамгийн их шагшин бахдаж явдаг гайхамшигт дурсгалт газрууддаа нийт олноороо аюул учруулж байгаа юм. Үнэндээ бид дэлхийн олон үндэсний паркууд болон бусад тусгай хамгаалалттай газар нутагт дур сонирхолтой байдгаараа бид өөрсдөө аюул тарьж байгаа билээ.


Адриан Филлипин, IUCN 1996

118



ДӨ-ийн газруудын талаар олон олон CD- ROM гарах боллоо. ЮНЕСКО-гийн ДӨ-ийн дурсгалт газруудын CD- ROM ын тусламжтайгаар дэлхийн бүх өнцөг буланд байгаа Камбожийн Анкор гэх мэтийн ДӨ-ийн 100 гаруй дурсгалт газруудад айлчлах боломжтой боллоо. Сайтар зохиомжилсон үзэсгэлэн болон www сайтууд ч ДӨ-ийн газруудад зочлох боломжийг сурагчдад олгож байна. Хэрэв та интернетэд холбогдсон бол ЮНЕСКО-гийн ДӨ-ийн төвийн вэб сайтад орж, ДӨ-ийн жагсаалтад орсон 754 түүх соёлын дурсгалт газруудын тухай илүү ихийг сурч мэдэх болно.

Викторийн Хүрхээд болсон Дэлхийн Өвийн Залуучуудын Чуулга Уулзалтад оролцогч сурагчид Зимбези усан онгоцон дээр амьтан ургамлын ертөнцтэй танилцаж байгаа нь



ДӨ-ийн дурсгалт газрууд дахь аялал жуулчлалын менежмент

ДӨ-ийг хамгаалахад тулгамдсан гол асуудал бол сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр дурсгалт газруудаар аялах боломжийг хүмүүст олгох явдал юм. Хүрч очих боломжгүй байсан учир гоё сайхнаараа, бүрэн бүтнээр хадгалагдан үлдсэн дурсгалт газрууд нь өнөөдөр аялал жуулчлал зохион байгуулагчдын анхаарал, сонирхлыг их татах боллоо. Ийм учраас ДӨ-ийн дурсгалт газар бүрт аялал жуулчлалын зөв зохистой менежмент явуулах шаардлага гарч байна.

Хятадын Их Цагаан хэрэм нь 1987 онд ДӨ-ийн жагсаалтад бүртгэгдсэн. Жил бүр сая сая гадаад дот оодын жуулчид ирж, үзэж байдаг Цагаан хэрэмний тийм нэг хэсгийн тоонд Минг гүрний үед Бээжингийн ойролцоох тоосго, чулуугаар барьсан Их Хэрмүүд орно. Бүр 2000 жилийн өмнөх үеийн ихээхэн сонирхол татсан эртний балгас тууриудыг Гансуу мужийн Их говь цөлд үзэж болно. Тэрхүү хэврэг материал бүтцүүдийг Их говийн хуурай нөхцөл өнөөг хүртэл хадгалж иржээ. Эдгээр балгас нь шавар цайзтай бөгөөд хойт зүгээс ирэх нүүдэлчдийн довтолгоог мэдэгдэх дохио өгөх гэрэлт цамхаг болгож гэрэлтүүлэхэд бэлэн байх ёстой чулуун багануудыг ч багтааж байдаг. Эдгээр балгас туурь байдаг Их Цагаан хэрэмний энэ хэсэгт цөөн тооны жуулчид ирдэг бөгөөд ирэх жуулчдын тоог цаашид нэмэгдүүлэх нь түүхэн энэ дурсгалт газрын хэврэгхэн туурь үлдэцийг устгах аюул учруулах вий гэж сэтгээл зовоож байна.

Хамгийн их сэтгэл булаам ДӨ-ийн байгалийн дурсгалт газрын нэг бол Шинэ Зеландын баруун урд хэсэгт орших Те Вахипоунаму юм. Шинэ Зеланд дэлхийн олон орноос алс зайдуу оршдог нь түүний хосгүй баялаг, биологийн олон төрөл

зүйлийг хэвээр нь хадгалан хамгаалахад тус болсоор байдаг юм.

Аялал жуулчлал үсрэнгүй хөгжиж, дэлхийн тээврийн хэрэгсэл асар их боловсронгуй болсон нь жуулчдад Шинэ Зеланд хүрэх өргөн боломжийг нээж өгсөн юм. Ийм учраас жуулчдад уг дурсгалт газрыг үзэхэд дөхөм болгох үүднээс түүгээр дайруулан Хааст, Милфорд гэсэн 2 хотыг холбосон зам тавих тухай асуудал маргаантай хэвээр байна. Ийнхүү зам тавихын илт давуу талууд болон түүний сөрөг талуудыг сурагчийн гүйцэтгэх ажил 28-аар хэлэлцэх болно.



Те Вахипоунаму,
Шинэ Зеланд
ЮНЕСКО/ F. Dondau



Дэлхийн Өвийн
газрын зураг



Дэлхийн Өв ба
хүрээлэн буй орчин

■ Сурагчийн гүйцэтгэх ажил 28

ДЭЛХИЙН ӨВИЙН БАЙГАЛИЙН ДУРСГАЛТ ГАЗРЫГ ДАЙРУУЛАН ЗАМ ТАВИХ

Зорилго: Хөгжил, аялал жуулчлал ба Дэлхийн өвийн дурсгалт газрын талаарх олон янзын үзэл Бодол, сонирхолыг ойлгох



Дүрийн
Тоглолт



Ангийн
ажил



Хөтөлбөрөөс
гадуурх
ажил



Хэд хэдэн
хичээлийн цаг,
сургуулиас
гадуур ажлын
цаг



Газар зүй,
Математик,
Шинжлэх
ухаан, хэл



Дасгал ажлын
хуудас "Дэлхийн
Өвийн байгалийн
дурсгалт газар
дайруулан зам
тавих" товч
тодорхойлолт,
Дэлхийн Өвийн
газрын зураг

□ Ангийг 5 бүлэг болгон хувааж, дасгалын хуудсыг хувилж, бүлэг бүрт тарааж өгнө. Тохирсон дүрээр мэдэгдэл хийлгэж өрсөлдөхийг сурагчдад санал болго. Дараа нь дүр бүрийг мөн бүлэг бүрийг дугаарлана. (1-5) Бүлэг бүрээр өөрсдийнх нь мэдэгдлийг цааш нь дэлгэрүүлж боловсруулахыг санал болго.

□ Мэдэгдлээ бэлтгэхэд хүрэлцэхүйц хугацаа өнгөрсний дараа бүлгүүд өөр өөрсдийн мэдэгдлийн үзэл санааг хамгаалах зорилгоор ангид зохион байгуулагдах хэлэлцүүлэгт оролцох нэг нэг хүнийг томилно. Мөн бүлэг бүрээс хэлэлцүүлгийн дараа шийдвэр гаргах шүүгчийн бүрэлдэхүүнд орох 1 хүнийг томилно. Ийнхүү хэлэлцэж, зам тавих хэрэгтэй юу үгүй юу гэдэг талаар шийдвэрээ гаргана.



1. Шинэ Зеландын унаган байгальд зам тавих нь тийм шаардлагатай зүйл биш. Зам тавих юм бол энэ унаган төрхөөрөө байгаа байгаль дэлхийд болон түүний эдийн засгийн онцлогт аюул авчрах болно. Энэ зам бол Шинэ Зеланд очих жуулчдын замыг л өөрчилж байгаагаас биш илүү олон хүнийг татаад байгаа юм биш. Бидэнд ч тийм хэрэгцээ байхгүй. Тийм юм хэзээ ч болохгүй.

Ой болон шувуу хамгааллын нийгэмлэгийн захирал

2. Энэхүү замыг тавих нь далайн эргийн аялал жуулчлал өсч идэвхжиж байгаатай шууд холбоотой. Энэ зам бол бидэнд дутагдаад байгаа бүхнийг нөхөх учиртай. Хэрэв Милфорд руу явдаг автобусны 10 хувь нь далайн баруун эрэгт ирдэг байсан бол бидний аялал жуулчлалын үйлдвэрлэл 2 дахин нэмэгдэхсэн.

Вестландын нутгийн зөвлөл, Ерөнхий менежер



3. Хөндийн дундуур энэ замыг тавих нь нуга намгийн экологийн байдлыг эмзэг болгох аюултай. Хөндийн хажуугийн бэлээр зам гаргавал бас тус дурсгалт газрын гоо үзэмж, үзэсгэлэнт байдлыг эвдэх болно.


Ойн зохицуулагч

4. Үзэсгэлэн төгөлдөр байгаль дэлхий нь үнэхээр гайхамшигтай. Энэхүү зам нь Шинэ Зеландын дотоодын жуулчлалыг өргөжүүлээд зогсохгүй Олон Улсын аялал жуулчлалд Шинэ Зеланд руу очих бас нэг сайхан боломжийг нээж байна. Хаастаас Милфорд руу дан машинаар явах боломжтой болно. Тээврийн сайд



5. Тайлангаас харахад энэ санал нь хор хохирол учруулахгүйг харж болно. Газар дээр хийсэн урьдчилсан судалгаанууд их хэмжээний өртөг зардал шаардахгүйг харуулж байна. Энэ нь түүнээс олох орлогын үлэмж хэсгийг хүртэж байгаа аялал жуулчлалынхан болон Өмнөд Вестланд ба Фиордландын хүн амд үр өгөөжтэй.

Отадийн Дейли Таймс сонины редактор
Греймонтын Их Сургууль. Шинэ Зеланд



СЭДВИЙН ДҮГНЭЛТ: ДЭЛХИЙН ӨВ БА АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Урлаг

Аялал жуулчлалын ажлыг зохиох, зурагт хуудас ашиглан түүх соёлын дурсгалт газарт ирэгчдийн анхаарлыг татах

Тухайн газар аялах мэдээллийн товхимлыг бэлтгэх, боломжтой бол хэвлүүлэн гаргах

Дурсгалт газрыг зурах, будах, зочлох буюу тухайн газрын тойм төсөөллөө хөгжүүлэх, жишээлбэл, хийсвэр урлаг, хувцасны загвар гэх мэт

Орон нутгийн, үндэсний болон бүс нутгийн ДӨ-ийн газруудыг хадгалж хамгаалах хэрэгцээ шаардлагын талаар зурагт хуудас гаргах

Тухайн газрын өнгөрсөн үеийн дүрс зураг, түүний бүтээгдсэн шалтгаан мөн жуулчлалын нөхцөл байдал өөрчлөгдсөн эсэх талаар судалгаа хийх

Газар зүй/ түүх

Яагаад энэ газар удаан хугацааны туршид жуулчдын зорьж ирдэг газар болсон юм бэ? Энэ талаар ярилц.

Түүх соёлын дурсгалт газрын түүх нь орон нутгийн, үндэсний, бүс нутгийн болон тив дэлхийн аялал жуулчлалд холбогдолтой болох талаар ярилц.

Дурсгалт газрын түүхийг жуулчдад хэрхэн тов тодорхой тайлбарлах талаар саналаа хэлэх.

Жуулчдын нөлөөнд дурсгалт газрууд хэрхэн автагдан элэгдэж байдгийг судалж, тусгай зам, зөрөг гаргах зэргээр шийдвэрүүдээ хэлэлцэн ярилц

Интернет

Дэлхийн Өвийн тухай болон тодорхой нэг улс орны эсхүл бүс нутгийн аялал жуулчлалын тухай илүү их мэдээлэл авахыг хүсвэл "World Heritage" ба "Tourism" гэсэн түлхүүр үгсийг ашиглан интернетэд холбогдоно уу.

Хэл утга зохиол

Нийт хүмүүст, тахир дутуу жуулчдад, гадаадын жуулчдад, залуучуудад гэх мэтээр жуулчдад зориулсан мэдээллийн ухуулах хуудас гаргах

Түүх соёлын дурсгалт газраа сурталчилсан уриа лоозон бичих

Түүх соёлын дурсгалт газрын аяллаар видео бичлэг хийх

Өвийн дурсгалт газрын үнэ цэнэ, аялал жуулчлалаас гарч болох аюул хохирол зэргээр дүрийн тоглолт хийж, мэтгэлцээн зохиох

Дурсгалт газрын тухай мэдээллийг бусад хэл рүү орчуулах

Орон нутгийн, бүсийн болон үндэсний Дэлхийн Өвийн газруудын талаарх сурталчилгааны ухуулах хуудаснуудынхаа цар хүрээг нь судал.

Тууж өгүүллэгт дурьдагдсан ямар нэг дурсгалт газрын тухай ишлэл тайлбар зэргийг судалж, зохиолоос түүвэрлэж авсан тайлбар ишлэлийг жуулчдад зориулсан товхимол болон бичиг баримтад хэрхэн оруулах тухай ярилцах.

Математик

Дэлхийн Өвийн газруудын талаарх жуулчдын чиг хандлага, хамаарлын талаар график, хүснэгт, статистик тоо бүртгэл ашиглан ярилц, асуулга судалгааны ажлын үр дүнг тооцон гаргах.

Нийгмийн шинжлэх ухаан

Асуулгын журмаар дурсгалт газар ирсэн жуулчдын дунд судалгаа явуулах Дэлхийн Өвийн газрын хамгаалалд аялал жуулчлалын үзүүлэх сайн нөлөө, учруулах хор хохирлыг мэдэж авах зорилгоор дурсгалт газрын менежерээс ярилцлага авах.

Залуучууд ба Дэлхийн Өвийн хадгалалт хамгаалалт

Танзаны БНУ, Киллманжаро үндэсний парк, ЮНЕСКО/М. Batisse



Залуучууд ба Дэлхийн Өвийн
хадгалалт хамгаалалт

**Байгаль орчныг шинжлэх ухааны
үндэс; эх сурвалж; харагдах
байдал; туршлага зэрэг олон
янзын аргаар ойлгож болно.**

**Ерөнхийлөгч Nelson Mandela,
1994 оны 10 сар**

Залуучууд ба Дэлхийн Өвийн хадгалалт хамгаалалт

	Хуудас
Зорилго	125
Мэдлэг	125
Арга хандлага	125
Ур чадвар	125
Залуучууд бай Дэлхийн Өвийн хадгалалт хамгаалалт	126
Сурагчийн гүйцэтгэх ажил 29: Экосистемүүд ба байгалийн тогтоцууд	127
Хүрээлэн буй орчны Олон улсын хадгалалт хамгаалалт	127
Сурагчийн гүйцэтгэх ажил 30: Хүрээлэн буй орчин элэгдэн доройтож байгаа нь	129
Дэлхийн Өвийг хадгалж, хамгаалах замаар биологийн төрөл зүйлийг хамгаалах нь	132
Сурагчийн гүйцэтгэх ажил 31: Биологийн олон төрөл зүйлд аюул учруулж болох хүчин зүйлс	133
Соёлын олон төрөл зүйл ба биологийн олон төрөл зүйл	133
Байгалийн төрөл зүйлийн хөгжил ба мөхөл	134
Сейчеллес дэх Майн хөднийн байгалийн дархан цаазат газар	135
Энэтхэгийн Манасын дархан цаазат газар	136
Шинэ Зеландын Те Вахипоунаму	136
Сурагчийн гүйцэтгэх ажил 32: Гондваналандыг эвлүүлэн тоглох нь	137
Сурагчийн дасгал ажлын хуудас: Гондваналандыг эвлүүлэн тоглох нь	138
Сурагчийн дасгал ажлын хуудас 33: Дэлхийн өвийн байгалийн дурсгалт газруудыг ижил шалгууруудаар харьцуулж таних	140
Экологийн болоод соёлын хувьд тогтвортой хөгжил	140
Мауританий Аргуйн эргийн Үндэсний парк	141
Сурагчийн гүйцэтгэх ажил 34: Хүрээлэн буй орчныг хамгаалах нь	142
Сурагчийн гүйцэтгэх ажил 35: Экологийн хувьд тогтвортой хөгжлийг хангах үйл ажиллагаа	143
Сурагчийн гүйцэтгэх ажил 36: Өвийн газруудаар аялах нь	143
Манай гаригийн ирээдүй	144
Сэдвийн дүгнэлт: Дэлхийн өв ба хүрээлэн буй орчин	145

Зорилго



Мэдлэг

- Байгалийн болон соёлын хүрээлэн буй орчин ба хүн, хүрээлэн буй орчны хоорондын харилцан үйлчлэл
- Тусгай хамгаалалттай Дэлхийн Өвийн дурсгалт газрууд болон биологийн төрөл зүйлүүд, устаж үгүй болохын аюул нүүрлээд байгаа ургамал, амьтныг хамгаалаллын ач холбогдол
- Дэлхийн Өвийн Конвенц нь хүрээлэн буй орчныг хамгаалах Олон Улсын хамтын үйл ажиллагааны чухал туслагч болох нь зэрэг чиглэлээр сурагчдын мэдлэг, ойлголтыг хөгжүүлнэ.

Арга хандлага

- Хүрээлэн буй орчныг хамгаалах ёс суртахууны тууштай зарчим, үүрэг хариуцлагыг төлөвшүүлэх
- Дэлхий дээр ургамал, амьтан, биологийн төрөл зүйлийг хамгаалахад дэмжлэг туслалцаа үзүүлэх, улмаар хойч үеийнхэн эрэлт хэрэгцээгээ хангах нөхцлийг нь үгүй хийчихгүйгээр хадгалж үлдээх арга ухаан эзэмшихэд нь сурагчдыг дэмжин хөгжүүлэх

Ур чадвар

- Хүрээлэн буй орчин ялангуяа Дэлхийн Өвийг хамгаалах үйл хэрэгт оролцох
- Ирээдүйд эх дэлхийгээ хүн төрөлхтөнтэй нь эрүүл саруул үлдээх үүднээс байгалийн тогтвортой хөгжлийг хангах үйл ажиллагаанд оролцох
- Дэлхийн Өвийг хамгаалах удирдлагын ухаанд сургах зэрэг ур чадвар эзэмшихэд нь сурагчдад тусална.


Залуучууд ба Дэлхийн Өвийн хадгалалт хамгаалалт

Дэлхийн Өвийн хадгалалт хамгаалалт нь хүрээлэн буй орчин, түүний соёлын ба байгалийн олон төрөл зүйлийг хамгаалах, хүн ба хүрээлэн буй орчин хоёрын харилцан үйлчлэлд маш чухал хувь нэмэр оруулдаг юм.

Түүнчлэн Дэлхийн Өвийн хадгалалт хамгаалалт нь ялангуяа устаж үгүй болохын аюул учирч буй ургамал амьтны тоо улам бүр өсөн нэмэгдэж байгаа болон биологийн төрөл зүйл мэдэгдэхүйц цөөрч байгаа зэрэг хүрээлэн буй орчны холбогдолтой өнөөгийн амин чухал асуудлуудад олны анхаарлыг хандуулахад түлхэц үзүүлж байгаа юм. Дэлхийн Өвийн газруудын хадгалалт хамгаалалтыг дэлхий дахины экологийн тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд авч үзэж байгаа билээ. Ингэхдээ Дэлхийн Өвийн газруудын хамгаалалтын статусыг орон нутгийн хүн амын амжиргааны эх үүсвэр, эдийн засгийн боломжтой нийцүүлж байгаа явдал нь бас чухал ач холбогдолтой юм. Нэмж хэлэхэд, Конвенц нь соёлын болон байгалийн өвийг хоёуланг нь мөн тэр хоёр хоорондоо онцгой харилцан холбоотой байдгийг хүлээн зөвшөөрч байдаг билээ.

Үүгээрээ Конвенц нь дурсгалт газрын байгалийн болон соёлын бүхий л олон төрөл зүйлийг хамгаалахад чиглэгдсэн тийм хүрээлэн буй орчныг хамгаалах нэгдмэл арга хандлагыг хэрэгжүүлэх ховор сайхан боломжийг олгож байна.

2004 оны байдлаар Дэлхийн Өвийн жагсаалтад бүртгэгдсэн 149 байгалийн дурсгалт газрууд нь олон төрөл зүйлийн амьтан, ургамал, экологийн системүүд, геологийн тогтоцууд, байгалийн болон биологийн үйл явц, байгалийн унаган орчинг төдийгүй ер бусын үзэсгэлэнтэй болон гоо сайхны хувьд онцгой газар нутгийг хамгаалж байдаг билээ. Эдгээр газрууд нь манай дэлхийн 10 орчим хувийг хамарч байгаа бөгөөд тусгай хамгаалалттай газар нутгийн нэгэн адил хадгалагдаж хамгаалагдаж байна.



Залуучууд хүрээлэн буй орчноо хамгаалах үйлсэд бүтээлчээр оролцохын тулд тулгарч буй хурц асуудлууд, зорилтуудыг болон хэрэгжүүлэх арга замыг сайтар ухамсарласан байх шаардлагатай. Хүрээлэн буй орчныг хамгаалахад Дэлхийн Өвийн Конвенцийн гүйцэтгэх чухал үүргийг ойлгож мэдсэнээр тэрхүү зорилгыг хэрэгжүүлэхэд тусалж чадна. Хүрээлэн буй орчныг хамгаалах гол гол асуудлууд, тэдгээрийн Дэлхийн Өвийн хадгалалт, хамгаалалтад үзүүлэх ач холбогдлын талаар гарын авлагын энэ бүлэгт тусгасан болно.

Гремоутын ахлах сургуулийн сурагчид Шинэ Зеландын баруун урд орших Те Вахипоунамийн мөсөн голыг судалж байгаа нь ЮНЕСКО

■ Сурагчийн гүйцэтгэх ажил 29

ЭКОСИСТЕМҮҮД БА БАЙГАЛИЙН ТОГТОЦУУД

Зорилго: Экологийн системүүд болон Дэлхийн Өвийн байгалийн дурсгалт газруудын төрөл хэлбэрийн талаар илүү мэдэж ойлгох



Дасгал



Ангийн ажил



Хичээлийн 2 цаг



Газар зүй, Шинжлэх ухаан



Дэлхийн өвийн газрын зураг, товч тодорхойлолт

□ Танай дэвсгэр нутагт экосистемүүд болон байгалийн тогтоцуудын төрөл хэлбэрүүдийн ямар нэг жишээ бий юу. Түүний үндсэн шинж төлөв байдал нь (намаг, нуур ...) ямар вэ? Амьтан ургамалын ямар төрөл зүйлүүд энэ дурсгалт газарт чинь байна вэ? (... усны шувууд гэх мэт).

□ Оюутнуудаар товч тодорхойлолтуудыг нь судлуулан шалгуулж, Дэлхийн Өвийн 20 байгалийн дурсгалт газрыг сонгон авч, дараах төрөл хэлбэрүүдэд ангилан бичүүл.

- ой мод
- эрэг орчмын газар
- уулс

□ Олж мэдсэн зүйлийнхээ дагуу ярилцаж, манай оронд байгаа адил төстэй газруудыг дээрхийн адил 3 төрөл хэлбэрт хуваан жагсааж бичүүл.

□ Дэлхийн Өвийн жагсаалтад орсон газруудаас дор дурдсан төрөл хэлбэрүүдэд жишээ татахыг сурагчдад санал болго.

- Далайн шүрэн уул
- Ой мод
- Арлууд
- Говь цөл
- Намгархаг газрууд

Дараа нь үр дүнгийх нь талаар хэлэлц.

Хүрээлэн буй орчны Олон Улсын хадгалалт хамгаалалт

Өнөөдөр хүн төрөлхтөн агаар, ус, хөрсний бохирдол, дэлхийн цаг уурын дулаарал, азоны давхрага цоорох, байгалийн болоод нөхөн сэргээгдэшгүй нөөц баялаг шавхагдах, амьтан ургамлын зарим төрөл зүйлүүд устаж үгүй болох биологийн олон төрөл зүйл цөөрөх зэргээр хүрээлэн буй орчин ерөнхийдөө доройтон муудах аюул заналтай учраад байна. Иймээс хэдийнээ бий болсон эвдрэл хохирлыг нөхөн сэргээх, дэлхийн байгаль ба соёлын олон төрөл зүйлийг хадгалж хамгаалан одоо ба ирээдүй хойч үеийнхээ тогтвортой хөгжлийг баталгаажуулах үүднээс бид бүхэн зайлшгүй хамтран ажиллах шардлагатай болж байна.



Харилцах
хаягууд


Дэлхийн Өвийг, ялангуяа Дэлхийн Өвийн байгалийн дурсгалт газрыг хамгаалах нь хүрээлэн буй орчныг хамгаалах, сайжруулахад үнэтэй хувь нэмэр болдог. Дэлхийн Өвийн Конвенцоос гадна хүрээлэн буй орчныг хамгаалах талаар Олон Улсын хэд хэдэн гэрээ хэлэлцээр байдаг юм. Эдгээр гэрээ хэлэлцээр, тэдгээрийн нарийн бичгийн дарга нарын газрын холбогдолтой мэдээ мэдээллийг Дэлхийн Өвийн төвийн вэбсайтаас аваарай. /<http://unesco.org/whc/>

Дэлхийн Өвийн Конвенц нь 1972 оны 9 дүгээр сард Швед улсын Стокгольмд болсон Хүрээлэн буй орчны асуудлаарх НҮБ-ын дэлхийн анхны Бага хурлаас хойш 2 сарын дараа батлагдсан. Стокгольмын Бага хурлаас хойш 20 жилийн дараа 1992 оны 6-р сард Бразилийн Рио дэ Жанеро-д болсон "Хүрээлэн буй орчин ба хөгжил" сэдэвт НҮБ-ын Бага хурал дээр дэлхийн удирдагчид уулзав. Энэхүү Рио-гийн Дэлхийн дээд хэмжээний уулзалт гэж алдаршсан уулзалтаар хүрээлэн буй байгаль орчны сэтгэл түгшээм элэгдэл доройтлыг дүгнэн үзэх, түүнийг сайжруулах стратеги бодлогыг боловсруулах асуудлыг авч хэлэлцсэн билээ.

Чуулга уулзалтаас эх дэлхийг авран хамгаалах тухай Санамж 21 хөтөлбөрийг хэлэлцэн баталсан ба 36-р бүлэгт нь түүнд боловсрол болон залуу үеийнхний гүйцэтгэх үүргийг тодорхой тусгасан байна. Үүний дээр биологийн төрөл зүйлийг хамгаалах хамтын үйл ажиллагаанд уриалсан Биологийн төрөл зүйлийн тухай Конвенцид 181 орон болон Европын нийгэмлэг гарын үсэг зуржээ. Рио-гийн Дэлхийн дээд хэмжээний уулзалтаас өөр хоёр Олон Улсын Конвенц, мөн ой хамгаалах тухай мэдэгдэл гарсан.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Конвенц нь 1994 оны 3 дугаар сарын 21-нд мөрдөгдөж эхэлсэн бөгөөд 186 ороноор батлагдсан. Энэ Конвенц агаар дахь хүлэмжийн хийн бүтцийг тогтворжуулах замаар Дэлхийн цаг уурын дулаарлын эсрэг тэмцэх зорилготой.

Цөлжилттэй тэмцэх НҮБ-ын Конвенц нь ган гачигийн аюулд тулгараад байгаа болон цөлжих үйл явц идэвхижиж байгаа улс орнуудад, ялангуяа Африкт 1996 оны 12 дугаар сарын 26-наас хэрэгжиж эхэлсэн. Конвенцийн зорилго бол ган гачиг, цөлжилтөөс хүн амд учирч буй бэрхшээл зовлон, экологийн гамшгийг арилгахад оршино.



Ичкеюп
байгалийн
цогцолбор
т газар,
Тунис
INCAFO


Түүнчлэн Риогийн Дэлхийн Дээд Хэмжээний уулзалтаас бүх төрлийн ойн менежмент, хадгалалт хамгаалалт ба тогтвортой хөгжлийн тухай ерөнхий тохиролцоонд хүрэх зарчмуудын хууль бусаар ашиглах тухай мэдэгдэл батлагдсан. Үүний зорилго нь ялангуяа ойжуулах ба байгалийн нөөц баялагийг хадгалж хамгаалах замаар эх дэлхийгээ цэцэрлэгжүүлэх хөдөлгөөнд бүх улс орныг өргөн оролцуулах явдал юм.

Үүний зэрэгцээ зэрлэг ургамал, амьтдын төрөл зүйлийг Олон Улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенц /CITES/ 1975 онд батлагдсан. CITES нь ховор амьтан ургамлыг улс хооронд худалдаалахад дэлхий дахины хяналтыг тогтоодог. Ховор амьтан ургамал сөнөж мөхөхийн аюулд орсон тохиолдолд Конвенц нь байгалийн төрөл зүйлийг бүх төрлөөр худалдан арилжаалахад хориг саад тавьдаг.

1971 оны Олон Улсын хэмжээнд ач холбогдол бүхий ус чийг намгархаг нутгийн тухай Рамсарын Конвенц нь ус чийг, намгархаг нутаг болон түүний нөөц баялгийг хадгалж хамгаалах, ухаалаг, зүй зохистой ашиглах талаарх Олон Улсын хамтын ажиллагааг зохицуулах Засгийн газар хоорондын хэлэлцээр юм.

Одоогийн байдлаар нийт 87 сая га талбай бүхий 1.094 ус чийг намгархаг газар нутаг Олон улсын хэмжээний ач холбогдол бүхий ус чийг намгархаг нутгийн Рамсарын жагсаалтад орохоор тодорхойлогдсон байна. Рамсарын жагсаалтад бүртгэгдсэн 25 газар нь Дэлхийн Өвийн жагсаалтад мөн орсон байна. Үүнд:

Алжир	Ла Валлее д лхерир /Дэлхийн Өвийн Тас сили и Ажжер газартай нийлсэн/	Унгар	Хортобажи байгалийн цогцолборт газар
Австрал	Алдарт элсэн цөл /Дэлхийн Өвийн Фразер араптай нийлсэн/ Какаду байгалийн цогцолбор газар	Энэтхэг	Кеоладео байгалийн цогцолбор газар
Бангладеш	Сандарданс	Ливан	Тайр
Болгар	Сребарна байгалийн дурсгалт газар	Майритан	Банк д Аргуйн байгалийн цогцолбор
Канад	Энх тайвны- Атабаска Делта Америк тогоруу Зуны цогцолбор /Дэлхийн Өвийн Воод Буфало байгалийн цогцолбор газарт орсон/	Нигер	Нигерийн W байгалийн цогцолбор газар
Коста Рика	Кокосийн үндэсний арал	Филиппин	Туббатаха Рийф Марин парк
Конгийн ардч илсан БН Улс	Вирунга байгалийн цогцолбор газар	Румин	Данюбийн мөрний бэлчир
Франц	Монт-Сэйнт-Мичел ба түүний	Оросын	Сэлэнгэ мөрний бэлчир /ДӨ болох Байгалы/ нуурын хэсэг/
Унгар/		Холбооны Улс	Джоудж Шувууны Үндэсний Дархан Цаазат газар
Словак БН Улс	Аггтелек Карст ба Словак Карстийн агуй	Сенегал	Скожжан Агуй
		Словен	Донана байгалийн цогцолбор газар
		Испани	Сжаунжа /ДӨ болох Лапониан нутгийн хэсэг/
		Швед	Ичкеул байгалийн цогцолбор газар
		Тунис	Эвергладес байгалийн цогцолбор газар
		АНУ	



Нигерийн "W" байгалийн цогцолбор газар ЮНЕСКО



Оросын Холбооны Улсын Байгал нуур ЮНЕСКО

Үүний зэрэгцээ ЮНЕСКО-гийн "Хүн ба Шим Мандал" хөтөлбөр нь хүрээлэн буй орчинд хүмүүсийн үйл ажиллагаа хэрхэн нөлөөлөх болон гарч буй өөрчлөлтийг нийгмийн зүгээс хэрхэн зохицуулж болохыг судалж хүрээлэн буй орчин ба байгалийн нөөц баялагийг ашиглах хөгжлийн хүчин зүйлүүдийн хоорондын зерчлийг тусган ажилладаг юм. Шим мандлын нөөц газрууд нь биологийн төрөл зүйлүүдийг болон эрүүл экосистемүүдийг хадгалж хамгаалахад дэмжлэг болж байдаг. Мөн тэрээр газар ашиглах уламжлалт аргаас суралцах, байгалийн нөөцийг тогтвортой зохистой ашиглах менежментийн талаарх мэдээллийг сурталчилан түгээх, байгалийн нөөцийн асуудлыг шийдвэрлэх талаар хамтран ажиллах зэрэгт бидэнд ихээхэн тусалж байдаг билээ.



Харилцах хаягууд

▲ Бусад Конвенцын вэбсайтууд

► Байгалийн өв

Биологийн төрөл зүйлийн тухай Конвенц	http://www.biodiv.org
Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг Олон Улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенц	http://www.cites.org
Нүүдлийн амьтдын тухай Конвенц	http://www.unep-wcmc.org/cms
Ус чийг, намгархаг газрын тухай Рамсарын Конвенц	http://www.ramsar.org
Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын Конвенц	http://www.unfccc.de
Цөлжилттэй тэмцэх НҮБ-ын Конвенц	http://www.unccd.int

► Соёлын өв

Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын өмчийг хамгаалах Конвенц
http://www.unesco.org/culture/legalprotection/war/html_eng/index_en.shtml

Соёлын үнэт зүйлсийг хууль бусаар хилээр гаргах, оруулах түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай
http://www.unesco.org/culture/legalprotection/theft/html_eng/index_en.shtml

Усан доорхи соёлын өвийг хамгаалах тухай Конвенц
http://www.unesco.org/culture/legalprotection/water/html_eng/index_en.shtml

Хулгайлагдсан буюу хууль бусаар хил давуулсан соёлын дурсгалт зүйлийн тухай ЮНИДРОЙТ-ын Конвенц
<http://www.unidroit.org/english/conventions/c-cult.htm>

Соёлын Өвийн бусад Конвенцууд
<http://fletcher.tufts.edu/multi/cultural.html>

► Европын соёлын талаарх эрх зүйн механизмууд

Мөн Европын зөвлөлийн гишүүн орнууд Олон Улсын эрх зүйн гэрээ хэлэлцээрүүдийг баталсан. Үүнд:

Европын соёлын Конвенц
[Http://conventions.coe.int/Treaty/en/Treaties/Html/018.htm](http://conventions.coe.int/Treaty/en/Treaties/Html/018.htm)

Археологийн өвийг хамгаалах тухай Европын Конвенц
[Http://conventions.coe.int/Treaty/en/Treaties/Html/066.htm](http://conventions.coe.int/Treaty/en/Treaties/Html/066.htm)

Европын уран барилгын өвийг хамгаалах тухай Конвенц
[Http://conventions.coe.int/Treaty/en/Treaties/Html/121.htm](http://conventions.coe.int/Treaty/en/Treaties/Html/121.htm)

Археологийн өвийг хамгаалах тухай Европын Конвенц (Засвар хийсэн)
[Http://conventions.coe.int/Treaty/en/Treaties/Html/143.htm](http://conventions.coe.int/Treaty/en/Treaties/Html/143.htm)

Байгалийн үзэсгэлэнт газрын тухай Европын Конвенц
[Http://www.nature.coe.int/english/main/landscape/conv.htm](http://www.nature.coe.int/english/main/landscape/conv.htm)

Европын гэрээ хэлэлцээрүүдийн зөвлөлийн бүрэн жагсаалт
[Http://conventions.coe.int/Treaty/EN/CadreListeTraites.htm](http://conventions.coe.int/Treaty/EN/CadreListeTraites.htm)



■ Сурагчийн гүйцэтгэх ажил 30

ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН ЭЛЭГДЭН ДОРЙТОЖ БАЙГАА НЬ

Зорилго: Улс орондоо тулгараад байгаа буюу үүсэн гарч болох байгаль орчны холбогдолтой шийдвэрлэвэл зохих асуудлууд болон тэдгээр нь Дэлхийн Өвийн байгалийн дурсгалт газруудтай ямар хамааралтай болохыг



Судалгаа



Ангийн ажил



Хичээлийн 3 цаг



Газар зүй, Шинжлэх ухаан



Дэлхийн өвийн газрын зураг, товч тодорхойлолт



Шинжлэх ухааны ном сонины хайчилбар (өгүүлбэрүүд)

□ Сурагчдаар өөрийн улс орон, бүс нутагт тулгарч байгаа буюу үүсэн Гарч болох шийдвэрлэвэл зохих асуудлууд, тухайлбал, хөрсний элэгдэл, цаг уурын өөрчлөлт, далайн усны төвшин дээшлэх, цөлжилт, ой мод сүйтгэх гэх мэт асуудлуудын жагсаалт гаргуулах. Эдгээр асуудлууд орон нутгийн, улс орны, бүс нутгийн, Дэлхийн өвийн газруудын хэмжээнд тулгараад байна уу гэдгийг ярилц.

□ Танай оронд, эсхүл танай бүс нутагт байгаль орчны холбогдолтой иймэрхүү бэрхшээлийг даван туулах арга хэмжээ авсан уу, амжилтанд хүрсэн үү? Ямар амжилтанд хүрсэн бэ? Орон нутгийн чанартай үйл ажиллагаа явуулсан уу. Олон улсын чанартай үйл ажиллагаа явуулж хэрэгжүүлсэн үү.

□ Нэг долоо хоногт гарсан байгаль орчны холбогдолтой хэвлэлийн нийтлэлүүдийг цуглуулж хичээл дээрээ тэдгээрт дүн шинжилгээ хий.

131

Дэлхий нийтийг хамарсан байгаль орчны аюулын гол шинжүүд

▶ Дэлхийн бүх шувууны аймгийн гуравны хоёроос илүү нь цөөрөн хорогдож, ихээхэн эмзэг болсон бөгөөд зарим нь сөнөж устах аюулд хүрээд байна.



▶ Сүүлийн 200 жилд дэлхийн шувууны аймгийн 1/4 нь, түүний дотор далайн арлуудын шувууд устаж үгүй болсон байна.



▶ Мэлхийн тоо буурч байгаа ч, юуны улмаас ийнхүү буурч байгаа нь тодорхой биш байна.

▶ Шүрэн уул хэмжээний хувьд багассаар

Дэлхийн Өвийг хадгалж, хамгаалах замаар биологийн төрөл зүйлийг хамгаалах нь

Биологийн төрөл зүйл гэдэг нь амьдралын бүх хэлбэрийн олон янз байдлыг илэрхийлэхэд хэрэглэгддэг нэр томъёо бөгөөд төрөл бүрийн ургамал, амьтан бичил биетнүүд, тэдгээрийн генүүд, тэдгээрийг агуулсан экологийн системүүдийг багтаана.

Дэлхийн биологийн төрөл зүйлийг хамгаалах нь дэлхий дээрх бүхий л амьдралыг хадгалж хамгаалах асуудлыг багтаадгийн хувьд маш том үүрэг зорилго юм. Үүнд, ус далай тэнгис, хүрээлэн буй орчин болон бичил биетүүдийг хамгаалах асуудал мөн орно.

Дэлхийн Өвийн хадгалалт хамгаалалт нь дэлхийн бөмбөрцөг дээрх биологийн олон төрөл зүйлийг хамгаалах бүх нийтийн хүчин чармайлтын нэг чухал хэсэг бөгөөд олон улсын хамтын ажиллагаанд ихээхэн тулгуурлах учиртай.

Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсын Оканийн дархан цаазат газар нь сөнөж мөхөхийн аюулд тулгараад байгаа биологийн олон төрөл зүйлийг хамгаалж байдаг Дэлхийн чухал ач холбогдол бүхий амьтан ургамлын амьдрах, ургах таатай орчин болсныхоо хувьд Дэлхийн Өвийн жагсаалтад бүртгэгдсэн юм. Энэ дархан цаазат газар устах аюулд нүүрлээд байгаа төрөл бүрийн сармагчин болон шувууд байдгаас гадна дэлхий дээр 30 000 орчим үлдсэн гэж тооцогддог бугын төрлийн 5000 орчим нь энд байдаг ажээ.

Ардчилсан Бүгд
Найрамдах Конго
Улс, Окари амьд
байгалийн нөөц
газар
IUCN/ J. Thorsell



Экологийн системийг хадгалж хамгаалах нь мөн Дэлхийн Өвийн хадгалалт хамгаалалтын нэг чухал хэсэг юм. Жишээ нь, 1996 онд Дэлхийн Өвийн жагсаалтад бүртгэгдсэн Белизийн усан доорхи хадан арлуудын дархан цаазат цогцолбор газар нь 93 400 га талбай эзлэн орших бөгөөд эрэг хавийн шүрэн хясаанууд, элсэн цөл, халуун орны ой шугуй, эрэг орчмын давст нуур зэргийг багтаасан гайхамшигт сайхан байгалийн бүтэцтэй юм. Бусад Дэлхийн Өвийн өргөн уудам газар нутаг нь ойн систем (Шри Ланк дахь Шикаража-гийн дархан цаазат ой), намгархаг нутаг (Испани дахь Донана үндэсний парк) зэргийг түүнчлэн хамгаалж байдаг.

Биологийн төрөл зүйл устаж үгүй болох нь ялангуяа далайн арлууд, намгархаг нутаг зэрэг аюулд учраад буй экологийн системийн хувьд үндсэндээ эргэж нөхөгдөх боломжгүй юм. Иймээс биологийн төрөл зүйлд учраад буй аюул хөнөөлийн учир шалтгааныг олж, түүнийг багасгаж арилгах арга хэмжээг нэн даруй авах хэрэгтэй болоод байна. Аюул тулгараад байгаа аливаа нэг төрөл зүйлийг хадгалж хамгаалахад байгаль, ургамал, амьтны аймаг болон үзэсгэлэнт сайхан газруудыг бүхэлд нь удаан хугацаагаар хадгалж хамгаалах явдлыг баталгаажуулах нь илүү үр ашигтай.



■ Сурагчийн гүйцэтгэх ажил 31

БИОЛОГИЙН ОЛОН ТӨРӨЛ ЗҮЙЛД АЮУЛ УЧРУУЛЖ БОЛОХ ХҮЧИН ЗҮЙЛС

Зорилго: Биологийн олон төрөл зүйлд учрах болзошгүй аюулыг олж тогтоох



Судалгаа



Ангийн ажил



Хээрийн судалгаа



Хичээлийн 4 цаг



Шинжлэх ухаан, биологи



Тэмдэглэл, дуран, үзэг

□ Биологийн төрөл зүйлд аюул учруулж байгаа доорхи хүчин зүйлүүдийн аль нь танай орон нутагт үйлчилж байгаа талаар сурагчдаас асуу.

- Амьтан ургамлын амьдарч ургах орчныг өөрчлөх. Жишээ нь: Хөдөө аж ахуйд ашиглах зориулалтаар газрын унаган хөрс ургамлыг сүйтгэх
- Шинэ төрөл зүйлийг нутагшуулах (нутгийн ургамал, амьтныг идэх, устгах эсвэл газар нутгийн төлөө нутгийн төрөл зүйлүүдтэй өрсөлдөх төрөл зүйлүүд гэх мэт)
- Бохирдол: Агаар, ус, хөрс болон дуу чимээ
- Уул уурхайн ажил
- Бусад

□ Орон нутгийн шувуу, ан амьтан, мод, ургамал танай орон нутагт хорогдож байгаа талаар мэдэж байгаа эсэхийг асуу.

□ Биологийн төрөл зүйлийн хорогдлыг зогсоох талаар ямар оролдлого хүчин чармайлт гаргаж байна вэ.

□ Ургамал, амьтны тооллого явуулах зэргээр орон нутгийнхаа биологийн төрөл зүйлийг судлах зорилгоор нутгийн парк (ургамал амьтны), ой мод, шувуудын нөөцөд хээрийн судалгаа явуулах, төлөвлөх. Сурагчид олж мэдсэн зүйлээ танилцуулах зорилгоор эцэг эхчүүдээ ангидаа урьж, тэднээс биологийн төрөл зүйлүүд тэдний залуу байх үеийнхээс хорогдсон, эсхүл нэмэгдсэн эсэхийг асуух.

▲ Соёлын олон төрөл зүйл ба биологийн олон төрөл зүйл

Дэлхийн соёлын болон байгалийн өвийн дурсгалт газрууд нь ихэнх тохиолдолд соёлын болон биологийн олон төрөл зүйлийн хоёулангийнх нь илэрхийлэл болж өгдөг.

Хэдийгээр аль аль нь хөгжиж байлаа ч гэсэн соёлын болон байгалийн олон төрөл зүйлийг хамтад нь хамгаалах шаардлагатай. Өөрийн дурсгалт газрын нөөц боломж, түүнийг хэрхэн ашиглаж болох тухай нутгийн хүн ардын уламжлалт мэдлэг, төсөөлөл нь нийт хүн төрөлхтний хувьд онцгой чухал нөөц боломж мөн.

Жеффри А.Мс Нийлей. / UCN. Байгаль ба нөөц баялаг. Vol 28, № 3. 1992

▲ Байгалийн төрөл зүйлийн хөгжил ба мөхөл

Байгалийн төрөл зүйлийн хөгжил бол байгалийн тасралтгүй үргэлжлэх үйл явц мөн. Шинэ төрөл зүйл нь генийн хувьслаас бий болох бөгөөд энэ нь ургамал амьтны олон төрөл зүйлийг баяжуулж байдаг билээ.

Дэлхийн Өвийн хадгалалт хамгаалалтын үндсэн зорилтуудын нэг нь төрөл зүйлийн хувьслыг бүртгэж судалж байдаг байгалийн дурсгалт газруудыг хамгаалах явдал юм. Дэлхийн Өвийн байгалийн дурсгалт газруудыг Дэлхийн Өвийн жагсаалтад оруулах номинацын үндсэн 4 шалгуурын нэг болох байгалийн дурсгалт газрын 1-р шалгуур нь:

Амьдралын хөгжил, хувьслын баримт, байгалийн тогтоцын үүсэл хөгжил дэх геологийн чухал ач холбогдолтой үйл явцууд, чухал ач холбогдолтой геоморфик буюу физографик шинж чанарууд зэрэг дэлхийн бөмбөрцөгийн үүсч хөгжсөн түүхэн үе шатуудын гайхамшигт жишээг харуулдаг.

Герман дахь Месселийн чулуужсан орд газар нь байгалийн өвийн шалгуур (I)-аар Дэлхийн Өвийн жагсаалтад бүртгэгдсэн дурсгалт газрын нэг жишээ мөн. Месселийн орд газар нь ялангуяа МЭӨ 57-36 сая жилийн хооронд Еосены үеийн чулуужсан ясны олдвороороо баялаг бөгөөд сүүн тэжээлтний хувьсал өөрчлөлтийн эхэн үеийн түүхэн хөгжлийн үе шатуудын тухай ховор мэдээллийг тэндээс олж болно.

Австралийн Риверслет болон Наракоорт дахь чулуужсан сүүн тэжээлтэн амьтдын дурсгалт газар нь Австралийн гайхамшигт амьтны ертөнцийн хөгжил хувьслын үе шатуудыг (жишээ нь, уутан хөхт сохор номин, өдөн сүүлт амьтад болон бусад ховордсон амьтад, уутан хөхт арслан гэх мэтийн одоо устаж үгүй болсон Австралийн сүүн тэжээлтэн амьтад) илтгэн харуулах бөгөөд сайн хадгалагдан үлджээ. Энэ дурсгалт газар нь Дэлхийн Өвийн жагсаалтад Дэлхийн Өвийн байгалийн дурсгалт газрын шалгуур I, II оор бүртгэгдсэн байна.



Австралийн чулуужсан хөхтөн амьтдын газар ЮНЕСКО

Шинэ төрөл зүйлийг нээх нь:

Динозаврын үеийн дурсгал болох Воллемийн нарс мод

1994 оны 12 дугаар сард Австралийн Сидней хотын ойролцоо модны шинэ төрлийг олж нээжээ. Воллемийн нарс нь 35м өндөр ургадаг, их биеийн диаметр нь 1м. Шинэ төрлийн мод, ялангуяа тийм өндөр ургадаг модыг нээх нь маш ховор тохиолдол юм. Воллемийн нарс мод ургаж буй энэхүү газар нутаг нь Сиднейн баруун хойд талд орших өндөр хадан хавцал бөгөөд түүнийг оршин тогтноход нөлөөлж болох, зэрэгдээх газруудад байнга гардаг гал түймрээс хамгаалагдсан байдаг. Шинэ төрлийн мод нээсэн явдал нь бидний биологийн зарим өв мэдээгдэж анзаарагдахгүйгээр үлдэж болдгийг харуулж байгаа нэгэн мод жишээ юм.

Австралийн байгаль орчны удирдах газар. 1996 он.

Их хэмжээний хур тунадас орох, температурын өөрчлөлт гэх мэт байгаль цаг уурын шинэ нөхцөл байдалд дасахгүй байх, нөхөн уржих, шалгаран үлдэх чадваргүй болох зэргээс шалтгаалан амьтан ургамлын төрөл зүйл устаж үгүй болдог байна. Чулуужсан ордны олдворын мэдээ судалгаанаас үзэхэд ургамал амьтны олон төрөл зүйл эцсийн эцэст устаж үгүй болж болзошгүй байна. Гэхдээ өнөөдөр амьтан ургамлын төрөл зүйл устаж үгүй болох нь шинэ төрөл зүйл үүсэн бий болохоос илүү хурдацтай байна гэж ерөнхийд нь үзэж болно. Энэ бол хэзээ ч эргэж нөхөгдөх боломжгүй дэлхий нийтийн өөрчлөлт хувирал юм.


Өнөөдөр:

- Үлдсэн шувуудын 11%
 - Сүүн тэжээлтний 11%
 - Загасны 5%
 - Ургамлын төрөл зүйлийн 8% - д
- сөнөж устахын аюул нүүрлээд байна.
- Маш олон тооны аварга том сүүн тэжээлтнүүдийг агнан хороосоор байна.
 - Загасчлах, халим агнах зэрэг нь далай тэнгисийн амьтад цөөрөх ноцтой шалтгаан болж байна.

Дэлхийн Өвийн олон газруудыг ховордсон амьтан ургамлын төрөл зүйлийг устаж үгүй болохоос урьдчилан хамгаалах явдлыг баталгаажуулах үүднээс Дэлхийн Өвийн дурсгалт газар болгон хадгалж хамгаалсан байдаг билээ.

▲ Сейчеллес дэх Майн хөндийн байгалийн дархан цаазат газар

Майн хөндийн байгалийн дархан цаазат газар нь Сейчеллес дэх Праслины жижиг арлын дунд хэсэгт орших ба 1983 оны Дэлхийн Өвийн жагсаалтад



Майн хөндийн байгалийн нөөц газар, Сейчеллес Үндэсний Газарзүйн Нийгэмлэг
Curtisinger

бүртгэгджээ. Энэ хөндийн ай савд унаган төрхөө алдаагүй дал модон ой байдаг. Энд 20 кг хүртэл жинтэй, дэлхийн хамгийн том наргил модны самар ургадаг. Энд анхандаа төрөл бүрийн наргил модны самараар дүүрсэн бүхэл бүтэн арал байсан боловч түүнийг хайр найргүй ашигласнаар амьтан ургамлын баялаг төрөл зүйл бүхий дал модон ойн талбай хорогдон багасч жижигхэн хөндий болон хувирчээ. Энэ ай сав газар болон түүний дал модны үнэт ой нь өөр газраас авчирсан ургамал амьтны чамин төрөл зүйл, наргил модны самрыг асар ихээр хурааж авах, гал түймэр гэх мэтийн аюултай байнга тулгардаг аж.

▲ Энэтхэгийн Манасын дархан цаазат газар

Энэтхэг дэх Манасын дархан цаазат газар нь Гималайн нурууны халуун орны ой руу хөтөлсөн модтой толгодууд бүхий бэлд оршдог бөгөөд Улаан Номонд орсон ховор амьтдын өлгий нутаг юм. Дэлхийн Өвийн жагсаалтад 1985 онд, аюул нүүрлээд байгаа Дэлхийн Өвийн дурсгалт газруудын жагсаалтад 1992 онд бүртгэгдсэн. Манасын ДЦГ-т Улаан Номонд орсон бар, зэрлэг гахай, Энэтхэгийн хирс, заан зэрэг амьтад байна. Эдгээр амьтдад учирч байдаг нэг гол аюул бол хулгайн ан юм. 1997 оны байдлаар 22 хирс алагдаж, одоо 10-15-хан тооны хирс үлджээ.



Дэлхийн Өвийн газрын зураг

Шинэ Зеландын Те Вахипоунаму

Те Вахипоунаму нь Шинэ Зеландын өмнөд арал дээр оршдог бөгөөд түүний газар нутгийн ихээхэн хэсэг нь, тухайлбал, Шинэ Зеландын газар нутгийн 10% буюу 2.6 сая га газар нь намаг, асар өндөр уулс, шууд далай руу түрэн орсон огцом өндөр хад асганаас бүрдэнэ. Энэхүү үзэсгэлэнт байгаль нь хадан хавцлуудын дундуур тал хөндийг зүсэн өнгөрөх асар том мөсөн гол, мөсөн галвын үеийн гайхамшигт газар нутгийн онцгой шинжүүдийг мод томруун илтгэн харуулж байдаг. Шинэ Зеландын алслагдсан энэхүү бөглүү газар нутаг нь хосгүй нандин шувуу, амьтан ургамлын ихэнх төрөл зүйлүүдээрээ алдартай. Хур тунадас ихтэй байдгаас шувууд нисдэггүй болж, мод ургамал нь хүртэл сонирхол татам дасан зохицжээ. Жишээ нь: Цагаан нарс гэхэд 30 м өндөр ургадаг. Энэ цагаан нарсан ой нь 65 сая орчим жилийн өмнөх динозаврын үеийн дүр төрхийг ихэнхдээ хадгалж үлдсэн байдаг учраас Динозаврын ой гэж нэрлэгдэх болжээ.

Европчууд ирж суурьшихад тэдэнтэй хамт олон төрлийн араатан амьтад, шавьж хорхой орж ирснээр эндэхийн ургамал, амьтны ертөнцөд аюул тулгарч зарим тохиолдолд устаж үгүй болж байна.

Хэт алслагдсан байдал болон геологи цаг уурын өөрчлөлтийн нөлөө нь Шинэ Зеландаас өөр хаана ч байхгүй амьтан ургамлын төрөл зүйлийг ийнхүү хувирган өөрчлөхөд бас хүргэж байна. Шинэ Зеландын хүрээлэн буй орчин, амьтан ургамлын ертөнцийг ийнхүү өөрчилж байгаа эдгээр хүчин зүйлс нь тэдгээрийг улам бүр маш эмзэг болгож байгаа нь харамсалтай. 1000 жилийн өмнөөс Шинэ Зеландад ирсэн анхны суурьшигчид болох Полинезчууд ургамал амьтны төрөл зүйл болон тэдгээрийн оршин амьдрах орчин устах эхлэлийг тавьжээ. Европчууд ирж, Шинэ Зеландыг колончилж эхлэх үед Шинэ Зеланд ой модныхоо 23%-ийг, тэнд амьдардаг шувуудын 30%-ийг аль хэдийнээ алдсан байсан бөгөөд түүний дотор нисдэггүй том Тао шувуу их хэмжээгээр хорогдсон байв. Мөн хүмүүс бөөнөөр ирж суурьшсанаар устаж мөхөхийн аюулд орсон ургамал амьтад 44 гэж тооцож байсан бол өнөөдөр 503 хүрчээ.



Эх сурвалж: Шинэ Зиландын Греймоут ахлах сургууль

■ Сурагчийн гүйцэтгэх ажил 32

ГОНДВАНАЛАНДЫГ ЭВЛҮҮЛЭН ТОГЛОХ НЬ

Зорилго: Тив дэлхий үүсч тогтсон болон тусгаарлагдсан байдал байгалийн өвийн хамгаалалд хэрхэн ашигтай болохыг сурч мэдэх



Дасгал



Ангийн ажил



Хичээлийн 2 цаг



Газар зүй, Түүх, Шинжлэх ухаан



ДӨ-ийн газрын зураг, "Гондваналанлыг эвлүүлэн Тоглох нь" сурагчийн дасгалын ажлын хуудас



Хайч, цавуу, дэлхийн газрын зураг

□ Сурагчдад Гандваналандын (эртний) тухай ярьж өгөх

Уул хад, чулуужсан зүйлийн физик шинж чанараар нь Шинэ Зеланд нь Гандваналандын Супер тивийн нэг хэсэг нь байсан гэж эрдэмтэд үздэг. Гандваналанд нь мөн Австри, Африк, Өмнөд Америк, Энэтхэг, Антрактид зэргийг багтааж байжээ. Ойролцоогоор 80 сая орчим жилийн өмнө Антрактид, Австралиас Шинэ Зеланд тасарсан тэр цагаас Шинэ Зеланд нь биеэ даасан газар нутаг болсон. Ингэснээрээ Шинэ Зеланд нь дэлхийг Гандваналандтай холбох чухал холбоос мөн юм. Шинэ Зеланд нь 1600 км усаар хүрээлэгдсэн бөгөөд 1000-аад жилийн өмнөөс хүмүүс суурьшиж эхэлсэн. Шинэ Зеландын ургамлын аймаг нь /ертөнц/ олон сая жилийн туршид хөндөгдөөгүй хэвээр үлдсэн. Өнөөдөр Шинэ Зеланд нь дэлхий дээрх хамгийн их тусгаарлагдсан газруудын нэг хэвээр байна.


□ Ангийг жижиг бүлгүүд болгон хувааж, бүлэг болгонд дасгалын хуудас өгнө. Тасархай зураасын дагуу хайчилж, салгаад Гандваналанд тив болгон эвлүүлж наах даалгавар өгнө. Супер тив Гандваналанд салж бутрах үед Шинэ Зеландыг дэлхийн бусад хэсгээс хэрхэн тусгаарлагдсан, энэ нь тэндхийн ургамал, амьтны аймгийн хадгалалт хамгаалалд яаж нөлөөлсөн тухай ярилц.

□ Гандваналандыг одоогийн бусад тивтэй харьцуулж үзэх

Эх сурвалж: Греимоутын ахлах сургууль. Шинэ Зеланд



Дэлхийн Өвийн газрын зураг







■ Сурагчийн гүйцэтгэх ажил 33

ДЭЛХИЙН ӨВИЙН БАЙГАЛИЙН ДУРСГАЛТ ГАЗРУУДЫГ ИЖИЛ ШАЛГУУРУУДААР ХАРЬЦУУЛЖ ТАНИХ

Зорилго: Дэлхийн Өвийн байгалийн дурсгалт газруудыг сонгох шалгууруудыг илүү сайн ойлгож мэдэх



Судалгаа



Ангийн ажил



Хичээлийн 3 цаг



Байгалийн шинжлэх ухаан, дүрслэх Урлаг



Гэрэл зургууд, Дэлхийн Өвийн карт, товч тодорхойлолт

□ Дэлхийн янз бүрийн хэсгээс 25 байгалийн дурсгалт газрыг товч тодорхойлолтыг нь үндэслэн сонгож ав. Гэрэл зургууд олох ба эсвэл гараар хуулж зурах, ингэхдээ ямар шалгуураар бүртгэснийг орхи.

□ Ангийг 5 бүлэгт хувааж, бүлэг бүрт сонгож авсан газруудаас 5 газрын тодорхойлолтыг өгнө. Энд сурагчид дурсгалт газруудын Дэлхийн Өвийн газрын зураг дээрх байршил, Дэлхийн Өвийн жагсаалтад тэдгээрийг ямар шалгууруудаар оруулсныг хэлэх ёстой. Бүлэг бүрээс хамт олонд саналаа танилцуулах нэг сурагч сонгоно. Хариултуудыг "Товч тодорхойлолтод" заагдсан бодит шалгууруудтай харьцуулж үзнэ.

□ Дэлхийн Өвийн дурсгалт газруудыг Дэлхийн Өвийн жагсаалтад оруулахад хэрэглэхэд 4 шалгуурыг санаж, орон нутгийн, үндэсний болон бүс нутгийн дурсгалт газруудыг 4 шалгуур тус бүрээр ангилан жагсаан бичүүл. Дараа нь Дэлхийн Өвийн газрын зураг дээрх дурсгалт газруудаас аль нэгийг нь сонгон авч, түүний тухай ярилц. Сурагчдаар сонгосон газруудаар нь, тэдний хадгалалт хамгаалалтыг дэмжсэн уриалга бүхий зурагт хуудсууд хийлгэ.

Экологийн болоод соёлын хувьд тогтвортой хөгжих

Ирээдүй хойч үеийнхэндээ эрэлт хэрэгцээгээ хангах боломжийг хадгалж, өнөө үеийнхний хэрэгцээ шаардлагыг хангаж байх явдал бол хөгжил тогтвортой байх баталгаа юм.

Хүрээлэн буй орчин ба тогтвортой хөгжил, Парис. ЮНЕСКО. 1997 он

Хүн төрөлхтөн ба хүрээлэн буй орчны хоорондын тэнцвэртэй байдлыг хамгаалах хэрэгцээ шаардлага нь Дэлхийн Өвийн Конвенцид тусгагдсан. Соёлын болон байгалийн өвийг хоёуланг нь багтаасан Дэлхийн Өвийн тодорхойлолт нь экологийн тогтвортой хөгжлийн үндэс суурь болсон хүн, байгаль орчин хоёрын харилцааны олон улсын нэгдмэл чанарын талаар сануулдаг.

Хөгжлийн үйл явцад бидний амьдралын оюун санааны эх ундрага, нэлээд энгийн утгаар авч үзвэл амьдралын эх үндэс аль аль нь болж байдаг байгаль дэлхий хүндтэй байр эзлэх учиртай.

Жеффрей А. Мк.Ниилей, IUCN, *Байгаль ба нөөц*, No. 3, 1992

Газар тариалан эрхлэх гэж ойг сүйтгэх, загасчлах, бохирдуулах гэх мэт одоогийн хөгжил, хүн амын өсөлттэй уялдан хүрээлэн буй орчинд нүүрлэж буй аюулуудыг зайлуулах арга хэмжээг дэлхийн ертөнцийн биологийн болон соёлын олон төрөл зүйл хамгаалагдсан байхуйцаар зохион байгуулах ёстой. Байгалиа хадгалж хамгаалах явдал газар тариалан эрхлэх, уул уурхайн олдворлолт, ойжуулах гэх мэт нөөц баялагийг ашиглах асуудал хоёр нь үргэлж харилцан зөрчилдөж, бие биеэ үгүйсгэж байдаг гэж үздэг. Энэ шалтгаанаар Дэлхийн Өвийн дурсгалт газрууд гэх мэт хамгаалагдсан газар нутагт нөөц баялагийг ашиглах нь голдуу хуулиар хориглогдсон байдаг. Гэвч нэлээд болгоомжтой зохион байгуулсан зарим тохиолдолд байгалийн болон соёлын өвийг хадгалж хамгаалах явдлыг зарим хатуу болзолтойгоор байгалийн нөөцийг ашиглахтай зөв хослох нь илүү үр ашигтай арга байж болно. Ингэхдээ өвийг хамгаалахдаа нутгийн иргэдийн сонирхлыг татсан тийм эдийн засгийн үйл ажиллагаа явуулж, нөөцийг тогтвортой ашиглах нөхцлийг хангах ёстой.

▲ **Мауританий Аргуйн эргийн Үндэсний парк**

Энэ үндэсний парк нь Баруун Африк дахь шувууны нутаг юм. Атлантын далайн хөвөөг эмжсэн элсэн манхан, эрэг орчмын балчиг намаг, жижиг арлууд, эрэг хавийн гүехэн ус зэрэг нь бүгд нийлэн далай тэнгис, эх газар гайхамшигтайгаар хосолсон ер бусын үзэсгэлэнт байгаль, биологийн олон төрөл зүйлийн баялаг ертөнцийг бий болгодог юм. Энэ паркт олон төрлийн нүүдлийн шувууд, далайн хэд хэдэн төрлийн яст мэлхий, далайн гахай нутагладаг юм.

Банк д Аргуйны нь орон нутгийн эдийн засагт маш чухал ач холбогдолтой: Загас агнуурын аж ахуйн 7 тосгон орон нутгийнхаа байгалийн баялаг нөөцөд тулгуурлан хөгжиж байгаа бөгөөд аялал жуулчлал хөгжих бааз суурь болдог аж. Орон нутгийн хүн амын загас агнах уламжлалт арга нь уг үндэсний парк дахь байгалийн нөөц баялагт төдийлөн хүчтэй сөрөг нөлөө үзүүлдэггүй. Гэвч хэрэв моторт завь хэрэглэн эхэлж, загас агнуурын хэмжээг нэмэгдүүлэх аваас тэр орчмын шувуудын амьдралд нэлээд сөрөг үр дагавар учруулах болно.

141



Мауританий
Аргуйн
эргийн Үндэсний
Парк
ЮНЕСКО/ IUCN/
J. Thorsell



■ Сурагчийн гүйцэтгэх ажил 34

ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫГ ХАМГААЛАХ НЬ

Зорилго: Дэлхийн Өвийн байгалийн дурсгалт газруудад сайн менежмент чухал ач холбогдолтой болохыг ойлгож мэдэх



Дүрийн Тоглолт



Ангийн ажил



Хэд хэдэн хичээлийн цаг



Хэл, газар зүй, Шинжлэх ухаан, биологи тодорхойлолт



Дэлхийн Өвийн карт товч тодорхойлолт

□ Мавританий Аргуйн эргийн үндэсний парк дахь нөхцөл байдлын талаар сурагчдад тайлбарла. Дараа нь Дэлхийн Өвийн зохиомол дурсгалт газар дээр тусгай дүрийн тоглолт зохион явуул. Ангийг өөр өөр сонирхолын булгууд болгон хуваа.

□ Бизнес эрхлэгчдийн хэсэг хүмүүс загас агнуурын аж ахуйг хөгжүүлэхийг хүсч байгаа бөгөөд төслөө санхүүжүүлэх гадаадын хөрөнгө оруулагчдыг тэд олсон байна. Гэтэл үндэсний паркийн менежер болон хүрээлэн буй орчны мэргэжилтнүүд загас агнуурыг ихээр өргөжүүлэх нь шувуудын амгалан тайван амьдралыг алдагдуулахад хүргэж болох юм хэмээн сэтгэл зовниж байна. Орон нутгийн удирдлагууд нутгийн оршин суугчдын мөнгөн орлогыг нэмэгдүүлэхийн төлөө байгаа ч буй болсон экологийн таатай тэнцвэрт байдлыг хөндөхгүй байх нь зүйтэй гэж үзжээ. Энэ бүгдийг бүх тал сэтгэл хангалуун байхуйцаар ямар шийдвэр гаргаж болох вэ?



■ Сурагчийн гүйцэтгэх ажил 35

ЭКОЛОГИЙН ХУВЬД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Зорилго: Хаягдал гаргахгүй байх ба түүнийг ашиглахад ухамсарлуулах



Дасгал



Ангийн ажил ба төлбөрөөс гадуурх ажил



Хичээлийн цөөн цаг ба сургуулиас гадуурх хэд хэдэн долоо хоног



Урлаг, Шинжлэх ухаан



Лонх, цаас, хөнгөн цагаан буюу төмөр лааз, сүүний хайрцаг гэх мэт хог хийх сав

□ Бохирдолт нь ямагт хэт хэрэглээ, хог хаягдалтай холбоотой байдаг. Хаягдлыг дахин боловсруулах явдалтай хосолж чадвал нөөц баялгийн зүй зохистой, тогтвортой хэрэглээ, бохирдолтын асуудлыг нааштайгаар шийдвэрлэж болох юм. Нөөц баялгийг оновчтой ашиглах, дахин боловсруулахад бид хэрхэн бүтээлчээр хувь нэмрээ оруулж болох вэ гэдэг талаар бид нэн даруй бодох хэрэгтэй. Байгаль орчны ажилтныг ангидаа урьж, хоёр дахь түүхий эдийг дахин боловсруулахын ач холбогдлын тухай, түүнийг хэрхэн хэрэгжүүлэх тухай яриулах. Сургууль, хамт олон, нутгийн иргэдийн дунд цаас, хөнгөн цагаан, төмөр, лааз, шил лонх гэх мэт хоёр дахь түүхий эдийг дахин боловсруулах аян зохион байгуулахад бэлтгэхийг сурагчдад санал болгох. Үүндээ тэдний эцэг эхчүүдийг оролцуулах. Дахин боловсруулалтад ямар бүтээгдэхүүн цуглуулахаа шийдэцгээ. Дүрслэх урлагийн ангийг энэ үйл хэрэгт татан оролцуулж, хоёр дахь түүхий эд цуглуулж, дахин боловсруулах энэхүү аяны тухай зурагт хуудас гаргуулах. Сурагчидтайгаа хамтарч энэхүү ажлынхаа үр дүнг тооцон гарга.

□ Дэлхийн Өвийн хадгалалт болон тогтвортой байдлын талаар ярилц. Хоёрдогч түүхий эдийн нөөцийг 2 дахин боловсруулах, дахин ашиглах, түүнийг хаяхгүй байхын учир шалтгаан, ач холбогдлын талаар ярилцах

□ Хог хаягдлыг нь түүж цуглуулах, тэдгээрийг хог авдаг газарт явуулах, ухаалгаар дахин боловсруулах замаар орон нутгийнхаа байгаль орчин, өвийн газруудыг цэвэр цэмцгэр байлгахад сурагчдыг татан оролцуул.

Тогтвортой хөгжлийг хангахад орон нутгийн дэмжлэг туслалцаа

Хэрэв Дэлхийн Өвийн дурсгалт газрууд зэрэг тусгай хамгаалалттай газар нутгийг нутгийн иргэд зүй зохистой тогтвортой ашиглах чадвартай байх юм бол тэр газруудыг хадгалж хамгаалахад орон нутгийн дэмжлэг туслалцааг улам бүр нэмэгдүүлж болно. Хадгалж хамгаалах буюу хөгжүүлэх төслүүдийг нь аль болохоор тусгай хамгаалалттай газар нутаг дээр болон түүний ойролцоо хэрэгжүүлж, хадгалалт хамгаалалтын төслүүдийг төлөвлөх, зохион байгуулах, удирдах үйл ажиллагаанд оролцох орон нутгийн оролцоо нь маш чухал ач холбогдолтой бөгөөд ингэхдээ эдгээр төсөл нь үнэхээр зохистой тогтвортой ашиглалтыг хангахад чиглэгдсэн байх учиртай.



■ Сурагчийн гүйцэтгэх ажил 36

ӨВИЙН ГАЗРУУДААР АЯЛАХ НЬ

Зорилго: Сурагчдад адал явдалтай учрах, бүтээлч байх, хүрээлэн буй орчноо илүү сайн танин мэдэх боломж олгох



Дасгал



Ангийн ажил



Хөтөлбөрөөс гадуурх ажил



Хичээлийн хэд хэдэн цаг, сургуулиас гадуурх ажлын цаг



Нийгэм судлал, шинжлэх ухаан, биологи



Газрын зураг

□ Сурагчид адал явдал, судалгаа хийх сонирхолтой байдаг учраас тусгай нэг өвийн газраар аялал зохиохыг санал болго. Байгалийн өвийн ажил, соёлын өвийн аялал, хотын өвийн аялал, цэцгийн аялал, фото аялал, видео аялал гэх мэтийн олон төрлийн аялалаас ямрыг нь сонгохоо хамтдаа шийд. Аялахаар шийдвэрлэсэн өвийн газрынхаа газрын зургийг ангидаа авчирч, бүгдэд нь харуул. Чөлөөт цагаараа сонгосон газар дээрээ очсон мэтээр байгаа газартаа аялах аялалыг төлөвлө. Төлөвлөсний дараа аяллын онцлох шинжүүдийг тусгасан дэвтэр бэлдүүлэх.

□ Явган аялал зохиох тусгай өдөр төлөвлө. Аяллын явцад үнэртэх, сонсох, харах гэх мэт мэдрэхүйн чадвараа дээшлүүлэхэд Анхаарах.

□ Аяллын үр дүн болон сурагчдад үзүүлсэн нөлөөг үндэслэн өөрийн болон бусад сургуулийн анги хамт олон, эцэг эх бусад хүмүүсийг оролцуулан зохиох явган аяллыг урьдчилан төлөвлө.

Канад улсын
Хейд-Смашед-ин-
Буффало Жамл
цогцолбор
өвийн газарт
хийсэн аялал
S. Titchen




Манай гаригийн ирээдүй

Риогийн дэлхийн дээд хэмжээний чуулга уулзалт болсон 1992 оноос хойш нийт 754 байгалийн, соёлын, холимог дурсгалт газар Дэлхийн Өвийн жагсаалтад бүртгэгдсэн бөгөөд 2004 оны 1 дүгээр сарын байдлаар тэдгээрийн 149 нь байгалийн дурсгалт газар байв.

Өндөр хөгжилтэй орнуудад нөөц баялагийн ашиглалтад илт нааштай өөрчлөлт гарч эрчим хүч, ус, газрын ашиглалт илүү сайн болсон. Харин агаар, ус, хөрсний бохирдолт нэмэгдсээр л байна. Гэтэл хөгжиж буй орнуудад бүр ч илүү их бохирдож байгааг бид харж байна. Нэг нааштай ололт нь тэд энэхүү тулгарч буй хурц асуудлыг шийдвэрлэх зам бол эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхдээ хүрээлэн буй орчноо хамгаалах асуудлыг салгаж болохгүй гэдгийг ухамсарлан ойлгож буй явдал юм.
Мостафа Толба, Тогтвортой хөгжлийн Комиссын дарга
ЮНЕСКО-гийн эх сурвалж. №92. 7-8-р сар 1997.


Энэ нь дэлхийн ба хүрээлэн буй байгаль орчныг хамгаалах үйлсэд оруулж буй онц чухал хувь нэмэр юм.

Дэлхийн Өвийн жагсаалтад бүртгэгдсэн өвүүд /2004 оны 1 сарын байдлаар/



Дэлхийн Өвийн дурсгалт газрууд Олон Улсын хэмжээнд "Дэлхий дахины нийтлэг гайхамшигт үнэт зүйл" гэж хүлээн зөвшөөрөгдсөн учраас тэдгээр нь үр дүнтэй менежментийн үлгэр загвар болох учиртай.

Бернд вон Дросте, Парисын ДӨ-ийн Төвийн захирал
Жеффри А. МкНийли, IUCN, ДӨ, *Хорин жилийн дараа*, 1992



Сэдвийн дүгнэлт: Дэлхийн Өв ба хүрээлэн буй орчин

Урлаг

Сурагчид хамгийн дуртай Дэлхийн Өвийн байгалийн дурсгалт газрыг нь сонгож, түүнийгээ зурах эсвэл дүрслэн үзүүл.

Биологи

Бүс нутагтаа байдаг Дэлхийн Өвийн байгалийн дурсгалт газрыг сонгож, тэнд байдаг ургамал, мод, амьтны жагсаалтыг гаргуулах
Гаргасан жагсаалтаа орон нутгийнхаа амьтан ургамал, модтой харьцуулж үз
Сурагчидтай хамтарч ургамал, амьтан ба геологийн шинжийг нь газар дээр нь судлах

Гадаад хэл

Хилийн чанад дахь сургуультай (болж өгвөл холбоот сургуулийн төслийн сүлжээний) холбоо тогтоох, хүрээлэн буй орчны талаар сэтгэл зовоож буй нийтлэг асуудал түүний Дэлхийн Өвийн хадгалалт хамгаалалтад үзүүлж болох үр дагаврын талаар үзэл бодлоо солилцох.

Түүх

Байгалийн дурсгалт газрыг сонгуулж, өнгөрсөн ба өнөөдөр түүний унаган төрх байдал, түүний хадгалалт хамгаалалтад цаашид учирч болох аюулуудын талаар эрэгцүүлж бодох.

Газар зүй

Мөсөн голыг багтаасан байгалийн дурсгалт газрыг сонгох (Аргентины Лос Гласнаресь товч тодорхойлолт хар) ба дэлхийн уур амьсгалын дулааралтын үр дагаварын талаар ярилцах. Судалгаанд зориулж геологийн буюу чулуужсан ордын газрыг сонго.

Хэл

Бохирдлоос болж аюулд учраад байгаа буюу учирч болох Дэлхийн Өвийн дурсгалт газрыг сурагчдаар сонгуулж бохирдлыг арилгах эсвэл зайлсхийхэд чиглэгдсэн сурталчилгааны аянд бэлтгэх, хадгалж хамгаалах талаарх арга хэмжээг эхлэх буюу эрчимжүүлэх.

Математик

Хорогдож цөөрсөн буюу устаж үгүй болохын аюул нүүрлээд байгаа нутгийн унаган ургамал, мод, шувуу, сүүн тэжээлтэн, загас зэрэг амьтдын төрөл зүйлийг судалж, хувиар тооцоолон гаргах.

Шинжлэх ухаан

Нутгийн нуур, голын уснаас бохирдолтын хэмжээг шалгах зорилгоор дээжийг нь ав. Байшин барилгын гадаргуу агаарын бохирдолтод хэрхэн өртөж байгааг шалган тогтоох, өвийн газруудыг хадгалж хамгаалахтай уялдан хүмүүсийн зан төлөв, биеэ авч явах байдлыг яаж өөрчилж болох талаар ярилцах.



Дэлхийн Өв ба Энхийн соёл

Польшийн Түүхэн хот Варшав. ЮНЕСКО



Дэлхийн Өв ба Энхийн соёл


**Хүмүүсийн оюун санаанд дайн
хийж бодол үүсдэг. Учраас тэдний
оюун санаанд энх тайвны
хамгааллыг бат бөхөөр суулгаж
өгөх учиртай.**

**ЮНЕСКО-гийн үндсэн хуулийн
оршил**

ДӨ ба Энхийн соёл

Зорилго	Хуудас
Мэдлэг	149
Арга хандлага	149
Ур чадвар	149
ДӨ ба энхийн соёл	150
Сурагчийн гүйцэтгэх ажил 37: Энх тайван ба ДӨ-ийг тодорхойлох	151
Энх тайвны бэлэгдэл болж байдаг дурсгалт газрууд	152
Сурагчийн гүйцэтгэх ажил 38: Танай бүс нутаг дахь ДӨ ба энх тайван	154
Дайны үед ДӨ-ийг хамгаалах нь	154
Сурагчийн гүйцэтгэх ажил 39: Дайнд сүйдсэн өвийг сэргээх нь	155
Гаагийн Конвенц соёлын өвийг хамгаалж байна	155
Сурагчийн гүйцэтгэх ажил 40: Дайны үед соёл ба байгалийн өвийг хамгаалах нь	157
Дайны үед байгалийн өвийг хамгаалах нь	157
ДӨ ба хүний эрх	158
Сурагчийн гүйцэтгэх ажил 41: Мухар сүсэг, муйхар санаа бол энх тайванд учрах аюул занал юм.	159
Сурагчийн гүйцэтгэх ажил 42: ДӨ ба энх тайвны талаар үгийн сүлжээ бүтээх	160
Сурагчийн дасгал ажлын хуудас: ДӨ ба энх тайвны талаар үгийн сүлжээ бүтээх	161
Сэдвийн дүгнэлт: ДӨ ба энхийн соёл	162

Зорилго



Мэдлэг

- ДӨ-ийн дурсгалт газрууд нь энх тайван, хүний Эрх, ардилсан ёсны баталгаа болох нь
- ЮНЕСКО ийн ёс зүйн уриалгууд ба ДӨ-ийн Конвенц
- Бүх үндэстэн ба тэдний соёлыг хүндэтгэх, арьс өнгөөр үл ялгаварлах, хүлээцтэй хандахын чухал болох талаар ойлголт авч мэдлэгээ дээшлүүлэхэд сурагчдад туслана.

Арга хадлана

- Бусад үндэстэн, тэдний соёлыг хүндэтгэх, амьдрал үйл ажиллагаандаа гарч болох маргаантай асуудлыг эв зүйгээр шийдвэрлэх арга замыг сүвэгчлэн олоход түлхэц үзүүлэх
- Дө-ийг хадгалж хамгаалах үйл ажиллагааг дэмжихэд эв нэгдэлтэйгээр хамтран ажиллах Зэрэгт сурагчдыг хөхүүлэн дэмжих

149

Ур чадвар

- Нэг баг болон хамтран ажиллах
- Гарч болох маргаантай асуудлыг эв зүйгээр Шийдвэрэх, энэ аргад суралцахад нь бусдад туслах
- Улс төрийн ба иргэний амьдрал, үйл Ажиллагаанд ардчилсан зарчмаар оролцох
- ЮНЕСКО-гийн ДӨ-ийн хамгааллын үйл хэрэгт хувь нэмэр оруулах зэрэг чадварыг эзэмшихэд сурагчдад туслана.

Дэлхийн Өв ба Энхийн соёл

Энх тайван нь улс гүрнүүдийн хооронд төдийгүй хувь хүмүүс, нийгмийн янз бүрийн бүлгүүдийн хооронд, улс орон ба түүний ард иргэдийн хооронд, хүн ба түүний хүрээлэн буй орчны хооронд хүч хэрэглэсэн бус уян хатан, нөхөрсөг харьцааг тогтооход чиглэгдэж байдаг. ДӨ-ийн жагсаалтад бүртгэгдсэн соёлын ба байгалийн дурсгалт газруудын тухай ойлгож мэдэх явдал эрх чөлөө, шудрага ёс, харилцан ойлголцол, харилцан хүндэтгэл, хайр дурлал, үерхэл нөхөрлөл зэрэг бидний мөнхийн хүсэл тэмүүллийг илэрхийлсэн байгалийн болон хүмүүний гайхамшигт бүтээлүүдийн тухай төсөөллийг бидэнд өгснөөрөө “энх тайвныг” олон талаас ойлгон мэдэхэд ач холбогдолтой. Эдгээр нь хүний суурь эрхийг бүрдүүлдэг бөгөөд хувь хүн болон нийгэм хамт олон бүрийн, бүр бүхэл бүтэн дэлхийн хувьд энх тайван болоод хөгжлийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болж байдаг.

1. а. Дайн ба байлдааны ажиллагааг зогсоосон юмуу чөлөөтэй байх байдал; бие биетэйгээ дайтахгүй тийм үндэстний болон нийгмийн нөхцөл байдал
 - б. Байлдаж байсан хоёр хүчний хооронд энх тайвны гэрээ, хэлэлцээр хийж баталгаажуулах
 2. Иргэний үймээн самуун, эмх замбараагүй байдлаас ангид байх ба нийтийн хэв журам, аюулгүй байдал хангагдсан байх
 3. Сэтгэл түгшсэн, айж мэгдсэн байдлаас ангид байх
- Оксфордын хураангуй товч толь*

150

Дэлхийн соёлын ба байгалийн өвийг хадгалж хамгаалах тухай конвенц болон түүний ДӨ-ийн сан нь дэлхийн хамгийн чухал газруудыг хамгаалах олон улсын хамтарсан үйл ажиллагаанд түшиглэн ажлаа явуулдаг.



Дэлхийн Өвийн
Конвенц

Бие биеэ болон бие биенийхээ амьдралыг мэдэхгүй байх нь хүн төрөлхтний бүхий л түүхэнд хүмүүсийн хооронд үл итгэлцэл, хардал сэрдэлтийн үндсэн шалтгаан болсоор ирсэн бөгөөд үүнээс үүдэн дайн гарч болдгийг түүх харуулж байна. Өнөөдрийн хувьд төгсгөл болсон дэлхийн томоохон аймшигт дайн нь хүмүүсийн нэр төртэй, тэгш эрхтэй байх, бие биеэ харилцан хүндлэх ардчилсан зарчмуудыг уландаа гишгэж, үүний оронд хүмүүсийн дунд тэгш бус байх, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах харгис номлолыг дэлгэрүүлэх болон мухар сүсэг, хоцрогдсон үзэл санаатай холбон тарааж байснаас үүдэн гарсан юм. Соёлын энэ их өргөн хүрээний солилцоо тархалт ба шудрага ёс, эрх чөлөө, энх тайвны төлөө энэрэнгүй ёсны хүмүүжил нь хүмүүсийн нэр төрийн хэргээс салгашгүй зүйл бөгөөд бүх улс үндэстнүүд харилцан туслалцах, харилцан санаа тавьж байх үзэл санааны үүднээс биелүүлж байвал зохих ариун үүрэг болдог билээ.

Иймээс хүн төрөлхтний оюун санаа, ёс суртахууны эв нэгдлийн хүчээр энх тайвныг баттай тогтоох учиртай.

ЮНЕСКО-гийн үндсэн хуулийн оршил хэсгээс

Энхийн соёл нь олон гол горихоор сэлбэгдэж байдаг эх мөрний нэгэн адил удамжлал, соёл, хэл, шашин болон улс төрийн агуулгаар улам баяжин хөгжиж байдаг. Үүний гол зорилго нь арвин баялаг соёлтой, соёлоо харилцан ойлголцсон, хүлээн зөвшөөрөлцсөн эв нэгдэлтэй байх уур амьсгалаар хамтдаа амьдарч чадах тийм дэлхий ертөнцийг бий болгох явдал юм.

Филлипин дэхь ЮНЕСКО-гийн үндэсний комисс, Холбоот Сургуулиудын Төслийн Сүлжээний зохицуулагч Рене С. Ромеро

■ Сурагчийн гүйцэтгэх ажил 37

ЭНХ ТАЙВАН БОЛОН ДЭЛХИЙН ӨВИЙГ ТОДОРХОЙЛОХ

Зорилго: Энх тайван ДӨ-ийн газрын зураг, товч тодорхойлолт



Ярилцлага



Ангийн хичээл



Хичээлийн нэг цаг



ДӨ-ийн конвенц



ДӨ-ийн газрын зураг, товч тодорхойлолт



Толь бичиг

□ “Энх тайван” гэсэн үгийг самбарт бичээд /эсвэл энэ үгийг хэлээд/ энэ үгтэй холбоотой аль болох олон үгийг сурагчдаар бичүүл. Сурагч бүр бичсэн үгнүүдээ уншаад, шинэ томъёонуудыг самбарт бичээд, давтагдсан үгнүүдийг хас. Ингэснээр “энх тайван” гэсэн үгтэй хамгийн өргөн хэрэглэгддэг үгнүүдийг мэдэх боломжтой болно.

□ Сурагчид ДӨ-ийн байршлын газрын зураг ашиглан нэрэнд нь энх тайван, эв зохицол, энх амгалан гэсэн үгнүүд эсвэл хамгаалалт, дайн /энх тайвны цогцолбор, цайз, бэхлэлт, хана хэрэм/ гэсэн үгнүүд орсон ДӨ-ийн дурсгалт газруудыг түүж авах байдлаар дээрх дасгалын адилаар хий. Дараа нь сурагчид энх тайвны холбогдолтой нэг буюу хэд хэдэн газрыг сонгон авч, сургуулийн номын сангаас нэвтэрхий толь бичиг, интернет зэргийг ашиглан тэр газрынхаа тухай болон түүний энх тайвны түүхэнд гүйцэтгэсэн үүрэг ролийн талаар ямар нэг нэмэлт мэдээллийг олж мэдэж болно.

Энх тайвныг бэлэгдсэн түүх соёлын дурсгалт газрууд

ДӨ-ийн олон дурсгалт газрууд нь энх тайван, хүний эрхийн үндсэн үнэт зүйлийг илэрхийлсэн байдаг бөгөөд тэдгээрийн хадгалалт хамгаалалтыг олон улсын хамтын ажиллагаагаар баталгаажуулсан байдаг юм. Тэдгээрийн зарим нь энэ утгаа маш хүчтэйгээр илэрхийлдэг. Жишээ нь: Канад АНУ-ын хил дээр орших Ватертон мөсөн голын олон улсын Энх Тайвны паркийн нэр нь энх тайвныг бэлхнээ илэрхийлж байна. 1995 онд ДӨ-ийн жагсаалтад орсон энэхүү дурсгалт газар нь Канадын Албертад орших Ватертон нуурын үндэсний парк болон АНУ-ын Монтана дахь мөсөн голын үндэсний паркийг багтааж байдаг. Тэдгээр нь нийлээд дэлхийн анхны олон улсын Энх Тайвны паркийг бүрдүүлж байгаа бөгөөд эндээс байгалийн хосгүй гайхамшигт дүр зураг, ургамал, сүүн тэжээлтэн амьтдын маш баялаг ертөнцтэй танилцаж болно.

Ватертон мөсөн гол- олон улсын энх тайвны парк, Канад, Америкийн Нэгдсэн Улс ЮНЕСКО



Хиросимын Энх Тайвны цогцолбор нь /Женбаку Дом/ 1996 онд ДӨ-ийн жагсаалтад бүртгэгдсэн бөгөөд энэ нь хүн төрөлхтөн урьд өмнө хэзээ ч бүтээж байгаагүй хамгийн хүчирхэг сүйрлийн зэвсэгийг хэрэглэснээс хойших хагас зуу гаруй жилийн туршид даян дэлхийн энх тайвны ололт амжилтын үнэнхүү хүчирхэг бэлэгдэл болсоор байна.

Домын хамгийн гол ач холбогдол нь юунд оршиж байна вэ гэвэл нэг талаас түүний чив чимээгүй үлдэгдэл нь хүн төрөлхтөнд ийм сүйрэл дахин хэзээ ч тохиолдохгүй байхыг бэлэгдэж байгаа бол нөгөө талаас 1945 оны 8-р сарын атомын бөмбөгийн дэлбэрэлтээр эхэлсэн даян дэлхийн энх тайвны үйл явц мөнхөд үргэлжлээсэй гэсэн хүсэл мөрөөдлийн уриа болж байдаг билээ. 1945 оны 8-р сард Хиросимад 140 мянган хүний амь насыг бүрэлгэсэн анхны атомын бөмбөгийг дэлбэлэхэд энэ барилга дэлбэрэлтийн голомтын ойролцоох барилгуудаас нуралгүй цор ганцаар үлдсэн бөгөөд өнөөдөр түүний арга хийцийг нь энд харж болно. Тэрээр түүнийг дахин сэргээн засварлаж эхэлсэн үеэс хамгаалалтад орсон бөгөөд Жимбакийн Дом гэж алдаршжээ. 1966 онд Хиросим хотын зөвлөл Дом нь мөнхийн хамгаалалтад байх ёстой гэсэн шийдвэр гаргажээ. Домын дурсгал үндсэн хэсэг нь болдог Энх Тайвны дурсгалын парк нь 1950-1964 оны хооронд байгуулагдсан бөгөөд 1952 оноос парк нь жил бүрийн 8-р сарын 6-нд Хиросимын энх тайвны дурсгалын ёслол хийдэг газар болжээ. Олон улсын хөшөө дурсгал, түүх соёлын дурсгалт газрын зөвлөл /COMOS/

Энх тайвны
бэлэг тэмдэг
болсон
Хиросимийн
энх тайвны
дурсгалт
газар, Япон
ЮНЕСКО



Хуучин Югослав улс тарж бутарснаар үүссэн дайнКроата дахь Дубровникийн эртний хотыг энх тайван, эрх чөлөөний бэлэгдлийн дурсгал болгосон юм. Далматын эрэг дээр орших "Адриатикийн сувд" гэж алдаршсан энэхүү эртний гайхамшигт хот нь олон зууны туршид өөрийн далбаан дээр "эрх чөлөө" гэдэг үгийг сийлж, бэлэгдэж ирсэн ажээ. Энэ хот 13-р зуунд хүчирхэг тэнгисийн цэргийн флот, бүх Европын орнуудыг хамарсан консулын газруудын төв, худалдаа наймааны газруудын сүлжээ бүхий газар дундын тэнгисийн чухал боомт газар болжээ. 1667 онд газар хөдлөлтийн улмаас нилээд их хэмжээний хохирол амссан хэдий ч Дубровник нь Готик, Ренэйсанс, Бароккийн хийцийн үзэсгэлэнт сүм хийдүүд, ордон, усан оргилуурууд түүнчлэн энэхүү эртний хотыг эргэн тойрон хүрээлсэн сэтгэл булаам чулуун хана зэргийг хадгалж хамгаалах талаар уйгагүй ажилласаар иржээ. Олон зууны туршид тэнгисийн зүгээс ирэх довтолгооноос хотоо хамгаалж байсан энэхүү хана нь хэдэн жилийн өмнө хотыг сүйрүүлсэн орчин үеийн хүчирхэг зэвсгээс харин хотыг хамгаалж чадсангүй. 1991 онд аюулд ороод байгаа ДӨ-ийн газруудын жагсаалтад бүртгэгдсэн Дубровник нь эвдэрч сүйрсэн барилгуудаа ЮНЕСКО-гийн дэмжлэг туслалцаатайгаар сэргээн засварлаж, энэхүү хот нь одоо олон улсын эв нэгдлийн бэлэг тэмдэг болсноос гадна, энх тайван, эрх чөлөөны бэлэгдэл байсан хэвээр байна.



Дэлхийн Өвийн
Конвенц

Дубровникийн хуучин хот, Хорват
ЮНЕСКО/ IUCN/
J. Thorsett



Дубровникийн
нурж сүйрсэн байдал, 1991
ЮНЕСКО/ D. Lefevre



■ Сурагчийн гүйцэтгэх ажил 38

ДӨ ба бүс нутгийн энх тайван

Зорилго: Энх тайвныг бэлэгдсэн өвийн дурсгалт газруудын тухай ойлгож мэдэх



Судалгаа



Ангийн ба
хөтөлбөрөөс
гадуурх
ажил



Хичээлийн
нэг цаг



Түүх,
Газар зүй,
Дүрслэх
Урлаг



ДӨ-ийн
газрын зураг,
товч
тодорхойлолт



Үндэсний
түүхийн
Сурах
бичгүүд

□ Сурагчдад энхийн гэрээ, хэлэлцээр байгуулж байсан эсвэл томоохон тулалдаанууд, чухал Тунхаг бичгүүд гэх мэт түүхэн үйл явдлуудтай холбоотой соёлын ба байгалийн дурсгалт газруудыг /болж өгвөл ДӨ-ийн газрууд/ олж тогтоохыг санал болгох.

□ Эдгээр газруудын талаар боломжоороо мэдээ цуглуулж, тэдгээрийн талаар юу бодож, итгэж найдаж явдгаа /бичих, зурах, будах гэх мэт/ бүтээлч хэлбэрээр илэрхийлэх.

Дайны үед Дэлхийн Өвийг хамгаалах нь

154

Аливаа томоохон дайнд соёлын ба байгалийн өв аль аль нь эрсдэж болно. Ард түмэн, үндэстнүүдийн өвөрмөц онцлогийг илэрхийлдэг эрхэм нандин бэлэгдэл болдгийнхоо хувьд зарим нэг онцгой соёлын дурсгалт газар зарим үед түүнийг устгах гэсэн зориудын довтолгоонд өртөгддөг. Байгалийн дурсгалт газруудын хувьд /ялангуяа ургамал амьтны ертөнцөд/ онцгой хамгаалалт бүхий байгалийн паркийн орчимд бөмбөг дэлбэлэх, түүнийг дайруулан цэрэг техникийн цувааг өнгөрүүлэх, гал түймэр, хулгайн ан, хүмүүс бөөнөөр ирж суурьших гэх мэт янз бүрийнбайдлаар аюулд өртөж болно. Аялал жуулчлалаас их хэмжээний орлого олдог соёлын ба байгалийн дурсгалт газрууд нь дайны үед санаатайгаар устгах гол бай болдог тал бий.



Дэлхийн Өв ба түүнийг таньж тогтоох нь

Дайны уршгаар үүссэн эмгэнэлт байдал дунд соёлын ба байгалийн дурсгалт газруудыг хамгаалах гэх нь байж болшгүй тансаглал мэт байж болох юм. Гэвч энэ нь нэг их юм бодолгүй анхны өнгөц ажиглалт төдий юм. Туршлагаас үзэхэд бидний соёлын ба байгалийн дурсгалт газруудыг хамгаалах нь, ялангуяа дайны үед үндэсний номын сангууд, сүм хийдүүд, музейнүүд, их сургуулиуд ба олон зуун настай эртний гүүрүүдийг хамгаалах нь онцгой чухал ач холбогдолтой, шаардлагатай болох нь харагдаж байна.



Дэлхийн Өв ба аялал жуулчлал

Дэлхийн 2-р дайны үед 1944 оны 8-р сард нацистуудын эзлэн түрэмгийлэгчдийн гараар хотын төвийн 85-иас илүү хувь нь сүйрсэн бөгөөд 1980 онд ДӨ-ийн жагсаалтад бүртгэгдсэн 13-р зууны Польшийн түүхэн хот Варшавыг сэргээн босгосон явдал бол сэтгэл татам үлгэр жишээ болдог. Хотын өнөөгийн сүм дуганууд, ордонууд, зах зээлийн газрууд нь дайны дараа хотын иргэдээс хотыг сэргээн босгох талаар хийсэн 5 жилийн их ажлын үр дүн юм. Энэ бол 13-20-р зууны хооронд бүрэн төгс сэргээн босгогдсон гайхамшигтай сайхан бахархам жишээ юм.



Дэлхийн Өв ба түүнийг таньж тогтоох нь

Залуучуудаас гаргасан Дубровникийн уриалга

Дубровникийн залуучуудын уриалга:

Бидний өвийг сүйтгэн устгаж байгаа дайны асуудлыг эв зүйгээр шийдвэрлэхийн төлөө илүү хүчин чармайлт гаргаж ажиллацгаая.



■ Сурагчийн гүйцэтгэх ажил 39

Дайнд эвдэрч муудсан өвийг сэргээх нь

Зорилго: ДӨ-ийг сэргээх засах талаар илүү сурч мэдэх



Судалгаа



Ангийн ажил



Хөтөлбөрөөс гадуурх ажил



Хичээлийн 1-2 цаг



Түүх



Нутгийн түүхийн Сурах бичгүүд, Нутгийн утга зохиол, хувь хүмүүсээс авсан Сурвалжлагууд

□ Сурагчид өөрсдийн өвөг дээдэс, хамаатан садан, ойр дотны ахмад хүмүүсээс дараах чиглэлээр сурвалжлага авах:

- Дайн, зэвсэгт мөргөлдөөнд оролцож байсан эсэх, энэ талаар юу мэдэж байгаа, тэрчлэн танай улсын соёлын ямар барилга байгууламж, байгалийн дурсгалт газрууд дайнд өртөж байсан талаар
- Тэдгээрийг сэргээн засварласан эсэх, сэргээн засварласан бол энэ талаар юу гэж бодож явдаг
- Сэргээн засварлах ажилд ДӨ-ийн газрууд хамрагдсан эсэх

□ Сурвалжлагуудаа нэгтгэн дүгнээд, үүнийгээ ярилцлагадаа ашигла.

155

▲ Соёлын өвийг хадгалж хамгаалах Гаагийн конвенц

Дэлхийн 2-р дайнд соёлын өв маш их хэмжээгээр сүйтгэгдсэнд дүгнэлт хийж 1954 онд Нидерландын Гаагд олон улсын хамтын нийгэмлэгээс Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хадгалж хагаалах тухай Конвенцийг баталсан билээ. Гаагийн Конвенцид ард түмнүүдийн онцгой ач холбогдол бүхий хөдөлгөөнт буюу үл хөдлөх соёлын өвийг, тэдгээрийн гарал үүсэл, хэний өмч болохыг үл харгалзан хамгаалах тухай заасан бөгөөд тийм дурсгалуудыг хамгаалахыг үүрэг болгосон юм.



Дэлхийн Өвийн Конвенц

1954 оны Гаагийн Конвенцийн оршил

Харилцан тохиролцогч улс орнууд

Сүүлийн үед зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлс ихээр өртөн сүйдэж байгааг болон цэрэг дайны арга техник улам боловсронгуй болж байгаагаас сүйрлийн хэмжээ улам нэмэгдэж буйг ойлгон мэдэж;

Үндэстэн бүр дэлхийн соёлд өөрийнхөө хувь нэмрээ оруулж байдаг учир ямар нэг үндэстэн ард түмний соёлын үнэт зүйлсэд учирч байгаа аюул нь нийт хүн төрөлхтний соёлын өвд учирч байгаа аюул гэдгийг ухамсарлаж;

Соёлын өвийг хадгалж хамгаалах нь дэлхийн бүх хүмүүст асар их чухал бөгөөд тийм ч учраас тухайн өвийг олон улсын хэмжээнд хамгаалах нь ач холбогдолтой гэж үзээд;

Тайван цаг үед үндэсний болон олон улсын хэмжээнд хадгалж хамгаалах арга хэмжээ авахгүй бол соёлын тэдгээр чухал өвийн хадгалалт хамгаалалт үр дүнтэй болж чадахгүй гэдгийг ойлгож;

*Соёлын үнэт зүйлсийг хамгаалах бололцоотой бүх алхмыг хийх нь зүйтэй гэж үзэж;
Саналаа нэгтгэж байна. . . .*

Гаагийн Конвенцийн гишүүн болсноор тухайн улс өөрийн газар нутаг дээр эдгээр үнэт зүйлсийг хамгаалах шаадлагатай бүхий л арга хэмжээг хэрэгжүүлж эхэлнэ. Товчлон авбал дараах зүйлийг Хийнэ:

- зэвсэгт мөргөлдөөний үед соёлын өвд учрах хор хөнөөлийг багасгах , тэрчлэн зөвхөн дайны үед төдийгүй тайван цагт соёлын үнэт зүйлсээ хамгаалах талаар урьдчилсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- хамгааллын механизмийг бүрдүүлэх; онцгой хамгаалалтад байх шаардлагатай чухал хөшөө дурсгал, барилга байгууламжуудад тусгай хамгаалалтын таних тэмдэг байрлуулах
- цэргийн хүчний дотор соёлын өвийг хамгаалах үүрэгтэй тусгай нэгжүүдийг бий болгох

Гаагийн Конвенцийг Ойрх Дорнодын 1967оны зөрчил мөргөлдөөн ба саяхны Босниа Герцеговин, Камбож, Хорват /Дубровникийн эртний хот/, Иракд болсон соёлын дурсгалт газруудыг сүйтгэж, мөхөлд хүргэсэн дайнүүдын үед жинхэнэ утгаар нь хэрэглэсэн билээ.

■ Сурагчийн гүйцэтгэх ажил 40

ДАЙНЫ ЦАГТ СОЁЛЫН БОЛОН БАЙГАЛИЙН ӨВИЙГ ХАМГААЛАХ НЬ

Зорилго: Гаагийн Конвенцийн тухай болон дайны үед хүрээлэн буй байгаль орчноо хамгаалах хэрэгцээ шаардлагын тухай сурч мэдэх



Судалгаа



Ангийн ажил



Хичээлийн нэг цаг



Түүх, Иргэний боловсрол



1954 оны Гаагийн конвенц

□ 1954 оны Гаагийн конвенцийн оршил хэсгийг сурагчидтайгаа ярилцах, өөрийн улсын ЮНЕСКО-гийн үндэсний комисс юмуу эсвэл ЮНЕСКО-гоос Конвенцийн бүрэн хуулбарыг олж авахыг хичээ. Дараах сэдвүүдээр үрилц:

- Гаагийн Конвенцийн анхны төслийг гаргасан түүхэн цаг үе /дэлхийн 2-р дайны дараах үе/
- Гаагийн Конвенцын зорилгууд болон тайван цагт эсвэл дайны цагт өв хамгаалах зорилтууд
- Гаагийн Конвенц болон ДӨ-ийн Конвенц хоёр нь юугаараа ялгаатай, юугаараа нийтлэг болох
- Сүүлийн үед гарч байгаа дайн ба зэвсэгт мөргөлдөөний үед Конвенцийг хэрэглэж буй жишээ
- Дайн хүрээлэн буй байгаль орчныг хэрхэн сүйтгэж байна вэ?

□ Дайн бидний байгаль орчныг хэрхэн сүйтгэж байгаа тухай ярилц.



Харилцах хаягууд

157

▲ Дайны цагт байгалийн өвийг хамгаалах нь

Сүүлийн үеийн дайны уршгаар манай гариг дээрх хамгийн чухал ач холбогдол бүхий зарим экосистемүүд сүйдэж байгаа нь цэргийн зэвсэг техникийг дайран өнгөрүүлэх, санаатайгаар гал түймэр тавих болон дайнаас дайжсан хүмүүсийг бөөнөөр нь оруулах зэрэг нөхцөл байдалд байгалийн өвийг хамгаалах нь хэчнээн бэрхшээлтэй байдгийг бэлхнээ харуулж байна. Зайр улсын Кахузи- Биегын /одоогийн Бүгд Найрамдах Конг улс/ ДӨ-ийн дурсгалт газар нь дээрхийг нотлох нэг тод жишээ юм. Рвандад болсон дайны уршгаар эрдэмтэн Георгий Скалерийн, хожим нь профессор Грэмик ба Диан Фоссейн судалсан ховордож бараг устаж үгүй болоод байгаа уулын мичны /горил/ өлгий нутаг болсон паркийн хилийн орчим 50 мянган хүний хорих лагерь барьжээ. ЮНЕСКО, НҮБ-ийн дүрзвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссар болон Германы тусламжийн агентлаг GTZ-ын удирдлагуудын хүчин чармайлт, ДӨ-ийн Сангийн санхүүгийн дэмжлэг тусалцаатайгаар хорих лагерьийг өөр илүү тохиромжтой газар нүүлгэн шилжүүлсэн байна.



Устах аюулд учраад байгаа уулын сармагчин, Бвинди байгалийн цогцолбор газар, Уганд ЮНЕСКО

ДӨ ба хүний эрх

Хүний эрхийг хүлээн зөвшөөрөх, хүндэтгэн дээдлэхийн төлөө хүн төрөлхтний тэмцэл нь голдуу энх тайван, эрх чөлөө, хөгжил дэвшлийн төлөөх үйл ажиллагааг дагуулж байдаг. Энэхүү тэмцэл нь түүнчлэн эртнээс нааш ардчилалын зарчмууд болон хүмүүсийн засаглалд оролцох оролцоотой холбоотой явжирсэн.


ДӨ-ийн олон дурсгалт газрууд нь хүний эрхийн үзэл санааг хэдийгээр янз бүрээр, заримдаа бүр ойлгоход амаргүй аргаар илэрхийлж байдаг ч тэдгээрийг өөртөө агуулж байдаг юм. Энэхүү үзэл санааг дараах жишээнүүдээр тайлбарлаж болох юм.

Нийслэл Дакарын ойролцоох Сенегалийн эргээс зайдуу орших Горее арал нь 15-19-р зуунд Африкийн эрэг дээрх боол худалдаалах хамгийн том төв байжээ. Португал, Голланд, Англи, Францын эрх мэдэлтнүүдийн ээлжлэн эзэмшиж ирсэн энэхүү аралын барилга архитектурын онцлог нь боолчуудын навсгар оромжууд болон боол худалдаалагчдын тансаг орд харшуудын хоорондын эрс тэс ялгаагаар тодорхойлогдоно. Энэ ялгаатай байдал нь одоо ч байсаар байна.

Хүний эрхийг уландаа гишгэж, сая сая гэм зэмгүй иргэдийг тарчлаан зовоож, үгээр илэрхийлэхийн аргагүйгээр зовлон зүдгүүрт учруулж байсан өөр нэг газар бол 1979 онд ДӨ-ийн жагсаалтад бүртгэгдсэн Польшийн Овсвенцийн хорих лагерь юм. Түүний цахилгаан гүйдэлд холбосон төмөр утсан хамгаалалт бүхий хана, тавцангууд, хуарангууд, дүүжлүүрүүд болон хамгийн аймшигтай нь хорт хийгээр утаж муужруулдаг тасалгаанууд, хүүр шатаах зуухнууд зэрэг нь дэлхийн 2-р дайны үед хүний эрх эрх чөлөөг туйлийн бүдүүлгээр зөрчиж байсныг гэрчилж байгаа билээ. Фашистууд энд 24 үндэстний, ялангуяа еврей үндэстний 1.5 сая хүний амь насыг хороосны дотор хүүхэд өндөр настнууд их хэмжээгээр байсан ажээ. Энэ дурсгал нь ирээдүйд тийм аймшигт зүйлийг гаргуулахгүйн төлөө байнга дурсаж байвал зохих хүн төрөлхтний түүхийн нэг үеийг төлөөлж байдаг юм. Энэ бол хорт муу бодлого зуршлийн аймшигт үр дагавар юм.

Өнөөдөр шоронгын тасалгаанууд, хорт хийн өрөөнүүд, хүүр шатаах зуух бүхий Овсвенцийн үндэсний музейд зочлон ирж болох бөгөөд музей нь ховор нандин архивтай түүхийн болон судалгаа шинжилгээний байгууллагын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж байна. Жил бүр дэлхийн өнцөг булан бүрээс сургуулийн бүхэл бүтэн анги, хамт олон зэрэг мянга мянган зочдыг хүлээн авдгаараа

Овсвенцийн музей нь даян дэлхийн энх тайван аюулгүй байдлын төлөө явуулж буй тэмцэлд ихээхэн хувь нэмэр оруулж байдаг юм.



Польшийн Овсвенцийн хорих лагерь
ЮНЕСКО/А. Husarska

■ Сурагчийн гүйцэтгэх ажил 41



МУХАР СҮСЭГ, МУЙХАР ҮЗЭЛ БОЛ ЭНХ ТАЙВАНД УЧИРЧ БҮЙ ТОМООХОН АЮУЛ ЮМ

Зорилго: Үл эвлэрэл, үл ойлголцлолыг арилгах, харилцан соёлоосоо суралцах, дэлхий ертөнцөө хүндлэн хайрлах



Ярилцлага



Ангийн ажил



Хөтөлбөрөөс гадуурх ажил



Хичээлийн хэд хэдэн цаг



Түүх, Иргэний боловсрол, хэл утга зохиол




Түүхийн сурах бичиг, нэвтэрхий толь

□ Мухар сүсэг, муйхар тэнэг үзэл, үл эвлэрэл, ялгаварлан гадуурхах үзэл зэргээс үүдэлтэй түүхэн гол үйл явдлууд /Дэлхийн 1, 2-р дайн, боолчлол гэх мэт/-ын талаар сурагчдын сэтгэгдлийг солилцуулах, ирээдүйн энх тайван амар амгалан байдлыг баталгаажуулах хэрэгцээ шаардлагын талаар богино өгүүллэг, шүлэг найраглал бичих, зураг зурах, зурагт хуудас гаргах, дуу хөгжим зохиох зэрэг хэлбэрээр сэтгэгдлээ илэрхийлэх

□ Ингэхдээ ДӨ-ийн талаарх мэдэж авсан бүх зүйлүүдтэйгээ холбон авч үзэх: ДӨ-ийн газруудыг сурч мэдэх замаар бусад соёл, амьдралын хэв маягийн тухай мэдэх явдал нь бусад ард түмэн, дэлхий ертөнцөө ойлгон, талархан хүндэтгэхэд хувь нэмэр болох уу?

Хамгийн нандин үнэт зүйл болсон эрх чөлөө нь зарим ДӨ-ийн дурсгалт газруудын гол мөн чанар, агуулга нь болж байдаг, тухайлбал АНУ-д байдаг Эрх чөлөөний Хөшөө ба Тусгаар Тогтнолын Ордон зэрэг. ДӨ-ийн жагсаалтад 1984 онд бүртгэгдсэн Эрх чөлөөний Хөшөө нь Нью-Йоркийн Харвар руу орох хаалган дээр байдаг ба 1886 онд анх нээгдсэн цагаас эхлэн Америк руу тэмүүлсэн сая сая цагаачдыг угтан авсан дурсгал юм. Энэ агуу том хөшөө дурсгал нь 46 метр өндөр бөгөөд түүнийг Францийн уран барималч Фредрик Август Бартолд Парист бүтээжээ. Тэрээр Францийн Парис хотын Эфлийн цамхаг бүтээн босгосон Густав Эйфелд төмөр эдлэлийг нь хийж гүйцэтгэхэд тусалдаг байсан байна. Эрх чөлөөний бэлэгдэл болсон энэ хөшөө нь 19-р зууны техникийн гарамгай ололтуудын нэг юм. Олон улсын хандиваар санхүүжигдсэн энэхүү хөшөөг Европод Францийн уран барималч бүтээсэн нь улс хоорондын энхийн соёлын солилцоог илэрхийлсэн Дө-ийн дурсгалт газрын бэлэгдэлийн шинжтэй үнэт чанарыг улам томруун илтгэж байгаа юм.

Пенсилваны Филадельф хотын төвд оршдог Тусгаар Тогтнолын Ордон нь 1776 онд АНУ-ын тусгаар тогтнолыг зарлан тунхаглаж, 1787 онд АНУ-ын үндсэн хуулийг албан ёсоор баталсан түүхт газар юм. Энэ цагаас хойш Арчилалын үндсэн зарчмууд анх тусгалаа олсон бөгөөд Америкийн болон дэлхийн түүхэнд чухал ач холбогдолтой энэхүү 2 үндсэн баримт бичиг дэлхийн ихэнх газруудын хууль тогтоогчдын хүсэл зоригийг бадраасаар иржээ. Тус газрыг ДӨ-ийн жагсаалтад 1979 онд бүртгэсэн билээ.



Америкийн Нэгдсэн Улсын Тусгаар Тогтнолын Ордон ЮНЕСКО

■ Сурагчийн гүйцэтгэх ажил 42



ДЭЛХИЙН ӨВ БА ЭНХ ТАЙВНЫ ХОЛБОГДОЛТОЙ ҮГИЙН СҮЛЖЭЭ

Зорилго: ДӨ-ийн хамгаалал ба энх тайван хоёрын хоорондын амин чухал уялдаа холбоог сурагчдын ой тоонд нь шингээж бэхжүүлэх



Дасгал



Хичээлийн
1-2 цаг



Нийгмийн
боловсрол




ДӨ-ийн газрын
зураг




Сурагчийн дасгал
ажлын хуудас,
үгийн сүлжээ,
толь бичиг,
нэвтэрхий толь

□ Сурагчдаар 1-рт ДӨ-ийн газруудын, 2-рт энх тайвантай холбоотой үгнүүдийн /энх тайван гэсэнтэй ижил утгатай: цэрэг дайны үйлдлийг зогсоох, энхийн хэлэлцээр, зохицол, эе эв, нөхөрсөг харьцаа, амар амгалан, тайван тогтуун гэх мэт; энх тайвантай холбогдолтой үгс; үл довтолцох, хүч үл хэрэглэх; энх тайвны эсрэг үгс; дайн, түрэмгийлэл, зэвсэгт мөргөлдөөн, дайсагнал, өшөө хонзон, тэмцэл, тулаан/ гэсэн 2 жагсаалт гаргуул.

□ Дараа нь ДӨ-ийн газруудын нэр болон жагсааж бичсэн үгнүүдээсээ ашиглан үгийн сүлжээ зохиох. Ингэхдээ сурагчид дасгал ажлын хуудсан дээрх үгийн сүлжээг жишээ болгон ашиглаж болно.





Сэдвийн дүгнэлт: Дэлхийн Өв ба Энхийн соёл

Урлаг

Энх тайван ба гоо зүйн холбогдолтой ДӨ-ийн газруудыг сонгох
Энх тайван, ДӨ-ийн хадгалалт хамгаалалтыг хоёуланг сурталчилсан зурагт хуудасгаргах

Гадаад хэл

Энх тайван буюу өвийн холбогдолтой үгсийг өөрийн мэддэг бусад хэл рүү орчуулж, жагсаалт гаргах,
цаашид гадаад хэл сурахдаа энх тайвны холбогдолтой ДӨ-ийн газруудыг судлах

Газарзүй

Өдөр тутмын сонин уншиж, дэлхийн янз бүрийн хэсэгт гарч буй зөрчил, хурцадмал байдлын үед ДӨ-д учирч болзошгүй аюул заналхийллийн талаар өгүүлэг материалуудыг хайчилж авч цуглуулах
Хайчилбаруудаа нэг сарын дараагаар Африк, Арабын нэгдсэн улс, Ази Номхон Далай, Европ, Хойд Америк, Латин Америк ба Карибын тэнгис гэх мэт газарзүйн бүсүүдээр нь харьцуулж жишиж үзүүл.
Аливаа ДӨ-ийн газар нь ямар нэг зөрчил түгшүүртэй газарт хэр ойр байгааг тогтоон, тэдгээр нь аюул сүйрэлд орж болох эсэх талаар ярилцах

Түүх

Өөрийн улсад буюу дэлхийн хаана нэг энх тайвныг бэлэгдсэн буюу энх тайвны холбогдолтой ДӨ-ийн жагсаалтад ороогүй газрыг олж тогтоон, түүхэн ач холбогдлыг нь хэлэлцэж ярилцах

Хэл

Энх тайван гэсэн үгний ижил утгатай үгсийг жагсаан бичиж, дараа нь аль нэгээр нь ДӨ-ийн холбогдолтой тэмдэглэл, өгүүлэл бичих


Математик

Сенегалийн Горее арал гэх мэт ДӨ-ийн газрыг сонгон авч, жишээ нь: арлаа орхиод Америк руу завиар гарч явсан боолчуудын тоог судалж 10, 100 жилээр хүснэгтэд тоо баримтуудыг үзүүлэх ба үр дүнг нь ярилцах

Эх сурвалж материалууд

Эх сурвалж материалууд

ЮНЕСКО/ V. Cousteron/ B. Galy/ B. Petit- JUCN/ Thorseil; Patrimoine 2001/ Christophe Lepetit




"ДӨ-ийн ач холбогдлыг ойлгоход бидэнд туслах сонирхолтой тэгээд тохирсон сургалтын материалууд бидэнд хэрэгтэй байна. Залуучууд тэдгээр материалуудыг бэлтгэхэд ч оролцох ёстой."

Норвегийн Бергенд болсон Олон улсын анхны ДӨ-ийн залуучуудын чуулганы Бидний Тангарагаас

Эх сурвалж материалууд

Товч тайлбар толь	Хуудас 165
Харилцах хаяг	169
ЮНЕСКО-гийн төв байр	169
ЮНЕСКО-гийн бүсийн ба дэд бүсийн байгууллагууд	171
Холбогдох байгууллагууд	172
Ашигласан материалын жагсаалт	175
ЮНЕСКО-гийн үнэгүй тараагддаг материалууд	175
ЮНЕСКО-гийн худалдаж борлуулдаг материалууд	176
Худалддаг бусад материал	177
Холбоо барих хаягийн жагсаалт	178
Бусад эх сурвалж материалууд	
ДӨ-ийн конвенц	
ДӨ-ийн газруудын товч тодорхойлолт	
ДӨ-ийн газруудын 26 гэрэл зураг	
ДӨ-ийн байршлын газрын зураг	
Зурагт хуудас	
Наадаг цааснууд	



Товч тайлбар толь

Холбоот Сургуулиудын Төслийн сүлжээ /ASPnet/

Энхийн соёл, хүлцэл тэвчээр, олон улсын харилцан ойлголцлыг дэмжин сурталчлахад боловсролын үүргийг хүчтэй болгох зорилгоор дэлхий даяар сургуулиудын хүчийг дайчлах үүднээс ЮНЕСКО 1953 онд энэхүү сүлжээний үйл ажиллагааг эхлүүлсэн юм. Өнгөрсөн 50 гаруй жилийн хугацаанд дээрх зорилгын хүрээнд дэлхийн 7000 гаруй сургууль боловсролын шинэ арга хандлага болон сургалтын материалыг хөгжүүлэн хэрэгжүүлэх зорилгоор энэ сүлжээнд нэгдэн орсон байна.

Биологийн/ амьтан ургамлын/ төрөл зүйлүүд

Дэлхий дээрх бүхий л төрөл зүйлийн амьтан, ургамал, бичил биетүүд, тэдгээрийн генүүд, мөн тэдгээрийг өөртөө багтаасан экосистемүүд энэ бүгдийг оруулсан амьд амьдралын бүхий л хэлбэрийн төрөл зүйлийг илэрхийлнэ.

Хадгалалт хамгаалалт

Онцгой үнэт зүйлийг нь хадгалж үлдээх үүднээс тодорхой газар нутгийг хадгалж хамгаалах үйл явц юм. Хадгалж хамгаалах нь хадгалах, хамгаалах, сэргээх, бүтээх, дахин байгуулах зэрэг орно.

Шалгуурууд, шалгуур

ДӨ-ийн Жагсаалтанд бүртгэхээр Дэлхийн дахины нийтлэг гайхамшигт үнэ цэнэ бүхий дурсгалт газрыг сонгон шалгаруулахад хэрэглэдэг шалгуурууд юм.

Энхийн соёл

Энх тайвны үзэл санааны гол зүрх болсон үнэт зүйлд үнэнч байх явдлыг хөхүүлэн дэмжих үүднээс ЮНЕСКО-гоос авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийг нэгтгэн зангидаж байгаа цогцолбор үзэл ойлголт юм.

Соёлын өв гэдэг нь

ДӨ-ийн Конвенцид хөшөө дурсгал, барилгын цогцолбор, дурсгалт газар гэж тодорхойлсон.

Соёлын дурсгалт газрууд

Хүн ба хүрээлэн буй байгаль орчны харилцан үйлчлэлийг харуулна.

ЮНЕСКО-гийн Ерөнхий бага хурал

ЮНЕСКО-гийн бүх гишүүн орнууд 2 жил тутам тус байгууллагын Хөтөлбөр, төсвийг батлахаар хуралддаг.

ICCROM Соёлын дурсгалт зүйлийн хамгаалалт, сэргээн засварлалтыг судлах олон улсын төв юм.

Соёлын өвийг хэрхэн хамгаалах ба сэргээн засварлах талаар мэргэжлийн зөвлөгөө өгч, сэргээн засах арга барилд сургах сургалтууд зохион байгуулна.

ICOM Олон улсын музейн зөвлөл

Дэлхийн хэмжээгээр музей болон музейн мэргэшлийг хөгжүүлж, дэмжлэг үзүүлнэ.

ICOMOS Хөшөө дурсгал ба дурсгалт газруудын олон улсын Зөвлөл

ДӨ-ийн жагсаалтад орохоор нэр нь дэвшигдсэн соёлын газрууд ба соёлын дурсгалт газруудын талаар техникийн мэргэшлийн үнэлгээ өгнө.

IUCN Дэлхийн байгаль хамгааллын холбоо

ДӨ-ийн Жагсаалтад оруулахаар нэр дэвшсэн байгалийн дурсгалт газрыг сонгон шалгаруулах талаар ДӨ-ийн хороонд зөвлөнө.

ДӨ-ийн аюулд ороод байгаа газруудын жагсаалт

Ноцтой аюулд учирснаар тэдгээрийг хамгаалах талаар олон улсын хадгалалт хамгаалалтын нийгэмлэгийн хамтын хүчин чармайлт зайлшгүй шаардлагатай болоод байгаа тухай ДӨ-ийн хорооны шийдвэр гарсан ДӨ-ийн дурсгалт газрууд орно.

166

Гишүүн орон /Оролцогч орон/

ЮНЕСКО-гийн оролцогч улс орнуудыг хэлнэ.

Байгалийн өв

ДӨ-ийн Конвенцид байгалийн шинж чанарууд, геологийн болон физиографик бүтцүүд болон байгалийн дурсгалт газар гэж тодорхойлсон.

Нэр дэвшүүлэх

ДӨ-ийн Конвенцид нэгдсэн гишүүн орон нь ДӨ-ийн Жагсаалтад дурсгалт газраа оруулж бүртгүүлэх гэсэн хүсэлтэй байдгаас урган гарсан үйл явц юм. Нэр дэвшүүлэх тусгай маягыг бөглөж, ЮНЕСКО-гийн ДӨ-ийн төвд явуулна.

Дэлхийн гайхамшигт үнэт зүйл

Устаж үгүй болбол түүнийг юугаар ч нөхөж орлуулах боломжгүй болж, дэлхийн бүх ард түмний хувьд их гэрз болох тийм дурсгалт газрыг хэлнэ. Үүнийг Дэлхийн үнэт өв гэж товчоор тодорхойлж болно.

Патримонито /Өв хамгаалагч/

Өв хамгаалагч залуу хүнийг бэлэгдсэн тодорхойлолт юм. Энэ нь 1995 онд Норвегийн Бергенд болсон ДӨ-ийн залуучуудын анхдугаар чуулга уулзалтад оролцогчдоос гарчээ.

Оролцогч орон /ганц/, оролцогч орнууд /олон/

ДӨ-ийн Конвенцид нэгдэн орсон орнуудыг хэлнэ. Тэдгээр нь Конвенцид орсноороо өөрийн улсын нутаг дэвсгэр дээрх дурсгалт газруудаа олж тогтоох, ДӨ-ийн жагсаалтад бүртгүүлэхээр нэрийг нь дэвшүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Оролцогч орон нь дурсгалт газрын нэрийг дэвшүүлэхдээ тус газар хэрхэн хамгаалагдсан талаар болон түүний хамгаалалтын менежментийн төлөвлөлт хэрхэн хийгдсэн тухай нарийвчилсан мэдээлэл өгнө. Оролцогч орнууд нь цаашилбал жагсаалд бүртгэгдсэн ДӨ-ийн дурсгалт газрын үнэт зүйлсийг хамгаалах ёстой бөгөөд хамгаалалтын нөхцөл байдлын талаар ЮНЕСКО-д тогтмол илтгэж байна. Бүх оролцогч улсууд 2 жилд нэг удаа оролцогч орнуудын Ерөнхий ассамблейн ЮНЕСКО-гийн ерөнхий бага хурлын ээлжит чуулганд цуглардаг. Ерөнхий ассемблейд оролцогч орнууд нь ДӨ-ийн хороог сонгоно. ДӨ-ийн сангийн тайланг хэлэлцэж, бодлогын чанартай асуудлуудаар шийдвэр гаргана.

Урьдчилсан Жагсаалт

Конвенцид оролцогч улс бүр дараагийн 5-10 жилд ДӨ-ийн жагсаалтад оруулахаар нэрийг нь дэвшүүлэх соёлын ба байгалийн дурсгалт газруудынхаа урьдчилсан жагсаалтыг гаргана.

НҮБ

2001 оны байдлаар 189 гишүүн орныг эгнээндээ нэгтгэсэн олон улсын байгууллага юм. Тэрээр дэлхийн II дайны дараа олон улсын энх тайван, аюулгүй байдал, үндэстнүүд хооронд нөхөрсөг харьцааг тогтоох, нийгмийн дэвшил хөгжил, хүний эрх, амьдралын түвшинг дэмжих зорилгоор байгуулагдсан.

ЮНЕСКО

2003 оны 10-р сарын байдлаар 190 орныг эгнээндээ нэгтгэсэн НҮБ-ын төрөлжсөн байгууллага юм. ЮНЕСКО-гийн зорилго нь олон улсын оюун санааны хамтын ажиллагаагаар дамжуулан эрэгтэй, эмэгтэй бүх хүний оюун бодолд энх тайвны хамгааллыг бат бөхөөр суулгах явдал юм.

ЮНЕСКО-гийн ДӨ-ийн төв

ДӨ-ийн хорооны гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх асуудлыг хариуцна.

ЮНЕСКО-гийн залуучуудын ДӨ-ийн төсөл

ЮНЕСКО-гийн ДӨ-ийн төв ба Холбоот Сургуулиудын Төслийн Сүлжээний зохицуулах нэгж хамтран зохицуулж байдаг бүс дундын төсөл юм. Энэ нь ДӨ-ийн дурсгалт газрууд, тэдгээрийн хамгааллын тухай илүү ихийг таниулж ойлгуулах үүднээс бүх бүс нутагт сургуулийн хөтөлбөрөөр ДӨ-ийг танилцуулах эрхэм зорилготой юм.

Дэлхийн Өв

ЮНЕСКО-гийн ДӨ-ийн Жагсаалтад бүртгэгдсэн дэлхийн гайхамшигт үнэт зүйл болох соёлын ба байгалийн дурсгалт газрууд юм.

Дэлхийн Өвийн Товчоо

ДӨ-ийн Хорооны 7 гишүүнээс бүрдэх бөгөөд хорооны ажлыг бэлтгэх зорилгоор

жилд 2 удаа хуралддаг.

Дэлхийн Өвийн хороо

21 гишүүнтэй, засгийн газар хоорондын байгууллага бөгөөд ДӨ-ийн Конвенцийг хэрэгжүүлэх асуудлыг хариуцна.

Дэлхийн Өвийн Конвенц

Соёлын болон байгалийн өвийг хадгалж хамгаалах тухай Конвенц нь 1972 онд ЮНЕСКО-гийн ерөнхий бага хурлын 16-р чуулганаар батлагдсан. Конвенцийн зорилго нь дэлхийн гайхамшигт үнэт зүйл болох соёлын ба байгалийн өвийг хадгалж хамгаалах, хойч үедээ өвлүүлэн үлдээх явдал юм.

Дэлхийн Өвийн сан

Сайн дурын болон албан журмаар орж ирсэн хандиваас бүрдэх бөгөөд ДӨ-ийн дурсгалт газруудыг хамгаалахад зориулагдсан.

Дэлхийн Өвийн Жагсаалт

Дэлхийн гайхамшигт үнэт зүйл болох соёлын, байгалийн мөн соёл, байгалийн хосолмол дурсгалт газруудын жагсаалт юм.

Дэлхийн Өвийн залуучуудын чуулга уулзалт

1995 онд Норвегийн Бергенд, 1996 онд Хорватын Дубровникт, 1996 онд Зимбабвейн Викториа Фаллст, 1997 онд Хятадын Бээжинд, 1998 онд Японы Осакад, 1999 онд Сенегалийн Ип де Гореед, 1999 онд Морокогийн Ифранд, 2000 онд Австралийн Кайрнсд, 2001 онд Перугийн Лимад, 2001 онд Шведийн Карлскронад, 2002 онд Словакийн Братиславт, 2002 онд Оросын Великий Новгород, 2002 онд Жорданы Оманд, 2003 онд Грекийн Родест тус тус болсон. Залуучуудын чуулга уулзалтын зорилго нь залуу үеийнхний дунд соёлоо харилцан ойлголцох, солилцох явдлыг дэмжих, ДӨ-ийн Конвенцийн чухал болохыг ойлгож ухамсарлуулах, ДӨ-ийн хамгаалалд залуучуудыг татан оролцуулах зорилгоор бүс нутгийн болон үндэсний үйл ажиллагааг хөгжүүлэх явдал юм.



Харилцах хаяг

■ ЮНЕСКО-гийн төв байр

UNESCO Headquarters

7 place de Fontenoy
75352 Paris 07 SP
France
Tel: (33 1) 45 68 10 00
Fax: (33 1) 45 67 16 90
<http://www.unesco.org>

ДӨ-ийн төв

UNESCO Headquarters
Tel: (33 1) 45 68 15 71
(33 1) 45 68 18 76
Fax: (33 1) 45 68 55 70
E-mail: wh-info@unesco.org
<http://www.unesco.org/whc>
www.unesco.org/whc/education

Холбоот сургуулиудын төслийн сүлжээ /ASPnet/

Education Sector
UNESCO Headquarters
Fax: (33 1) 45 68 56 39
E-mail: aspnet@unesco.org
<http://www.unesco.org/education/asp>

ЮНЕСКО-гийн соёлын өвийн хэлтэс

Соёлын хэлтэс дотор байх бөгөөд ДӨ-ийн үнэт зүйлсийг хамгаалах талаар олон улсын үйл ажиллагааг удирдан явуулах асуудлыг зарчмын хувьд хариуцдаг. Мөн ДӨ-ийн төв, ICCROM, ICOMOS-той хамтран төсөл хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэнэ.

Division of Culture Heritage
Sector for Culture
1 rue Miollis
75732 Paris Cedex 15
France
Tel: (33 1) 45 68 37 56
Fax: (33 1) 45 68 55 96

Олон улсын стандартын хэлтэс

Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлсийг хадгалж хамгаалах тухай 1954 оны Гаагийн Конвенц, соёлын үнэт зүйлсийг хууль бусаар хилээр оруулах гаргах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох ба урьдчилан сэргийлэх тухай 1970 оны конвенцийг хэрэгжүүлэх ажлыг удирдана.

International Standards Section
Division of Cultural Heritage, Sector for Culture
UNESCO Headquarters

ЮНЕСКО-гийн шинжлэх ухааны хэлтэс

Байгалийн шинжлэх ухааны хэлтэс, Дэлхий ертөнцийн шинжлэх ухааны хэлтэс ба Хүрээлэн буй орчны хөтөлбөрийн зохицуулалтын товчоон дотор байх бөгөөд ДӨ-ийн төв ба IUCN-той хамтран ДӨ-ийн байгалийн үнэт зүйл, ялангуяа ЮНЕСКО-гийн био сферийн хамгаалалтад байдаг газруудтай холбоотой төсөл хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэдэг.

Division of Ecological Sciences
Science Sector
1 rue Miollis
75732 Paris Cedex 15
France
Tel: (33 1) 45 68 40 67
Fax: (33 1) 45 68 58 04

Хүн ба биосферийн хөтөлбөр:
E-mail: mab@unesco.org
<http://www.unesco.org/mab>

Энхийн соёлын хөтөлбөр

Энх тайвны зүрх болсон үнэт зүйлүүдийг хадгалж хамгаалах зорилгоор ЮНЕСКО-гийн хэрэгжүүлэх үйл ажиглагаанд хамтран оролцох явдал юм.

Culture of Peace Co-ordination
UNESCO Headquarters
Tel: (33 1) 45 68 12 20
Fax: (33 1) 45 68 55 57
E-mail: cp@unesco.org
[Http://www.unesco.org/cp](http://www.unesco.org/cp)

ЮНЕСКО-гийн хэвлэх газар /UPO/D/

UNESCO Headquarters
Tel: (33 1) 45 68 46 25

■ ЮНЕСКО-гийн бүсийн ба дэд бүсийн байгууллагууд

Fax: (33 1) 45 68 57 39

<http://upo.unesco.org>

ЮНЕСКО Дакар

12 Avenue Roume, BP 3311, Dakar, Senegal

Tel: (221) 8492323

Fax: (221) 8238393

E-mail: dakar@unesco.org

ЮНЕСКО Сантьяго

Calle Enrique Delpiano 2058, Casilla 3187, Santiago, Chile

Tel: (56 2) 6551050

Fax: (56 2) 655 1046

E-mail: uhst@unesco.org

ЮНЕСКО Банкок

Prakanong Post Office, Box 967, Bangkok, 10110, Thailand

Tel: (662) 391 0879/0577/0550

Fax: (662) 391 0866

E-mail: bangkok@unesco.org

ЮНЕСКО Амман

PO Box 2270, Wadi Saqra, Amman 11181, Jordan

Tel: (962 6) 5514234/6559

Fax: (962 6) 5532183

E-mail: amman@unesco.org

ЮНЕСКО Апиа

PO Box 5766

Matautu, UTA Post Office, Apia, Samoa

Tel: (685) 24 276

Fax: (685) 22 253

E-mail: unesco.apia@unesco.org

ЮНЕСКО Хараре

PO Box HG 435, Highlands, Harare, Zimbabwe

Tel: (263 4) 77 6114/15

Fax: (263 4) 77 60 55

E-mail: harare@unesco.org

ЮНЕСКО Сан Жосе

Ap. Postal 220, San Francisco 2120, San Jose, Costa Rica

Tel: (506) 296 37 81/ 220 44 00

Fax: (506) 231 22 02

E-mail: san-jose@unesco.org

ЮНЕСКО Доха

PO Box 3945, Doha, Qatar

Tel: (974) 86 77 07/77 08

■ Холбогдох байгууллагууд

Fax: (974) 86 76 44

E-mail: doha@unesco.org

Соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн засварлах судалгааны олон улсын төв /ICCROM/

ICCROM

Via di San Michele 13

1-00153 Rome

Italy

Tel: (396) 585 531

Fax: (396) 585 533 49

E-mail: iccrom@iccrom.org

<http://www.icomos.org/iccrom>

Хөшөө дурсгал, дурсгалт газрын олон улсын зөвлөл /ICOMOS/

ICOMOS

49-51 rue de la Federation

75015 Paris

France

Tel: (33 1) 45 67 67 70

Fax: (33 1) 45 66 06 22

E-mail: secretariat@icomos.org

<http://www.icomos.org>

Дэлхийн хадгалалт хамгаалалтын холбоо /IUCN/

IUCN

Rue Mauverney 28

CH- 1196 Gland

Switzerland

Tel: (41) 22 999 0001

Fax: (41) 22 999 0010

E-mail: mail@iucn.org

<http://www.iucn.org>

Олон улсын музейн зөвлөл /ICOM/

ICOM

1 rue Miollis

75732 Paris Cedex 15

France

Tel: (33 1) 47 34 05 00

Fax: (33 1) 43 06 78 62

E-mail: secretariat@icom.org

<http://www.icom.org>

Скандинавын орнуудын ДӨ-ийн байгууллага /NWHO/

NWHO

Postbox 8196 Dep.

N- 0034 Oslo

Norway

Tel: (47) 22 94 05 80

Fax: (47) 22 94 05 81

E-mail: nwho@ra.no
<http://www.grida.no/ext/nwho/index.htm>

ДӨ-ийн хотуудын байгууллага /OWHC/

OWHC
56 Rue Saint-Pierre
Quebec G1K 4 A 1
Canada
Tel: (1) 418 692 0000
Fax: (1) 418 692 5558
E-mail: secretariat@ovpm.org
<http://www.ovpm.org>

***НҮБ-ийн боловсролын хөтөлбөрийн дэлхий нийтийн
хамгааллыг хянах төв /WCMC/***

UNEP WCMC
219 Huntingdon Road
Cambridge CB3 0DL
United Kingdom
Tel: (44) 1223 277 314
Fax: (44) 1223 277 136
E-mail: info@unep-wcmc.org
<http://www.unep-wcmc.org>

Дэлхийн аялал жуулчлалын байгууллага /WTO/

WTO
Capitan Haya 42
28020 Madrid
Spain
Tel: (34 91) 567 81 00
Fax: (34 91) 571 37 33

Тэмдэглэгээ: дээрх мэдээлэл өөрчлөгдөж болно. Өөрчлөгдөсөн хаягуудыг мэдэхийг хүсвэл ЮНЕСКО-гийн удирдах байгууллагт хандаарай.





Ашигласан материалын жагсаалт

■ ЮНЕСКО-гийн үнэгүй тараагддаг материал

Дэлхийн Өвийн газрын зураг /эмхмэл зураг/
Англи, Франц, Испани хэлээр

Дэлхийн Өвийн жагсаалт
Англи, Франц хэлээр

Дэлхийн Өв /мэдээллийн хуудсууд/
Англи, Франц, Испани хэлээр

Дэлхийн Өв 2002 /мэдээллийн өнгөт товхимол/
Англи, Франц, Испани хэлээр 2002 оны 4-р сараас

Дэлхийн Соёлын ба Байгалийн Өвийг Хадгалж Хамгаалах Конвенц
Парис, ЮНЕСКО, 1972
Англи, Франц, Испани, Орос, Араб хэлээр

Дэлхийн Өвийн Конвенцийг хэрэгжүүлэхэд ашиглах удирдамж
Англи, Франц хэлээр

Дэлхийн Өвийн сар тутмын мэдээллийн хэвлэл
ДӨ-д тулгарч буй асуудлууд, хамгийн сүүлийн үеийн мэдээ, мэдээлэл
Англи, Франц хэлээр

Дэлхийн Өвийн Боловсролын эмхэтгэл
ДӨ-ийн боловсрол ба Холбоот Сургуулиудын төслийн сүлжээний тухай товч тодорхойлсон 4 хуудас бүхий сэтгүүл
Англи, Франц хэл дээр

Холбоот Сургуулиудын Төслийн сүлжээний танилцуулга хуудас
Холбоот Сургуулиудын Төслийн сүлжээний талаар товч тодорхойлсон бяцхан ном

ЮНЕСКО-гийн Холбоот Сургуулиудын Төслийн сүлжээнд хэрэглэгдэх түлхүүр үгс
Холбоот Сургуулиудын Төслийн сүлжээний холбогдолтой багц дүрэм

Дэлхийн Өвийн Залуучуудын Чуулга Уулзалтаас гаргасан уриалгыг Дэлхийн Өвийн Боловсролын вэб сайтаас аваарай: <http://www.unesco.org/whc/education>

- Дэлхийн Өвийн Залуучуудын Анхдугаар Чуулга Уулзалт, Берген, Норвег 24-1995-VI-24-28
- Дэлхийн Өвийн Европын Залуучуудын Анхдугаар Чуулга Уулзалт, Дубровник, Хорват 1996-V-25-30
- Дэлхийн Өвийн Африкийн Залуучуудын Анхдугаар Чуулга Уулзалт, Викториа Хүрхрээ, Зимбабве, 1996-X-18-24
- Ази- Номхон Далайн орнуудын Дэлхийн Өвийн Залуучуудын Чуулга Уулзалт, БНХАУ, Бээжин 1997-XI-15-21
- Дэлхийн Өвийн Залуучуудын Олон Улсын 2-р чуулга уулзалт Япон, Осака 1998-XI-21-29
- Дэлхийн Өвийн Залуучуудын Арабын Нэгдсэн Улсын анхдугаар чуулга уулзалт, Марокко, Ифран 1999-XI-22-28
- Дэлхийн Өвийн Залуучуудын Номхон Далайн чуулга уулзалт, Австрали, Кайрнс 2000-XI-23-28

Тогтмол хэвлэл

Biosphere Reserves, Bulletin of World Research

ЮНЕСКО-гийн МАВ хөтөлбөр
Англи, Франц хэлээр

Товхимлууд

Biodiversity Environment and Development Briefs

Шинжлэх Ухаан, Хамгаалал ба зохистой хэрэглээ
Парис, ЮНЕСКО, 1994
Англи хэлээр

176

■ ЮНЕСКО-гийн худалдаалагддаг материалууд

Дэлхийн Өвийн үндсэн хэвлэлүүд

Management Guidelines for World Cultural Heritage Sites

Bernard M. Feilden and Jukka Jokilehto, ICCROM/UNESCO, 1993

The World Heritage Desk Diary

San Marcos/ UNESCO, Madrid / Paris
Англи, Франц, Испани хэлээр

The World heritage

Хүүхдийн хэвлэл/ ЮНЕСКО, Парис
Англи, Франц, Испани хэлээр

Patrimonio de la Humanidad

12 боть нэвтэрхий толь
San Marcos/ UNESCO, Madrid/ Paris, 1995
Испани хэлээр

World Heritage

12 боть нэвтэрхий толь
Verlagshaus Stuttgart/Plaza y Janes/ UNESCO
Stuttgart/ Paris, 1996/ 1997
Герман хэлээр

The World Heritage

12 боть нэвтэрхий толь
Kodansha/ UNESCO, Tokyo/ Paris, 1996/ 1997
Япон хэлээр

Schatze der Menschheit

Frederking & Thaler/ UNESCO, Munchen/ Paris, 1996/ 1997
Герман хэлээр

Our Creative Diversity: Report of the World Commisiion on Culture and Development

Paris, UNESCO, 1995

ТОГТМОЛ ХЭВЛЭЛ

The World Heritage Review

Дэлхийн Өвийн Соёлын ба Байгалийн дурсгалт газруудын талаарх сард 2 удаа
Англи, Франц, Испани хэлээр

■ Бусад худалдаалагддаг материалууд

177

Masterworks of Man and Nature

Patonga, Australia, Harper-MacRae Publishing, 1992
ISBN: 0-646-05376-0
Англи хэлээр
Захиалах хаяг: IUCU, rue Mauverney 28, 1196 Gland, Switzerland

Paradise on Earth

Patonga, Austarlia, JIDD Publishers, 1995
ISBN: 0-646-19397-X
Англи хэлээр
Захиалах хаяг: IUCU, rue Mauverney 28, 1196 Gland, Switzerland

World Heritage Twenty Years Later

Gland, Switzerland, IUCN, 1992
ISBN: 2-8317-0109-0
Англи хэлээр
Захиалах хаяг: IUCU, rue Mauverney 28, 1196 Gland, Switzerland

Дээрх материалуудыг захиалахыг хүсвэл: <http://www.iucn.org/bookstore>

World Cultural and Natural Property

Залуучуудад зориулсан хэвлэл
Токуо, Gakken, 1994
Япон хэлээр

■ Харилцах хаягууд

ЮНЕСКО-гийн үнэгүй тараагдах материал:

UNESCO World Heritage Center
7, place de Fontenoy, 75352 Paris 07 SP, France
Факс: (33 1) 01 45 68 55 70
И-мэйл: wh-info@unesco.org

Associated Schools Project Network (ASPnet)
Education sector
UNESCO, 7, place de Fontenoy, 75352 Paris 07 SP, France
Факс: (33 1) 01 45 68 56 39
И-мэйл: aspnet@unesco.org

ЮНЕСКО-гийн худалдаалагдах материал:

UNESCO Publishing Office
1, rue Miollis, 75732 Paris Cedex 15, France
Факс: (33 1) 45 68 57 41
И-мэйл: c.laje@unesco.org

Түүнчлэн Дэлхийн Өв болон Холбоот Сургуулиудын
Төслийн Сүлжээний
талаар мэдээлэл авахыг хүсвэл:
Дэлхийн Өвийн Төв
<http://www.unesco.org/whc>

Холбоот Сургуулиудын Төслийн Сүлжээ /ASPnet/
<http://www.unesco.org/education/asp>

Англи хэлнээс хөрвүүлсэн:

Н. Уртнасан

Ц. Самдан

Хянан тохиолдуулсан:

Н. Уртнасан

Хаяг: ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисс
Засгийн газрын 11-р байр, Хувьсгалчдын өргөн чөлөө
Шуудангийн салбар 38

Утас: (976)-11-315652

Факс: (976)-11-322612

Э шуудан: mon.unesco@mongol.net

